



ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Андеррайтер



2018 он



Үнэт цаасны танилцуулга



ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 23-р зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, 38-р зүйлийн 38.8 дахь хэсэг, 62-р зүйлийн 62.1.3, 62.1.4 дэх заалтууд, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлсийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг болон Үнэт цаас гаргагчийн дүрмийн 6.2-т заасныг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын , 2018 оны 06 сарын 07 өдрийн 05/2018 тоот тогтоолоор тус компанийн нийт хувьцааны 25 хувь 50,000,000 ширхэг хувьцаа нэмж гарган Монголын хөрөнгийн биржийн II ангиллаар анх удаа нийтэд санал болгон арилжихаар шийдвэрлэсэн байна.


ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БУЙ ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ


Үнэт цаас гаргагч	"Түмэн шувуут" ХХК
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Нийт гаргасан хувьцааны тоо	150,000,000
Нэмж гаргаж буй хувьцааны тоо	50,000,000
Нэмж гаргасны дараах нийт хувьцааны тоо	200,000,000
Нэмж гаргаж буй хувьцааны хувь	25%
Олон нийтэд санал болгох нэгж хувьцааны үнэ	200 төгрөг
Нийт татан төвлөрүүлэх дүн	10,000,000,000 төгрөг
Компанийн нийт хувьцааны зах зээлийн үнэ	40,000,000,000 төгрөг
Хувьцааг арилжаалах арга	Тогтоосон үнийн арга



Андеррайтер

2018 он





Үнэт цаасны танилцуулга



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын "Компанийн тухай хууль", "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль" болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох журмуудын дагуу өөрийн хувьцаанаас анх удаа олон нийтэд санал болгож байна.


Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас 200 төгрөгийн үнийн дүн бүхий нийт 50,000,000 ширхэг энгийн хувьцааг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй арилжихтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно.


Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд өөрийн мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэйгээ зөвлөлдөхийг зөвлөж байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа аль болох үнэн зөв мэдээллийг ашиглан бодит байдалд нийцүүлэхийг зорьсон боловч мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭР ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.


Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч болон Андеррайтер Голомт Капитал ҮЦК ХХК-д хандаж тодруулна уу.







Агуулга

1.	ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ	10
1.1	Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга	10
1.2	Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр;	13
1.3	Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид	13
1.4	Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн мэдээлэл	18
1.5	Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, шинжилгээ	19
1.6	Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай;	26
1.7	Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдийн тухай;	26
1.8	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, үйл ажиллагааны онцлог зах зээлд эзэлж буй байр суурь, өрсөлдөгч байгууллагуудын тухай мэдээлэл;	28
1.8.1	Үйлдвэрийн хүчин чадал	28
1.8.2	Өндөгний борлуулалт	29
1.8.3	Өндөг үйлдвэрлэх үйл явц	30
1.8.4	Эрүүл мэндийн хяналт шалгалт	31
1.8.5	Малын тэжээлийн зах зээл, эрэлт хэрэгцээ, Аргофийд тэжээлийн үйлдвэр	32
2.	ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛ	34
2.1	Монгол улсын эдийн засгийн төлөв байдал	34
2.1.1	Үнэт цаасны зах зээлийн тухай	38
2.2	Мал аж ахуй	39
2.2.1	Эрчимжүүлсэн мал аж ахуйг хөгжүүлэх төрийн бодлого	40
2.3	Өндөгний зах зээлийн бүтэц, ерөнхий байдал	41
2.4	Тэжээлийн зах зээлийн бүтэц, ерөнхий байдал	44
2.5	Тахиа, тэжээвэр шувууны махны зах зээл	46
2.6	Бордооны зах зээл	51
2.7	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;	52
2.7.1	Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө	57
3.	ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ	58
3.1	Нийтэд санал болгох үнэт цаасны төрөл тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ, нийтэд санал болгох болон арилжих нөхцөл	58
3.2	Нийтэд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг;	58
3.3	Үнэт цаас эзэмшигчийн үүрэг	60
3.4	Үнэт цаасны үнэ тогтоосон үндэслэл	61
3.4.1	Үнэт цаасны үнэ тогтоосон үндэслэл	61
3.4.1.1	Цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах арга (Discounted Cash Flow)	62
3.5	Үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах бизнесийн төлөвлөгөө;	64
3.5.1	Өндөгний 8-р байр	65





- 3.5.1.1 Өндөг боловсруулах үйлдвэр..... 67
- 3.5.2 Тахианы махны аж ахуй, тэжээл үйлдвэрлэл 69
- 3.5.3 Сангасны аж ахуй..... 72
- 3.5.4 Тэжээлийн үйлдвэрийн өргөтгөл, царгас тариалалт 74
- 3.5.5 Үнэт цаас гаргаснаар бий болох үр өгөөж 77
- 3.6 Цаашдын бизнес төлөвлөгөөний тойм; 78
- 3.7 Ирээдүйн санхүүгийн төсөөлөл 96
- 3.8 Ногдол ашгийн бодлого 98
- 3.9 Үнэт цаасны эрх зүйн орчин 99
 - 3.9.1 Хууль эрх зүйн орчин 99
 - 3.9.2 Холбогдох журмууд 100
 - 3.9.3 Татвар..... 102
- 3.10 ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ 102
 - 3.10.1 Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа 102
 - 3.10.2 Үнэт цаасыг олон нийтэд арилжаалах журам 105
 - 3.10.3 Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа 105
- 4. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ..... 107
 - 4.1 Үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагаанд мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээдүүд 107
 - 4.1.1 Андеррайтер..... 107
 - 4.1.2 Хараат бус аудит 107
 - 4.1.3 Хуулийн байгууллага 108
 - 4.1.4 Үнэлгээний байгууллага 109
 - 4.2 Тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын тухай мэдээлэл. 110
 - 4.2.1 Андеррайтертай байгуулсан гэрээ 110
 - 4.2.2 Хараат бус аудитын гэрээ 111
 - 4.2.3 Хуулийн гэрээ 111
 - 4.2.4 Үнэлгээний гэрээ 112
- 5. Үнэт цаасны үйл ажиллагаанд оролцсон талуудын дүгнэлт 113
 - 5.1 Андеррайтерийн дүгнэлт 113
 - 5.2 Аудитын тайлан 125
 - 5.1 Хуулийн дүгнэлт 182
 - 5.2 Хөрөнгийн үнэлгээний тайлан..... 218
 - 5.3 Бизнесийн үнэлгээний тайлан..... **Error! Bookmark not defined.**
 - 5.4 Усжуулах ХК-ийн хөрөнгийн үнэлгээний тайлан..... **Error! Bookmark not defined.**
- 6. ХАВСРАЛТ 218
 - 6.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол 348
 - 6.2 Компанийн гэрчилгээ 350
 - 6.3 Компанийн дүрэм 352





Үнэт цаасны танилцуулга

6.4	Хувьцаат компанийн дүрмийн төсөл.....	358
6.5	Засаглалын гэрчилгээ.....	373
6.6	Андеррайтерийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл.....	375
6.7	Хуулийн байгууллагын гэрчилгээ, тусгай зөвшөөрөл.....	379
6.8	Аудитын байгууллагын гэрчилгээ, тусгай зөвшөөрөл.....	381
6.9	Үнэлгээний гэрчилгээ, тусгай зөвшөөрөл.....	383
6.10	Тусгай зөвшөөрлүүд.....	387
6.11	Усжуулах гэрчилгээ.....	389
6.12	Усжуулах хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл.....	390
6.13	Үнэт цаас гаргагчийн холбогдох лавлагаанууд.....	391

ХҮСНЭГТ

Хүснэгт: 1	Хувьцаа эзэмшлийн мэдээлэл.....	13
Хүснэгт: 2	Хувьцаа эзэмшлийн мэдээлэл /IPO-ны дараа/.....	14
Хүснэгт: 3	Ажилчдын тоо, бүтэц.....	15
Хүснэгт: 5	Үйлдвэрийн хүчин чадал.....	28
Хүснэгт: 6	Валютын ханш.....	36
Хүснэгт: 7	Монгол улсын зээлжих зэрэглэл.....	36
Хүснэгт: 8	ОУВС-н Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн нөхцөл.....	37
Хүснэгт: 9	ДНБ-ий төсөөлөл, Эх сурвалж: СЯ, ОУВС.....	37
Хүснэгт: 10	УУ-н бүтээгдэхүүний үнэ.....	37
Хүснэгт: 12	Мал аж ахуйн мэдээлэл.....	43
Хүснэгт: 13	Тэжээлийн үйлдвэрүүдийн хүчин чадал.....	45
Хүснэгт: 14	Монгол улсын бэлтгэсэн тэжээл.....	45
Хүснэгт: 15	Тахианы махны импортын мэдээ.....	48
Хүснэгт: 16	Тахианы махны зах зээлийн бүтэц.....	48
Хүснэгт: 17	Хөрөнгө оруулалтын задаргаа.....	65
Хүснэгт: 18	Гаалийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо.....	75
Хүснэгт: 19	Хадлан авсан байдал, Эх сурвалж: ҮСХ.....	77
Хүснэгт: 20	Гурилын дотоодын үйлдвэрлэл, Эх сурвалж: ГЕГ, ҮСХ.....	81
Хүснэгт: 21	Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, Эх сурвалж: ҮСХ.....	82
Хүснэгт: 22	Экспортлосон мах (Мянган тн).....	82
Хүснэгт: 23	Увс аймгийн цаг агаарын түүхэн мэдээ.....	83
Хүснэгт: 24	Царгасны тэжээллэг чанарын үзүүлэлт.....	84
Хүснэгт: 25	Баруунтуруун сумын Бортын хошууны тариалангийн талбайн хөрсний шинжилгээ 2017 оны 10-р сард.....	85
Хүснэгт: 26	Монгол хонины махны гарц.....	85
Хүснэгт: 27	Увс аймгийн 2016 онд бойжуулсан хурга.....	86
Хүснэгт: 28	Баруун аймгуудын гурилын жилийн хэрэгцээ.....	89
Хүснэгт: 29	Мах бэлтгэл (мянган тонноор).....	90
Хүснэгт: 30	Австрали улсаас 2015 онд экспортлосон хурганы мах.....	93
Хүснэгт: 31	Үнэт цаас худалдан авах дараалал.....	104





Үнэт цаасны танилцуулга





ГРАФИК

График 1 Ашигт ажиллагааны харьцаанууд.....	22
График 2 Компанийн өгөөжийн тооцоолол.....	22
График 3 Санхүүгийн хөшүүргийн мэдээлэл.....	23
График 4 ББӨ ба ерөнхий ба удирдлагын зардал.....	25
График 5 Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний статистик.....	29
График 6 Борлуулсан бүтээгдэхүүний статистик.....	29
График 7 Малын тоо.....	39
График 8 Өндөглөгч шувууны статистик мэдээлэл.....	42
График 9 Импортын өндөгний зах зээлийн мэдээлэл.....	42
График 10 Малын тэжээлийн импорт.....	46
График 11 Cobb-500 тахиа.....	47
График 12 Тахианы мах үйлдвэрлэл.....	47
График 13 Тэжээвэр шувууны махны импорт.....	48
График 14 Тахианы мах экспортлогч/импортлогч ТОП-5 улс.....	49
График 15 Азотын бороо.....	52
График 16 Бусад бороо.....	52
График 18 Царгас экспортогч орнууд.....	90
График 19 Өвсний экспортын хэмжээ.....	91
График 20 Зарим орны импортлосон царгас, бусад өвс (тн-оор).....	91
График 21 Бусад өвсний экспортын хэмжээ.....	91
График 22 Арван том экспортлогч, арван том үйлдвэрлэгч орон.....	92
График 23 Хурганы мах үйлдвэрлэгч 10 орон.....	92
График 24 Австралийн хурганы махны экспорт.....	93
График 25 Австралиас Ойрх Дорнодруу экспортлосон хурга (улаан), хонь (цэнхэр)-ны махны хэмжээ.....	94
График 26 Хонь хурганы махны үнийн дүн.....	94
График 27 Австралийн экспортын хурганы махны үнэ.....	95
График 28 Шинэ Зеландаас экспортлосон нэг тонн хурганы махны үнэ.....	95


ЗУРАГ

Зураг 1 Харилцагч компаниудын нэрс.....	12
Зураг 2 Байгууллагын бүтэц.....	15
Зураг 3 Усжуулах ХК-ны талбай.....	28
Зураг 4 Усжуулах ХК-ны план зураг.....	28
Зураг 5 Усжуулах ХК-ны тоног төхөөрөмж.....	28
Зураг 6 Усжуулах ХК-ны тоног төхөөрөмж.....	28
Зураг 7 Өндөг бий болох дараалал.....	31
Зураг 8 Өндөглөгч тахианы үр ашгийн муруй.....	31
Зураг 10 Аргофийд үйлдвэрийн бүтээгдэхүүнүүд.....	34
Зураг 11 Блүүмберг агентлаг.....	35
Зураг 12 ДНБ-ий задаргаа, Эх сурвалж: ҮСХ.....	35
Зураг 13 Тэжээлийн үйлдвэрүүдийн байршил.....	44
Зураг 14 Тахианы үйлдвэрийн зураг.....	65
Зураг 15 Өндөглөгчийн байрны план зураг.....	66
Зураг 16 Nabel брендийн өндөг боловсруулах тоног төхөөрөмж.....	68
Зураг 19 Өндөг боловсрох хугацааны дараалал.....	69
Зураг 20 Махны тахианы үйлдвэрийн зураг.....	70
Зураг 17 Тахианы үйлдвэрийн доторх зураг.....	72
Зураг 18 Тахианы үйлдвэрийн доторх зураг.....	72
Зураг 21 Сангасны үйлдвэрийн зураг, Эх сурвалж: Kohsin компани.....	73
Зураг 22 Органик бордоо.....	74
Зураг 23 Услалтын системийн толгойн байгууламж, ус хуримтлуулсан цөөрөм.....	84
Зураг 24 Толгойн байгууламжаас илүүдэл ус дамжуулах хэсэг.....	84






Үнэт цаасны танилцуулга



Зураг 25 Илүүдэл усыг Туруун голоор урсгах хэсэг 84
 Зураг 26 Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө 102
 Зураг 27 Анхдагч зах зээлд оролцох заавар 103

ХАВСРАЛТ

Хавсралт 1 Түмэн шувуут ХХК-н дүрэм 357
 Хавсралт 2 Засаглалын гэрчилгээ 374
 Хавсралт 3 Андеррайтерийн УБ-н гэрчилгээ 375
 Хавсралт 4 Андеррайтерийн тусгай зөвшөөрөл 378
 Хавсралт 6 Хуулийн байгууллагын УБ-н гэрчилгээ 379
 Хавсралт 7 Хуулийн байгууллагын тусгай зөвшөөрөл 380
 Хавсралт 9 Аудитын байгууллагын УБ-н гэрчилгээ 381
 Хавсралт 10 Аудитын байгууллагын тусгай зөвшөөрөл 382
 Хавсралт 12 Үнэлгээний байгууллагын УБ-н гэрчилгээ 384
 Хавсралт 13 Үнэлгээний байгууллагын тусгай зөвшөөрөл 386
 Хавсралт 15 Тусгай зөвшөөрөл 387
 Хавсралт 16 Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрөл 388
 Хавсралт 17 Усжуулах ХК-н УБ-н гэрчилгээ 389
 Хавсралт 18 Усжуулах ХК-н хувьцаа эзэмшлийн тодорхойлолт 390
 Хавсралт 19 ОӨУБЕГ-н лавлагаа 391
 Хавсралт 20 ОӨУБЕГ-н Бүртгэлийн архивын газрын лавлагаа 392
 Хавсралт 21 Гаалийн ерөнхий газрын лавлагаа 393
 Хавсралт 22 Эрүүл мэнд нийгмийн даатгалын газрын лавлагаа 393
 Хавсралт 23 Татварын ерөнхий газрын лавлагаа 394
 Хавсралт 24 Төрийн банкны лавлагаа 394
 Хавсралт 25 Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн лавлагаа 395
 Хавсралт 26 Голомт банк, Хас банкны лавлагаа 396
 Хавсралт 27 Хаан банкны лавлагаа 397
 Хавсралт 28 Мал хамгаалах сангийн лавлагаа 397
 Хавсралт 29 ХХААХҮЯ-ны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн лавлагаа 398
 Хавсралт 30 Монголын олон улсын үндэсний арбитрагийн лавлагаа 398
 Хавсралт 31 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба 399
 Хавсралт 32 Шүүхийн ерөнхий зөвлөхийн Шүүхийн төрөлжсөн архив 399
 Хавсралт 33 Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны Шүүхийн тамгын газрын лавлагаа 400
 Хавсралт 34 Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газрын лавлагаа 401
 Хавсралт 35 Усжуулах ХК-н Төрийн банкны лавлагаа 402
 Хавсралт 36 Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн лавлагаа 402
 Хавсралт 37 Усжуулах ХК-н Хаан банкны лавлагаа 403
 Хавсралт 38 Усжуулах ХК-н Мал хамгаалах сангийн лавлагаа 403
 Хавсралт 39 Усжуулах ХК-н ГЕГ-н тодорхойлолт 404
 Хавсралт 40 Усжуулах ХК-н Арилжааны төлбөр тооцоо ХХК-н лавлагаа 404
 Хавсралт 41 Усжуулах ХК-н Монголын олон улсын үндэсний арбитрагийн лавлагаа 405





Үнэт цаасны танилцуулга



Товчилсон үгийн жагсаалт

Үнэт цаас гаргагч, компани гэж

МХБ
СЗХ
АНУ
ОХУ
БНХАУ
ХНХ
ОН
ТӨХК
ХХААЯ
ҮЦЗЗТХ
ЗХУ
ҮЦТХТ
АТТ
DCF
APU
MMX
SUU
TCK
TTL
MNP
GOV
NEH
MIK
ATR
DNU
UBH
TAN
RMC

Түмэн шувуут ХХК-г
Монголын хөрөнгийн бирж
Санхүүгийн зохицуулах хороо
Америкийн Нэгдсэн Улс
Оросын Холбооны Улс
Бүгд Найрамдах Хятад Ард Улс
Хувь нийлүүлсэн хөрөнгө
Олон нийт
Төрийн өмчит хувьцаат компани
Хүнс хөдөө аж ахуйн яам
Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
Зөвлөлт холбоот улс
Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
Арилжааны төлбөр тооцоо
Discounted Cash flow
АПУ ХК
Мах Импекс ХК
Сүү ХК
Талх Чихэр ХК
Таван Толгой ХК
Монгол Шуудан ХК
Говь ХК
Дархан Нэхий ХК
Мик ХК
Атар Өргөө ХК
Дархан Хүнс ХК
Улаанбаатар Хивс ХК
Тахь-Ко ХК
Ремикон ХК





Үнэт цаасны танилцуулга



1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

1.1 Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга

Компанийн оноосон нэр	"Түмэн Шувуут" ХХК
Хаяг байршил	Хан-Уул дүүрэг, 13-р хороо, Туул тосгон, Түмэн шувуут ХХК байр
Үйл ажиллагааны чиглэл	Тахиа шувууны аж ахуй Малын тэжээлийн үйлдвэрлэл Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл Сав, баглаа боодлын үйлдвэрлэл, худалдаа Гадаад худалдаа
Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэх	Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж байгаагүй
Утас	+ 976 - 70005115 + 976 - 88001125
И-мэйл хаяг	info@tumenshuvuut.mn
Вэбсайт	http://tumenshuvuut.mn/

Түмэн шувуут ХХК нь (цаашид Компани эсвэл Үнэт цаас гаргагч гэх) анх 2004 онд 20,000 өндөглөгч тахиатайгаар үүсгэн байгуулагдсан цагаас өнөөг хүртэл тахиа шувууны аж ахуйн үйл ажиллагааг тогтвортой, амжилттай эрхэлж өнөөгийн байдлаар 250,000 гаруй өндөглөгч тахиатай, 140 ажилтантай Монгол улсын өндөгний хэрэгцээний 30 орчим хувийг дангаар хангагч аж ахуй болон хөгжөөд байна.


Компани хэрэглэгчдэд өдөр бүр 140,000 орчим шинэ өндөг хүргэхээс гадна шувууны аж ахуйтай холбоотой дараах үйл ажиллагааг цогцоор нь эрхэлж байна. Үүнд:

- **Нэг хоногийн настай дэгдээхэй нийлүүлэх**


Үнэт цаас гаргагч нь үр хөврөл бүхий өндөгийг импортоор тусгай зориулалтын автомашинаар тээвэрлэн нэг ээлжиндээ 150 мянган өндөг дарах хүчин чадал бүхий инкубатор төвд авчирч 18-21 хоног дарсны эцэст нэг хоногийн настай дэгдээхэйг гарган авдаг. Уг дэгдээхэйгээр өөрийн компанийн сүргийг бүрдүүлэхийн зэрэгцээ бусад өндөглөгч тахианы аж ахуйнуудад борлуулж тэдгээр аж ахуйн нэгжүүдийн сүргийн нөхөн үйлдвэрлэлийг хангаж, тогтвортой үйл ажиллагааг нь дэмжиж байна. Үнэт цаас гаргагч нь 2004 оноос хойш өндөг амилуулах инкубатор цех ажиллуулж Монгол улсын өндөглөгч тахианы сүргийн нөхөн үйлдвэрлэлийг дотоодоосоо хангаж байгаа ганц аж ахуй юм.

- **Өндөгний сав баглаа, боодол**

Өндгийг хэрэглэгчдэд чанар, стандартын дагуу, бүрэн бүтэн хүргэх хамгийн чухал нөхцөлүүдийн нэг нь сав баглаа боодол байдаг. Тус компани хаягдал цаасаар өндөгний сав баглаа үйлдвэрлэж цөйльсийн 400 градус хүртэл өндөр температурт ариутгаж өөрийн хэрэгцээнд болон бусад аж ахуйн нэгжүүдэд нийлүүлж байна. Үйлдвэрлэж буй сав баглаа боодол нь байгаль орчинд ээлтэй, хэрэглэгчдийн хувьд эдийн засгийн хэмнэлттэй, компанийн бизнесийн нэгэн чухал хэсэг болон хөгжсөн. Компани өөрийн хэрэгцээнээс илүү гарсан сав баглаа боодлыг бусад аж ахуй нэгжүүдэд борлуулдаг бөгөөд компанийн орлогын 1.2 хувийг буюу жилд 170 сая төгрөгийн эх үүсвэрийг уг борлуулалтаар бүрдүүлдэг байна.



Handwritten signature



■ Шувууны болон малын тэжээл

Үнэт цаас гаргагч нь 2015 онд хоногт 100 тонн шувууны болон малын тэжээл үйлдвэрлэх хүчин чадал бүхий Агро Фийд (Agro Feed) үйлдвэрийг Сонгино хайрхан дүүргийн 21-р хороонд байрлах өөрийн эзэмшлийн 150,000 м² талбайд байгуулсан. Уг үйлдвэрт улаан буудай, арвай, хивэг, халгай, өвсний гурил, рапсын шахдас, ургамлын тос, хужир, шүү, давс зэрэг дотоодын түүхий эд болон эрдэнэ шиш, шар буурцаг, үл орлогдох амин хүчил, витаминь бэлдмэлийг гадаадын нэр хүндтэй харилцагч байгууллагуудаас авч өсвөр шувуу, өндөглөгч шувууны 5 нэр төрлийн тэжээл үйлдвэрлэж өөрийн компанийн хэрэгцээнд болон бусад өндөглөгч тахианы аж ахуйнуудад нийлүүлж байна. Агрофийд тэжээлийн үйлдвэр ашиглалтанд орж дотооддоо тахианы тэжээлээ үйлдвэрлэдэг болсон нь Монгол хүний хүнсэнд хэрэглэж байгаа өндөгийг ямар тэжээлээр тэжээсэн өндөглөгчөөс нийлүүлж байгаад өдөр тутам хяналт тавих боломжийг бий болгож хүнсний аюулгүй байдлын хяналтанд томоохон дэвшил гарсан байна.

Үнэт цаас гаргагч нь мэргэжлийн хүний нөөцдөө түшиглэн олон жилийн идэвхитэй, уйгагүй судалгаа хийсний үр дүнд тэжээлийн үйлдвэртээ малын төрөл, насны ангилал, тухайн амьтдын физиологийн онцлог зэрэгт нийцүүлэн шувууны 5 төрлийн, малын 6 төрлийн тэжээл үйлдвэрлэж байна. Тус компани нь Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захиалгаар Монгол хүний цусан дахь селений дутагдлыг нөхөх хөтөлбөр хэрэгжүүлж олон улсын зөвшөөрөгдсөн технологиор тахианы тэжээлийг селенээр баяжуулж баяжуулсан тэжээрээр өндөглөгч тахиа тэжээн "СЕЛЕНТЭЙ ӨНДӨГ" шинэ бүтээгдэхүүнийг худалдаанд гаргасан нь хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн болсон байна. Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн эрдэмтдийн хийсэн судалгаагаар Монгол хүний цусанд байх селений хэмжээ бусад орнуудтай харьцуулахад бага буюу Монгол хүмүүс селений дутагдалтай болохыг тогтоосон байна.¹ Селений дутагдал нь дархлааг сулруулах, хорт хавдраар өвчлөх эрсдэлийг нэмэгдүүлж, өсвөр насны хүүхдийн тархины хөгжлийг саатуулдаг болох нь тогтоогдсон. Селенээр баяжуулсан өндөг нь жирийн өндөгнөөс 3 дахин их селений агууламжтай, хүн өдрийнхөө селений нормын 40 хувийг 2 ширхэг селентэй өндөгнөөс авч чадна. Тиймдээ ч "Селентэй өндөг"-ний борлуулалт жилээс жилд өсч байна.


Цаашлаад компани нь бүх төрлийн малд зориулсан "Тарга", саалийн үнээний "Сүүт", хурдан морины "Хурд", адууны "Амар", "Шингүүртэй овъёос" зэрэг шинэ нэр төрлийн, төгс чанарын тэжээл үйлдвэрлэж байгаа нь хэрэглэгчдээс өндөр үнэлгээ авч байна. Тэжээлийн үйлдвэр нь өөртөө итгэмжлэгдсэн чанарын лаборатортой бөгөөд түүхий эд хүлээн авахад, үйлдвэрлэсэн бэлэн бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийж, гарал үүсэл чанарын баталгааг хангаж байна

■ Тахианы мах үйлдвэрлэх

Өндөглөгч шувуу нь 640-700 хоног насалсны эцэст үржил шим нь буурдаг тул шинэ залуу тахиагаар солих шаардлага үүсдэг. Компани өөрийн бүрэн автомат нядалгааны төвд өндөглөх идэвхтэй үе нь дууссан тахиаг бэлтгэн тахианы мах зах зээлд нийлүүлдэг. Хэдийгээр өндөглөгч тахианы мах нь махны чиглэлийн тахианыхтай харьцуулахад жин бага байдаг боловч органик тэжээлээр тэжээж, бордоо бага хэрэглэдэг тул шим тэжээллэгийн хувьд давуу байдгаараа ялгардаг.

Азийн ихэнхи орны хэрэглэгчид өндөглөгч тахианы шөл нь нь ядаргаа тайлах үнэт хүнс гэж үздэг. Тийм ч учраас сүүлийн жилүүдэд азийн орнуудад өндөглөгч тахианы ядаргаа тайлах шөл нийтийн хоолны хоолны сүлжээнд өргөн дэлгэрч байна.

¹ насанд хүрсэн монгол хүний ийлдэс дэх селений дундаж хэмжээг Бүс нутгаар харьцуулан тогтоох, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн судалгаа



Үнэт цаасны танилцуулга



Түмэншувуут ХХК



Алсын Хараа

Өндөг үйлдвэрлэх туршлагаараа хамгийн инновацлаг, тэргүүлэгч байх

Эрхэм Зорилго

- Монгол хүний эрүүл мэндийн төлөө шинэ, чанартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, хэрэглэгчдэд нийлүүлэх.
- Мэргэшсэн, ёс зүйтэй, хариуцлагатай баг хамт олон байх.
- Хүнс, тэжээл үйлдвэрлэх үйл ажиллагаагаараа мал аж ахуй, газар тариалангийн салбарын уялдаа холбоог сайжруулж, байгаль орчныг хамгаалах.

Гадаад харилцаа

Үнэт цаас гаргагч нь олон улсын нэр хүнд бүхий компаниудтай нягт уялдаа холбоотой ажилладаг бөгөөд тэдгээр үйлдвэрлэгч нарын үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж, түүхий эдийг өөрийн үйлдвэртээ ашиглан олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэдэг.

СОНИРХОЛТОЙ БАРИМТ-1
Өндгийг хэр хугацаанд хадгалах вэ?
 Монгол Улсад мөрдөгдөж байгаа MNS 0095:77 стандартын дагуу өндгийг 0 градусаас +2 градустай орчинд 30 хоног хадгалж болно. Хэрвээ өндөгний хальс цуурсан, хагарсан бол хадгалах хугацаа 5 хоног хүртэл буурдаг. Чанасан, шарж болгосон өндгийг мөн адил градуст 12-18 цаг хадгална.

Хамтран ажилладаг байгууллагуудад:



АНУ-н Каргилл – Провими компани



Аллтек компани



Нидерландын – Нуово компани



ОХУ-н Свердловскийн шувууны аж ахуй



ОХУ-н Янта компани



БНХАУ-н GX компани



БНХАУ-н Famsun групп




Олон улсын SGS лаборатори



Зураг 1. Харилцагч компаниудын нэрс



Үнэт цаасны танилцуулга



Манай компани нь АНУ-ын Alltech компаниас хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болох органик селенийг, АНУ-ын Каргилл Провими компаниас тэжээлийн түүхий эд болох премиксийг, ОХУ-ын Янта-Т компаниас тэжээлийн түүхий эд болох шарбуурцагны шахдасыг, БНХАУ-ын GX компаниас шувууны үйлдвэрийн тоног төхөөрөмжийг, мөн БНХАУ-ын Famsun группээс тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг, ОХУ-ын Свердловскийн шувууны аж ахуйгаас үржлийн өндгийг, Ниперландын Нуово компаниас өндөг тамгалах зориулалтаар хүнсний будаг зэргийг авдаг ба Олон улсын SGS лабораторит түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулан гадаад хяналт хийлгэн хамтран ажилладаг.

Мөн компани Япон улсын Kohshin, Nabel зэрэг компаниудтай хамтран ажиллаж, тухайн компаниудын үйлдвэрлэсэн өндөг савлах, ангилах болон тахианы сангасаар бордоо үйлдвэрлэх тоног төхөөрөмж худалдан авах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

1.2 Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр;

Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл

Байгуулагдсан огноо	2004.08.20
Компанийн хэлбэр	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Улсын бүртгэлийн дугаар	9011127143
Регистрийн дугаар	2844753
Бүртгэгдсэн он сар өдөр	2006.06.29

Түмэн шувуут нь “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн дагуу Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2011.12.30-ны өдрийн А/369 дугаар тушаалаар Малын эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 13)-ийг 2011.12.30-ний өдөр авсан ба Монгол Улсын Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014.09.16-ны өдрийн А/342 дугаар тушаалаар Үржлийн тахиа, дэгдээхэй, үржлийн өндөг импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 14) 2014.09.16-ны өдөр авсан байна.

1.3 Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

Үнэт цаас гаргагч нь нэр бүр нь 20 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 150,000,000 ширхэг энгийн хувьцаатай бөгөөд нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 3,000,000,000 /гурван тэрбум/ төгрөг байна. Энэхүү танилцуулгыг бэлтгэх үед үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийг дор дурдсан нэр бүхий Монгол Улсын 4 иргэн эзэмшиж байна.

№	Овог Нэр	Хувьцааны тоо	Хувь эзэмшил	ХНХ-н хэмжээ /төгрөг/	Эрхэлж буй тушаал	албан
1	Ломбын Эрхэмбаяр	60,000,000	40%	1,200,000,000	Түмэн шувуут зөвлөх	ХХК-н
2	Балайгийн Тунгалаг	60,000,000	40%	1,200,000,000	Түмэн шувуут зөвлөх	ХХК-н
3	Жигжидийн Болд	15,000,000	10%	300,000,000	Түмэн шувуут Гүйцэтгэх захирал	ХХК-н
4	Эрхэмбаярын Баяржаргал	15,000,000	10%	300,000,000	Түмэн шувуут гадаад харилцааны менежер	ХХК-н
	НИЙТ	150,000,000		3,000,000,000		

Хүснэгт: 1 Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл



Handwritten signature and red stamp.



Үнэт цаасны танилцуулга

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д зааснаар тухайн компанийн гаргасан Саналын эрхтэй нийт хувьцааны тав болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг “нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж тодорхойлсон тул эдгээр 4 иргэн бүгд нөлөө бүхий хувьцаа эзэмшигч мөн.

Компанийн тухай хуулийн 23-р зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, 38-р зүйлийн 38.8 дахь хэсэг, 62-р зүйлийн 62.1.3, 62.1.4 дэх заалтууд, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлсийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг болон Үнэт цаас гаргагчийн дүрмийн 6.2-т заасныг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2018 оны 06 сарын 07 өдрийн 05/2018 тоот тогтоолоор компанийн нийт энгийн хувьцааны 25 хувь буюу 50,000,000 ширхэг энгийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-иар дамжуулан анх удаа олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгон арилжихаар шийдвэрлэсэн байна.

МХБ-ээр дамжуулан хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгосны дараах хувьцаа эзэмшлийн байдал, олон нийтийн эзэмшлийн хувийг доорх хүснэгтээр харуулав.

№	Нэр	ОН-д санал болгохоос өмнө		ОН-д санал болгосны дараа	
		ширхэг	Хувь эзэмшил	ширхэг	Хувь эзэмшил
1	Л. Эрхэмбаяр	60,000,000	40%	60,000,000	30%
2	Б. Тунгалаг	60,000,000	40%	60,000,000	30%
3	Ж. Болд	15,000,000	10%	15,000,000	7.5%
4	Э. Баяржаргал	15,000,000	10%	15,000,000	7.5%
5	Олон нийт	-		50,000,000	25%
	НИЙТ	150,000,000		200,000,000	100%

Хүснэгт: 2 Хувьцаа эзэмшлийн мэдээлэл / IPO-ны дараа

Үнэт цаас гаргасны дараа олон нийтийн эзэмшлийн хувь 25 хувь байхаар шийдвэрлэсэн нь Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 11.2.3-т заасан хувьцааны бүртгэлийн хоёрдугаар ангиллын үнэт цаасны шалгуур хангаж байгаа юм.

Түмэн шувуут нь нэг охин компанитай. Үнэт цаас гаргагч нь 2018 оны 3, 4 дүгээр сард Монголын хөрөнгийн биржийн III ангилалд бүртгэлтэй “Усжуулах” хувьцаат компанийн нийт энгийн хувьцааны 80.6 хувийг худалдан авснаар “Усжуулах” компанийн толгой компани болсон юм.

СОНИРХОЛТОЙ БАРИМТ- 2

Тахиа өдөрт хэд өндөглөдөг вэ?

Тахиа өдөрт 140 грамм тэжээл идэж нэг удаа өндөглөдөг. Тэжээлийн дутагдал, орчны температур, агаарын чанараас шалтгаалан заримдаа өнжиж өндөглөх нь бий. Өндөгний чанар нь тэжээл, тахианы амьдрах орчноос шууд хамааралтай.

Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт

Түмэн шувуут ХХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Тус компани Төлөөлөн удирдах зөвлөлгүй бөгөөд Компанийн тухай хуулиар ХХК нь төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болдог. Компанийн Гүйцэтгэх захирал нь өдөр тумын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, Компанийн тухай хуульд заасан эрх эдэлж үүрэг хүлээх бөгөөд Хувьцаа эзэмшигчид болон Гүйцэтгэх захирлын хооронд байгуулсан Хөлсөөр ажиллах гэрээгээр талуудын эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлсон байна.

Үнэт цаас гаргагч нь дотоод бүтцийн хувьд нийт 7 алба, 150 үндсэн ажилтан, 9 гэрээт, 8 түр ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.



Үнэт цаасны танилцуулга



№	Үйлдвэр, албадын нэр	Үндсэн ажилтан	Гэрээт ажилтан	Түр ажилтан
1	Захиргааны алба	14		
2	Санхүүгийн алба	6		
3	Борлуулалтын алба	35		
4	Шувууны аж ахуй	66	8	8
5	Тэжээлийн үйлдвэр	17	1	
6	Сорилт шинжилгээний лаборатори	4		
7	Үүрний үйлдвэр	8		
	Нийт тоо	150	9	8

Хүснэгт: 3 Ажилчдын тоо, бүтэц

Нийт ажилтнуудын 75 хувь нь тахиа шувууг технологийн горимын дагуу өсгөн үржүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх Шувууны болон тэжээлийн аж ахуй дээр ажиллаж байгаа бол 25 хувь нь борлуулалтын албанд ажиллаж байна.





Зураг 2 Байгууллагын бүтэц

Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл

Ломбын Эрхэмбаяр

Овог нэр	Ломбын Эрхэмбаяр
Албан тушаал	Түмэн шувуут ХХК-н зөвлөх
Төрсөн огноо	1962/02/21
Ажлын туршлага	2017- Түмэн шувуут ХХК-н зөвлөх 2014-2017 Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга 2008-2014 Монгол улсын Ерөнхийлөгчийн хот хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх 2002-2008 Түмэн шувуут ХХК-н ТУЗ-н гишүүн 1999-2002 ЗГХЭГ-н реферант 1996-1999 Архангай аймгийн засаг дарга 1992-1995 "Бээт" ХХК-н захирал 1989-1992 Архангай аймгийн Ихтамир сум дахь Өндөр уулын бүсийн мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан 1986-1989 Архангай аймгийн Тариат сумын "Тэрхийн бор сарлагийн үржлийн ферм" багийн дарга 1985-1986 Архангай аймгийн ХААУГ-н мэргэжилтэн
Боловсрол	2010-2013 МУИС-н Хуулийн сургууль, эрх зүйч бакалавр 2005 онд Хөдөө аж ахуйн их сургуульд ХАА-н докторын зэрэг хамгаалсан 1980-1985 Хөдөө аж ахуйн их сургууль, зоотехникч, бакалавр 1970-1980 Архангай аймгийн 10-н жилийн 1-р дунд сургууль





Үнэт цаасны танилцуулга



Овог нэр	Балаагийн Тунгалаг
Албан тушаал	Түмэн шувуут ХХК-н зөвлөх
Төрсөн огноо	1962/09/20
Ажлын туршлага	2010- Түмэн шувуут ХХК-н зөвлөх 2004-2010 Түмэн шувуут ерөнхий захирал 1999-2004 Батнаяд ХХК-н ерөнхий захирал 1992-1999 Бээт ХХК-н захирал 1990-1992 Архангай аймгийн мал аж ахуйн эрдэм шинжилгээний станц- Эрдэм шинжилгээний ажилтан 1987-1990 Архангай аймгийн Цагаан нуур сумын сарлагийн улсын үржлийн ферм- Мэргэжилтэн 1985-1987 Архангай аймгийн өндөр уулын бүс үржил селекцийн улсын станц- Мэргэжилтэн
Боловсрол	1980-1985 Хөдөө аж ахуйн их сургууль, зоотехникч, баклавр 1970-1980 Ховд аймгийн Зэрэг сумын 10-н жилийн дунд сургууль

Овог нэр	Жигжидийн Болд
Албан тушаал	Гүйцэтгэх захирал
Төрсөн огноо	1978/05/05
Ажлын туршлага	2005- Түмэн шувуут ХХК-н гүйцэтгэх захирал 2003-2005 Капитрон банкны Эдийн засагч 2001-2003 Хас банкны эдийн засагч
Боловсрол	1997-2001 МУИС-н Эдийн засгийн сургууль, эдийн засагч 1985-1996 82-р сургууль

Овог нэр	Эрхэмбаярын Баяржаргал
Албан тушаал	Түмэн шувуут ХХК-н гадаад харилцааны албаны захирал
Төрсөн огноо	1982/03/05
Ажлын туршлага	2007- Түмэн шувуут ХХК-н гадаад харилцааны албаны захирал 2006-2007 БСБ ХХК-н захиалгын мэргэжилтэн
Боловсрол	2000-2005 БНХАУ-н ОУЭЗДС эдийн засагч, баклавр 1998-2000 СЭЗДС эдийн засагч, баклавр 1988-1998 Архангай аймгийн 10-н жилийн сургууль



Эрх бүхий албан тушаалтны мэдээлэл

Дарамбазарын Баянмөнх – Тэжээлийн үйлдвэрийн дарга

Д. Баянмөнх нь 2015 оноос хойш Агро Фийд тэжээлийн үйлдвэрийн даргаар ажиллаж байна. Тэрээр 1994-1997 оны хооронд "Бээт" ХХК, 1999-2002 онуудын хооронд "Батнаяд" ХХК компанид ажиллаж байсан туршлагатай боловсон хүчин юм. Д. Баянмөнх нь Архангай аймгийн 10 жилийг 1984-1994 оны хооронд дүүргэж төгссөн цагаас хойш Түмэн шувуут ХХК-н удирдлагууд болох Л. Эрхэмбаяр, Б. Тунгалаг нартай хамтран ажиллаж байна.

Бөхцэвээний Мөнгөнтуяа – Борлуулалтын албаны дарга

Б. Мөнхтуяа нь 2013 оноос хойш Түмэн шувуут ХХК-ны борлуулалтын албанд олон жил үр бүтээлтэй ажиллаж байна. Үнэт цаас гаргагч компанид орохоос өмнө тэрээр Эм Си Эс кока кола компанид 2004-2012, Витафит ХХК-д 2001-2004 онуудад ажиллаж байсан борлуулалт, худалдааны чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин юм.





Үнэт цаасны танилцуулга



Б. Мөнхтуяа нь 1996-2001 онд Техникийн Их сургуульд бакалаврын зэрэг, 2004-2006 онуудад Монгол Улсын их сургуульд Магистрийн зэрэг, 2010-2012 онуудад Хүмүүнлэгийн Ухааны их сургуульд тус тус суралцаж төгссөн.

Найманжингийн Должинсүрэн – Ерөнхий нягтлан бодогч

Н. Должинсүрэн нь 2010 оноос хойш Түмэн шувуут ХХК-н нягтлан бодогчоор ажиллаж байна. Түмэн шувуут ХХК-д орохоос өмнө тэрээр 2004-2010 онуудын хооронд Батнаяд ХХК-д, 1996-1997 онд Нийгмийн даатгалын байцаагч, 1993-1995 онуудад Баганхангай ХХК-д ажиллаж байсан арвин туршлагатай.

Тэрээр 2003-2006 онуудад МУИС-н Эдийн засгийн сургууль, нягтлан бодогч, бакалавр 1990-1992 онуудад Худалдааны техникүмд нягтлан бодогч, эдийн засагчаар суралцаж төгссөн.

Чогдондаржаагийн Нэмэхжаргал - Шувууны аж ахуйн дарга


Ч. Нэмэхжаргал нь 2010 оноос хойш Түмэн шувуут ХХК шувууны аж ахуйн даргаар ажиллаж байна. 1985-1987 онд Хуулийн дунд сургуулийг архив бичиг хэрэг, 1991-1992 онд Хөдөө Аж Ахуйн дээд сургуулийг нягтлан бодогч, 1996-1998 онд Санхүү Эдийн Засгийн дээд сургуульд эчнээгээр суралцан нягтлан бодогч мэргэжлээр тус тус суралцаж төгссөн. Ч.Нэмэхжаргал нь манай компанид тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа тэргүүний ажилчдын нэг юм.

Удирдлагын баг


Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэж байх энэ хугацаанд дараах хүмүүс компанийн удирдлагад ажиллаж байна.

Нэр	Нас	Албан тушаал	Компанид ажилласан жил
Л. Эрхэмбаяр	56	Хувьцаа эзэмшигч	14 жил
Б. Тунгалаг	56	Хувьцаа эзэмшигч	14 жил
Ж. Болд	40	Гүйцэтгэх захирал	13 жил
Э. Баяржаргал	36	Хувьцаа эзэмшигч	11 жил
Д. Баянмөнх	42	Тэжээлийн үйлдвэрийн дарга	3 жил
Б. Мөнгөнтуяа	40	Борлуулалтын албаны дарга	5 жил
Н. Должинсүрэн	46	Ерөнхий нягтлан бодогч	8 жил
Ч. Нэмэхжаргал	54	Шувууны аж ахуйн дарга	8 жил

Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц тогтвортой, шийдвэр гаргах түвшний болон гүйцэтгэх удирдлагад олон жил тогтвортой хамтран ажиллаж зохих мэргэжил, дадлага туршлага эзэмшсэн нь үнэт цаас гаргагч нь өргөдөл гаргахаас өмнө 3-аас доошгүй жил тухайн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх (МХБ бүртгэлийн журмын 11.1.1), сүүлийн 2 жилийн дотор гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүний 2/3 хэмжээнд болон сүүлийн 1 жилд хувьцааны хяналтын багц эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт ороогүй байх (МХБ бүртгэлийн журмын 11.1.4) хувьцааны бүртгэлийн хоёрдугаар ангиллын шалгуурыг хангаж байна.



Үнэт цаасны танилцуулга



1.4 Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн “Улаанбаатар Аудит Корпораци”-аар гүйцэтгүүлсэн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын тайланд компанийн нийт хөрөнгө 14.3 тэрбум, үүнээс 9.2 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, 5 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй байна. Нийт хөрөнгийн 35 хувь нь эргэлтийн хөрөнгө, үүнээс 11 хувь нь бэлэн мөнгө, 9 хувь бараа материал байгаа бол эргэлтийн бус хөрөнгө нийт хөрөнгийг 65 хувийг эзэлж байна. Эргэлтийн бус хөрөнгийн дийлэнх хэсэг буюу нийт хөрөнгийн 62 хувийг барилга, тоног төхөөрөмж эзэлж байна.


Нөгөө талаар компанийн нийт хөрөнгийн 35 хувь буюу 5 тэрбум төгрөг нь өр төлбөр, 65 хувь буюу 9.3 тэрбум төгрөгийг эздийн өмч бүрдүүлж байна. Эздийн өмчийн 9.3 тэрбум төгрөгийн 3 тэрбум нь хувь нийлүүлсэн хөрөнгө, 6.2 тэрбум төгрөг нь хуримтлагдсан ашгаар бүрдсэн байна.

Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн үнэлгээг үнэлгээний “Итгэлт Эстимэйт” ХХК гүйцэтгэсэн ба тайланд компанийн үндсэн хөрөнгийг дараах байдалтайгаар тусгажээ.

№	Нэр	Үнэлгээний дүн	Балансын үнэ	Дахин үнэлгээний нэмэгдэл
1	Газар	1,296,076.6	9,750.8	1,286,325.8
2	Барилга байгууламж-СХД	472,624.1	237,902.9	234,721.2
3	Барилга байгууламж-ХУД	7,746,506.7	3,605,299.0	4,141,207.7
4	Барилга байгууламж-Тэжээлийн үйлдвэр	1,771,736.9	1,428,444.1	343,292.8
5	Машин, тоног төхөөрөмж	4,841,244.7	2,036,378.5	2,804,866.2
6	Машин, тоног төхөөрөмж-Тэжээлийн үйлдвэр	2,065,541.6	949,000.1	1,116,541.5
7	Үндсэн сүргийн мал, амьтад	2,253,679.0	371,598.6	1,882,080.4
8	Машин тоног төхөөрөмж үүрний үйлдвэр	183,156.3	113,783.9	69,372.4
9	Машин тоног төхөөрөмж МБУ	124,905.4	114,418.9	10,486.5
10	Программ хангамж	11,500.0	5,773.3	5,726.7
11	Тээврийн хэрэгсэл	429,000.0	304,567.3	124,432.7
12	Тээврийн хэрэгсэл	98,500.0	87,696.0	10,804.0
13	Машин тоног төхөөрөмж	560.0	487.5	72.5
14	Усжуулах ХК-ийн хөрөнгө	266,369.5		266,369.5
ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН		21,561,400.8	9,265,101	12,296,299.9

Компани өөрийн хөрөнгийг баланс дээр анхны үнээр нь бүртгэж үйл ажиллагаагаа эрхэлдэг бөгөөд хөрөнгийн үнэлгээний компани тухайн компанийн хөрөнгийн үнэлгээг 2018 оны 5 сарын 25-ны өдрийн байдлаар нийт 21.5 тэрбум төгрөгийн үнэ цэнэтэй гэж үзсэн байна. Дахин үнэлгээний нэмэгдэл гэдэг нь тухайн компанийн хөрөнгийг өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэн, нэмэгдүүлж эсвэл хорогдуулдаг бөгөөд тухайн компанийн өмч хөрөнгийг өнөөдрийн байдлаар худалдах бодит үнэ цэнийг илэрхийлдэг. Харин балансын дүн буюу хөрөнгийн анхны үнэ цэнийн бүртгэл нь тухайн хөрөнгийг худалдан авах үеийн үнэ цэнийг илэрхийлдэг тул төдийлөн тухайн хөрөнгийн бодит үнэ цэнэ болж чаддаггүй. Тэр ч утгаараа хөрөнгийн үнэлгээг хөндлөнгийн мэргэжлийн үнэлгээний байгууллагаар гүйцэтгүүлэн тайланг хавсаргасан байна.

Компанийн баланс дээрх үндсэн хөрөнгийн хэмжээ нь 9.3 тэрбум төгрөг байгаа бол дахин үнэлгээний нэмэгдлээр 12.3 тэрбум төгрөгийг нэмэгдүүлж нийт 21.5 тэрбум төгрөгийн үнэ цэнэтэй болох нь харагдаж байна.





Үнэт цаасны танилцуулга



Дэлгэрэнгүйг хавсралт дахь Хөрөнгийн үнэлгээний тайлангаас харна уу.

1.5 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, шинжилгээ

Орлого үр дүнгийн тайлан

Үзүүлэлтүүд мян.төг	2013	2014	2015	2016	2017
Борлуулалтын орлого (цэвэр)	4,431,156	10,233,734	6,439,121	10,310,224	13,229,757
Борлуулалтын өртөг	3,671,815	6,335,159	5,309,589	8,396,788	10,754,152
Нийт ашиг	759,341	3,898,575	1,129,532	1,913,435	2,742,982
Түрээсийн орлого	0	0	0	11,164	10,276
Хүүний орлого	0	0	11,556	20,937	-13,072
Ерөнхий ба удирдлагын зардал	511,321	804,503	790,374	1,015,820	1,133,347
Бусад зардал	8,611	7,639	9,243	8,445	105,522
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0	20,809	17,450	4,659	5,247
Татвар төлөхийн өмнөх ашиг	231,176	3,098,702	363,466	925,949	1,537,197
Орлогын татварын зардал	23,118	47,645	35,677	93,237	156,758
Тайлант үеийн цэвэр ашиг	208,058	3,051,057	327,790	832,712	1,380,439

Үнэт цаас гаргагч нь 2017 онд 13.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 1.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд өмнөх тайлант оны түвшнээс борлуулалтын орлого 28 хувь, цэвэр ашиг 66 хувиар өссөн байна. Өнгөрсөн жилүүдэд үнэт цаас гаргагч нь жил бүр өөрийн хүчин чадлаа нэмэгдүүлж тахианы шинэ байр ашиглалтад оруулах, тэжээлийн үйлдвэр барих зэргээр орлогын хэмжээг нэмэгдүүлж ирсэн. 2014 онд өндөгний импорт буурч дотоодын өндөг үйлдвэрлэл нэмэгдсэн нь компанийн орлогыг 2014 онд 10.2 тэрбум, цэвэр ашгийг 3 тэрбум төгрөгт хүрэхэд нөлөөлсөн байна.

2017 оны сүүлийн хагасд компани өндөглөгч шувууны 7-р байрыг ашиглалтад оруулсан бөгөөд 2018 онд өндөглөгч шувууны байр 8-г ашиглалтад оруулснаар борлуулалтын орлогын түвшин болон цэвэр ашгийн түвшин 30-40 хувиар нэмэгдэх боломжтой. Мөн тэжээлийн үйлдвэрт шинэ бүтээгдэхүүнийг хөгжүүлж, зах зээлд түлхүү таниулж ажиллаж байгаа нь цаашдаа компанийг илүү өндөр санхүүгийн үзүүлэлттэй ажиллахад нөлөөлөх юм.

Санхүү байдлын тайлан

Үзүүлэлтүүд мян.төг	2013	2014	2015	2016	2017
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,051,602	2,633,038	433,413	180,925	1,583,994
Дансны авлага	209,440	398,329	636,230	692,641	980,306
Татвар, НДШ – ийн авлага	25,792	17,760	0	0	0
Бусад авлага	0	0	0	0	1,080
Бараа материал	548,599	70,004	1,035,294	983,471	1,243,310
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	922,723	4,544,438	464,403	1,047,851	1,231,060
Эргэлтийн хөрөнгийн дүн	3,758,156	7,663,569	2,569,340	2,904,888	5,039,749
Үндсэн хөрөнгө	1,910,911	2,723,584	8,070,385	7,804,669	8,806,622
Биет бус хөрөнгө	0	0	20,874	13,303	15,524
Биологийн хөрөнгө	809,466	562,425	430,409	699,702	442,955
Урт хугацаат хөрөнгө оруулалт	0	0	0	0	0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,720,378	3,286,009	8,521,668	8,517,674	9,265,101
Нийт хөрөнгийн дүн	6,478,533	10,949,578	11,091,008	11,422,563	14,304,851
Дансны өглөг	200,148	11,550	17,226	205,279	73,081
Цалингийн өглөг	0	0	0	45,775	0
Татварын өр	14,299	23,488	44,803	227,200	203,787
НДШ - ийн өглөг	969	1,444	2,663	5,064	0
Богино хугацаат зээл	0	0	0	0	675,000
Ногдол ашгийн өглөг	0	0	14,744	37,473	59,934





Үнэт цаасны танилцуулга



Урьдчилж орсон орлого	14	9,885	573	806	0
Бусад богино хугацаат өр төлбөр	850,000	0	1,105,682	734,962	1,069,869
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,065,430	46,368	1,185,691	1,256,559	2,021,737
Урт хугацаат зээл	2,232,125	4,257,125	2,727,125	2,196,735	3,000,000
Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,232,125	4,257,125	2,727,125	2,196,735	3,000,000
Өр төлбөрийн нийт дүн	3,297,555	4,303,493	3,912,816	3,453,294	5,021,737
Өмч	2,627,150	2,627,150	2,847,850	2,847,850	2,847,850
-хувийн	2,627,150	2,627,150	2,847,850	2,847,850	3,000,000
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0	0	0	0	0
Хуримтлагдсан ашиг	553,828	4,018,936	4,330,342	5,121,419	6,283,114
Эздийн өмчийн дүн	3,180,978	6,646,086	7,178,192	7,969,269	9,283,114
Өр төлбөр ба эздийн өмч	6,478,533	10,949,578	11,091,008	11,422,563	14,304,851

Үнэт цаас гаргагч нь 2017 онд нийт 14.3 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй үйл ажиллагаа явуулж байгаагаас 5 тэрбум төгрөг нь өр төлбөр, 9 тэрбум төгрөг нь эздийн өмчөөр бүрдэж байна. Өнгөрсөн хугацаанд нийт хөрөнгөд гарсан хамгийн өндөр үзүүлэлт нь 2013-2014 онд нийт хөрөнгө 6.5-11 тэрбум төгрөг болон нэмэгдсэн бөгөөд энэ нь "Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай" хуулийн дагуу компани өнгөрсөн хугацаанд ил тодоор тайлагнаагүй орлого болон ашгийн хэмжээгээ тайлагнасанатай холбоотойгоор хуримтлагдсан ашиг нэмэгдсэнээр илэрхийлэгдэж байна.

Үнэт цаас гаргагч нь 2014-2017 онуудын хооронд тогтмол ашигтай ажилласан ба жил бүрийн хуримтлагдсан ашгаар эздийн өмчийг 6.6-9.2 тэрбум төгрөгт хүргэн нэмэгдүүлж чаджээ. Мөн 2015 онд Агрофийд үйлдвэрийг ашиглалтад оруулж малын болон шувууны тэжээлийг өөрийн үйлдвэрт үйлдвэрлэж эхэлсэн нь үндсэн хөрөнгийг нэмэгдүүлэхэд нөлөөлжээ.

Мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлтүүд мян.төг	2013	2014	2015	2016	2017
Мөнгөн орлогын дүн	4,909,730	12,534,062	6,933,929	11,540,568	14,372,395
Бараа борлуулсны орлого	4,712,955	10,981,991	6,933,909	11,540,322	14,370,801
Буцаан авсан албан татвар	186,299	0	0	0	694
Бусад мөнгөн орлого	10,476	1,552,071	20	246	900
Мөнгөн зарлагын дүн	5,539,402	12,994,761	8,286,730	10,681,809	13,197,008
Ажиллагчдад төлсөн	235,293	616,575	738,760	940,968	1,254,682
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	93,161	165,094	196,470	262,087	334,585
Бараа материал худалдан авахад төлсөн	4,793,882	11,622,265	6,670,760	8,824,391	10,357,019
Ашиглалтын зардалд төлсөн	45,284	14,424	11,577	18,688	25,407
Түлш шатахуун, тээврийн хөлс, Хүүний төлбөрт төлсөн	132,625	197,680	126,805	70,154	103,344
Татварын байгууллагад төлсөн	42,779	113,151	92,925	11,967	19,016
Даатгалын төлбөрт төлсөн	131,568	193,737	337,200	476,600	999,157
Бусад мөнгөн зарлага	659	965	1,259	1,680	1,716
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	64,152	70,871	110,975	75,274	102,083
Мөнгөн орлогын дүн	-629,672	-460,699	-1,352,800	858,759	1,175,386
Үндсэн хөрөнгө борлуулсны	0	0	5,105	2,256	11,024
Хүлээн авсан хүүний орлого	0	0	4,545	0	0
Мөнгөн зарлагын дүн	0	0	559	2,256	11,024
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	25,830	148,220	16,904	20,807	79,291
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-25,830	-148,220	-11,799	-18,551	-68,267



Үнэт цаасны танилцуулга



Мөнгөн орлогын дүн	2,850,000	2,400,000	1,635,551	2,127,395	4,612,056
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,850,000	2,400,000	1,620,000	2,121,835	4,612,000
Мөнгөн зарлагын дүн	371,173	1,230,455	2,466,391	3,220,091	4,316,107
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	365,718	1,225,000	2,459,937	3,186,191	4,251,308
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	5,455	5,455	6,455	18,370	27,308
Төлсөн ногдол ашиг	0	0	0	14,744	37,473
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,478,827	1,169,546	-830,841	1,092,696	295,949
Валютын ханшийн зөрүү	0	20,809	-4,185	0	0
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,823,325	560,626	-2,195,440	-252,488	1,403,069
МӨНГӨ ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	228,277	2,051,602	2,612,229	433,413	180,925
МӨНГӨ ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	2,051,602	2,612,229	433,413	180,925	1,583,994

Ашигт ажиллагааны харьцаа

	2013	2014	2015	2016	2017
Борлуулалтын өсөлт	29%	131%	-37%	60%	28%
Нийт ашиг	17%	38%	18%	19%	21%
Цэвэр ашиг	5%	30%	5%	8%	10%
Цэвэр ашгийн өсөлт	-12%	1366%	-89%	154%	65.8%

Үнэт цаас гаргагч нь борлуулалтын орлогоо 2016 онд 60 хувь, 2017 онд 28 хувь өссөн байсан төдийгүй 17-21 хувийн нийт ашигтай, 5-10 хувийн цэвэр ашигтай ажиллаж буй нь хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг Монголын хөрөнгийн бирж дээрх компаниудтай харьцуулахад өндөр үзүүлэлт болж байна. Жишээлбэл:

Ахиуц ашиг болон өгөөжийн харьцуулалт

(Сая төгрөгөөр)	Түмэн шувуут	МХБ-н дундаж
Орлого	13,229.8	55,765.7
Цэвэр ашиг	1,380.4	5,428.8
Нийт ашиг=Нийт ашиг/Орлого	18.7%	22.3%
Үйл ажиллагааны ашиг=Үйл ажиллагааны орлого/Орлого	11.6%	5.1%
Цэвэр ахиуц ашиг=Цэвэр ашиг/Орлого	10.4%	5.8%
Хөрөнгө	14,304.9	114,651.0
Хөрөнгийн эргэц=Орлого/Дундаж нийт хөрөнгө	0.5x	0.8x
Хөрөнгийн өгөөж=Цэвэр ахиуц ашиг*Хөрөнгийн эргэц	5%	3%
Эздийн өмч	9,283.1	83,401.3
Хөшүүрэг=Дундаж нийт хөрөнгө/Дундаж эздийн өмч	1.5x	1.8x
Эздийн өмчийн өгөөж=Хөрөнгийн өгөөж*санхүүгийн хөшүүрэг	8%	6.2%

МХБ-н нэгдүгээр самбарын 7 компани болон хоёрдугаар самбарын хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудтай Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг харьцуулахад нийт ашиг болон цэвэр ашгийн хэмжээгээр тэдгээр компаниудаас өндөг дүнтэй ажилладаг нь нотлогдсон. Харьцуулалт хийсэн компаниудад АПУ ХК, Мах Импекс ХК, Сүү ХК, Талх чихэр ХК,



Үнэт цаасны танилцуулга



Монгол шуудан ХК, Говь ХК, Дархан нэхий ХК, Атар өргөө ХК, Дархан хүнс ХК зэрэг компаниуд багтаж байгаа бол Таван толгой ХК болон Мик ХК-ийн санхүүгийн үзүүлэлтийг харьцуулалтад хэтэрхий өндөр нөлөөлөл үзүүлэх, нөгөө талаар үйл ажиллагааны чиглэлийн хувьд өвөрмөц тул оруулаагүй болно.

МХБ дээр үйл ажиллагаа явуулдаг дээрх компаниудын дундаж орлого нь 55.7 тэрбум, дундаж цэвэр ашиг 5.4 тэрбум төгрөг байгаа бол Үнэт цаас гаргагч компанийн орлого 13.2 тэрбум, цэвэр ашиг 1.4 тэрбум байна. Харин цэвэр ашгийн маржин буюу ашгийн нийт орлогод эзлэх хувийг харьцуулбал МХБ-н дундаж 5.8 хувь, Үнэт цаас гаргагч компани 10.4 хувьтай буюу ойролцоогоор 2 дахин илүү ашгийн маржинтай үйл ажиллагаа явуулж байна.

Хөрөнгийн өгөөж буюу цэвэр ахиуц ашгийг хөрөнгийн эргэцтэй харьцуулсан харьцаа нь 5 хувь буюу МХБ-н дундаж болох 3-н хувьтай харьцуулахад даруй 1 дахин өндөр байгаа нь компани хөрөнгөө үр өгөөжтэй ашиглаж байгааг илтгэж байна. Эздийн өмчийн харьцаа нь 6.2 болон 8 хувьтай байгаа нь компани эздийн өмчөө МХБ-н дундажтай харьцуулахад илүү үр өгөөжтэй ашиглаж байгааг харуулж байна.

Дээрх харьцуулалтаас харахад Үнэт цаас гаргагч компани нь МХБ-д бүртгэгдсэнээр нийт зах зээлд ашиг өндөртэй ажилладаг компаниудын тоог нэмээд зогсохгүй, хөрөнгө оруулагчдад тогтмол ногдол ашиг хүртэх боломжийг бий болгох юм.

Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагааны түүхэн харьцаанууд




График 1. Ашигт ажиллагааны харьцаанууд

График 1-т Үнэт цаас гаргагчийн сүүлийн 5-н жилийн нийт ахиуц ашиг, цэвэр ахиуц ашиг болон үйл ажиллагааны ахиуц ашгийг харуулж байна. Дээрх графикаас харахад 2015 оноос хойш компанийн ашгийн хэмжээ жил ирэх тусам нэмэгдсэн байна. Харин 2014 оны дүнтэй харьцуулахад ашгийн хэмжээ бага байгаа нь тухайн жилийн дотоодын өндөг үйлдвэрлэл өсч импорт буурсантай холбогдон компанийн орлогын болон цэвэр ашгийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өгөөж




График 2. Компанийн өгөөжийн тооцоолол



Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн өгөөж буюу цэвэр ашгийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа сүүлийн 3 жил тогтмол өсөлттэй байна. 2017 оны байдлаар хөрөнгийн өгөөж 5.4 хувь, хувьцаат капиталын өгөөж 8.0 хувь болж өнгөрсөн оноос нэмэгдэхэд борлуулалт өмнөх оноос 28 хувь, цэвэр ашгийн хэмжээ 66 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Санхүүгийн хөшүүрэг





График 3 Санхүүгийн хөшүүргийн мэдээлэл

Санхүүгийн хөшүүрэг буюу өр төлбөрийг эздийн өмчид харьцуулсан харьцаа нь 1.5-1.8 харьцаатай байгаа нь компанийн өр төлбөр өөрийн хөрөнгийн харьцаа тогтвортой хэвийн түвшинд хадгалагдаж байгааг илтгэж байна. Уг харьцаа нь 2 бүхлээс бага байх тохиолдолд тухайн компанийг санхүүгийн хувьд боломжит харьцаатай үйл ажиллагаа явуулж байна гэж үздэг бол Үнэт цаас гаргагчийн харьцаа нь 2-с бага байгаа нь компанийн санхүүгийн бүтцийг үйл ажиллагаа явуулахад тогтвортой байгааг харуулж байна.

Санхүүгийн тайлан дахь бүтцийн шинжилгээ

Орлогын тайлан

	2013	2014	2015	2016	2017
Борлуулалтын орлого (цэвэр)	100%	100%	100%	100%	100%
Борлуулалтын өртөг	83%	62%	82%	81%	79%
Нийт ашиг (алдагдал)	17%	38%	18%	19%	21%
Үйл ажиллагааны бусад орлого	0%	0%	0%	0%	0%
Түрээсийн орлого	0%	0%	0%	0%	0%
Хүүний орлого	0%	0%	0%	0%	0%
Бусад орлого	0%	0%	0%	0%	0%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0%	0%	0%	0%	0%
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	0%	0%	1%	0%	0%
Нийт үйл ажиллагааны бусад (цэвэр) орлого	0%	0%	0%	0%	0%
Үйл ажиллагааны зардал	0%	0%	0%	0%	0%
Борлуулалт, маркетингийн зардал	0%	0%	0%	0%	0%
Ерөнхий ба удирдлагын зардал	12%	8%	12%	10%	10%
Бусад зардал	0%	0%	0%	0%	0%
Нийт үйл ажиллагааны зардал	12%	8%	12%	10%	10%
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	5%	30%	6%	9%	11%
Орлогын татварын зардал	1%	0%	1%	1%	1%
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	5%	30%	5%	8%	10%







Үнэт цаасны танилцуулга



Үнэт цаас гаргагчийн нийт борлуулалтын 79 хувийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 10 хувийг үйл ажиллагааны зардал эзэлж цэвэр ашиг 10 хувьтай байна. Цэвэр ашгийн хэмжээ 10 хувь байгаа нь цаашид компанийн хувь эзэмшигчдэд өгөөж хүртэх боломж өндөр байгааг илтгэж байна. Ялангуяа үнэт цаас гаргагчийн авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажилд борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардлыг бууруулах арга хэмжээнүүд тусгагдсан, цаашлаад шинээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд ашигт ажиллагааны хувь өндөртэй махны тахиа, шинэ төрлийн тэжээлүүдийг бий болгох нь ашигт ажиллагааны хувийг нэмэгдүүлэхээр байна.

Санхүү байдлын тайлан

	2013	2014	2015	2016	2017
Хөрөнгө					
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	32%	24%	4%	2%	10%
Дансны авлага	3%	4%	6%	6%	6%
Татвар, НДШ-ийн авлага	0%	0%	0%	0%	0%
Бусад авлага	0%	0%	0%	0%	0%
Бараа материал	8%	1%	9%	9%	8%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	14%	42%	4%	9%	8%
Эргэлтийн хөрөнгийн дүн	58%	70%	23%	25%	31%
Үндсэн хөрөнгө	29%	25%	73%	68%	61%
Биет бус хөрөнгө	0%	0%	0%	0%	0%
Биологийн хөрөнгө	12%	5%	4%	6%	3%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	0%	0%	0%	0%	5%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	42%	30%	77%	75%	69%
Нийт хөрөнгийн дүн	100%	100%	100%	100%	100%
Өр төлбөр	0%	0%	0%	0%	0%
Дансны өглөг	3%	0%	0%	2%	0%
Цалингийн өглөг	0%	0%	0%	0%	0%
Татварын өр	0%	0%	0%	2%	1%
НДШ - ийн өглөг	0%	0%	0%	0%	0%
Богино хугацаат зээл	0%	0%	0%	0%	4%
Ногдол ашгийн өглөг	0%	0%	0%	0%	0%
Урьдчилж орсон орлого	0%	0%	0%	0%	0%
Бусад богино хугацаат өр төлбөр	13%	0%	10%	6%	10%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	16%	0%	11%	11%	16%
Урт хугацаат зээл	34%	39%	25%	19%	19%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	34%	39%	25%	19%	20%
Нийт өр төлбөрийн дүн	51%	39%	35%	30%	36%
Өөрийн хөрөнгө	0%	0%	0%	0%	0%
Өмч	41%	24%	26%	25%	18%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0%	0%	0%	0%	5%
Хуримтлагдсан ашиг	9%	37%	39%	45%	40%
Нийт өөрийн хөрөнгийн дүн	49%	61%	65%	70%	64%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө	100%	100%	100%	100%	100%



Компанийн нийт хөрөнгийн 31 хувийг эргэлтийн хөрөнгө, 69 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна. Өндөгний аж ахуй болон тэжээлийн үйлдвэр нь капитал ихээр шаарддаг бизнес тул эргэлтийн бус хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хэмжээ нь зохистой түвшинд байгааг илтгэж байна. Харин нийт хөрөнгийн 64 хувийг өөрийн хөрөнгө 36 хувийг өр төлбөр бүрдүүлж байгаа бол өр төлбөр дунд урт хугацаат Хас банкны хөнгөлөлттэй зээл хамгийн өндөр хувь буюу 20 хувийг эзэлж байна.

Үнэт цаас гаргагчийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг болон ерөнхий ба удирдлагын зардал жил ирэх тусам буурч, нийт орлогод эзлэх хэмжээ багасч буй нь компани өөрийн зардалдаа илүү хянамгай хандаж, ашгийг өндөр байлгах түвшинд компанийг удирдаж байгааг илтгэж байна. Компанийн менежмент нь жил бүр шинэ тоног төхөөрөмж, шинэ үйлдвэрлэлийн төрлийг нэмэгдүүлэх философитой бөгөөд тэр ч утгаараа үр ашиггүй зардлаас татгалзаж үйл ажиллагаа явуулж байгааг доорх график үзүүлж байна.

Борлуулсан бүтээгдэхүүн болон ерөнхий ба удирдлагын зардлын график




График 4 ББӨ ба ерөнхий ба удирдлагын зардал

СОНИРХОЛТОЙ БАРИМТ- 3

Сувиллын өндөг гэж ямар өндгийг хэлдэг вэ?

Тахианаас гараад 7 хүртэл хонож байгаа өндгийг сувиллын өндөг гэж нэрлэнэ. Энэ хугацаанд өндгөнд агуулагдах шим тэжээл хамгийн өндөр байдаг.

Аудитын компанийн дүгнэлт

Аудитын “Улаанбаатар аудит корпораци” ХХК нь 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн Санхүүгийн тайлан (цаашид “Санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийсэн байна. Аудитын дүгнэлтээр, “Түмэн шувуут” ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна гэж үзжээ.

Уг дүгнэлтийг гаргахдаа “Улаанбаатар аудит корпораци” ХХК нь дараах үндэслэлийг баримталсан байна.

“Улаанбаатар аудит корпораци” ХХК нь энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. “Улаанбаатар аудит корпораци” ХХК нь Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай



Үнэт цаасны танилцуулга



холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

(Дэлгэрэнгүй мэдээллийг Аудитын тайлангаас харна уу)

1.6 Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай;

Үнэт цаас гаргагч нь 2016-2018 оны хооронд хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн нийт 17 гэрээ байгуулсан байна. Эдгээр гэрээнүүдээс хамгийн өндөр дүн эзэлж буй нь 4 сая ам.долларын тэжээлийн түүхий эд худалдан авах гэрээ байгаа бол хамгийн бага дүнтэй гэрээ нь 80.0 ам.долларын үнэ бүхий тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүн авах гэрээ байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг бичиж байх үед гэрээнүүдийн хэрэгжилт дуусаагүй, хэвийн үргэлжилж байна.

СОНИРХОЛТОЙ БАРИМТ- 4
Яагаад өндөг том жижиг байдаг вэ?

Гарах өндөгний хэмжээ нь тахианы насжилттай шууд холбоотой байдаг. Залуу тахианаас жижиг өндөг. Нас бие гүйцсэн тахианаас том өндөг гарна.

1.7 Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдийн тухай;

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30-д: "холбогдох этгээд" гэж дараах этгээдийг ойлгоно: ...4.1.30-д компани бол түүний толгой, хараат, охин, зэргэлдээ компани" гэж заасан. Үнэт цаас гаргагч нэг охин компанитай. Өөрөөр хэлбэл Түмэн шувуут нь Монголын хөрөнгийн биржийн хувьцааны III ангилалд бүртгэлтэй "Усжуулах" ХК-ны нийт энгийн хувьцааны 80.6 хувийг 3 удаагийн хэлцлээр 2017 онд шилжүүлэн авч, эзэмшиж байгааг ҮЦТХТ бүртгэсэн байна. (Хавсралт 6.12)


"Усжуулах" ХК нь Увс аймгийн Баруунтурууны сангийн аж ахуйн өмчийг хувьчлахад төрийн өмчит хувьцаат компаний хэлбэрээр 1991 онд анх байгуулагдаж, 1998 онд өөрчлөгдөн зохион байгуулагдсан. Компанийн үндсэн үйл ажиллагаа нь газар тариалан, мал аж ахуй, үйлдвэрлэл, худалдаа. Байгуулагдсанаасаа хойш эдүгээ хүртэл жил бүр 324-540 га-д усалгаатайгаар үр тариа, малын тэжээл тарьж байна. 2004 онд 108 га-д царгас тариалж 8 жил ургац хураан жилд дунджаар 13,000 боодол (325 тн) хадлан бэлтгэж байсан. Сүүлийн жилүүдэд зөвхөн улаан буудай тариалж, га тутмаас 12-17 ц ургац хурааж, түүгээрээ өөрийн гурилын үйлдвэрт чанар сайтай "Хан хөхий" гурил үйлдвэрлэж Увс, Завхан, Ховд, Баян-өлгий аймгуудад нийлүүлж байна.


СОНИРХОЛТОЙ БАРИМТ- 5
Хос шартай ихэр өндөг яагаад гардаг вэ?

Тахиа өдөрт нэг өндөглөх боловч зарим тахиа хоёр өдөрт нэг өндөглөдөг. Энэ тохиолдолд хос шартай ихэр өндөг гарна. Энэ нь байгалийн жам ёсны үзэгдэл бөгөөд 200 хоногоос дээш насжилттай тахианд ихэвчлэн тохиолдоно.

Компани жил дараалан аймаг, сумандаа шилдэг аж ахуйн нэгжээр шалгарсан. Газар тариалан, мал аж ахуй эрхлэх туршлагатай, мэргэшсэн ажилтнуудтай.

Баруунтурууны услалтын систем нь "Усжуулах" ХК-ны өмч ба энэхүү услалтын систем нь техник эдийн засгийн үзүүлэлтээрээ 4,000 га тариалангийн талбайг услах хүчин чадалтай ч





Үнэт цаасны танилцуулга




2,000 га талбайг услах хэсэг нь угсрагдаж, ашиглалтанд орсон байгаа бол нөгөө хэсгийн тоног төхөөрөмж нь өмч хувьчлалын явцад үрэгдсэн байна. Усжуулах ХК Баруунтуруун сумын ЗДТГ-тай гэрээ байгуулж, 1,575 га тариалангийн талбайг эзэмших 40 жилийн хугацаатай эрх 2008 онд авсан. Энэхүү гэрээнд заагдсанаар тус бүрдээ 54 га, 29 талбай тус компанийн эзэмшилд байдаг.

Түмэн шувуут компани нь Увс аймгийн Баруун туруун сум дахь усалгаатай газар тариалан бүхий "Усжуулах" ХК компанийн нийт энгийн хувьцааны 80.6 хувийг худалдан авахдаа дараах алсын хараа, бизнесийн зорилгод тулгуурласан байна. Үүнд:

- ЗХУ-ын тусламжаар баригдсан Усжуулах компанийн 15 сая шоо мерт багтаамжтай усан сангийн толгойн барилга байгууламж, өөрийн даралтаар ус түгээх 40 гаруй км урт цэвэр усны далд сүлжээг ашиглан цаашид эрсдэлгүй газар тариалан эрхлэх. Жич: Тус компанийн усан сангийн усны нөөцийн эх үүсвэр нь 100 гаруй км урт үргэлжилсэн Ханхөхий нурууны уулсаас эх авдаг, өвөл хаврын халиа, үерийг цуглуулж хуримтлуулах зарчимаар байгуулагдсан дахин давтагдахгүй байгалийн өвөрмөц тогтоц бүхий байгууламж юм.
- Царгас тариалж уургийн өндөр агууламжтай тэжээлээр өсөн нэмэгдэж байгаа малын тэжээлийн хэрэгцээг хангаж, гадаадаас өндөр үнээр авдаг эрдэнэ шиш, шар буурцаг зэрэг түүхий эдийг орлуулах,
- Улаан буудай тариалалтыг нэмэгдүүлж, одоо ашиглагдаж байгаа гурилын үйлдвэрийг жилийн турш тогтвортой ажиллуулж баруун бүсийн хүн амыг улаан буудайн гурилаар хангах. Увс, Ховд, Баян-Өлгий аймаг 1000-1700 км алс Улаанбаатар хотоос гурил тээвэрлэдгээс үнэ өндөг байгааг орон нутагт үйлдвэрлэснээр 10-15 хувиар бууруулах.
- Ногоон тэжээл тариалах үйл ажиллагааг нэмэгдүүлж, тэжээлийн үйлдвэр байгуулах, баруун бүсийн малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, баруун аймгийн төвүүдэд сүүний чиглэлийн ферм эрхлэж сүүний хангамжийг нэмэгдүүлэхэд гол бэрхшээл болж байгаа тэжээлийн хангамжийг шийдвэрлэх.
- 2021 оноос эхлэн мал эмнэлэг, хорио цээрийн олон улсын шаардлага хангасан нэг ээлжиндээ 60 мянган хонь бордох, мах боловсруулах цогцолбор байгуулж дундад ази, Хятадын зах зээлд нийлүүлэх

Усжуулах компанийн үйл ажиллагааг дээрхи зорилгоор хөгжүүлэх нь Түмэн шувуут компанийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж Монгол улсын хөдөө аж ахуйн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулна гэж тооцсон байна.



Үнэт цаасны танилцуулга



Зураг 3 Усжуулах ХК-ны талбай



Зураг 4 Усжуулах ХК-ны ллан зураг



Зураг 5 Усжуулах ХК-ны тоног талхвэрэмж



Зураг 6 Усжуулах ХК-ны тоног талхвэрэмж



Зураг 7 Хан Хөхийн уулс



Зураг 8 Нуурын толгойн байгууламж



Зураг 9 Нуурын цуглуулах хэсэг



Зураг 10 Хиймэл нуур

1.8 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, үйл ажиллагааны онцлог зах зээлд эзэлж буй байр суурь, өрсөлдөгч байгууллагуудын тухай мэдээлэл;

1.8.1 Үйлдвэрийн хүчин чадал


Салбар	Үзүүлэлт
Өндөглөгч тахиа	250,000 тахиа
Дэгдээхэй бойжуулагч нэг ээлжийн хүчин чадал	80,000 толгой
Инкубаторын цехийн нэгж ээлжийн хүчин чадал	153,600 өндөг
Нийт ажиллагсад	167 ажилтан


Хүснэгт: 4 Үйлдвэрийн хүчин чадал

Үнэт цаас гаргагч нь жил ирэх тусам үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж ирсэн бөгөөд 2013 онд 35.6 сая өндөг үйлдвэрлэдэг байсан бол 2017 онд уг тоо нь даруй 44 хувиар нэмэгдэн 51.3 сая өндөгт хүрээд байна. Улмаар компани өндөглөгч тахианы байрны тоогоо нэмснээр зах зээлд эзлэх хувиа өсгөх, борлуулалтын орлогоо нэмэгдүүлэх бүрэн боломжтой юм.

СОНИРХОЛТОЙ БАРИМТ- 6 Бор өндөг, Цагаан өндөг ялгаатай юу?

Ялгаагүй. Цагаан тахианаас цагаан өндөг. Бор тахианаас бор өндөг гарна. Бүр нарийвчилбал тахианы чих орчмын өнгө ямар байхаас өндөгний өнгө шалтгаалдаг. Өндөгний чанар нь бор цагаанаас бус тахианы идэж байгаа тэжээлээс шууд хамаардаг.





Үнэт цаасны танилцуулга



График 5 Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний статистик

1.8.2 Өндөгний борлуулалт

Үнэт цаас гаргагч нь 2017 онд нийт 13.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийснээс нийт өндөгний борлуулалт 90 орчим хувийг эзэлж байна. Өндөгний борлуулалтыг борлуулалтын сувгаар нь ангилбал 33 хувийг нь сүлжээ дэлгүүр, 24 хувийг нь жижиг дэлгүүрүүд эзэлж байна.

Компани өндөгөө нас, жин, баяжуулалт, шинж чанараас нь хамааруулан 6, 10, 12, 30-аар нь савлан хэрэглэгчдэд худалдан борлуулдаг. Нийт борлуулах өндөгний дийлэнх хэсгийг нь задгайгаар буюу 30 ширхэгээр нь картон цаасан үүрэнд хийж борлуулдаг бөгөөд энэ нь өндөгийг олноор хэрэглэдэг ресторан, зочид буудал, цайны газар зэрэг хэрэглэгчдэд хүрдэг.





График 6 Борлуулсан бүтээгдэхүүний статистик

Нийт борлуулагдсан өндөгүүдийг савлагааны бүтцээр нь ангилвал дийлэнх хэсэг буюу 75 хувийг задгай 30 ширхэгээр савласан байдлаар, 25 хувийг 6, 10, 12-той савласан байдалтайгаар дэлгүүрүүдээр худалдан борлуулж байна.

Жижиглэнгээр савлан борлуулсан өндөгнүүд нь супермаркетуудаар дамжин эцсийн хэрэглэгчдэд хүрдэг бөгөөд хэрэглэгчдэд сувиллын буюу шинэ өндөг, залуу тахианы буюу уураг ихт өндөг, АА ангилал буюу нас гүйцсэн тахианы өндөг, селинээр баяжуулсан бүтээгдэхүүнүүдийг өдөр бүр хэрэглэх боломжоор хангаж байдаг.





Үнэт цаасны танилцуулга



№	Өндөгний төрөл	Онцлог давуу тал	Жин	Савлагаа
1	Сувиллын өндөг	MNS 92 – 77 стандартад зааснаар тахиа өндөглөснөөс хойш 7 хоногийн дотор хүнсэнд хэрэглэж буй өндгийг "Сувиллын өндөг" гэнэ. Сувиллын шинэ өндөг нь хүний биенд 96% - ийн шингэцтэй байдаг.	55-65 гр	
2	Баяжуулсан өндөг	Хүн болон амьд организмын амьдралд чухал үүрэгтэй 19 нэн шаардлагатай элементүүдийн нэг болог селенээр баяжуулсан. Селен нь хорт хавдраар өвчлөх эрсдлийг бууруулж, хүний биеийн дархлааг дэмждэг. Мөн жирэмсэн, хөхүүл эх болон нярайн төрөлхийн эмгэгээс урьдчилан сэргийлэх гэх мэт олон ашиг тустай.	55-65 гр	
3	Залуу тахианы өндөг	Дөнгөж өндөглөж эхэлж буй залуу тахианаас гарч байгаа жин багатай боловч уураг амин дэмийн агууламжаар баялаг өндөг.	45-50 гр	
4	Өглөөний өндөг	Стандарт өндөгнөөс жингийн хувьд илүү ихэвчлэн 2 шар уурагтай байдаг. Бусад өндөгнөөс уургийн агууламж өндөр агуулагддаг.	65-70 гр	



1.8.3 Өндөг үйлдвэрлэх үйл явц

Үнэт цаас гаргагч нь өөрийн эзэмшлийн Хан Уул дүүргийн, 13-р хороо буюу Шувуунфабрик дахь 144,125 м² талбайд нийт 250,000 ширхэг өндөглөгч тахиаг 7-н өндөглөгч шувууны байр, 2 дэгдээхэйний байр, 1 инкубатор байртайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Өндөглөгч тахианы долоон байр нь 26,600-40,000 тахианы багтаамжтай, Guangzhou Guangxing Poultry брендийн бүрэн автомат тэжээлийн болон өндөг хураах төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Дэгдээхэйний 2 байр мөн Guangzhou Guangxing Poultry брендийн орчин үеийн стандартад нийцсэн тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан байгууламж юм. Түмэн шувуут компанийн үйлдвэрлэл, борлуулалт тогтвортой нэмэгдэж байгаагийн нэг гол хүчин зүйл нь техник, технологийн шинэчлэлийг цаг тухайд нь хийж өндөглөгч шувууны арчилгаа малалгаанд ОХУ, БНХАУ-ын сүүлийн үеийн шинэ технологи, тэргүүний туршлагыг нэвтрүүлж байдагтай холбоотой.


Дээр дурдсан тоног төхөөрөмжүүдийг нийлүүлэгч Guangzhou Guangxing Poultry компани нь БНХАУ-ын Гуандонг мужид 2000 онд байгуулагдсан, тахиа үржүүлгийн олон төрлийн автомат тоног төхөөрөмж үйлдвэрлэж, Дундад ази, Африк, Зүүн өмнөд азийн орнуудад жилд дунджаар 50 сая ам.долларын борлуулалт хийдэг БНХАУ-ын томоохон аж ахуйн нэгжүүдийн нэг юм.

Үнэт цаас гаргагч нь Hy-line brown үүлдрийн өндөглөгч тахианы өндөгийн БНХАУ-с, Leghorn үүлдрийн өндөгийг ОХУ-аас импортоор худалдан авдаг бөгөөд тус өндөгнүүдийг инкубатор






Үнэт цаасны танилцуулга




төвдөө 21 хоног дарсны эцэст дэгдээхэй болгон авдаг. Улмаар гарсан эм дэгдээхэйнүүдийг 100-150 хоног тусгай зориулалтын тахианы тэжээлээр тэжээн, эрүүл мэндийн үзлэгт хамруулсны эцэст өндөглөгч тахианы байранд оруулдаг бөгөөд уг байранд 640-700 хоног хүртлээ тухайн тахианууд нь өндөг гаргадаг. Харин өндөглөх давтамж нь буурч хөгширсөн тахиаг Үнэт цаас гаргагчийн махны үйлдвэрт нядлагаанд оруулан, худалдан борлуулдаг.



Зураг 11 Өндөг бий болох дараалал

Тахиа нь 5-н сартай буюу ойролцоогоор 150 хоногтойдоо өндөг гаргадаг бөгөөд нас залуу ид үе болох 8-16 сар хүртлээ хамгийн өндөг өгөөж буюу сард 26-30 өндөг гаргадаг онцлогтой амьтан юм.



Зураг 12 Өндөглөгч тахианы үр ашгийн муруй


2017 оны байдлаар Үнэт цаас гаргагч нь нийт 50 сая ширхэг өндөгийг зах зээлд худалдан борлуулсан бөгөөд уг тоо жил ирэх тусам өндөгний байр нэмэгдэн хүчин чадал өсч буйтай холбоотойгоор нэмэгдэж байна. Компани 2017 оны дунд үед өндөглөгч тахианы 7-р байрыг ашиглалтад оруулсан бөгөөд уг тахианы байранд буй тахиануудын өндөглөх оргил үе нь 2018 онд тохиож байна. Тэр ч утгаараа компанийн орлогын хэмжээ ирэх онуудад нэмэгдэх юм.

1.8.4 Эрүүл мэндийн хяналт шалгалт

Үнэт цаас гаргагч нь дотоодын өөрийн үйлдвэрийн дэргэдэх итгэмлэгдсэн нян судлалын лабораторидао микробиологи, орчины нян судлал, ус гэсэн гурван чиглэлээр сорилт шинжилгээг олон улсын ISO болон үндэсний MNS стандарт арга зүйн дагуу хийж гүйцэтгэдэг. Үүнд:

- Өндөг
- Шувууны мах, дайвар түүхий эд бүтээгдэхүүн
- Шувууны тэжээл, тэжээлийн түүхий эд
- Шувууны байр болон бусад цех тасгийн агаар
- Эд зүйлсийн гадаргуугын арчдас
- Төвлөрсөн хангамжийн ус гэсэн хэсгүүд багтдаг.





Үнэт-цаасны танилцуулга



Жишээ нь: Өндөгөнд нийт 6-н төрлийн түгээмэл нянгийн шинжилгээг хийж, баталгаажуулсны дараагаар зах зээлд нийлүүлдэг. Үүнд: Нянгийн ерөнхий тоо, Salmonella, E.Coli, Staphilliosoccus, Pseudomonas болон хөгц мөөгөнгөцөр гэсэн сорилго тавьж шинжилгээ хийдэг. Өндөгний хамгийн гол анхаарч хянаж байх нянгууд нь Salmonella, E.Coli, Staphilliosoccus юм.

Salmonella гэдэг нь хэсэг бүлэг бактериудын нийлмэл хэлбэр бөгөөд АНУ-д хоолны хордлогын гол шалтгаан болдог. Salmonella нь ихэвчлэн түүхий шувууны мах, үхрийн мах, зарим тохиолдолд угаагүй хүнсний ногоонд агуулагдаж байдаг.

Salmonella-р халдварласан хүнд халуурах, дотор муухайрч бөөлжих, суулгах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Уг шинж тэмдэгүүд нь 4-7 хоног үргэжилдэг бөгөөд ихэнх тохиолдолд уг бактериар халдварласан хүн ямар нэгэн эмчилгээгүйгээр зүгээр болдог. Хариг уг бактериуд нь хүүхэд эсвэл хөгшидөд шинж тэмдэг нь хурцаар илэрдэг бөгөөд хэрвээ цусанд уг бактер нь орвол амь насанд хүртэл хүрэх аюулыг дагуулж байдаг. Салмолниаг антибиотикийн аргаар эмчлэх боломжтой.

E.Coli нь хүний бие дотор амьдардаг бактериудын нэршил юм. Ихэнх E.Coli бактер нь ямар нэг хор нөлөөгүй боловч зарим тохиолдолд бөөжүүлэх, суулгах зэрэг шинж тэмдэгийг дагуулж байдаг. Хамгийн ноцтой тохиолдолд хэрвээ E.Coli бактер цусаар дамжин халдварлавал бөөрний дутагдлаас амь насанд хүртэл хүрэх боломжтой байдаг.

Ихэнх тохиолдолд хүнсний бүтээгдэхүүнээр дамжин E.Coli нь халдварладаг бөгөөд хоолны хордлогын шинж тэмдгийг хүнд үзүүлдэг. Тиймээс хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэхдээ бүрэн болгох, сайтар угаах нь дээрх төрлийн бактериудаас хамгаалах гол арга зам юм. E.Coli нь өндөгний шохойн хальсанд байх тул түүхий өндөгний хальсыг амандаа хийх, өндөгийг амандаа хүргэх нь уг нян халдварлах нөхцлийг бий болгодог.

Эх сурвалж: АНУ-н Эрүүл мэндийн яам, <https://www.hhs.gov/answers/public-health-and-safety/what-is-the-difference-between-salmonella-and-e-coli/index.html>


Үйлдвэрт гадны биетийг оруулахгүй, хорио цээрийн дэглэмийг өндөр түвшин сахиж, ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтсон графикайн дагуу хийж, дагуу хяналт шалгалтыг Дотоод хяналтын журмын дагуу хэрэгжүүлснээр нянгийн тархалтаас сэргийлж ажилладаг. Үнэт цаас гаргагч нь дээрх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэн шинжилгээг графикайн дагуу буюу долоо хоногт 1-2 удаа 24-72 цагийн давтамжтайгаар гүйцэтгэж, хэрэглэгчдийг эрүүл, аюулгүй хүнсээр хангах нөхцөл боломжийг бүрдүүлдэг.

1.8.5 Малын тэжээлийн зах зээл, эрэлт хэрэгцээ, Аргофийд тэжээлийн үйлдвэр

Дэлхийн цаг агаарын өөрчлөлт, ган, зудын давтамж ихсэх болсон нь малын тэжээлийн эрэлтийг улам бүр нэмэгдүүлж байна. 2017 оны байдлаар улсын хэмжээнд бэлтгэх өвс тэжээлийн дөнгөж 56 хувийг бэлтгэжээ. Зөвхөн Улаанбаатар хот орчимд сүүний үхрийн хүчит тэжээлийн 1 жилийн хэрэгцээ 50 гаруй мянган тн байгаагаас одоогоор дөнгөж 30 хувийг хангаж байгааг ХХААЯ-ны албан ёсны сайт хуудсанд тэмдэглэсэн байна.

Малын тэжээлийн хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа энэ үед үнэт цаас гаргагч нь 2015 онд хоногт 100 тонн тахианы болон малын тэжээл үйлдвэрлэх хүчин чадал бүхий Агро Фийд (Agro Feed) үйлдвэрийг Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны Рашаантын өртөө дахь өөрийн эзэмшлийн 150,000 м2 талбайд байгуулсан.

Аргофийд тэжээлийн үйлдвэр байгуулагдсанаар тахианы тэжээлийн импорт сүүлийн 3 жилд 60 хувь хүртэл буурч эх орны үйлдвэрийн малын төрөл бүрийн тэжээл зах зээлд нийлүүлж, гарал үүсэл, чанарын баталгааг итгэмжлэгдсэн лабораторт хянан баталгаажуулдаг болсон байна.



Үнэт цаасны танилцуулга



Монгол улс 2010-2014 онуудад жил бүр 15-20 мянган тн тахианы тэжээл импортолж 10 гаруй сая ам.доллар зарцуулдаг байсан бол Аргофийд тэжээлийн үйлдвэр ашиглалтанд орсноор жил бүр 7-9 мянган тн өндөглөгч тахианы тэжээл үйлдвэрлэж импортын хэмжээг 50 хүртэл хувиар бууруулж эх орондоо үйлдвэрлэж байна.

Үнэт цаас гаргагч компани цаашид өндөглөгч шувууны тоо толгойг нэмэгдүүлснээр өндөглөгч тахианы тэжээл үйлдвэрлэл 15-25 хувиар өсөж үйлдвэрлэлийн үр өгөөж нэмэгдэнэ гэж тооцож байна.

Аргофийд тэжээлийн үйлдвэрийн хурдан морины "ХУРД" тэжээл анх 2017 онд худалдаанд гарч тухайн жилдээ 152,369,000 төгрөгийн борлуулалттай байсан бол 2018 оны эхний 5 сард борлуулалт 15 хувиар нэмэгдсэн байна.

Саалийн үнээний "СҮҮТ" тэжээл энергийн хангамж, уураг, амин дэм, эрдэс бодисоор баланслагдсан цаашид хот орчмын сүүний үхрийн тэжээлийн зах зээлийн 10 хүртэл хувийг эзлэхээр төлөвлөж байна.

Аргофийд тэжээлийн үйлдвэрээс 2018 оны нэгдүгээр сард шинээр худалдаанд гаргасан бог малыг "БОНДГОР" бүрэн найрлагат хүчит тэжээлийг өвөл хаврын улиралд нэг хонин толгойд бүтэн өдрийн туршид 250 гр өгөхөд тарга хүчээ 60-70 хоног тогтвортой барьж онд бүрэн ордог болох нь нэгэнт тогтоогдсон эдийн засгийн хувьд хамгийн хэмнэлттэй үр ашигтай тэжээл болсон байна. БОНДГОР тэжээлийн жорын агуулга зөвхөн тус компанийн оюуны өмч болно. Бондгор тэжээлийн зах зээлд эзлэх хувь хэмжээ 2019 оноос эхлэн эрчимтэй нэмэгдэж, цаашдаа 50 мянган тн-д хүрнэ гэж тооцож байна. Түүхий эдийн хангамжийг нэмэгдүүлснээр БОНДГОР тэжээл үйлдвэрлэх үйлдвэрийн салбарыг 2021 оноос эхлэн бүс нутгуудад байгуулахаар төлөвлөж байна.

Адууны "ШИНГҮҮРТЭЙ ОВЪЁОС", "АМАР" зэрэг тэжээл нь хурдан морь сонирхогчдын хэрэглэж дадсан танил бүтээгдэхүүн болоод байна. Эдгээр тэжээл нь 21 аймаг, нийслэлд борлуулах сүлжээтэй болсон байна. Тэжээлийн түүхий эд дахь хог хольц, чулууг үйлдвэрийн аргаар цэвэрлэж, шингэцийг сайжруулах зорилгоор тодорхой хэмжээтэй няцалж буталсан, эрдэс бодисоор баяжуулсан байдгаараа Шингүүртэй овъёос, Амар тэжээлүүд хэрэглэгчдийн таашаалд нийцэж байна.

Аргофийд тэжээлийн үйлдвэр нь тэжээлийн нэмэлт бүтээгдхүүн, амин дэм, микро элементийн үйлдвэрлэлтээр дэлхийд тэргүүлэгч Каргилл компанийн Провими брендийн бүтээгдэхүүнийг авч тэжээлийн чанарыг сайжруулж байна.

Провими бренд нь анх 1927 онд Нидерланд улсад үүсгэн байгуулагдсан бүх төрлийн малын тэжээлийг үйлдвэрлэгч дэлхийн хамгийн том брендүүдийн нэг юм. Дэлхий даяар 16,000 гаруй ажилчидтай уг бренд компани нь 2011 онд АНУ-н хөдөө аж ахуйн тэргүүлэгч Каргилл компанийн нэг хэсэг болсон юм. Провими бренд хөдөө аж ахуйн салбарт хэрэглэгчдийн хүсэл сонирхолд нийцсэн бүх төрлийн тэжээлийг үйлдвэрлэх чадвар бүхий шинжлэх ухаан, судалгаа шинжилгээний нэгэн тэргүүлэгч байгууллага юм.



Мөн бүх төрлийн малд зориулсан "Тарга", саалийн үнээний "Сүүт", хурдан морины "Хурд", адууны "Амар", "Шингүүртэй овъёос", мал бордлогооны "Бондгор" зэрэг шинэ нэр төрлийн, төгс чанарын тэжээл үйлдвэрлэж зах зээлд 2017 оны сүүл 2018 оны эхээр нийлүүлж эхлээд буй нь 4-н улирлын шинж чанартай, фермийн мал үржүүлэг багатай Монгол орны онцлогт таарсан бүтээгдэхүүн болж чадсан юм.



Үнэт цаасны танилцуулга



Зураг 13 Агрофидийн үйлдвэрийн бүтээгдэхүүнүүд

Тэжээлийн үйлдвэрийн хүчин чадлыг цаашид өргөжүүлж, нийт орлогод эзлэх хувийг нэмэгдүүлж буй нь компанийн орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх, нэг төрлийн бизнесээс хамаарсан байдлыг бууруулахад чухал ач холбогдол өгөх юм. Ялангуяа малын өндөр чанар бүхий тэжээл нь Монгол улсын хувьд нэн шаардлагатай бүтээгдэхүүн тул борлуулалтын орлогод эзлэх хувь нэмэгдсэнээр өндөгний үйлдвэрээс хамаарах хараат байдлыг бууруулж, эрсдэлийг бууруулах өндөр ач холбогдолтой.

СОНИРХОЛТОЙ БАРИМТ- 7
Өндгөнд холестерин байдаг уу?
Өндгөнд ханасан холестерин байдаг. Ханаагүй холестерин жин нэмж, судсанд өөх тос хуримтлагдах эрсдэл үүсгэдэг бол ханасан холестерин үүний эсрэг үйлчилгээ үзүүлдэг.

2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛ

Үнэт цаас гаргагч компани нь Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс хөрөнгө татах, улмаар уг татан төвлөрүүлсэн хөрөнгөөр тодорхой төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Төсөл хөтөлбөр амжилттай хэрэгжихэд тухайн компанийн удирдлага менежментээс гадна макро эдийн засгийн нөлөөлөх хүчин зүйлс чухал байдаг. Тиймээс макро эдийн засгийн төлөв байдлыг зөвөөр үнэлж, цаашид хэрэгжүүлэх төсөл хөтөлбөртөө удирдлага болгон, эрсдлийг бууруулах төлөвлөгөөтэй байх нь цаашид компанийн үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөх юм.

2.1 Монгол улсын эдийн засгийн төлөв байдал

Монгол Улсын эдийн засгийн өсөлт, бууралт нь экспортын гол бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, Монгол улсад хэрэгжүүлж буй өндөр дүнтэй төсөл хөтөлбөрийн хэмжээнээс шууд хамаарч байна.

Тэр ч утгаараа Оюу Толгой төслийн бүтээн байгуулалтын ажил эхэлсэн 2009-2012 онуудад Монгол улсын эдийн засаг хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн ба 2012 онд 17.5 хувь хүрч өссөн нь уг төслийн бүтээн байгуулалт, тухайн үеийн экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ дэлхийн зах зээлд өссөнтэй холбоотой байлаа.



Монгол улсын гадаад худалдааны 70 орчим хувийг бүрдүүлэгч зэс, нүүрсний үнийн өөрчлөлтийн график



Зураг 14 Блүүмберг агентлаг

Харин 2012-2016 онуудад дэлхийн зах зээл дээрх уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурсан, Оюу Толгойн ил уурхайн бүтээн байгуулалт дууссан, Монгол Улсын Засгийн газрын тогтвортой бус бодлого зэрэг хэд хэдэн хүчин зүйлсээс хамаарч, эдийн засагт орж ирэх гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ багассан, экспортын хэмжээ буурсан, дотоодын худалдан авагчдын бодит орлого буурсан нь эдийн засгийн өсөлт 2014-2016 онд буурах нөхцлийг бүрдүүлсэн бөгөөд 2016 онд ДНБ-ийн өсөлт 1.2 хувь хүрсэн юм.

Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ 2016-2018 онд сэргэж дэлхийн зах зээлд дэх зэс, нүүрсний үнэ өссөн нь уул уурхайн салбарыг дагасан бусад салбаруудын өсөлтийг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг 2017 онд 5.1 хувь болоход нөлөөлсөн. Үүний үр дүнд 2018 оны 1-р улирлын байдлаар эдийн засгийн өсөлт 6.1 хувь болсон нь уул уурхайн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр өндөр байсан, улмаар гадаад худалдаанд эргэц сайжирсантай холбоотой байна.

Монгол Улсын эдийн засгийг бүтцийн ангиллаар авч үзвэл уул уурхайн салбар хамгийн өндөр буюу 24 хувийг эзэлж байна. Харин бусад салбарууд болох хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр, бөөний болон жижиглэнгийн худалдаа голлох байр суурийг буюу нийт эдийн засгийн 35 хувийг бүрдүүлж байна.




Зураг 15 ДНБ-ий задаргаа, Эх сурвалж: ҮСХ

Мөн сүүлийн жилүүдэд дотоодын эдийн засагт ажиглагдсан гол өөрчлөлтүүдийн нэг нь Олон улсын зах зээл дээрээс Монгол улсын босгосон гадаад өрийн бичиг байсан юм. Уг гадаад зээлүүдийн нөлөөллөөр 2012-2016 онуудад төсвийн болон мөнгөний тэлэх бодлогыг хэрэгжүүлж эдийн засгийн өсөлтөд тодорхой хэмжээний эерэг үзүүлэлтүүдийг авчирч байв.



Үнэт цаасны танилцуулга



Харин уг бодлогуудын сөрөг тал нь төгрөгийн гадаадын валюттай харьцах ханшинд муугаар нөлөөлж 2014-2017 оны хооронд төгрөг Ам.долларын эсрэг 46 хувь, Еврогийн эсрэг 27 хувь, БНХАУ-н Юанийн эсрэг 36 хувь тус тус сулрахад хүргэсэн. Цаашлаад Монгол улсын эдийн засаг нь гадаад өрийн дарамтад орсон бөгөөд бондын эргэн төлөлтийг төсвийн тэнцлээр төлөх боломжгүй болсны улмаас 2017 онд дефолт зарлах хэмжээний эрсдэлд ороод байв.

	2013	2014	2015	2016	2017	3/31/2018
АНУ-ын доллар (өсөлт, бууралт)	1,659.3	1,888.4	1,995.5	2,489.5	2,428.2	2,392.7
		13.8%	5.7%	24.8%	-2.5%	-1.5%
Евро (өсөлт, бууралт)	2,288.8	2,295.4	2,181.1	2,605.7	2,922.6	2,948.2
		0.3%	-5.0%	19.5%	12.2%	0.9%
Рубль (өсөлт, бууралт)	50.5	33.9	27.0	41.0	42.1	41.7
		-32.8%	-20.5%	51.9%	2.8%	-1.0%
Юань (өсөлт, бууралт)	274.1	304.5	307.3	357.9	373.7	381.3
		11.1%	0.9%	16.5%	4.4%	2.0%

Хүснэгт: 5 Валютын ханш



Энэ үед Монгол улсын зээлжих зэрэглэл жил дараалан буурсан бөгөөд зээлжих зэрэглэл олон улсын үнэлгээний агентлагуудын нэг болох Moody's агентлагаас 2017 оны 2 сард Саа1 Negative watch ангилалд шилжсэн нь өнгөрсөн жилүүдэд авч байсан хамгийн бага үнэлгээ байлаа.

Агентлаг	Дүн	Шинж	Өдөр
Moody's	B3	stable	Jan 18 2018
Fitch	B-	positive	Nov 17 2017
Moody's	Саа1	stable	Mar 30 2017
Moody's	Саа1	negative watch	Feb 15 2017
Fitch	B-	stable	Nov 22 2016
Moody's	Саа1	stable	Nov 18 2016
Moody's	B3	negative watch	Aug 26 2016
S&P	B-	stable	Aug 19 2016
Fitch	B	stable	Nov 24 2015
S&P	B	stable	Nov 03 2015

Хүснэгт: 6 Монгол улсын зээлжих зэрэглэл


Монгол улсын гадаад өрийг эдийн засгийн дотоод боломжоор төлөх чадваргүй болсон цаг үед Засгийн газар ОУВС-тай хамтран Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжүүлэх болж 2017-2020 оны хооронд нийт 5.5 тэрбум ам.долларын дотогшлох урсгалыг бий болгосон нь гадаад өрийн дарамтыг бууруулж, валютын ханшид эерэгээр нөлөөлсөний улмаас 2018 онд Монголын улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ B3 болж өссөн.

2017 оны 5 сарын 24-ны өдөр батлагдсан ОУВС-тай хамтран хэрэгжүүлэх 3 жилийн хөтөлбөр нь ОУВС-аас 434.3 сая ам.долларын санхүүжилт, олон улсын байгууллагууд болон хандивлагч орнуудаас нийтдээ 5.5 орчим тэрбум ам.долларын хөнгөлөлттэй санхүүжилтийг төсвийн алдагдал, төлбөрийн тэнцлийн зориулалтаар авч ашиглах юм.





Үнэт цаасны танилцуулга



Хөтөлбөрийн хүрээнд авах санхүүжилтийн задаргаа

№	Санхүүжүүлэх байгууллага	Дүн	Хугацаа	Хүү
1.	ОУВС	434.3 сая	15	<2%
2.	Азийн Хөгжлийн Банк	900 сая	тодорхойгүй	тодорхойгүй
3.	Дэлхийн Банк	600 сая	15	2%
4.	Япон улс	850 сая	>10	1-1.5%
5.	БНСУ	450 сая	тодорхойгүй	тодорхойгүй
6.	БНХАУ-ын Төв банкны своп	2.2 тэрбум (15 тэрбум юань)	3	-
	Нийт	5.5 тэрбум		

Хүснэгт: 7 ОУВС-н Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн нөхцөл

Эх сурвалж: ОУВС, Санхүүжилт

Цаашлаад төлбөрийн тэнцлийг сайжруулан макро эдийн засгийн тэнцвэрийг хангаж, дунд хугацаанд өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн үнээс хэт хамааралтай байдлыг өөрчлөх, бизнесийн таатай орчин бүрдүүлэх зэрэг бодлого хэрэгжүүлснээр, дунд хугацаанд эдийн засгийн өсөлт нэмэгдэж 6.3%, инфляцийн түвшин 6.1-7.0% болно гэж хөтөлбөрийн хүлээгдэж буй гүйцэтгэлд тусгажээ.

Хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын төлбөрийн тэнцэл сайжирч, төсвийн нэгдмэл байр суурьтай болж татварын бодлогыг шинэчлэх ба төсвийн зарлагыг үе шаттай бууруулж, Хөгжлийн банкны засаглалыг сайжруулж бие даасан хараат бус байдлыг хангаж, өрийн тогтвортой байдлыг хангах юм.

Үр дүнд нь дотоодын эдийн засагт инфляцийн тогтвортой орчин, гадаад худалдааны эерэг баланс, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдал тогтох бөгөөд 2017 онд ажиглагдсан уг өсөлтийг цаашид хадгалагдан 2020 онд мөн жилд 5 хувиар өсөх таамаглалыг ОУВС-аас дэвшүүлээд байна. Мөн хөтөлбөр нь 2018-2020 онд үргэлжлэн хэрэгжсэнээр ДНБ-ий өсөлтийн хэмжээ 2018 онд 5.0, 2019 онд 6.3, 2020 онд 5.0 хувиар тус тус өсөх төлөвтэй байна.

	Гүйцэтгэл				Төсөөлөл		
	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөг)	22,227	23,150	23,935	27,167	30,662	34,383	38,019
ДНБ-ий бодит өсөлт (хувиар)	7.9%	2.4%	1.2%	5.1%	5.0%	6.3%	5.0%


Хүснэгт: 8 ДНБ-ий төсөөлөл, Эх сурвалж: СЯ, ОУВС


Үүн дээр нэмэгдээд дэлхийн эдийн засгийн өсөлт дунд хугацаанд харьцангуй тогтвортой байх хандлагатай байгаа нь эрдэс бүтээгдэхүүний үнэ тогтвортой байх боломжийг бүрдүүлж байна. Гэсэн хэдий ч БНХАУ болон зарим хөгжингүй орнууд нүүрсний хэрэглээнээс татгалзаж, хэрэглээгээ бууруулах бодлого баримталж байгаа нь нүүрсний үнэ 2018-2020 онд 2017 оны түвшингээс буурч болзошгүй байна.

ам.доллар	2016	2017	2018	2019	2020
Зэс	4,868	6,170	6,430	6,462	6,471
Нүүрс	71	88	85	79	75
Газрын тос	43	53	50	51	51
Төмрийн хүдэр	58	72	62	57	55
Цайр	2,090	2,890	2,926	2,799	2,663

Хүснэгт: 9 УУ-н бүтээгдэхүүний үнэ

Дээрх анализаас харахад Монгол улсын эдийн засгийн байдал нь ойрын хугацаандаа буюу Олон улсын валютын сангийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд тогтвортой байх төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй компаниуд аливаа төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд макро эдийн засгийн хувьд тогтвортой





Үнэт цаасны танилцуулга



орчин бий болснийг илтгэж байна. Ялангуяа Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөртэй холбоотойгоор дотоодыг чиглэх валютын урсгал нь тогтвортой ханшийг бий болгох тул шинээр тоног төхөөрөмж худалдан авах, хөрөнгө оруулахад таатай орчинг бий болгох юм.

2.1.1 Үнэт цаасны зах зээлийн тухай

Монголын хөрөнгийн зах зээл сүүлийн жилүүдэд буюу 2014-2018 оны хооронд маш өндөр идэвхиж зах зээлийн үнэлгээ 2017 онд түүхэн дээд үзүүлэлт болох 2.4 их наяд төгрөгт хүрсэн. Энэ өндөр өсөлтөд нөлөөлсөн хүчин зүйлс нь эдийн засгийн ерөнхий байдлаас гадна, хөрөнгө оруулагчдын боловсролын хэмжээ нэмэгдсэнээр зах зээлд оролцогчдын тоо өссөнтэй холбоотой байна.

Доорх графикт Хөрөнгийн зах зээлийн 2012-2017 оны үнэлгээний хэмжээ болон арилжааны хэмжээг харуулав.




График 7 Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



График 8 Хөрөнгийн зах зээлийн арилжааны түүх

Ялангуяа сүүлийн жилүүдэд Монгол улсын хэмжээнд Монгол банкны бодлогын хүү бүүрч буйтай холбоотойгоор зээл, хадгаламжийн хүү бүүрч байгаа нь хөрөнгийн зах зээлийг цаашид улам сонирхолтой салбар болоход нөлөөлж байна. Иргэд, аж ахуйн нэгжүүд банкны хадгаламжаас илүүтэйгээр хөрөнгийн зах зээлийг сонирхох болж, хөрөнгийн тодорхой хэсгээр үнэт цаас худалдан авч буй нь нийт зах зээлд тэлэлт үүсэхэд чухал хувь нэмэр оруулж байна.

Үүний үр дүнд Монголын хөрөнгийн зах зээлд 2018 онд шинээр бүртгэгдэж арилжаа нь эхэлсэн Лэнд.мн болон Монголбазальт зэрэг компаниудын анхдагч зах зээлд арилжигдсан идэвхи маш өндөр байсан. Тухайлбал Лэнд.мн –ийн хувьцааны 2.5 тэрбум төгрөгийн захиалгад нийт 41.2 тэрбум төгрөгийн захиалга, Монголбазальт ХК-н олон нийтээс татан төвлөрүүлэх 6.4 тэрбум төгрөгт нийт 20.3 тэрбум төгрөгийн захиалга ирсэн юм. Цаашид МХБ-ээр дамжуулан санхүүжилт татах компаниудын тоо нэмэгдэж, зах зээлд шинэ бүтээгдэхүүнүүд их хэмжээгээр нэвтэрч буй нь нийт зах зээлд маш сайн бөгөөд хөрөнгө оруулагчдад урт хугацаанд тогтвортой ногдол ашиг тараах чадварлаг компаниуд бий болж буй нь онцлог байна. Энэхүү проспектусыг бичиж байх энэ үед буюу 2018 оны 6 сарын эхний байдлаар Канад улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Эрдэнэ Ресурс Девелопмент ХК-ны хувьцаа МХБ-д давхар бүртгэл хийж, олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэхээр ажиллаж байгаа нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн шатанд шинэ алхам болсон үйл явдал болж байна. Цаашлаад иргэдийн боловсрол нэмэгдэх, хөрөнгө оруулах олон төрлийн чанартай компаниуд зах зээлд шинээр нэвтэрснээр Монголын ард түмэн энэхүү зах зээлээс ашиг хүртэх боломж нь нэмэгдэх юм.





Үнэт цаасны танилцуулга



2.2 Мал аж ахуй

Улсын хэмжээнд 2017 онд нийт 66.2 сая таван хошуу мал тоологдсоноос 45 хувийг хонь, 41 хувийг ямаа, 6 хувийг адуу, 7 хувийг үхэр, 1 хувийг тэмээ эзэлж байна. Малын тоо 2016 онд 61.5 сая байсан бол 2017 онд 7.5 хувиар өсч түүхэн дээд амжилтыг үзүүлээд байна. Монгол улс нь хэдийгээр олон малтай болж, малын нийт тоо нэмэгдэж буй боловч малын чанарт анхаарч эрчимжүүлсэн мал аж ахуйг хөгжүүлэх зайлшгүй шаардлага үүсээд буйг Хүнс Хөдөө аж ахуйн яамны судалгаанаас харж болохоор байна.

Малын тоо /мянгаар/






График 9 Малын тоо

Малын чанарт илүү анхаарлыг хандуулж, нэгж малаас гарах гарцыг нэмэгдүүлснээр бэлчээрийн даацад эерэгээр нөлөөлж эдийн засагт үр өгөөж авчрах юм. Ялангуяа үхэр, хонь зэрэг мах сүүний чиглэлээр түлхүү ашиглагддаг малыг эрчимжүүлж мах сүүний гарцыг нэмэгдүүлэх нь эдийн засагт өндөр ач холбогдолтой.

Тэр ч утгаараа Монгол улсын хөдөө аж ахуйн бодлогод эрчимжүүлсэн мал аж ахуйг дэмжихээр 2020-2025 онуудын хооронд төрөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээнд:

- “Малын төрөл бүрийн тэжээлийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлж, түүний шимт чанарыг сайжруулах үйл ажиллагааг тогтворжуулах”
- “Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд бүртгэлээр дамжуулан хяналт тавьж гарал үүсэл, эрүүл мэндийг баталгаажуулан нийгмийн эрүүл мэндийг хамгаалах”,
- “Малаас гаралтай органик түүхий эд бэлтгэлийн хэмжээ, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж экспортын чиг баримжаатай дотоодын үйлдвэрлэлийг дэмжих” гэж тус тус тусгасан байгаа нь цаашлаад төрийн зүгээс эрүүл ахуйн шаардлага хангасан мал аж ахуйг хөгжүүлж, малын эрчимжүүлсэн аж ахуй хөгжүүлэгчдэд бодлогын таатай орчинг бий болгох нь харагдаж байна. <http://mofa.gov.mn/exp/blog/7/240>

Харин уг хөтөлбөр арга хэмжээний гол хүчин зүйл нь тухайн эрчимжүүлсэн мал аж ахуй хүчит тэжээл, тэжээлийн ургамлаар бэлдсэн малын тэжээлээр хангах юм. Сайжруулсан тэжээлээр малыг бордох нь нэгж малд ногдох тэжээлийн зардлыг бууруулах, малын тарга, шимт байдлыг бууруулдаггүй зэрэг чухал ач холбогдолтой. Жишээ нь: Сэлэнгэ үүлдрийн өсвөр үхрийг бордох судалгаанд ХААИС-н Биологийн нөөцийн менежментийн сургуулийн эрдэмтэд болох А. Эрдэнэчимэг, Н. Тогтохбаяр, Х. Гэндарам зэргийн гүйцэтгэсэн судалгааг үзвэл өсвөр үхэрт зориулсан уураг, амин дэм, эрдэсээр баялаг багсармал тэжээлийн идэмж нь 100 хувь буюу аль ч насны үхэр маш дуртайгаар идэж байсан бөгөөд судалгааны үр дүнд





Үнэт цаасны танилцуулга



өндөр чанар бүхий эрдэс бодисоор баялаг багсармал тэжээлийг хямд өртөгтэй үйлдвэрлэн эрчимжсэн технологи бүхий бүтээмж ихтэй махны үхрийг бордон тэжээх нь хүн амын махны хэрэгцээг хангахад нэн чухал ач холбогдолтой болохыг баталсан.²

СОНИРХОЛТОЙ БАРИМТ- 8

Өндөг таргалуулдаг уу?

Эсрэгээрээ. Өндөг тураадаг. Чанасан өндөгний дэглэм нь хамгийн эрүүлээр жингээ барих аргад тооцогддог. boiled egg diet гэсэн хайлтаар маш их мэдээлэл авах боломжтой.

2.2.1 Эрчимжүүлсэн мал аж ахуйг хөгжүүлэх төрийн бодлого

Монгол Улсын хувьд эрчимжүүлсэн мал аж ахуйг үржүүлэх бодит шаардлага байгааг Хүнс Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамны МАА-н салбарын 2017-2020 он хүртэлх хөгжлийн бодлого, стратегийн зорилтод "Төрөл бүрийн мал, амьтныг эрчимжүүлсэн технологиор төрөлжүүлэн үржүүлэх, бойжуулах, бусад жижиг аж ахуйг үржлийн өсвөр малаар хангах цогцолбор аж ахуйг бүсчлэн хөгжүүлэхийг дэмжих" гэж оруулсан төдийгүй МАА-н салбарын 2020-2025 оны хөгжлийн хандлага, стратегийн зорилтод "Бодлого нь мэдлэгт суурилсан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, шинэ технологи, инновацийг нэвтрүүлэх, мэргэжлийн үйлчилгээг төгөлдөршүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмжээс хүртэх үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ" гэж тусгажээ.

Цаашлаад 2020-2025 онуудын хооронд төрөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээнд:

- "Малын төрөл бүрийн тэжээлийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлж, түүний шимт чанарыг сайжруулах үйл ажиллагааг тогтворжуулах"
- "Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд бүртгэлээр дамжуулан хяналт тавьж гарал үүсэл, эрүүл мэндийг баталгаажуулан нийгмийн эрүүл мэндийг хамгаалах",
- "Малаас гаралтай органик түүхий эд бэлтгэлийн хэмжээ, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж экспортын чиг баримжаатай дотоодын үйлдвэрлэлийг дэмжих" гэж тус тус тусгасан байгаа нь цаашлаад төрийн зүгээс эрүүл ахуйн шаардлага хангасан мал аж ахуйг хөгжүүлж, малын эрчимжүүлсэн аж ахуй хөгжүүлэгчдэд бодлогын таатай орчинг бий болгох нь харагдаж байна. <http://mofa.gov.mn/exp/blog/7/240>

Мал аж ахуйн салбарын 2025-2030 оны хөгжлийн хандлага, хүлээх үр дүн:

Мал аж ахуйн салбарын 2030 он хүртэлх хөгжлийн хандлага нь бэлчээрийн мал аж ахуйн өв соёлыг дэлхий нийтэд таниулсан органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн урсгалыг бий болгож үнэ цэнийн сүлжээг хөгжүүлсэн, тогтвортой үйлдвэрлэлийг явуулахад бодлого чиглэгдэнэ.

Хүлээх үр дүн:

- Малын биологийн нөөцийг бүрэн ашиглахад суурилсан биотехнологийн үйлдвэрлэл өргөжиж, улс орны эдийн засгийн орлогын шинэ эх үүсвэрийг бүрдүүлж эхлэнэ.
- Мал аж ахуйн үйлдвэрлэл дэх хөдөлмөр хөнгөлөлт, техникийн шинэчлэл одоогийн түвшнээс 30 хүртэл хувиар нэмэгдэнэ.
- Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг биржээр арилжаалах систем төлөвшиж, олон улсад IPO гаргана.
- Мал аж ахуйн үйлдвэрлэл дэх ажлын байр төдийлөн буурахгүй хадгалагдах ба хот суурингийн төвлөрөлтөөс зайлсхийж, нийгмийн ая тухтай байдлаа сайжруулан хөдөөд

² Сэлэнгэ үйлдрийн өсвөр үхрийг бордох судалгаанд ХААИС-н Биологийн нөөцийн менежментийн сургуулийн эрдэмтэд болох А. Эрдэнэчимэг, Н. Тогтохбаяр, Х. Гэндарам



Үнэт цаасны танилцуулга



- ажиллах сонирхолын нөхцөл бүрдэж, зорилтот зах зээлд чиглэсэн, үр ашигтай “ухаалаг” аж ахуй эрхлэх загварт шилжинэ.
- Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид газар зүйн болон бусад мэдээллийн системийг бүрэн ашиглан холбогдох мэдээллийг өөрсдөө улсын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд дамжуулах чадавхитай болж, маркетингийн сүлжээний хөгжил, үр ашиг, бүтээмжээр өрсөлдөх болно.
 - Олон улсын худалдааны хориг бүхий малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, тэмцэх, зооноз, халдварт зарим өвчнөөс мал сүргийг бүрэн эрүүлжүүлж, гадаад, дотоод зах зээлд малын гаралтай бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүсчлэн бүрдүүлнэ.

Стратегийн ач холбогдлыг харгалзан мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд төрөөс дэмжлэг зүүлэх, урамшуулал олгох систем тодорхой хэмжээнд хадгалагдна гэж заасан байна.

Монгол улсын эдийн засгийн ерөнхий байдал, мал аж ахуйг цаашид хөгжүүлэх төрийн бодлого тэр дундаа эрчимжүүлсэн мал аж ахуйг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө зэргээс дүгнэхэд эдийн засгийн байдал болон мал аж ахуйг хөгжүүлэх бодлого нь Үнэт цаас гаргагч компанийн цаашид авч хэрэгжүүлэх төсөл хөтөлбөртэй нягт уялдаатай буюу мал аж ахуйг хөгжүүлэх, дотоодод нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэрэг үйл ажиллагааг дэмжсэн орчинг бий болгож байна.

2.3 Өндөгний зах зээлийн бүтэц, ерөнхий байдал

Манай улсын хувьд шувууны аж ахуй нь хожим хөгжсөн хөдөө аж ахуйн залуу салбар. 1960 оны дунд үе хүртэл үндсэндээ шувууны аж ахуйн тухай маш бага мэдээлэлтэй, энэ аж ахуй манай улсад огт хөгжөөгүй, нутгийн хүмүүс хэрэглэж заншаагүй, тэр үеийн Монголд аж төрж байсан Оросууд болон гадаадынхан мөн төр засгийн хэрэгцээнд гаднаас захиж авчруулж хэрэглэдэг байсантай холбоотой юм. Манайд шувуун фабрик байгуулагдсан хойно ч энэ аж ахуйн өндөг нь зөвхөн хотын хүн амын цөөн хэсэгт хүртээгддэг, иргэн бүр өргөн дэлгэр хэрэглээд байдаг хүнсний бүтээгдэхүүн биш байлаа. Энэ байдал чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжсэн 1990-д оны дунд үе хүртэл үргэлжилсэн гэж хэлж болно.

Манай улсын шувууны аж ахуйн хөгжил 1960-д оноос эхэлсэн. 1963 онд анхны шувууны аж ахуй Шувуун фабрик нэртэйгээр байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлжээ. Энэ фабрик нь 30,000 өндөглөгч шувууны хүчин чадалтай, жилдээ 4.5 сая ширхэг өндөг, 70 тонн мах үйлдвэрлэх болсон байна. 1973 онд ЗХУ-н техник эдийн засгийн үндэслэлээр 100,000 өндөглөгчтэй болгох өргөтгөл хийж, үүний үр дүнд жилд 22.6 сая ширхэг өндөг, 250 тонн тахианы мах үйлдвэрлэх хүчин чадалтай болжээ.

Өндөг нь хэдийгээр Монголчуудын хүнсний хэрэглээний өчүүхэн хэсгийг эзэлж ирсэн боловч сүүлийн үед энэ тоо хэмжээ нэлээд өссөн нь ард түмний амьжиргааны түвшин дээшилж байгаа, мөн чөлөөт зах зээлийн эдийн засаг хэрэгжсэний үр дүнд хот, хөдөөгийн хүнсний бүтээгдэхүүний хангамж сайжирч, сонголт өргөн болсон, гадаад, дотоод худалдаа хөгжснөөр импортын өндөг орж ирдэг болсон, хувийн жижиг шувууны аж ахуйнууд олноор бий болсноор өндөгний үйлдвэрлэл нэмэгдсэн нь ард түмнийг энэ хүнсний бүтээгдэхүүнийг өргөнөөр хэрэглэх эрэлт хэрэгцээг бий болгосон юм. Импортын өндөгний хувьд манай улс ОХУ-н тэргүүлэх шувууны аж ахуй Белореченское-ээс өндөг авч хэрэглэдэг байна.

Монгол улсын хэмжээнд нийт 705 мянган ширхэг шувуу бүртгэлтэй байгаа бол үүний 444 мянган ширхэг нь өндөглөгч шувуу байна. Уг тоо сүүлийн жилүүдэд өөрчлөлт ихтэй байгаа нь өндөгний зах зээлд импортын өндөгний байр суурь нэмэгдсэн, дотоодын зах зээлд жижиг үйлдвэрүүд оршин тогтноход өрсөлдөөн их хэмжээгээр нэмэгдсэн зэрэг нь нөлөөлж байна.



Үнэт цаасны танилцуулга




График 10 Өндөглөгч шувууны статистик мэдээлэл

Монгол улс 2017 оны байдлаар нийт 7.4 сая ам.долларын өртөг бүхий 120 сая ширхэг өндөгийг импортоор оруулж ирэн хэрэглэсэн бөгөөд уг дүн нь өмнөх оноос даруй 43 хувь өссөн байгаа нь хүн амын хэрэглээний бүтцэд өндөгний эзлэх байр суурь нэмэгдсэн, Монгол хүмүүсийн бие физиологигоо анхаарал хандуулах хандлага нэмэгдэх фитнес, бодибилдингээр хичээллэгчдийн тоо өссөн зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна.



График 11 Импортын өндөгний зах зээлийн мэдээлэл



Мөн нөгөө талаар импортоор оруулж ирсэн тахиа, тэжээвэр шувууны тоо 2017 онд 257 мянган толгойд хүрч нийт 349 мянга ам.долларын буюу 840 орчим сая төгрөгийн тахиаг импортоор худалдан авсан байна. Монгол улс нь тахианы дэгдээхэйг импортоор худалдан авдаг ба нэгж дэгдээхэйний өртөг нь 1-1.3 ам.долларын өртөгтэй байна.

Монгол Улсын нэг хүний өндөгний дундаж хэрэглээ нь жилд 87 ширхэг байгаа бол олон улсын түвшинд 220 ширхэг өндөг хэрэглэж байна. Энэ нь цаашлаад Монгол Улсын хэрэглэгчдийн түвшин олон улсын түвшинд хүрэхэд нийт зах зээл 2.5 дахин нэмэгдэж нийт өндөгний хэрэглээ 660 сая ширхэг болох боломжтойг илтгэж байна.

Өндөгний зах зээлийн өрсөлдөгчийн судалгаа

Монгол Улсын өндөгний зах зээлд хамгийн өндөр хүчин чадал бүхий компани нь НВЦ буюу МонЭгг компани юм. "НВЦ" ХХК нь хөдөө аж ахуйн цогц үйлдвэрлэл, үйл-ажиллагаа явуулах зорилготой 1998 онд байгуулагдсан, өндөгний үйлдвэрлэлийг гол чиглэлээ болгосон үндэсний үйлдвэрлэгч компани юм.

ОХУ-ын шувууны аж ахуйн тэргүүлэгч компани "Белореченское" ХХК-ийн Монгол Улс дахь албан ёсны төлөөлөгчөөр 1999 оноос, мөн тахианы мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр





Үнэт цаасны танилцуулга



АНУ-ын "Пилгримс прайд" корпорацийн дистрибьютерээр 2005 оноос өнөөг хүртэл ажиллаж байна.


Өндөгний зах зээлийн эрэлт хэрэгцээг импортоор хангаж үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол, 2003 оноос дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор 100 мянган шувууны аж ахуй бүхий "Монэгг" ХХК-ийг өөрийн хөрөнгө оруулалтаар байгуулан "Баян" өндгийг зах зээлд нийлүүлж байна.

Тоног төхөөрөмж	Германы Биг Дачмэн (Big Dutchman), Голландын Моба (Moba)
Өндөг татан авалт	"Белореченск" компаниас нэг хоногийн настай 100 мянган дэгдээхий тэд хүлээн авдаг
Хүчин чадал	Тахианы 4 байранд нийт 400,000 өндөглөгч, Дэгдээхэйний 2 байранд 100,000 дэгдээхэй
Үйлдвэрлэл	Өдөрт 260,000 өндөг, жилд 95 орчим сая өндөг үйлдвэрлэдэг
Зах зээлд эзлэх байр суурь	НВЦ компани нь зах зээлд тэргүүлэх байр суурийг эзэлдэг

Монгол улсад Үндэсний статистик, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны судалгаа статистик мэдээнээс үзэхэд 2017 онд нийт 798 мянган тахиатай, тахианы 40 ферм үйл ажиллагаа явуулж байна.

Тахианы тоо толгой өнгөрсөн жилийн үзүүлэлтээс 82 мянгаар буурсан байгаа боловч сүүлийн таван жилд 47 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь манай улсад тахианы аж ахуй эрчимжиж буй болон махны тахианы үйлдвэрлэл эхэлсэнтэй холбоотой юм.

Харин фермерийн аж ахуйн тоо хэдийгээр 40 байгаа боловч үйл ажиллагаа нь идэвхитэй, олон тооны тахиа үржүүлэх чадвар бүхий компани хоёр ширхэг байгаа юм.





Хүснэгт: 10 Мал аж ахуйн мэдээлэл³

Монгол улсан үйл ажиллагаа явуулж буй бусад томоохон аж ахуйн нэгжүүдийн хүчин чадлын үзүүлэлт.

Аж ахуйн нэр	Өндөглөгчийн хүчин чадал ⁴
1 НВЦ ХХК	400,000
2 Түмэн Шувуут ХХК	250,000
3 Баянууд ХХК	22,000
4 Угтуул Алтай ХХК	25,000
5 Нионшель ХХК	30,000
Нийт	727,000

³ <http://mofa.gov.mn/exp/blog/7/4>

⁴ Дээрх Голомт банкны 2017 онд гүйцэтгэсэн судалгаа нь тухайн үеийн зах зээлийн мэдээллийг багтаасан бөгөөд өөрчлөгдсөн байх боломжтой.





Үнэт цаасны танилцуулга



Өндөгний аж ахуй нь 20,000-аас дээш шувуутай байж ашигтай ажиллах нөхцөл нь бүрддэг аж ахуйн төрөл тус сүүлийн жилүүдэд жижиг аж ахуйн нэгжүүд зах зээлийн зарчмаар дампууралд орох эсвэл үйлдвэрээ бусад том аж ахуйн нэгжүүдэд худалдан үйл ажиллагаагаа зогсоогоод байна.

Өндөгний зах зээлийн мэдээлэл сул, нэгдсэн датабааз байхгүй тул тухайн компани бүрийн хүчин чадлыг тооцоолоход ашигласан мэдээлэл нь бодит байдлаас зөрөх боломжтой юм. Судлаачид олон нийтэд нээлттэй байгаа бүхий л төрлийн мэдээллийг энд тусгахыг зорьж ажиллаа.


2.4 Тэжээлийн зах зээлийн бүтэц, ерөнхий байдал

Малын тэжээлийн үйлдвэрлэл, хангамж

Манай улсын тэжээл үйлдвэрлэл анхнаасаа уламжлалт гэж болох бүсийн шинжтэй явж ирсэн. Нийт тэжээлийн ихэнх хэсгийг ойт хээр, өндөр уул, ялангуяа газар тариалангийн бүсэд бэлтгэж байсан. Тэжээл үйлдвэрлэл, тариалалтын хувьд оргил үе нь 1987 онд нийт 160,0 гаруй мянган га-д тэжээлийн ургамал тариалж 600.0 гаруй мянган тн тэжээлийн ургамал хураан авч байсан түүхтэй. Өнөөдөр манай улсад тэжээлийн ургамал тариалах талбай 5 дахин багассанаар ургац хураалт 10 дахин буурсан үзүүлэлттэй байна. /30.0 мянга орчим га-д тариалж 45.0 мянга орчим тэжээлийн ургамал хураан авч байна./

Дэлхийн цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох, тухайлбал цөлжилт, ган, зуд, цаг агаарын гэнэтийн онц аюултай үзэгдлээс үүсч буй эрсдлийн нөлөөг багасгах, бэлчээрийн мал аж ахуйг нэмэгдэл тэжээл /өвөл, хавар тэжээлд дутагдаж буй хуурай бодис, түүнд агуулагдах шимт ба биологийн идэвхт бодисын нийт хэрэгцээ/ -ээр тэжээж, мал сүргийн таваарлаг байдлыг дээшлүүлэхийн тулд тэжээл, тэжээллэгийг анхаарч сайжруулах, хүн ам ихээр суурьшсан төв, суурин газрын иргэдийг эрүүл, аюулгүй хүнсээр хангахад эрчимжсэн аж ахуйг түлхүү хөгжүүлж, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Манай улсад нийт 68 тэжээлийн үйлдвэр байгаагаас цагт 2 тн-с дээш тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай тэжээлийн үйлдвэр 12 /гурилын үйлдвэр ороод/, үлдсэн нь жижиг оврын тэжээлийн цех байна.



Зураг 16 Тэжээлийн үйлдвэрлэлийн байршил



Үнэт цаасны танилцуулга



Малын тэжээлээр дагнасан томоохон 6 аж ахуйн нэгж байгаагаас Улаанбаатар хотод 4, Сэлэнгэ аймагт 1, Дорнод аймагт 1 байна.

№	Компанийн нэр	Хүчин чадал /хоног/	Тэжээлийн төрөл	Үйлдвэрлэсэн хэмжээ 2016
1	"Алтан тариа" ХХК	100 тн	Хивэг, хорголжин тэжээл	240,000 тн
2	"Түмэн шувуут" ХХК	100 тн	Тахианы насны онцлогт тохирсон 5-6 төрлийн тэжээл, хурдан морины тэжээл	25,000 тн
3	"Милл хаус" ХХК	160 тн	Хивэг, хорголжин тэжээл	40,000 тн
4	"Баялаг эмээлт" ХХК	20 тн	Хорголжин тэжээл /хүчит тэжээл/ нийт тэжээлийн 90 хувь шувуунд, 10 хувь үхэр, хонь, ямаанд	5,000 тн
5	"Майнд теч" ХХК	100 тн	Уурагт тэжээл, Сүү, махны үхэр, гахай, шувуунд	3,000 тн

Хүснэгт: 11 Тэжээлийн үйлдвэрүүдийн хүчин чадал

Малын тэжээл үйлдвэрлэл жилд 40,000 тн орчим, гурилын үйлдвэрүүдийн үйлдвэрлэж буй хивэгний үйлдвэрлэл жилд 70,000 тн орчим байна.

Бэлтгэсэн тэжээл, нэр төрлөөр /мян.тн/

№	Төрөл	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
1	Байгалын хадлан	1030	912.3	1137	1195	1175	1169	1178	1028	1100
2	Сүрэл	11.1	8.5	8.3	7.9	4.6	3.1	7.9	8.5	35.7
3	Гар тэжээл	34.4	25.8	32.7	46.7	39.1	36.6	40.3	39.9	38.1
4	Бэлтгэсэн дарш	0.9	0.5	4.0	8.5	2.1	3.9	4.0	1.6	7.9
5	Эрдэс тэжээл	53.8	44.4	48.0	40.4	36.6	31.8	29.7	61.3	105.6
6	Бүгд /тэж.нэгж/	560.4	499.2	618.6	663.2	624.6	609.8	614.0	576.9	649.6

Хүснэгт: 12 Монгол улсын бэлтгэсэн тэжээл

Манай улсын сүүний үхрийн аж ахуйд 66.9 мянган тн, мах-сүүний үхрийн аж ахуйд 7.6 мянган тн, махны үхрийн аж ахуйд 22.5 мянган тн, эрчимжсэн хонины аж ахуйд 23.6 мянган тн, сүүний чиглэлийн ямааны аж ахуйд 0.2 мянган тн, гахай, шувууны аж ахуйд 66.9 мянган тн, нийт эрчимжсэн мал аж ахуйд байгаа мал, амьтанд /187.4 мянган тн тэжээл шаардлагатай.



СОНИРХОЛТОЙ БАРИМТ- 9
Чанасан өндөгний хальс хууллахгүй байна?

Шинэ өндөгний хальс хуулардаггүй. Өндөг хуучрах тусам хальс нь амархан сална.

Тиймээс таны чанасан өндөгний арьс хуулахад хүндрэлтэй байгаа бол та шинэ өндөг идэж байна гэж бодох хэрэгтэй.



Цаашид Монгол улсын Засгийн газраас тэжээлийн үйлдвэрийг бүсчилэн байгуулж тухайн бүс нутгийн онцлогт тохирсон тэжээл үйлдвэрлэлийг бий болгох чиглэлээр ажиллаж байна.⁵

Дээрх үйлдвэрч нараас “Милл Хаус” ХХК хамгийн өндөр хүчин чадалтай үйлдвэртэй бол “Алтан тариа” ХХК 2016 онд хамгийн их малын тэжээл үйлдвэрлэсэн байна. Үнэт цаас гаргагчийн тэжээлийн үйлдвэр Агро Фийд нь үйлдвэрлэх хүчин чадлын Монгол улсдаа тэргүүн эгнээнд багтах хүчин чадал бүхий үйлдвэр бөгөөд цаашид үйлдвэрийн ашиглалт нэмэгдсэнээр үйлдвэрийн бүтээгдэхүүний гарц сайжирч, компанийн ашигт ажиллагаа нэмэгдэх боломжтой юм. Малын тэжээлийн импортын зах зээл сүүлийн жилүүдэд илт өргөжин тэлсэн байдалтай байна. Энэ нь малын тэжээлийн эрэлт эрс нэмэгдсэн, дотоодын үйлдвэрлэгч нар зах зээлээ бүрэн хангаж чадахгүй байдалтай байгааг илтгэж байна.

Манай улс 2017 оны байдлаар нийт **4.4 сая ам.доллар буюу 10.7 тэрбум төгрөгийн** тэжээлийг импортоор авсан нь дотоодын үйлдвэрүүдэд зах зээлээ тэлэх өргөн боломж байгааг харуулж байна.




График 12 Малын тэжээлийн импорт

2.5 Тахиа, тэжээвэр шувууны махны зах зээл

Үнэт цаас гаргагч нь тахианы махны зах зээлд хөл тавьж дотоодод тахианы махны үйлдвэрийг эхлүүлэхээр зорин ажиллаж байна. Тэр ч утгаараа зах зээлээ зөв тооцоолж, хөрөнгө оруулагчдад хамгийн өндөр өгөөжтэй байх зарчмаар үйлдвэрлэлээ эхлүүлэх нь зохистой юм.

Монгол улсын махны тахианы зах зээлд гадны буюу импортын махны дийлэнх хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны байдлаар нийт 14.8 сая ам.доллар буюу 35.6 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий тахиа, шувууны махыг импортоор худалдаж авсан нь сүүлийн 3-н жилийн хугацаанд дүн нь жилийн 16-17 хувиар өссөн үзүүлэлт юм.

Дотоодын махны тахианы аж ахуйн хамгийн том компани нь Ажигана ХХК-н “Оргио” бренд бөгөөд сүүлийн жилүүдэд хэрэглэгчдийн хүсэл зорилгод нийцсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.

Эндээс харахад дотоодын хэрэглэгчдийн дунд Монгол улсад үйлдвэрлэсэн махыг худалдан авах эрэлт их буюу цаашид махны тахианы үйлдвэрлэлийг эрхлэх боломж буйг харуулж байна.

Хэрэглэгчдийн дунд ОХУ болон БНХАУ-с импортоор орж ирсэн тахиануудын чанарт итгэх итгэл сул, гарал үүсэл тодорхойгүй байгаа байдал зэрэг нь цаашид дотоодод үйлдвэрлэсэн тахианы махыг худалдан авах мөн нэгэн түлхэц хүч болж өгөх юм.

⁵ <http://mofa.gov.mn/exp/blog/7/5>

Иймээс Түмэн шувуут ХХК 2013 оноос Махны Шувууны аж ахуй байгуулах төсөл хэрэгжүүлэхээр судалгааны ажил хийж эхлээд байна.

Монгол улсад махны тахианы аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах, импортыг орлох экологийн цэвэр бүтээгдэхүүн болох тахианы махаар хэрэглэгчдэд хангах явдал юм.

Үүний тулд доорхи зориолтуудыг тавьж ажиллаж байна. Үүнд:

- Өөрийн эзэмшлийн Сонгинохайрхан дүүргийн нутагт байрлах 5 га газрыг шинээр бүтээн байгуулалт хийх
- Махны тахианы Cobb-500 үүлдрийн 20 мянган шувуу суух 6 байрыг барьж, шинэ тоног төхөөрөмжөөр тоноглон ашиглалтад оруулах
- Хорио цээр халдваргүйжүүлэлтийн иж бүрэн тоноглол бүхий тоног төхөөрөмжийг шинээр худалдан авч үйл ажиллагаандаа ашиглах
- Хөргүүрийн иж бүрэн цехийг шинээр барьж тоногжуулан ажиллагаанд оруулах
- Тус аж ахуйг явуулахад шаардагдах тэжээл, нядалгааны үйлдвэр, чанарын хяналт хийх лаборатори зэрэг бүрэн шийдэгдсэн төсөл хэрэгжүүлэхэд давуу тал болж байна



График 13 Cobb-500 тахиа

СОНИРХОЛТОЙ БАРИМТ- 10

Чанасан өндөгний шарыг тойроод хөх туяа үүсч байна?

Хэт чанасан өндөгний шарны гадуур хөх туяа үүсдэг. Зарим эзэгтэй нар хөх туяа үүсгэхгүйн тулд чанасан өндгийг сойхдоо хальсыг нь салгаж сойдог. Энэ хөх туяа нь өндгөнд агуулагдах төмөр болон бусад эрдсийн үлмээс үүсдэг бөгөөд тэжээл дэх төмрийн хэмжээ их байвал бас үүснэ.

Дотоодын үйлдвэрлэл

Монгол улс нь тахианы мах үйлдвэрлэгч орны нэг бөгөөд 2016 оны байдлаар дэлхийн дээрх нийт импортийн 0.01 хувийг бүрдүүлж 153-р байрт эрэмблэгдсэн байна. Монгол улсад 1997-2016 оны хооронд үйлдвэрлэсэн тахианы махны тоо хэмжээг дараах графикаас харж болно.

Mongolia's Production Trend




График 14 Тахианы мах үйлдвэрлэл⁶

⁶ <https://www.tridge.com/intelligences/fresh-chicken-meat/MN/variety>

(Handwritten signature and official stamp)

(Handwritten signature and official stamp)



Үнэт цаасны танилцуулга

мян.USD

Улс	2015 он		2016 он		2017 он	
	Тоо/кг	Үнэ	Тоо/кг	Үнэ	Тоо/кг	Үнэ
БНСУ	112	0			112	0
БНХАУ	3,389,501	6,711	5,935,155	10,564	9,196,616	14,507
Бразил			81,000	127	24,990	46
ОХУ	369,982	610	1,314,124	1,869	146,652	254
Польш	20,158	18	24,980	35	9,830	16
Беларусь			17,057	37		
Америкийн Нэгдсэн Улс	1,622,974	2,609				
Украйн	423,697	883				
НИЙТ	5,826,312	10,831	7,372,316	12,631	9,378,200	14,824

Хүснэгт: 13 Тахианы махны импортын мэдээ

Монгол улсын тэжээвэр шувууны махны сүүлийн гурван жилийн импортийн мэдээг нэгтгэн харвал нийт импортийн худалдааны 81 хувийг Хятад улс, 8 хувийг Америкийн нэгдсэн улс, 7 хувийг Оросын холбооны улс, 4 хувийг бусад улс орон эзэлж байна.



График 15 Тэжээвэр шувууны махны импорт

Тэжээвэр шувууны мах болон дайвар бүтээгдэхүүний импортийн тоо хэмжээ 2016 болон 2017 онд өмнөх оноос тус тус 27 хувиар өссөн байна. Харин импортийн үнийн дүнгийн хувьд дээрх онуудад өмнөх оноос 17 хувиар өссөн байна.

Монгол улсын тэжээвэр шувууны махны үйлдвэрлэлийн тоо хэмжээ болон импорт дээр суурилан тэжээвэр шувууны махны зах зээлийн багтаамжийг тодорхойлов.

Монголын тахианы махны зах зээл	2015	2016	2017
Үйлдвэрлэл (тн)	542	459	619
Импорт (тн)	5,826	7,372	9,378
Нийт зах зээл (тн)	6,368	7,831	9,997
Дотоод зах зээл (мян.USD)			910
Импорт (мян.USD)	10,831	12,631	14,824
Нийт зах зээл (мян.USD)	10,831	12,631	15,734
Импортийн үнэ (тн/мян.USD)	1.9	1.7	1.5
Үйлдвэрлэл/Нийт зах зээл тоо хэмжээ (тн)	8.51%	5.86%	6.19%

Хүснэгт: 14 Тахианы махны зах зээлийн бүтэц

Монгол улс 2015 онд тэжээвэр шувууны махны нийт хэрэгцээний 8.5 хувь буюу 542 тонн, 2016 онд 6 хувь буюу 459 тоннийг тус тус үйлдвэрлэсэн байна. Дээрх тоонууд дээр үндэслэн тооцоолоход Монгол улсын тахианы махны нийт зээл ойролцоогоор **16 сая доллар буюу 38.4 тэрбум төгрөгөөр** хэмжигдэж байна.





Үнэт цаасны танилцуулга



Тахианы махны гадаад зах зээлийн судалгаа

Тэжээвэр шувууны махны экспорт болон импортийн худалдаанд оролцсон ТОП-5 улсыг дор харуулав.

ТОП-5 экспортлогч болон импортлогчид /2017/




График 16 Тахианы мах экспортлогч/импортлогч ТОП-5 улс

Дээрх графикаас харахад нийт тэжээвэр шувууны махны зах зээлийн ихэнхи хувийг Бразил улс болон Америкийн нэгдсэн улс бүрдүүлж байна.

Тэжээвэр шувууны махны үйлдвэрлэлийн тоо хэмжээ 2003-17 /мян тонн/







График 17 Тэжээвэр шувууны махны үйлдвэрлэлийн тоо хэмжээ 2003-17

Дэлхийн тэжээвэр шувууны махны үйлдвэрлэлийн тоо хэмжээ сүүлийн 15 жилийн хугацаанд 55 хувь өсөж 75.9 сая тонноос 118.1 сая тоннд хүрсэн байна.

Энэ нь дэлхийн хүн амын өсөлттэй холбоотой ба Нэгдсэн үндэсний байгууллагын хүн амын урьдчилсан мэдээгээр доор харуулав.

Дэлхийн хүн амын төсөөлөл 2050 он хүртэл





Үнэт цаасны танилцуулга

Дэлхийн хүн амын өсөлттэй уялдуулан OECD, Food and Agriculture байгууллагаас гаргасан урьдчилсан мэдээг харвал тэжээвэр шувууны махны үйлдвэрлэл 2026 он гэхэд 2014-2016 оны дундажаас 16 хувиар өснө гэж төсөөлж байна.


Дэлхийн тэжээвэр шувууны махны үйлвэрлэлийн тоо хэмжээ 2017 оны байдлаар 118 сая тонн байгаа бол OECD, Food and Agriculture байгууллагын гаргасан судалгаагаар 2026 онд 2017 оноос 131 сая тонноор илүү байх төлөвтэй байна. Үүний шалтгаан нь дэлхий нийтээрээ өсөж буй хоолны дэглэмийн өөрчлөлтийн хандлагатай холбоотой байна. Тахианы мах нь хоолны дэглэм барьж байгаа хүмүүсийн хувьд хямд өртөгтэй уураг болдог ба улаан махтай харьцуулахад үйлдвэрлэлийн өртөг бага, үнэ хямд байдаг. 2026 он хүртэлх үйлдвэрлэлийн тоо хэмжээний урьдчилсан таамгийг доорх графикаас харж болно.

х 1000 м.тн Тэжээвэр шувууны махны үйлдвэрлэл болон хэрэглээний төсөөлөл 2026 он хүртэл




Тэжээвэр шувууны махны экспорт 2013-2017 оны хооронд 10.3 сая тонноос 11.1 сая тонн хүртэл 9 хувиар өссөн бол импорт 8.7 сая тонноос 9.3 сая тонн хүртэл 7 хувиар өссөн байна. Өсөлт нь дараах графикаас харагдаж байна.

х 1000 м.тн Тэжээвэр шувууны махны худалдааны трэнд 2013-17



Импорт болон экспортийн хэмжээ 2026 он хүртэл өсөх хандлагатай байна. Ирэх жилүүдэд хөгжингүй орнууд тэжээвэр шувууны махны гол нийлүүлэгч хэвээрээ байх бол хөгжиж буй орнууд буюу тухайлбал зүүн азийн орнууд гол худалдан авагч болно.





Үнэт цаасны танилцуулга



Тахианы махны худалдаа



2.6 Бордооны зах зээл

Үнэт цаас гаргагчийн цаашид хөгжүүлэх бизнесийн төрлүүд дотор сангасны бордооны эзлэх хувь өндөр байна. Одоогийн байдлаар компани тахианы сангасыг хаягдал хэлбэрээр үр ашиггүй зарцуулж байгаа бол бордооны үйлдвэрийг хөгжүүлснээр уг бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд үр ашиг өндөртэй импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой болох юм. Мөн цаашдаа компани махны тахианы үйлдвэрийг нэмэгдүүлэх нь нийт тахианы тоог өсгөх бөгөөд бордооны үйлдвэрийн түүхий эдийн тасралтгүй байдалд нөлөөлөх чухал хүчин зүйл болох юм.

Монгол улсад тариалангийн салбар 1921 оноос бага зэрэг суурь нь тавигдсаар (улсын тариалангийн сан нэртэйгээр) бүр хожим 1960-оноос атар эзэмших анхны аяныг эхлүүлж цааш 1976 оноос атрын 2-р аяныг, 2008 онд атрын 3 дахь аян зарлагдан тариалан ХАА-н үндсэн салбар болон хөгжиж байр сууриа олсон.

Газар тариаланд сайн үр, сайн усалгаанаас гадна хөрсний үржил шим, түүнийг нэмэгдүүлэх бордооны оролцох оролцоо маш өндөр байдаг. Тариан талбайгаас жил бүр ургац авахад тухайн талбайн үржил шимт байдал нь байнга алдагдаж байдаг бөгөөд үүнийг нөхөхөд тариаланчид химийн болон органик бордоог хэрэглэдэг.

Химийн бордоод азот, фосфор, калийн бордоо мөн нийлмэл бордоо орох бөгөөд эдгээр ургамалд түргэн хугацаанд нөлөөлж ургац нэмэгдүүлэх сайн талтай боловч хөрсөн дэхь ашигтай микро организмыг үхүүлж цаашид хөрсний байгалийн үржил шимийг бууруулдагаараа муу талтай. Иймд тариалангийн талбайгаа үе дамжин ашигшгүй гэж бодож байгаа бол химийн бордооноос татгалзах зайлшгүй шаардлага үүсгэдэг. Нөгөө талаар химийн бордоогоор бордсон хүнсний бүтээгдэхүүн таны эрүүл мэндэд ч хортой байх өндөр магадлалтай байдаг.

Харин органик бордоо буюу малын бууц, гахай, тахиа болон бусад амьтны ялгадас, ургамлын жүүс, шингэн бордоо, багсармал бордоо /холимог бордоо/, био нүүрс, нүүрсний хаягдал, био ялзмаг зэрэг байгалийн гаралтай бордоо байдаг.

Манай орны хувьд химийн бордоо 100,000 тонн химийн бордоог импортоор авч хэрэглэдэг нь маш өндөр үзүүлэлт бөгөөд зайлшгүй органик бордооны зах зээлийг хөгжүүлэх шаардлагыг нэмэгдүүлж байдаг.

Ялангуяа фермерийн аж ахуйг дагасан малын бууц, гахай тахианы ялгадсыг боловсруулах үйлдвэр барих шаардлага өндөр байдаг бөгөөд түүхий эдийн тасралтгүй байдал, эрчимжүүлсэн газар тариаланг дэмжих түлхэц болох юм.



Үнэт цаасны танилцуулга



Азотын бордоо



График 17 Азотын бороо

Бусад бордоо




График 18 Бусад бороо

СОНИРХОЛТОЙ БАРИМТ- 11

Өндгийг угаах нь зөв үү?

Тахиа өндгийг гаргахдаа хальсны гадуур нян бактериас хамгаалсан тосон бүрхүүл үүсгэдэг. Энэ бүрхүүл нь өндөгний дотор талд элдэв бохирдол орохоос найдвартай хамгаалдаг. Энэ шалтгааны улмаас европын холбоонд мөрдөгддөг дүрмийн дагуу бол өндөг угаах нь хориотой. Харин АНУ-ын стандартаар бол өндгийг угаасан бол заавал нэмэлт тосон бүрхүүл үүсгэн хамгаалах ёстой байдаг.

Хэрэглэхийн өмнө өндгийг угаах нь буруу. Ус хамгаалалтын тосон бүрхүүлийг урсгаж өндөгний хатуу хальсанд байх жижиг нүхээр гадаад орчны бохирдол чөлөөтэй нэвтрэх боломжийг үүсгэнэ. Хэрвээ угаасан бол өндгийг маш сайн болгож хэрэглэх бөгөөд түүхийгээр нь хэрэглэхгүй байхыг зөвлөж байна.

Сонирхуулахад Их Британид угаагаагүй өндгийг тасалгааны температурт хадгалахыг зөвшөөрдөг.

2.7 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;

Үнэт цаас гаргагч нь тахианы аж ахуй, тэжээлийн үйлдвэрлэл эрхлэн явуулахад дараах эрсдэлүүд тулгарч болно. Үүнд:

<p>Гадаад</p> <ul style="list-style-type: none"> • Улс төр, хууль • Эдийн засаг • Байгалийн гамшиг • Хөрөнгийн зах зээлийн эрсдэл 	<p>Бууруулах арга:</p> <ul style="list-style-type: none"> • Үүрэг хариуцлагыг салгах • Давхар хяналт • Дүрэм журам • Гэрээжүүлэх • Даатгал • Хүний нөөцийг чадавхижуулах 	<p>Дотоод</p> <ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагааны эрсдэл • Хүний нөөц • Засаглалын эрсдэл • Бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн эрсдэл • Нэр хүндийн эрсдэл
--	---	--





Үнэт цаасны танилцуулга



Монголын эдийн засгийн эрсдэл

Монгол Улс 2017 онд Олон улсын валютын сангийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг авч хэрэгжүүлснээр гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн, гадаад валютын ханш тогтворжсон зэрэг эерэг үзүүлэлтүүд гарсан бол энэ үед эдийн засгийн гол салбарын нэг уул уурхайн бүтээгдэхүүний үнэ олон улсын зах зээл дээр өсөлттэй байсан зэрэг нь манай улсын ДНБ-г 2017 онд 5.1 хувь, 2018 оны 1-р улиралд 6.1 хувь өсөхөд нөлөөлсөн. Цаашлаад ОУВС-н өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг 2020 он хүртэл хэрэгжүүлэх тул эдийн засаг тогтвортой байх төсөөлөлтэй байна.

Үнэт цаас гаргагчийн орлогын 90 хувийг бүрдүүлэгч өндөг нь өргөн хэрэглээний бараа тул эдийн засгийн хямралын үед худалдан авах чадвар төдийлөн бууралт ажиглагддаггүй. Ялангуяа өндөгийг ихээр хэрэглэдэг ресторан, гуанз, талх нарийн боовны үйлдвэрүүд, зочид буудал зэрэг газрууд нь эдийн засгийн голлох салбарын нэг хэсэг бөгөөд үйл ажиллагаа нь харьцангуй тогтмол явагддаг. Тэр ч утгаараа эдийн засгийн хямрал болох үед өндөгний хэрэглээ төдийлөн багасахгүй юм. Тухайлбал, Европын холбооны шийдвэрээр 2012 онд тахиаг үржүүлэх талбайн хэмжээг нэмснээр өндөг үйлдвэрлэгчдийн зардал тодорхой хэмжээгээр нэмэгдэн, өндөгний үнэ зах зээл дээр өссөн боловч эрэлтэд ямар нэгэн нөлөө үзүүлээгүй нь өндөгийн үнийн өөрчлөлтийн мэдрэмж багатай бүтээгдэхүүн гэдгийг баталж өгсөн юм. Нөгөө талаар хүн амын орлогын хэмжээ буурсан хямралтай он жилүүдэд өндөгний нийт хэрэглээ буураагүй нь мөн л өндөгийг өргөн хэрэглээний бүтээгдэхүүн болохыг баталж өгч чадсан.⁷

Харин эдийн засагт гардаг нэг томоохон үзэгдэл нь дулааны улирал буюу хүн ам ихээр амардаг 7-9 саруудын хооронд цаг үеийн мөчлөгтэй уялдаад өндөгний борлуулалтын хэмжээ багасдаг нь өндөг үйлдвэрлэгч нарыг үнийн стратегиар өрсөлдөхөд хүргэдэг.

Малын тэжээлийн үйл ажиллагаа нь Монгол орон цаг агаарын өөрчлөлт ихтэй, эрс тэс уур амьсгалтай орны хувьд эдийн засгаас хамаарах хамаарал нь бага юм. Учир нь фермерийн мал аж ахуйн хамгийн чухал үзүүлэлт нь нэгж малын ашиг шим байдаг. Тэр ч утгаараа эцсийн бүтээгдэхүүний үнийг өсгөх замаар малдаа чанар өндөртэй, ашиг шимийг нь 100 хувь гаргаж чадах бүтээгдэхүүнийг авах нь тодорхой. Мөн ган, зудтай жилүүдэд малчдын гол зорилго нь бүх малаа бүрэн бүтэн авч үлдэх байдаг бөгөөд чанар өндөртэй бүтээгдэхүүнийг малдаа өгснөөр уг зорилгодоо хүрэх боломжтой.

Үйл ажиллагааны эрсдэл

Үнэт цаас гаргагч нь нийт 5-н төрлийн үйл ажиллагааг эрхэлж байна, үүнд тахианы өндөг, өндөгний сав баглаа боодол, тахианы мах, тахиа малын тэжээл болон дэгдээхэй борлуулалт. Эдгээр үйл ажиллагаа тус бүр нь өөрийн гэсэн үйл ажиллагааны эрсдэлийг дагуулж байдаг тул тус бүрт нь ангилан авч үзэх нь зохимжтой.

Өндөг үйлдвэрлэхэд гарах эрсдэл

Тахиа үржүүлэх, өндөг үйлдвэрлэх процесст гардаг эрсдэлүүд нь шувууны өвчин, өндөгний байрны горим алдагдах, тэжээлийн горим алдагдах, өндөгөнд байх уураг бодисын хэмжээ хэвийн хэмжээнээс дутах, эрүүл ахуйн вакцинжуулалтын эрсдэл зэрэг юм. Тэр ч утгаараа эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрэн хангасан боловсон хүчнийг байнга бэлтгэн, тахианы аж ахуйн эрүүл ахуйн шаардлагыг өндөр түвшинд ханган ажиллах зайлшгүй шаардлагыг үүсгэдэг.

Үнэт цаас гаргагчийн тахианы ферм нь өндөр харуул хамгаалалтын доор, тахиануудыг гадны биетээс хамгаалсан зохион байгуулалттайгаар бүтээгдсэн байдаг тул гадны биетээс хамаарсан халдвар авах нөхцлийг бууруулдаг. Нөгөө талаар дэгдээхэйнүүдийг шинэ байранд



<https://www.wattagnet.com/articles/12450-how-price-elastic-is-demand-for-eggs>



оруулахаас өмнө ариутгалыг маш сайн үйлддэг нь шувууны байр хооронд гарч болох холилтоос сэргийлдэг.

Үнэт цаас гаргагч нь нийт өндөглөгч тахианы тоог 300,000 дотор барих нь олон талын ач холбогдолтой бөгөөд тэр дундаа компанийн одоогийн хүчин чадалд суурилсан тоног төхөөрөмжийн хувьд хамгийн боломжит тоо тул стандартын чанар хангасан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжийг бий болгодог. Нийт өндөглөгчийн тоо нэмэгдэх нь компанийн үйл ажиллагаанд нэмэлт ачааллыг өгөхөөс гадна дахин хөрөнгө оруулалт шаардагдах тул одоогийн үйл ажиллагаа явуулж буй түвшин нь уг эрсдэлээс сэргийлж өгч байна.

Шувууны тэжээлийн хувьд Guangzhou Guangxing Poultry брендийн тоног төхөөрөмж нь шувуунд хэтэрхий их хоол өгөхөөс сэргийлсэн тогтолцоотой бөгөөд тахианы зүрхний шигдээснээс сэргийлж байдаг. Мөн тэжээлийн чанарыг Агро Фийд үйлдвэрт гарц бүрт шалган, шувууны үйлдвэрт нийлүүлдэг нь муу чанартай тэжээлээр тахиаг хангахаас сэргийлдэг.

Дэгдээхэй болон нас бие гүйцсэн тахианд эрүүл ахуйн вакцинжуулалтыг нэг хоногийн настайд нь хийдэг ба шувууны томуу өвчин зэрэг олныг хамарсан халдварт өвчин гарахгүй байх нөхцлийг хангадаг.

Шувууны аж ахуйн хамгийн чухал нэг бүрэлдэхүүн хэсэг нь тахианы байрны горим юм. Агаарын солилцоо, дулааны хэм зэрэг хүчин зүйлс тог тасрах, эрчим хүчний саатлаас болж алдагдах тохиолдолд тахиа олноор үхэх аюултай байдаг. Тэр ч утгаараа Үнэт цаас гаргагч нь байрны хэвийн температурыг хадгалах дохиоллын систем, нөөц эрчим хүчний эх үүсвэрийг суурилуулсан нь уг эрсдэлээс сэргийлж өгч байна.

Тэжээлийн үйлдвэрийн эрсдэл

"Тэжээлийн үйлдвэрт MNS 5929:2008 стандартыг дагаж мөрддөг бөгөөд үйлдвэрт гарч болох хамгийн том эрсдэл нь чанар муу түүхий эдийг ашиглан тэжээл үйлдвэрлэх байдаг. Харин Үнэт цаас гаргагч нь Сорилт шинжилгээний лабораторитоо Итали улсын BEL, BIO BASE брендийн 15 тоног төхөөрөмжийг суурилуулж өгсөн нь уг эрсдэлийг бүрэн хааж өгч чадаж байгаа юм. Эдгээр брендийн тоног төхөөрөмжүүд нь бүрэн автомажсан, ухаалаг шийдэлтэй, нарийвчлал өндөртэй, алдааны хязгаар маш бага, аюулгүй байдлыг дээд зэргээс хангасан зэрэг давуу талуудтай бөгөөд 45 сая төгрөгний үнэтэй маш чанартай төхөөрөмжүүд юм. "Сорилт шинжилгээний лаборатори " MNS ISO 17025 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж энэ оны 4-р сард Стандарт хэмжил зүйн үнэлгээгээр амжилттай дүгнүүлээд байна.

6-р сард MNS ISO 17025 стандартыг хэрэгжүүлсэн "Итгэмжлэлийн гэрчилгээ" –гээ хүлээн авах гэж байна. Нөгөө талаар тэжээлийн үйлдвэрийн үйл ажиллагааны эрсдэлд нийлүүлэлт, борлуулалтын эрсдэлүүд орж байна. Тэр ч утгаараа дээрх эрсдэлүүдийг бууруулах зорилгоор харилцагчдын тоог нэмэгдүүлэх, шинэ салбар нээх, хөдөө орон нутагт өөрийн салбаруудыг шинээр үүсгэх, реклам суртчилгаа, сургалт судалгаа явуулах идэвхижүүлэх тал дээр маш шургуу ажлыг хийж гүйцэтгэж байна.

Өндөгний сав баглаа боодлыг үйлдвэрийн эрсдэл

Өндөгний сав баглааны үйлдвэрийн үндсэн түүхий эд нь картон цаас болон сонингийн цаас байдаг. Уг түүхий эдийг 400 градусын халуунд бүрэн ариутгасны эцэст шахмал байдалд оруулан өндөгний үүрийг үйлдвэрлэдэг. Учирч болох гол эрсдэл нь цахилгааны тасалдал байдаг бол уг үйлдвэр нь өндөгний үйлдвэрийн дэргэд байрладгаараа цахилгааны нөөц эх үүсвэрт хамрагдсан эрсдэлийг бууруулж чадсан юм.

Тахианы махны үйлдвэрийн эрсдэл

Тахианы маханд гарч болох гол эрсдэл нь тахианы эрүүл ахуйн байдал юм. Тэр ч утгаараа өндөглөгч тахиануудыг олон давхар эрүүл мэндийн үзлэгт оруулдаг нь уг эрсдэлийг бууруулж өгч буй юм. Өндөглөгч тахианы мах нь бордсон тахианы махтай харьцуулахад үнэ хямд байдаг тул зах зээл дээр хурдан борлогддог хүнсний бүтээгдэхүүн болдог.



Дэгдээхэйний эрсдэл

Үр хөврөл тогтсон өндөгнөөс дэгдээхэй гарах магадлал нь тухайн нийлүүлэгч компанийн үржүүлгийн арга горимоос шууд хамаарч байдаг. Ерөнхийдөө нийт өндөгний 70 хувь нь дэгдээхэй болоход эдийн засгийн хувьд боломжтой гэж үздэг бол энэ тоо багасах нь дэгдээхэй гарч ирэх тоог бууруулж, өндөглөгч тахианы тоог бууруулах боломжтой. Нөгөө талаарай дэгдээхэй нь маш эмзэг байдаг тул инкубатор төвийн дулааны горим, тэжээлийн байдал зэрэг нөхцлүүдийг маш нарийн тооцоолох шаардлагатай байдаг. Үнэт цаас гаргагч компани нь олон жилийн туршлага бүхий боловсон хүчинтэй бөгөөд тогтсон стандартыг баримтлан аж ахуйгаа явуулж байгаа нь уг эрсдлийг бууруулж өгөх гол хүчин зүйл болдог.

Компанийн удирдлага, засаглалаас шалтгаалах эрсдэл

Компанийн гүйцэтгэх удирдлагын бодлого шийдвэр, менежментийн хэв маяг нь бизнесийн ашиг, маркетинг, хүний нөөцийн бодлого, нийгмийн хариуцлага гэх мэт компанийн бүх үйл ажиллагаа, нэр хүндийг тодорхойлж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх нөлөөтэй. Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчид болон гүйцэтгэх удирдлагын хооронд эрх ашиг, сонирхлын зөрчил үүсэх асуудал ч байдаг. Тиймээс, гүйцэтгэх удирдлагын туршлагын байдал, багийн буруу бодлого, алдаатай шийдвэрээс шалтгаалан компанийн үйл ажиллагаа доголдох, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөх эрсдэл байхыг үгүйсгэхгүй. Түүнчлэн, компанийн хувьцааны хяналтын багц эзэмшигчид нэгж хувьцаанд ногдох саналын эрхийн дагуу аливаа бодлого шийдвэр гаргахад давамгайлж, жижиг хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөх эрсдэл байдаг. Компанийн сайн засаглал, соёлыг зөв бүрдүүлэх, хувьцааны төвлөрлийг бууруулах, хууль журмын дагуу ажиллахыг шаардах, хяналт тавихад хувьцаа эзэмшигчид идэвхтэй оролцож, эрхээ хэрэгжүүлэх хэрэгтэй байдаг. Мөн гүйцэтгэх удирдлага, тэр дундаа шинээр байгуулагдах Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэг, ажлын зохион байгуулалтыг компанийн дүрэм, журамд тодорхой тусгаж, гишүүдийг Компанийн засаглалын сургалтанд суулгах зэргээр компанийн сайн засаглалыг нэвтрүүлэх нь энэ төрлийн эрсдлийг зөв удирдахад чухал ач холбогдолтой.

Хууль эрх зүйн эрсдэл ба Хорио цээрийн эрсдэл

Тахианы аж ахуй нь эрчимжүүлсэн аж ахуйн нэг тул Монгол Улсын Хүнс Хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны 2017-2030 оны бодлогуудад ихээр дэмжигдэж буй салбар юм. Тэр ч утгаараа фермерийн аж ахуйг хориглосон хууль, тогтоомж гарах магадлал тун бага. Харин дэлхий дахин болон бүс нутгийг дамжсан халдварт өвчин гарч, хорио цээр тогтоох нөхцөл бүрдэх тохиолдолд аж ахуйд эрсдэл үүсэх боломжтой.

Нэгэнт халдвар өвчин гарч тахианы сүрэг гол халдварт өвчинд нэрвэгдэн устгалд орсон тохиолдолд "Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль"-н 15.1.4-т Өвчтэй малыг зайлшгүй шаардлагаар устгасан тохиолдолд тухайн үеийн улсын дундаж үнийн 90 хувийг нөхөн төлөх, устгахад шаардагдах хөрөнгө /Устгагдсан малын нөхөн төлбөрийг хорио цээр, хязгаарлалтын дэглэм цуцлагдсанаас хойш 30 хоногийн дотор олгоно/ гэж заасны дагуу нөхөн төлбөрийг компанид олгох юм. Энэ нь халдварт өвчнөөс үүдсэн хор хохирлыг бууруулах маш том түлхэц, хүчин зүйл болж байна.

Гадаад валютын эрсдэл

Үнэт цаас гаргагч нь гадаадаас тоног төхөөрөмж, үр хөврөлтэй өндөг, зарим тэжээл баяжуулах гол эрдэс бодисоо худалдан авдаг. Тиймээс гадаад валютын огцом савлалт нь үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг. Харин Монгол улс ОУВС-н Өргөтгөсөн Санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсан, гадаад худалдааны тэнцэл сайн байгаа зэрэг нь төгрөгийг гадаад валютын эсрэг сулрах нөхцлийг хааж өгч байна.

Мөн компани олон жил харилцсан гадны түнш байгууллагууд ихтэй байдаг нь гадаад валютаас үүсэх эрсдэлийг багасгах, төлбөрийн уян хатан нөхцлийг бүрдүүлэх боломжийг бий болгодог.

Өрсөлдөгчийн эрсдэл

Тахианы аж ахуйн өрсөлдөгчийн эрсдэл харьцангуй багатай салбар юм. Учир нь их хэмжээний тахиатай аж ахуй эрхлэхэд маш их хөрөнгө, мэдлэг, цаг хугацаа шаарддаг салбар тул шинэ оролцогчид орж ирэх нөхцөл харьцангуй бага байна. Ялангуяа НВЦ, Түмэн шувуут гэсэн 2 акул үйлдвэрүүд дотоодын зах зээлийн ихэнх хэсгийг хангаж буй тохиолдолд дотоодын үйлдвэрлэгчид хүч түрэн гарч ирэх боломж багатай.

Харин импортын өндөгний өрсөлдөгчид зах зээлд нийлүүлэлтийн эрсдэл үүсгэх боломжтой байдаг. Хэдийгээр Монголын Засгийн газраас өндөгөнд ногдуулах гаалийн албан татварыг 15% болгон нэмэгдүүлсэн боловч ОХУ-н хямд өртөгтэй өндөгнүүд зах зээлд ихээр нийлүүлэгдэх явдал багасахгүй байна. Энэ нь дотоодын үйлдвэрлэгчидэд хүндрэлийг авчирдаг боловч эрүүл мэндийн хувьд баталгаатай, шинэ, дотоодод ургасан ургамал ашигласан тэжээлээр тэжээгдсэн шувууны өндөгний эрэлт цаашид хэрэглэгчдийн боловсрол нэмэгдэх, эрүүл мэнддээ хандах хандлага нь өсөхийн хэрээр эрэлт нь нэмэгдэх юм.

Мөн Үнэт цаас гаргагч нь хувьцаагаа олон нийтэд арилжсанаар хэрэглэгчдийн дунд роялти үүсгэх боломжтой бөгөөд тухайн хэрэглэгчид бүгд компанийн хувь эзэмшигчид болсноор компанийн борлуулалт нэмэгдэх боломжийг бий болгох юм.

Нэр хүндийн эрсдэл

Өргөн хэрэглээний барааны зах зээлд бүтээгдэхүүний нэр хүндтэй холбоотой эрсдэл маш өндөр жинг эзэлдэг. Зах зээл дэх бүтээгдэхүүний тоо хэмжээ их байх хэрээр өрсөлдөгчдийн хэрэглэх бүтээгдэхүүнээ солих, өөр брендийн бүтээгдэхүүн хэрэглэх нөхцлийг бүрдүүлж байдаг. Тиймээс компани өөрийн бүтээгдэхүүний чанарт үргэлж анхаарал хандуулан, брендийн үнэ цэнийг хангаж ажиллах шаардлагыг бий болгож байдаг.

Зах зээл дээр бүтээгдэхүүний нэр хүндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс бүтээгдэхүүний чанар муу, сав баглаа боодлын чанаргүй байдал зэрэг нөлөөлдөг. Харин компаниас хэрэглэгчдийн санал хүсэлт, гомдлыг өөрийн цахим хуудас, олон нийттэй харилцдаг фэйсбүүк хуудас зэргээр хүлээн авч, бууруулах тал дээр ажилладаг нь бүтээгдэхүүний нэр хүндийг хадгалахад чухал нөлөөг эзэлж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэл


Үнэт цаас гаргагчийн ихэнх ажилчид нь шувуу болон шувууны тэжээлтэй шууд харьцдаг буюу тухайн хүмүүсд малын гаралтай өвчин халдварлах боломжтой орчинд ажилладаг. Ажилчдыг чадавхижуулах, мэдлэг мэдээллээр байнга хангах нь тухайн хүмүүсийг аливаа төрлийн эрсдэлээс хамгаалах хамгийн том хүчин зүйл болдог. Тиймээс компани ажилчиддаа зориулсан сургалтуудыг тогтмол зохион байгуулж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын ажилчидтай хамтран Мал аж ахуй, хорио цээрийн алхамуудыг дагаж мөрдөн эрүүл мэнд, эрүүл орчныг хангах сургалтуудыг зохион байгуулдаг нь ажилчдыг хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлээс сэргийлж өгөх юм.

Үнэт цаасны зах зээлийн эрсдэл

Үнэт цаасны зах зээлд оролцогчдийн итгэл үнэмшил буурч дотоодын үнэт цаасны зах зээлийн эрэлт буурснаар үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадвар саарах, арилцааны идэвх буурах, хувьцаа үнэгүйдэх зэрэг зах зээлд эрсдэл үүсдэг. Энэ нь үнэт цаас гаргагчийн хувьцаанд болон гаргахаар төлөвлөж буй өрийн бичигт сөргөөр нөлөөлж ханшийн хэлбээлийг нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгодог.

Үнэт цаасны зах зээлийн эрэлттэй холбоотой үүсч болох эрсдэл

Монголын хөрөнгийн зах зээл дээр 2005 оноос хойш нийт 31 компани хөрөнгийн зах зээлээс хувьцаагаар хөрөнгө татан төвлөрүүлсэн бөгөөд нийт 190 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татсан байна. Үүнээс сүүлийн 1 жилд хийгдсэн Сүү бонд, Ай Түүлс ХК, Лэнд.мн ББСБ ХК, н хувьцааны арилжаа амжилттай явагдсан нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө




Үнэт цаасны танилцуулга



оруулагчдын идэвх сонирхлыг нэмэгдүүлсэн гэж үзэж байна. Гэсэн хэдий ч нийт иргэдийн санхүүгийн боловсрол, хуримтлалын түвшин бусад өндөр хөгжилтэй улсуудтай харьцуулахад бага, зах зээлд идэвхитэй тоглогч оролцогчдын тоо харьцангуй цөөн хэвээр байгаа тул үнэт цаасны хөрвөх чадвар сул байх эрсдлийг дагуулж байна.

2.7.1 Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө

Эрсдэлийн төрөл	Эрсдэлийг бууруулах төлөвлөгөө
Монголын эдийн засгийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> Эдийн засгийн байдалтай уялдсан бизнес төлөвлөгөөг боловсруулах Ханшийн хэлбэлзлээс сэргийлсэн фьючирс, хэджинг хэрэгсэл ашиглах Өндөг, тэжээлийн үнийг зах зээлийн эрэлттэй нийлүүлж, үнийн уян хатан бодлогыг баримтлах
Үйл ажиллагааны эрсдэл	<ul style="list-style-type: none"> Үйл ажиллагаандаа олон улсын ISO стандартыг дагаж мөрдөх Өндөг, тэжээлийн чанарыг дотоодын болон хөндлөнгийн лабораторит тогтмол шинжлүүлэх, бүтээгдэхүүний чанарын баталгааг хангах
Хууль эрх зүйн эрсдэл ба Хорио цээрийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> Малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх бодлого баримтлах Тэжээлийн болон шувууны байрлуу гадны хүнийг оруулахгүй хорио цээрийг үргэлж тогтоох
Өрсөлдөгчийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> Импортын өндөгтэй чанараар өрсөлдөх, өөрсдийн бүтээгдэхүүний давуу талыг харилцагчдад ойлгуулах, таньж мэдүүлэх Дотоодын өрсөлдөгчидтэй өөрийн брендээр ялгарал үүсгэх, харилцагчдын дунд рояалти хөтөлбөрийг эхлүүлэх Нийлүүлэгч байгууллагуудтай урт хугацааны тогтвортой харилцааг бэхжүүлж, харилцааг дээдлэх хадгалах
Нэр хүндийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> Бүтээгдэхүүний чанарт онцгой анхаарч, хэрэглэгчдийн гомдлыг цаг тухайд нь барагдуулах Өрсөлдөгч байгууллагуудаас өөрсдийн чанартэй бүтээгдэхүүнээр ялгарах, брендийн чанарыг зах зээлд илүүтэйгээр мэдрүүлэх
Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэл	<ul style="list-style-type: none"> Хөдөлмөрийн стандартыг нэвтрүүлэх Ажилчдыг тогтмол сургалтад хамруулж, үйл ажиллагааны тогтвортой, найдвартай байдлыг хангах
Үнэт цаасны зах зээлийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> Хувьцааг олон нийтэд сурталчлах ажилд маркетингийн олон сувгийг ашиглан, хөрөнгө оруулагчдад бүтээгдэхүүний давуу тал, компанийн найдвартай байдлыг сурталчлах Нэгэнт хөрөнгийн зах зээлд бүртгэгдсэн цагаас хойш ҮЦЗЗТХ, СЗХ, МХБ-ийн холбогдох журмуудыг баримтлан хөрөнгө оруулалтын тогтвортой компанийг бий болгох





3. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

3.1 Нийтэд санал болгох үнэт цаасны төрөл тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ, нийтэд санал болгох болон арилжих нөхцөл

Үнэт цаас гаргагч	“Түмэн шувуу” ХХК
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Нийт гаргасан хувьцааны тоо	150,000,000
Нэмж гаргаж буй хувьцааны тоо	50,000,000
Нэмж гаргасны дараах нийт хувьцааны тоо	200,000,000
Нэмж гаргаж буй хувьцааны хувь	25%
Олон нийтэд санал болгох нэгж хувьцааны үнэ	200 төгрөг
Нийт татан төвлөрүүлэх дүн	10,000,000,000 төгрөг
Компанийн нийт хувьцааны зах зээлийн үнэ	40,000,000,000 төгрөг
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	<ul style="list-style-type: none"> ▪ Тахианы мах үйлдвэрлэх төсөл ▪ Өндөгний үйлдвэрийг өргөжүүлэх төсөл ▪ Бордооны үйлдвэрийн төсөл ▪ Тэжээлийн үйлдвэрийн төсөл
Хувьцааг арилжаалах арга	Тогтоосон үнийн арга

3.2 Нийтэд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг;

Үнэт цаас гаргагч компанийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн дүрэм болон хувьцаат компанийн дүрмийн төсөлд зааснаар дараах ЭРХҮҮДИЙГ ЭДЭЛНЭ. Үүнд:

- Бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах
- Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэр гаргах үед Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх
- ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дагуу эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хуульд заасан хугацаанд хуваарилаагүй бол алданги төлөхийг шаардах
- Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх







Үнэт цаасны танилцуулга



- Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу компанийн нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах, энэ эрхээ бусдад бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлаар шийдвэр гаргахад эерэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн авахыг шаардах эрхтэй. Үүнд:
 - Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх
 - Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх
 - Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг дүрэмд оруулсан эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийг шинэчилсэн найруулгыг батлах
 - Хувьцаа эзэмшигч дангаараа эсвэл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа, түүнчлэн төрийн өмчийн эзэмшилд байсан компанийн хувьцааны хяналтын багцыг хувьчлан авсан тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компаниас хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй
- Хувьцаа эзэмшигч нь компаниас доорх мэдээллийг шаардан авах эрхтэй. Үүнд:
 - Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн тайлан, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах
 - Компанийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн дүрэм журмаар тогтоосон бусад мэдээлэлтэй танилцах
 - Компанийн бусад энгийн хувьцаа эзэмшигчдийн эцэг/эх-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардах эрхтэй бөгөөд үүнтэй холбогдон гарах зардлыг шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч хариуцна.
- Энгийн хувьцааны 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх
- Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон ТУЗ, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх
- Энгийн хувьцааны 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч нь компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д саналаа хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах
- Хувьцаа эзэмшигч нь доорх үндэслэлээр Санхүүгийн зохицуулах хороо болон цүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй. Үүнд:






- Компанийн тухай хууль, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас тогтоосон журам, компанийн дүрэмд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаагүй тохиолдолд гомдол гаргах
 - ТУЗ, Гүйцэтгэх удирдлага нь компанийн тухай хуулийн 84.4-т заасан үүргээ биелүүлээгүй бол уг албан тушаалтанаар компанид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах
 - Компанийн энгийн хувьцааны нэг буюу түүнээс хувийг эзэмшигч нь компанид учруулсан хохирлыг компанийн эрх бүхий албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах
 - Компанийн энгийн хувьцааны эзэмшигч нь сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас компани, түүний хараат болон охин компанид учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах
- Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тогтоосон бусад эрх

3.3 Үнэт цаас эзэмшигчийн үүрэг

Компанийн хувьцаа эзэмшигчид дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр үнэт цаасны бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэх
- Энгийн хувьцааны хяналтын багцийг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авах хүсэлтэй этгээд нь компанийн тухай хууль болон Үнэт цаасны тухай хуульд заасан журмын дагуу энэ тухайгаа нийтэд мэдээлэх
- Компанийн хувьцааг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сониролтой этгээдтэй хамтран худалдан авснаар тухайн этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь хяналтын багц болон түүнээс дээш хэмжээнд хүрсэн бол хяналтын багц эзэмшигч болсон өдрөөс хойш ажлын 60 хоногийн дотор бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааг сүүлийн 6 сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал гаргах
- Хувьцаат компанийн энгийн хувьцааны гуравны нэгээс дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан буюу эзэмшиж байгаа этгээд нь энэ хэмжээний хувьцааг худалдан авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор өөрийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, тус бүрийн эзэмшлийн хувьцааны тоо зэргийн талаарх мэдэгдлийг тухайн компани болон Санхүүгийн зохицуулах хороонд тус тус бичгээр мэдэгдэх
- Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээг хувийн хувьцаа эзэмшигч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.
- Компанийн хувьцааг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшигч нь өөрийн эзэмшлийн үнэт цаасны тухай мэдээллээ нэгдмэл сонирхолтой этгээд болсон өдрөөс, эсхүл компанийн хувьцааны тав буюу түүнээс дээш багц болон хяналтын багцийг хамтран эзэмших болсноос хойш ажлын 3 өдрийн дотор компанид бичгээр мэдэгдэх
- Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг харицахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ



- Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад үүрэг

3.4 Үнэт цаасны үнэ тогтоосон үндэслэл

3.4.1 Үнэт цаасны үнэ тогтоосон үндэслэл

Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2018 оны 06 сарын 07 өдрийн 05/2018 тоот тогтоолоор анхдагч зах зээл дээр олон нийтэд санал болгох үнийг 200 төгрөг байхаар тогтоосон. Хувьцааны энэхүү үнэлгээ нь Үнэт цаас гаргагчийн "Итгэлт Эстимэйт" ХХК-тай 2018 оны 4 сарын 11-ны өдөр байгуулсан 18/02 тоот Хөрөнгийн үнэлгээний ажлын гэрээний дагуу гүйцэтгүүлсэн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлан дээр үндэслэсэн болно. Үнэлгээг бизнесийн ирээдүйн цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах (Discounted Cash Flow) аргаар тооцсон болно.

Итгэлт Эстимэйт ХХК-н 2018 оны 5 сарын 25-ны Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайланд Үнэт цаас гаргагчийн үндсэн хөрөнгийг үнэлгээний олон улсын стандарт 400-г ашиглан Үнэлгээчин Ө. Эрдэнэбаяр Сангийн яамны хөрөнгийн үнэлгээ хийх 071200002 тоот тусгай зөвшөөрлийн хүрээнд өөрийн хуримтлуулсан 19 жилийн туршлага дээр үндэслэн гүйцэтгэсэн.


Тайланд Үнэт цаас гаргагчийг 21.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 43.5-50.3 тэрбум төгрөгийн бизнесийн үнэлгээтэй гэж тооцоолсон байна. Дэлгэрэнгүйг хавсралт дахь Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлангаас харна уу.

Үндсэн хөрөнгийн задаргаа

№	Нэр	Үнэлгээний дүн	Балансын үнэ	Дахин үнэлгээний нэмэгдэл	мян.төг
1	Газар	1 296 076,6	9,750.8		1,286,325.8
2	Барилга байгууламж-СХД	472 624,1	237,902.9		234,721.2
3	Барилга байгууламж-ХУД	7 746 506,7	3,605,299.0		4,141,207.7
4	Барилга байгууламж-Тэжээлийн үйлдвэр	1 771 736,9	1,428,444.1		343,292.8
5	Машин, тоног төхөөрөмж	4 841 244,7	2,036,378.5		2,804,866.2
6	Машин, тоног төхөөрөмж-Тэжээлийн үйлдвэр	2 065 541,6	949,000.1		1,116,541.5
7	Үндсэн сүргийн мал, амьтад	2 253 679,0	371,598.6		1,882,080.4
8	Машин тоног төхөөрөмж үүрний үйлдвэр	183 156,3	113,783.9		69,372.4
9	Машин тоног төхөөрөмж МБУ	124 905,4	114,418.9		10,486.5
10	Программ хангамж	11 500,0	5,773.3		5,726.7
11	Тээврийн хэрэгсэл	429 000,0	304,567.3		124,432.7
12	Тээврийн хэрэгсэл	98 500,0	87,696.0		10,804.0
13	Машин тоног төхөөрөмж	560,0	487.5		72.5
14	Усжуулах ХК-ийн хөрөнгө	266,369.5			266,369.5
	ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН	21,561,400.8	9,265,101		12,296,299.9

Аливаа компанийн хувьцааг олон нийтэд санал болгоход компанийн үнэлгээг зөв тогтоох нь маш чухал байдаг бөгөөд үүнд ямар үнэлгээний аргачлал ашиглах нь чухал нөлөө үзүүлнэ. Үнэт цаас гаргагчийн хувьд орлогын дийлэнх өсөлт нь ирээдүйд болно, борлуулалтын өсөлттэй байгаа компани, мөн үйлдвэрлэл эрхэлдэг бизнес гэдэг үндэслэлээр нэгж хувьцааны





үнэлгээг цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах арга (Discounted Cash Flow)-г ашиглан тооцоолсон байна.

3.4.1.1 Цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах арга (Discounted Cash Flow)

Цэвэр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн үнэлгээний аргаар компанийн ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын төсөөллийг жигнэсэн дундаж санхүүжилтийн зардлаар (WACC) хорогдуулан өнөөгийн үнэ цэнийг тооцоолох ба нийлбэр нь компанийн нийт үнэлгээ (Enterprise Value) болдог. Компанийн нийт үнэлгээнээс цэвэр өр төлбөрийг (Net Debt) хасч тооцооноор компанийн хувьцааны үнэлгээг (Equity Value) гаргаж авдаг.

Мөнгөн гүйлгээг хорогдуулан тооцох хувийг тогтоосон тухай.

Мөнгөн гүйлгээг хорогдуулан тооцох хувийг тогтоохдоо нийлбэрийн аргыг ашиглан дараах томъёогоор тодорхойлсон. Үүнд:

МГХТХ- Мөнгөн гүйлгээг хорогдуулан тооцох хувь

$$МГХТХ = K1 + K2 + K3 + K4$$

K1- Засгийн газрын бондын хүү

K2- Макро төвшиний нөлөөллийн хувь

K3- Салбарын гадаад эрсдлийн хувь

K4- Компанийн дотоод эрсдлийн хувь

K1- Засгийн газрын бондын хүү-"Түмэн Шувуут" ХХК-нь жилийн 8 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийн шаардлагыг хангасан бөгөөд одоо 8 хувийн хүүтэй зээл авч байгааг үндэслэн K1-8% байна гэж тооцоолов.

K2- Макро төвшиний нөлөөллийн хувь Монгол улсын сүүлийн 5 жилийн инфляцийн дунджаар тооцоолов.

Нэр	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	Дундаж
Инфляцийн хувь	12.5%	11%	2.4%	1.1%	6.4%	6.7%

K3- Салбарын гадаад эрсдлийн хувь. Өрсөлдөгч нэмэгдэх, Шувууны ханиад гарах гэм мэт эрсдлийг тооцоолж 2% байна гэж тооцов.

K4- Компанийн дотоод эрсдлийн хувь



Байгуулалтын санхүүгийн нөөц-1%


Борлуулалтын таамаглал-1%

Компанийн дотоод эрсдлийн хувь нийт 2.5% байхаар тооцов.

Коеф-ийн ангилал	Коефициентийн агуулага	Хувь
K1	хөнгөлөлттэй зээлийн хүү	8.0%
K2	Монгол улсын сүүлийн 5 жилийн инфляцийн дундаж	6.7%
K3	Салбарын гадаад эрсдлийн хувь	2.0%
K4	Компанийн дотоод эрсдлийн хувь	2.5%
Мөнгөн гүйлгээг хорогдуулан тооцох хувь /МГХТХ/		19.2%

Цаашид жил бүр тогтмол өсөлтийг хувийг 8% байна гэж тооцоолов.





Үнэт цаасны танилцуулга




2018-2025 оны хооронд олох цэвэр мөнгөн урсгал дээр тулгуурлан хорогдуулах аргыг ашиглан тооцоолол хийхэд Үнэт цаас гаргагчийн ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн нийлбэр буюу компанийн нийт үнэлгээ нь 45.7 тэрбум төгрөг болж байгаа бөгөөд үүнээс цэвэр өр төлбөр 3.4 тэрбум төгрөгийг хасахад компанийн нийт хувьцааны үнэлгээ 40.1 тэрбум төгрөг нэгж хувьцаанд ногдох үнэ 200 төгрөг болж байна.

Дээрх тооцоололд ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын төсөөллийг компанийн цаашид авч хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүд болох махны тахиа, өндөгний үйлдвэрийн өргөтгөл, тэжээлийн үйлдвэрийн өргөтгөл болон бордооны аж ахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлж борлуулалтын орлогын хэмжээг нэмэгдүүлнэ гэж тооцооллоо. Ялангуяа дотоодын өндөг, тахианы мах, малын тэжээлийн эрэлт нэмэгдэж буй энэ үед компанийн үйлдвэрлэгч бүтээгдэхүүнүүдийн эрэлтийн хэмжээ тогтвортой нэмэгдэж зах зээл дэх байр сууриа өргөжүүлнэ гэж тооцоолж байна. (Дэлгэрэнгүйг Ирээдүйн санхүүгийн төсөөллөөс харна уу).

Үнэлгээний "Итгэлт Эстимэйт" ХХК нь бизнесийн үнэлгээг зах зээлийн харьцуулалтын аргыг ашиглан гүйцэтгэсэн бөгөөд харьцуулалтад Монгол хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй 1,2 ангиллын дараах компаниудын 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаарх санхүүгийн мэдээллийн судалж үзсэн байна.


Ангилал	Тикер	Компанийн нэр
1-р ангилал	APU	АПУ ХК
	MMX	Мах Импекс ХК
	SUU	Сүү ХК
	TCK	Талх Чихэр ХК
	TTL	Таван Толгой ХК
	MNP	Монгол Шуудан ХК
	GOV	Говь ХК
	NEH	Дархан Нэхий ХК
	MIK	Мик ХК
2-р ангилал	ATR	Атар Өргөө ХК
	DHU	Дархан Хүнс ХК
	UBH	Улаанбаатар Хивс ХК
	TAN	Тахь-Ко ХК
	RMC	Ремикон ХК
Үнэлгээ хийж буй компани		Түмэн шувуут ХХК

Дээрх компаниудын санхүүгийн үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй судалсны үндсэнд (Дэлгэрэнгүйг Бизнесийн үнэлгээний тайлангаас харна уу) "Сүү" ХК, "Талх Чихэр" ХК, "Мах Импекс" ХК-ийн санхүүгийн үзүүлэлтүүд болон үйл ажиллагааны чиглэл нь Үнэт цаас гаргагч компанийн бизнестэй төстэй тул дээрх 3-н компанийн үзүүлэлтийг үндэслэн компанийн үнэлгээг 50.4 тэрбум төгрөгийн үнэ цэнэтэй байх боломжтой гэж тооцоолсон байна.





Үнэт цаасны танилцуулга



№	Нэр	Аж ахуй нэгжийн үнэ цэнэ /ААНҮЦ/ цэнэ	Цэвэр ашиг	ААНҮЦ/ЦА	Ач холбогдол	мян.төг
						Дүн
1	"Сүү" ХК	98,495,019.4	2,430,127.7	40.5	0.33	13.4
2	"Талх чихэр" ХК	32,209,161.8	1,128,017.0	28.6	0.34	9.7
3	"Мах импекс" ХК	17,092,148.9	354,752.4	48.2	0.33	15.9
	ДУНДАЖ					39.0

Харьцуулалтын аргад суурилсан бизнесийн үнэлгээний дүн

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН
1	Цэвэр ашиг /мян.төг/	1,380,439.60
2	ААНҮЦ/ЦА	39
3	ААНҮЦ /мян.төг/	53,813,679.5
4	Өр төлбөр /мян.төг/	5,021,700.0
5	Бэлэн мөнгө /мян.төг/	1,583,994.0
6	ЗЗҮ /мян.төг/	50,375,973.5

Дээрх үнэлгээний аргууд болон компанийн цаашид авч хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжсэнээр компанийн үнэлгээ нэмэгдэх боломжийг үндэслэн Үнэт цаас гаргагч компанийн хувьцаа эзэмшигчид 2018 оны 06 сарын 07-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 05/2018 тоот тогтоолоор компанийн нэгж хувьцааны үнэ цэнийг 200 төгрөг, компанийн нийт үнэлгээг 40 тэрбум төгрөг байхаар шийдвэрлэсэн байна.

Үнэлгээний дэлгэрэнгүй мэдээллийг "Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ"-ний тайлангаас харна уу.



3.5 Үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах бизнесийн төлөвлөгөө;

Үнэт цаас гаргагч нь компанийн энгийн хувьцааны 25 хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгох замаар нийт 10 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Үнэт цаасны тухай хуулийн 12.9, МХБ-н Үнэт цаасны бүртгэлийн журмын 15.2.1.5-г үндэслэн Үнэт цаас гаргагч нь олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулахаар энэхүү танилцуулгад дэлгэрэнгүй мэдээллийг тусгав, үүнд:

1. Өндөгний үйлдвэрийн үйл ажиллагааг өргөжүүлэх төсөл
2. Махны тахианы үйлдвэр эрхлэх төсөл
3. Сангас боловсруулж бордоо үйлдвэрлэх төсөл
4. Тэжээлийн үйлдвэрийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх зэрэг төслүүд багтаж байна.

Дээрх ажлуудын хүрээнд компани дараах байдлаар хөрөнгө оруулалтын зарцуулалтын төлөвлөгөө гаргаад буй бөгөөд олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг хамгийн өндөр өгөөж болохуйц бизнесийн салбаруудад зарцуулахаар төлөвлөсөн байна.





Үнэт цаасны танилцуулга



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАДАРГАА

	сая.төг	Эзлэх хувь
Өндөглөгчийн 8-р байр	1,249	13%
Өндөг боловсруулах үйлдвэр	1,531	15%
Махны тахианы аж ахуй, тэжээл үйлдвэрлэл	3,928	39%
Сангасны бордооны үйлдвэр	946	10%
Сангасны бордооны байр	705	7%
Усжуулах ХК-д хөрөнгө оруулалт	625	6%
Эргэлтийн хөрөнгө	1,016	10%
НИЙТ	10,000	100%

Хүснэгт: 15 Хөрөнгө оруулалтын задаргаа

Нийт хөрөнгө оруулалтын 40 хувийг тахианы махны төсөлд зарцуулах бөгөөд улмаар цаашдын бизнесийн гол шугамыг нээхээр төлөвлөж байна. Мөн өндөгний үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өндөгний өртөгийг бууруулахад нийт хөрөнгө оруулалтын 28 хувь буюу 2.8 тэрбум төгрөгийг зарцуулах юм. Уг ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

3.5.1 Өндөгний 8-р байр

Үнэт цаас гаргагч нь 2018 онд "Өндөглөгчийн 8" төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд уг хөрөнгө оруулалтад нийт 1.2 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн. Уг байрыг ашиглалтад оруулснаар нийт тахианы тоог 250.0-300.0 болгон нэмэгдүүлдэг зогсохгүй жилийн 65-70 сая өндөг үйлдвэрлэх боломжтой болох юм. Энэ нь 2016 оны борлуулалтын хэмжээ болох 50 сая ширхэг өндөгнөөс даруй 30-40 хувиар их юм. Өндөг үйлдвэрлэх процессд сүргийн бүтцийг зөв тодорхойлох, дэгдээхэйний байр, өндөглөгчийн байрны зохистой харьцааг тогтоох нь чухал байдаг. Үнэт цаас гаргагч нь 2016 онд 6-н өндөглөгчийн байртай, 2 дэгдээхэйний байртай үйл ажиллагаа явуулж байсан бол 2017 онд 1 өндөглөгчийн байр нэмж оруулснаар бүтээмжийг 25-30 хувиар нэмэгдүүлсэн. Харин 2018 онд дахин нэг өндөглөгчийн байр нэмж барьсанаар инкубатор, дэгдээхэй, өндөглөгчийн байрны зохистой харьцааг зөв тогтоох боломжтой болох юм.

Өндөглөгч тахианы олон улсын стандартаар 4-н өндөглөгчийн байрны дунд 1 дэгдээхэйний байр байх зөвлөмжтэй байдаг тул 8-р байрыг ашиглалтад оруулах нь уг зохистой харьцааг ханган, үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллахад өндөр хувь нэмэр оруулна.

Өндөглөгчийн байрны тоог 8-д хүргэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөв. Үүнд:

- Өндөглөгч тахианы байр барих:

13м*100м*3.8м хэмжээтэй барилга барина. Барилгын үндсэн материалыг БНХАУ-ын Дуовэ компаниас авахаар төлөвлөв. Тус компанийн үйлдвэрлэсэн төмөр хийц, 15см зузаан чулуун хөвөн (rock wool) сэндвич хавтанг сонгов. Полуретан чулуун хөвөн хавтан нь галд шатдаггүй, дулаан тусгаарлах чадвар сайн, байгальд ээлтэй, хулгана, мэрэгч амьтан үүрлэх боломжгүй, өнгө үзэмжтэй, чанартай шувууны аж ахуйд хамгийн тохиромжтой материал юм.




Зураг 17 Тахианы үйлдвэрийн зураг


Нийт зардал нь ойролцоогоор 705 сая төгрөг болно.

- Өндөглөгч тахианы тоног төхөөрөмж худалдан авах:

38,400 шувуу тэжээх хүчин чадалтай иж бүрэн тоног төхөөрөмжийг БНХАУ-ын Гуангжоу Гуаншинг Полтри Экиупмент (GX) компаниас худалдан авахаар төлөвлөв. GX компани нь Хятадад төдийгүй өндөр хөгжилтэй бусад оронд ч хүлээн зөвшөөрөгдсөн, шувууны аж ахуйн тоног төхөөрөмж



Үйлдвэрлэлээр тэргүүлэгч компани юм. Бид 10 гаруй жилийн турш хэрэглэж ирсэн туршлага дээрээ үндэслэж GX компаниас 8 иж бүрэн өндөглөгч тахианы тоног төхөөрөмж худалдан авах бөгөөд уг тоног төхөөрөмж нь манай хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж байгаа гэж үзэж байна. Өндөглөгч тахианы байр барьж, шинээр тоног төхөөрөмж суурилуулснаар Түмэн Шувуут ХХК-ийн өндөглөгч тахианы тоо толгой 40,000-аар нэмэгдэж, үйлдвэрлэл борлуулалтын хэмжээ 20-30 хувь өсөх боломжтой. Дотоодод үйлдвэрлэсэн өндөгний үнэ импортын өндөгний үнээс өндөр байгаа хэдий ч чанар болон шинэлэг байдал зэрэг давуу талаараа импортын өндөгнөөс эрэлт ихтэй байгаа нь үйлдвэрлэлийн хэмжээг өсгөх зайлшгүй шаардлагыг бий болгож байна. Нийт зах зээлийн 60 хувийг дотоодын өндөг, 40 хувийг импортын өндгөөр хангаж байна. Сүүлийн үед ОХУ-ын рублийн ханш өсөж байгаа нь импортын өндөгний өртгийг нэмэгдүүлэх хандлагатай байна.



Зураг 18 Өндөглөгчийн байрны план зураг

Манай улсад өндөгний зах зээл (хэрэглээ) жил тутамд нэмэгдэж байна. 2000 оны байдлаар жилд 1 хүнд ногдох өндөгний хэрэглээ 15 ширхэг байсан бол 2016 онд 75 ширхэг болж нэмэгдсэн. Харин Европын орнуудад 1 хүнд ноогдох өндөгний хэрэглээ 250 ширхэг байдаг нь монгол хүний өдрийн хэрэглээнээс 175 ширхэгээр илүү. Энэ нь тухайн бүтээгдэхүүний зах зээл дахь өсөлтийн хандлагыг харуулж байна.

Түмэн шувуут ХХК нь 38,400 толгой шувуутай заалаар үйлдвэрээ өргөжүүлснээр:

- Зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлнэ. (үйлдвэрлэл нэмэгдсэнээр өрсөлдөх чадвар сайжирна)
- Тэжээлийн үйлдвэрийн ашигт ажиллагаа сайжирна.
- Өндөгний сав баглааны үйлдвэрийн ашигт ажиллагаа сайжирна.
- Тахианы мах боловсруулах үйлдвэрийн ашигт ажиллагаа сайжирна
- Нэгж бүтээгдэхүүний өөрийн өртөг буурч ашиг орлого нэмэгдэнэ.

Өндөглөгч тахианы тоног төхөөрөмж, тээврийн зардал нэмэгдээд нийт 533.1 сая төгрөг болох юм. Харин тахианы үйлдвэрийн тоног, төхөөрөмж нь гааль, НӨАТ-н албан татвараас чөлөөлөгдсөн байдаг давуу талтай юм.

Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах хөрөнгө оруулалт шаардлагатай

Тоног төхөөрөмж		Нийт
Шувууны 8-р байрны тоног төхөөрөмж	төгрөг	543,898,573
Байр	төгрөг	705,000,000
Нийт	төгрөг	1,248,898,573

(Handwritten signature and stamp)

(Handwritten signature and stamp)



Үнэт цаасны танилцуулга



Үржлийн өндөг болон дэгдээхий

Тахианы аж ахуй эрхлэхэд хамгийн чухал зүйл нь сайн чанарын үр тогтсон үржлийн өндгийг худалдан авч, инкубаторт дарж дэгдээхий гарган авна. Гаргаж авсан дэгдээхийг 100 хоногийн нас хүртэл нь бойжуулж нас бие гүйцнэ. Залуу өндөглөгч тахиа 130 хоногийн наснаас эхлэн өндөглөж эхэлнэ. Өндөглөх хүртэлх хугацааны зардлыг дэгдээхий, есвөр шувуу бойжуулах зардал гэх бөгөөд энэ хугацаанд нэг шувуунд нийт 13,000 төгрөгийн зардал гардаг.

Өндөглөгчийн 8-р байранд 38,400 шувуу тэжээхэд нийт 499.2 сая төгрөгийн зардал гарах тооцоотой байна. Харин уг хөрөнгийг компани өөрийн эргэлтийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

3.5.1.1 Өндөг боловсруулах үйлдвэр

Үнэт цаас гаргагч нь Япон улсын Набел компанитай хамтран өндөг боловсруулах үйлдвэрийг одоогийн байгаа үйлдвэр дээрээ суурилуулах юм. Өндөг боловсруулах үйлдвэрийг барьж ашиглалтад оруулахад нийт 1.5 тэрбум төгрөг шаардлагатай ба уг өндөг боловсруулах тоног төхөөрөмж нь дараах давуу талыг компанид авчирах юм. Үүнд:

1. Өндөгийг угааж, цэвэрхэн болгоно
2. Өндөгийн чанарыг тухай бүр шалган, жинг хэмжин ангилна
3. Өндөгийг ангилсны дараа савлана

Эдгээр үйл ажиллагаа нь өнөөдрийн байдлаар гар ажиллагаатай буюу хүн хүч их хэмжээгээр шаардан, зарлыг өсгөж байгаа бол шинэ тоног төхөөрөмжийг суурилуулснаар зардлыг хэмнээд зогсохгүй, өндөгний чанарыг дээд зэргийн түвшинд байлгах юм.

Нөгөө талаар өндөгийг ангилах, тээвэрлэх, угаах явцад гардаг хагарал, цаг алдалтыг багасгана.

Улмаар гар ажиллагааг багасган, зардлыг хэмнэснээр өндөгний үйлдвэр нь 5-6 жилийн дотор өөрийн өртөгөө нөхөх бөгөөд цаашид компанид хэмнэлтийг авчран, өндөгний үнийг бууруулан хэрэглэгчдэд хямд бүтээгдэхүүн нийлүүлэхэд нэг алхам нэмэх юм.



NABEL NABEL Co.,Ltd.

Набел компани нь 1977 онд Япон улсад үүсгэн байгуулагдсан өндөгний тоног, төхөөрөмжийн судалгаа, үйлдвэрлэлээр тэргүүлэгч компани юм. 2017 онд 5.8 тэрбум иений борлуулалт хийсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 4 хувиар өссөн.


Компани нийт 185 ажиллагсадтай, 542 ашигтай загварын гэрчилгээтэй өнгөрсөн жилүүдэд 29th SME Technological Merit/New Product Award, 2017 Kyoto prefecture Industrial Contributor зэрэг шагналуудыг авч байсан нэр хүндтэй үйлдвэрлэгч юм.

Grader: CANOPUS





Үнэт цаасны танилцуулга



Зураг 19 Nabel брендийн өндөг боловсруулах тоног төхөөрөмж

Тоног төхөөрөмж	Хэмжээ	НИЙТ
Өндөг ангилах /Egg grading and packaging system mex 3000 /	1	40,020,000
Дотоод системийн тэжээл үүсгүүр Accumulator (for in-line system)	1	2,460,000
Хэт ягаан туяагаар ариутгагч /Uv sterilizer/	1	2,500,000
Хагарал, цуурал тодорхойлогч /Automatic crack detector/	1	11,000,000
Өндөгний чанар шалгагч /Automatic abnormal egg detector/	1	4,100,000
Өндөгний тамга дарагч /Inkjet printer software for videojet printer/	1	600,000
Өндөг савлагч /Multi denester (per 1 packing lane)/	1	1,200,000
Суулгах, угсрах зардал /Installation and general expenses/	1	2,550,000
Гааль, татварын зардал /Cif charge and export packing/	1	1,500,000
	ИЕН	65,930,000
Нийт	Мян.төг	1,531,447


Өндөг боловсруулах үйлдвэрийн ач холбогдол

Өнөөдрийн байдлаар үйлдвэрт өндөгийг цуглуулах, тээвэрлэх, угаах, ялгах зэрэг үйлдлүүдийг гар ажиллагаагаар хийж байна. Тиймээс өндөгний жинг нарийн тогтоох, зөв ангилахад хүндрэл тохиолддог. Ялангуяа өндөг нь жингийн хувьд өөр хоорондоо төдийлөн энгийн нүдээр ялгахад бэрх хүнсний бүтээгдэхүүн тул том жижгээр ангилан савлахад алдаа гардаг. Мөн угаах, савлах зэрэг үйл ажиллагааг гараар гүйцэтгэснээр үйлдвэрт ажилчдын нэмэлт зардал гарч байна. Өндөгийг угаасны дараа заавал маслоор тосон бүрхүүл үүсгэн хамгаалах шаардлагатай байдаг тул уг ажиллагаа нь мөн хөдөлмөр ихээр шаарддаг.


Харин дээрх үйл ажиллагааг автомат буюу машины тусламжтайгаар гүйцэтгэснээр бүх өндөгийг угааж цэвэрлэх, өндөгний яг нарийн жинг тохируулж ангилах зэрэг үйл ажиллагаа хялбаржин, үйлдвэрийн бүтээмжид эерэг үзүүлэлт гарна.

Цаашлаад компани жилд 60-70 сая өндөг үйлдвэрлэх тул уг үйл ажиллагааг автоматжуулан хялбарчилах нь нэн чухал бөгөөд эцсийн бүтээгдэхүүний чанарын хяналтад өндөр хувь нэмэр оруулах юм. Нөгөө талаар өндөг боловсруулах үйлдвэрээр дамжсан бүтээгдэхүүн нь физик гэмтэл бага, аливаа төрлийн бохирдлыг цэвэрлэдэг тул стандартын шаардлагыг хангасан бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд хувь нэмэр оруулна.

Үнэт цаас гаргагч нь нийт өндөгний 2-3 хувь нь хагарч гэмтсэн өндөг байдаг тул зах зээлийн үнээс даруй 50 хувь хямдруулсан үнээр нийлүүлж борлуулж байна. Тиймээс өндөг боловсруулах үйлдвэрийг барьж ашиглалтад оруулснаар үнийн тогтвортой бодлогыг баримталж ашигт ажиллагааг хэвийн түвшинд барих боломжийг үүсгэх юм.



Үнэт цаасны танилцуулга



Махны тахианы шинэ үйлдвэрийг барих ажлын хүрээнд

3.5.2 Тахианы махны аж ахуй, тэжээл үйлдвэрлэл

Зорилго, зорилтууд

Монгол улсад махны тахианы аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах замаар импортыг орлох экологийн цэвэр бүтээгдэхүүн болох тахианы мах үйлдвэрлэн хэрэглэгчдийг эрүүл хүнсээр хангах юм.

Төсөл нь үндсэн 3-н үе шаттай бөгөөд дараах байдлаар хуваагдаж байна. Үүнд:

- 2019 онд махны тахиа үржүүлэх 3-н байр, махны хөргөгч/хөлдөөгч, инкубаторыг барьж ашиглалтад оруулах
- 2020 онд нэмэлт 3-н тахианы байр барих
- 2023 онд дахин 4-н байрыг ашиглалтад оруулж нийт 10-н махны тахиа үржүүлэх байртайгаар жилд нэг байр 5-н удаагийн эргэлттэй байх буюу нийт 600 мянган тахианы махыг зах зээлд нийлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Тахиа үржүүлгийн гол сүрэг болох Cobb-500 үүлдэр нь дэлхийд шалгарсан бренд бөгөөд бага тэжээлээр их жин авч чаддаг онцлог шувуу юм. Cobb-500 шувуу тэжээлийн зардал бага тул, их хэмжээний ашиг олох боломжийг олгодог онцлог чанараараа шалгарч дэлхий дахинд хамгийн өргөн хэрэглэгдэж байна.

Cobb-500 шувууны давуу талыг онцолвол:

- Бага зардлаар нэгж шувууны зардал гарах
- Тэжээл сайн авч, таргалах чадвар өндөртэй
- Хурдан өсч том болдог
- Махлахад жигд буюу биеийн ерөнхий бүтэц өөр хоорондоо төстэй
- Өсч үржих чадвар сайтай зэрэг чанаруудаараа шалгардаг.



Тахиа үржүүлэх схем зураг




Зураг 20 Өндөг боловсрох хугацааны дараалал

Махны тахиа нь өндөгний тахиатай харьцуулахад эргэц хурдан байдаг нь нэг талаар давуу талыг авчирдаг боловч нөгөө талаар хөдөлмөр ихээр шаарддаг. Нэг махны шувуу амьдралынхаа хугацаанд нийт 5.5 кг тэжээл иддэг нь зах зээлийн үнээр 6,400 төгрөг болдог.

1	Нэг шувууны амьдрах хугацаа	45 хоног
2	Нийт зарцуулах тэжээл	5.5кг
3	Амьдын жин	2.9-3.1кг
4	Махны жин	2.1-2.3кг
5	Зах зээлийн өнөөгийн ханш /бүтэн тахиа/	9,500-10,500төг






Үнэт цаасны танилцуулга



ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧ
ТҮМЭН ШУВУУТ ХХК




Үнэт цаас гаргагч нь шувууны аж ахуй хөгжүүлсэн олон жилийн туршлага дээрээ үндэслэн тахианы махны аж ахуйг хөгжүүлж, хэрэглэгчдийг чанартай, найдвартай бүтээгдэхүүнээр хангах ба уг ажлын хүрээнд нэг ээлжиндээ 20 мянган тахиа тэжээх чадвар бүхий 3-н тахианы байрыг 2019 онд тоног төхөөрөмжийн хамт барьж ашиглалтад оруулахад нийт 3.9 тэрбум төгрөг зарцуулах юм. Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах байдлаар зарцуулахаар төлөвлөж байна.

Хөрөнгө оруулалт	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Тахианы байр	3 ширхэг	700 сая	2,100 сая
Тоног төхөөрөмж	3 байр	200 сая	600 сая
Инкубатор төв	1 ширхэг	328 сая	328 сая
Дэгдээхэйний байр	1 ширхэг	300 сая	300 сая
Нядалгааны байрыг зөөвөрлөх зардал		200 сая	200 сая
Хөлдөөгч		200 сая	200 сая
Түгээлтийн системийг бий болгох		200 сая	200 сая
НИЙТ			3,928 сая

Тахианы махны төслийн хүрээнд 5 га талбайд дэд бүтцэд холбож $36 \times 12 = 432 \text{ м.}^2$ талбай бүхий махны тахианы өндөг дарах байрыг шинээр барих, $12 \times 106 = 1,272 \text{ м.}^2$ талбайтай махны тахианы 6-н байрыг 2019 онд 3, 2020 онд 3-г ээлж дараалан шинэ тоног төхөөрөмжийн хамт ашиглалтад оруулна.

- Мөн хорио цээр халдваргүйжүүлэлтийн иж бүрэн тоноглол бүхий тоног төхөөрөмжийг шинээр худалдан авч үйл ажиллагаандаа ашиглах
- Хөргүүрийн иж бүрэн цехийг шинээр барьж тоногжуулан ажиллагаанд оруулах
- Үйлдвэрлэсэн махыг чанрын өндөр түвшинд ангилан савлаж хөлдөөн хэрэглэгчдэд хүргэх ажлуудыг гүйцэтгэнэ.



Зураг 21 Махны тахианы үйлдвэрийн зураг

Үнэт цаас гаргагч нь тахианы аж ахуйн дэргэд хоногт 5,000 тахиа боловсруулах хүчин чадал бүхий нядалгааны байртай бөгөөд одоогийн байдлаар тухайн байрыг хүчин чадлын бүрэн хэмжээнд ашигладаггүй. Учир нь өндөглөгч тахиа нь махны тахиятай харьцуулахад нас урт буюу 24 сар тэжээдэг нь төдийлөн нядалгааны байрыг ашиглах шаардлагыг үүсгэдэггүй. Тиймээс уг байрыг шинээр бий болгох тахианы махны аж ахуйн дэргэд байрлуулж, хүчин чадлыг бүрэн хэмжээнд ашиглахаар төлөвлөж байна. Мөн махны тахианы өндөгийг дарж дэгдээхэйг бий болгох инкубатор төвийг ашиглалтад оруулах ба үүнд 328 сая төгрөгийг төсөвлөөд байна.



Handwritten signature in blue ink.

Махны тахианы өндөглөгч тахианаас ялгарах бас нэг онцлог нь өөр тэжээл шаардлагатай байдаг. Тиймээс компани тэжээлийн үйлдвэрийн шугаманд зохих өөрчлөлтийг оруулж махны тахианы тэжээл үйлдвэрлэх юм.

Өнөөдрийн байдлаар компани нас нь хөгширсөн буюу 640-700 хоногтой өндөглөгч тахиаг нядлан, мах бэлтгэн зах зээлд нийлүүлж буй туршлагатай бөгөөд уг туршлагад үндэслэн махны тахианы үйлдвэрийг амжилттай эрхлэх төлөвлөгөөг гаргаад байна.

Монголын зах зээлд Ажигана ХХК-н "Оргю" бренд амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өөр дотоодын том аж ахуйн нэгж махны үйл ажиллагааг дагнан эрхлэхгүй байна. Харин олон компани импортын тахианы махыг БНХАУ, ОХУ, АНУ зэрэг орнуудаас оруулж ирэн худалдаалж байна, жишээ нь Монгол улс 2017 онд импортоор 14.8 сая ам.доллар буюу 30 гаруй тэрбум төгрөгийн үнэ бүхий махыг худалдан авсан байна. Цаашлаад хүн амын хэрэглээ нэмэгдэхийн хэрээр тахианы махны эрэлт нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд дотоодод үржүүлсэн, чанартай тэжээлээр бордсон тахианы мах нь зах зээлд эрэлт өндөртэй байх хүлээттэй байна.

Монголын хэрэглэгчдийн дунд гарал үүсэл тодорхой, өөрийн үйлдвэрт бэлтгэсэн тэжээлээр хооллосон, чанарын өндөр түвшний лабораторид бэлтгэгдсэн тахианы махны эрэлт өндөр байгааг компанийн явуулсан судалгаа харуулж байна. Судалгаанд нийт 100 хүн хамрагдсанаар 92 хувь нь дотоодод үйлдвэрлэсэн тахианы махыг импортын махтай харьцуулахад өндөр үнэтэй боловч хүнсэндээ хэрэглэнэ гэж хариулсан.⁸ Өөрөөр хэлбэл импортын бүтээгдэхүүнтэй харьцуулахад дотоодод тэжээсэн тахианы махны үнэ өндөр боловч чанарын хувьд илүү байх нь харагдаж байна.

Тахианы махны үйл ажиллагаа явуулахад компанид өөрийн эзэмшлийн газар хангалттай байгаа нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх үндсэн суурь баазийг бий болгож байна. Хөрөнгийн зах зээлээс олон нийтээр татан төвлөрүүлсэн хөрөнгөөр тахиа үржүүлэх байр, Jansen Bromaxx Broiler компанийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулан үйл ажиллагаагаа эхлүүлэх юм. Үйлдвэрт Cobb-500 үүлдрийн бага тэжээлээр их хэмжээний мах гаргах чадвартай, чанар сайтай тахиаг үржүүлэх бөгөөд үр тогтсон өндөгийг ОХУ-с худалдан авахаар төлөвлөн ажиллаж байна.

Jansen компанийн Bromaxx брэндийн тахианы үйлдвэрлэлийн систем нь шинэ төрсөн дэгдээхийг үржүүлэх сүүлийн үеийн технологид суурилсан шинэ тоног төхөөрөмж болно. Тахиан хийгдэж буй антибиотик, коксидиостатсийн хэрэглээг бууруулж, тэжээл хөрвүүлэлтийн харьцааг өсгөн тахиаг зорилтот жинд хурдан хүргэдгээрэй онцлогтой. Мөн махны чанарыг дээшлүүлж үйлдвэрлэлийн өртгийг бууруулан илүү олон тахиа үйлдвэрлэх боломжийг олгодог.

Энэхүү төхөөрөмж нь дараах үр ашигтай:

- Бодит өсөлт
- Одоогийн үйлдвэрлэлээс илүү олон тахиа үйлдвэрлэнэ.
- Илүү тохиромжтой тэжээл хөрвүүлэлтийн харьцаа
- Махны чанарын өсөлт
- Үйл ажиллагааны зардал бага
- Хялбар, үр ашигтай удирдлага
- Тохиромжтой лед гэрэлтүүлэг
- Баталгаатай тэжээлийн нийлүүлэлтийн систем
- Автомат усжуулалтын систем

Тахиа үржүүлэх тусгаарлах хэрэгслийн шал нь нүхтэй цоолсон хэлбэртэй ба уг хэсгээрээ доор байрлах сангас гадагшлуулах хэсэг рүү сангасыг хялбар унагаж өгдөг. Тусгаарлах хэсгийн шал нь тахианы цээж болон хөлөнд тохирсон тав тухтай байдлыг хангахаар бүтээгдсэн.

⁸ Голомт Капитал ҮЦК-н тахианы махны судалгаа



Үнэт цаасны танилцуулга



Тахианы өсөлтөнд нөлөөлөх зөв гэрэлтүүлгийн систем тусгаарлах хэрэгсэл бүрт байршуулсан. Тахианы тав тухтай байдлыг хангахаар бүтээгдсэн энэхүү тусгаарлах хэрэгсэл нь Тахианы халдвар, сарвууны гэмтэл болон цээжний цэврүү зэрэг эмгэгүүдийг тусахаас сэргийлж өгдөг. Тахиа үржүүлэхэд тэжээлийн хаягдал гаргахгүйгээр бүх насны тахианууд тэжээлийг хүргэх байдлаар бүтээгдсэн. Тэжээл нь эрүүл тахиа боожиход маш өндөр үр нөлөөтэй ба тахианы жингийн өсөлтийг сайн барихад тусалдаг.

Харагдах байдал



Зураг 22 Тахианы үйлдвэрийн доторх зураг

Компани үр тогтсон өндөг худалдан авдаг арвин туршлагатай бөгөөд өөрийн инкубаторт тухайн өндөгийг дэгдээхэй болгон амилуулж, бордогч байранд байрлуулах юм. Улмаар 40-45 хоног бордсоны эцэст мах үйлдвэрлэх бөгөөд өөрийн махны нядалгааны үйлдвэрт боловсруулан, хөргөгчинд хадгалан хэрэглэгчдийн гар дээр нойтон болон хөлдүү махыг нийлүүлэх юм.

Нөгөө талаар махны тахиаг үржүүлснээр шувууны сангасаар бордоо үйлдвэрлэх үйлдвэрийн түүхий эдийг нэмэгдүүлэх тул эдийн засгийн хувьд давхар ач холбогдолтой.



Зураг 23 Тахианы үйлдвэрийн доторх зураг

Дээрх өндөглөгчийн 8-р байр болон махны тахианы төслийг хэрэгжүүлэхэд дагаж гарч ирэх бас нэгэн бизнесийн чухал шугам нь сангасны аж ахуй байх юм. Одоогийн байдлаар ашиглагдахгүй байгаа тахианы сангасыг боловсруулах бордооны үйлдвэрийг барих ба өндөглөгч болон тахианы махны аж ахуйд байрлах 350 мянга орчим тахианы сангасаар жилдээ 1-2 мянган тонн бордоог үйлдвэрлэх юм. Уг бордоогоор хөдөө аж ахуйд нэн шаардлагатай байгаа бордоог улаанбуудай болон бусад тариалалтын аж ахуй эрхлэгчдэд нийлүүлэх бөгөөд Монгол улсын бордооны импортыг багасган, валютын гадагшлах урсгалыг багасгахад тодорхой хувь нэмэр оруулна.

3.5.3 Сангасны аж ахуй

Өндөглөгч тахианы дайвар бүтээгдэхүүн сангас нь биологийн бордоо болохуйц шим тэжээл бүхий органик бүтээгдэхүүн юм. Өнөөдрийн байдлаар компанийн эзэмшиж буй 250,000 гаруй шувуу нь жилдээ 5,750 тонн сангасыг үйлдвэрлэж байгааг компани хаягдал байдлаар өөрийн хашаандаа буулган, тухайн орчмын айл, аж ахуйн нэгжүүдэд үнэгүй өгч байна.

Уг сангасыг боловсруулан, хөдөө аж ахуйн компаниудад борлуулах нь эдийн засгийн хувьд хамгийн оновчтой шийдэл төдийгүй, эрүүл ахуйн хувьд тухайн ойр орчмыг цэвэр байлгах





Үнэт цаасны танилцуулга



чухал шийдэл юм. Уг бордооны үйлдвэрийг барьж ашиглалтад оруулахад 1.6 тэрбум төгрөгийг төсөвлөөд байна.

Сангас боловсруулах үйлдвэрт шаардлагатай байр, тоног төхөөрөмжийн задаргаа

Тоног төхөөрөмж	Хэмжээ	Үнэ (USD)	Нийт
Knll-6000shw (pit=150m)	1	216,350	216,350
ELECTRIC CABLE (m)	175	55	9,625
Pulley double	38	140	5,320
Pulley cleaner	1	145	145
ZAM-H I-BEAM (100x75)	26	230	5,980
Zam-h joint	25	23	575
Rail hanger a	36	21	756
Rail hanger b	4	40	160
Aeration system	6	8,500	51,000
12k rail	45	260	11,700
12k rail joint	42	18	756
POLYCARBONATE SHEET (L=8.7m/322) 2800	13	36,400	
Polycarbonate top cover	161	15	2,415
Packaging	1	1,500	1,500
Technical assistance fee	1	9,000	9,000
Insurance	1	3,450	3,450
Domestic charges (in japan)	1	11,000	
Freight	4	7,000	28,000
Total		USD	394,132
		MNT	945,916,800
Байр			705,000,000
Нийт		MNT	1,650,916,800

Дэлхийн технологийн компаниуд дундаас сангасны бордооны үйлдвэрлэлээр мэргэшсэн Кошин (Kohshin – www.kohshin-s.jp) компаниас тоног төхөөрөмжөө худалдан авч, өөрийн эзэмшлийн газарт шинээр үйлдвэр байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.


Сангасны үйлдвэрийн тоног төхөөрөмж нь нийт 394.1 мянган ам.доллар бөгөөд үйлдвэрийн барилгын өртөг нь 700 сая төгрөг орчим болох юм.

Шувууны сангас нь өөрийн онцлог байдлаас хамааран жилийн улирал бүрт өөр өөр чийгшлийг агуулан эцсийн бүтээгдэхүүн болдог бөгөөд нийт гарцийн 25 орчим хувь нь эцсийн бүтээгдэхүүн болдог онцлогтой.



Зураг 24 Сангасны үйлдвэрийн зураг, Эх сурвалж: Kohshin компани

Тиймээс компани үйлдвэр байгуулсан эхний жилдээ 1,360 тонн бордоо үйлдвэрлэх бөгөөд нэг тонн бордоог дунджаар 400-500 мянган төгрөгөөр зах зээлийн үнээс хямд борлуулан ашигт ажиллагаагаа нэмэгдүүлнэ.



Үнэт цаас гаргагч нь шувууны сангасаар бордоо үйлдвэрлэх энэхүү төслийг олон жилийн судалгаа, шинжилгээний үр дүнд хөгжүүлэхээр ажиллаж байгаа ба гол түүхий эд нь үнэгүй байдаг тул компанийн санхүүд өндөр хувь нэмэр оруулах төсөл юм.

Сангасаар бордоо үйлдвэрлэх технологийг Япон улсын Кошин (Kohshin – www.kohshin-s.jp) үйлдвэрээс шууд авч хэрэглэх ба сангасыг олон хоногийн турш хатааж, өөр тусгай биологийн бүтээгдэхүүнүүдтэй тусгай жорын дагуу хольсноор газар тариаланд өргөнөөр хэрэглэх боломж бүхий бүтээгдэхүүнийг гарган авдаг.

Монгол улсад 2 бордооны үйлдвэр үйл ажиллагаа явуулж буй бөгөөд дотоодын үйлдвэрлэл нийт бордооны хэрэглээний ердөө 1-2 хувийг хангаж байна.



Зураг 25 Органик бордоо

Тэжээлийн үйлдвэрийг өргөжүүлэх, шинэ тэжээл үйлдвэрлэх ажлын хүрээнд

3.5.4 Тэжээлийн үйлдвэрийн өргөтгөл, царгас тариалалт

Үнэт цаас гаргагч нь өөрийн эзэмшлийн Агро Фийд тэжээлийн үйлдвэртээ 10 гаруй нэр төрлийн малын болон тахиа, шувууны тэжээл үйлдвэрлэж байна. Хоногт 100 тонн тэжээл үйлдвэрлэх хүчин чадал бүхий уг үйлдвэрийн гол түүхий эд нь улаанбуудай, хивэг, рапс, рапсын тос зэрэг дотоодод үйлдвэрлэж болохуйц бүтээгдэхүүнүүд байгаа бол зарим нэр төрлийн орцууд болох эрдэнэшиш, шар буурцаг, премикс зэрэг нь импортоор орж ирж байна. Тиймээс энэ нь малын тэжээлийн өртөг нэмэгдэх үндсэн хүчин зүйл болж байна.

Компани Агрофийд үйлдвэртээ түүхий эд бэлдэх, цаашлаад хямд үнэтэй боловч уургийн агууламжаар баялаг тэжээл үйлдвэрлэх зорилгоор Увс аймгийн Баруунтуруун суманд байрлах усалгаатай газар тариалан бүхий Усжуулах ХК-ны нийт хувьцааны 80.6 хувийг худалдан аваад байна.

“Усжуулах” ХК нь Увс аймгийн Баруунтурууны сангийн аж ахуйн өмчийг хувьчлахад төрийн өмчит хувьцаат компаний хэлбэрээр 1991 онд анх байгуулагдаж, 1998 онд өөрчлөгдөн зохион байгуулагдсан. Компаний үндсэн үйл ажиллагаа нь газар тариалан, мал аж ахуй, үйлдвэрлэл, худалдаа. Байгуулагдсанаасаа хойш эдүгээ хүртэл жил бүр 324-540 га-д усалгаатайгаар үр тариа, малын тэжээл тарьж байна. 2004 онд 108 га-д царгас тариалж 8 жил ургац хураан жилд дунджаар 13000 боодол (325 тн) хадлан бэлтгэж байсан

Түмэн шувуут ХХК нь тус компанийн 80.6 хувийг худалдан авч, 2018 оны 5 сарын байдлаар тариалалтаа эхлүүлэн, үйл ажиллагааг нь нэмэгдүүлэн ажиллаж байна. 2018 онд уг талбайд 500 га улаанбуудай, 500 га-д царгас тариалан тэжээлийн үйлдвэрийн түүхий эдээ бэлдэх, тухайн орон нутгийг гурилаар хангах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах юм.

Усжуулах ХК-д Үнэт цаас гаргагч нь олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн 16 хувийг зарцуулахаар төлөвлөж байгаа ба 700 орчим сая төгрөгийг 2018 онд, 927 сая төгрөгийг 2019 онд зарцуулахаар төлөвлөж байна.

Түмэн шувуут ХХК

74



Үнэт цаасны танилцуулга



Усжуулах 2018 хөрөнгө оруулалт	2018 ОН /сая.төг/
140 цемент шон	58.8
Тээвэр	1.8
Цахилгаан дамжуулах шугам	30
Трансформатор	21
Унагалдай эксковатор	50
Далд шугам	72
Ажлын хөлс	30
Бороожуулагч угсрах	150
Тээвэр зардал	128
Комбани	77.2
Үрлэгч	80
Будаа цэвэрлэгч	18
Чиргүүлийн жатк	10
Нийт	726.8

Усжуулах компанид 2019 онд мөн тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг хийж үйлдвэрлэлийг сайжруулахаар төлөвлөж байна. Үүнд:

Усжуулах 2019 хөрөнгө оруулалт	2019 ОН /сая.төг/
Өвсний үйлдвэр	600
Барилга	180
Трактор	35
Комбани	77.2
Фотон	10
Хуйлан боогч	12
Нийт	914.2

Усжуулах ХК-д дараах нэн шаардлагатай хөрөнгө оруулалтыг оруулснаар царгас, улаанбуудай, ногоон тэжээлийг 2000 га талбайд тариалах боломжийг бүрдүүлэх юм.

Гурил үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлага



Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан "Хүнсний аюулгүй байдал" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд импортын хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх, улмаар экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нэн чухал юм. Хүнсний тухай хууль"-ийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтад "стратегийн хүнс" гэж монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаанбуудай, гурил, ундны усыг хэлнэ гэж заасан байдаг.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 257 тоот тушаалаар баталсан "Жишсэн дундаж хүний илчлэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ"-нд заасны дагуу жишсэн дундаж нэг хүний хоногт хэрэглэх гурил (100 гр/хоног), гурилан бүтээгдэхүүний (220 гр/хоног) хэмжээг үндэслэн тооцов.

Гурилын дотоодын үйлдвэрлэл, импортын тоо хэмжээ


Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Хүн амын хэрэгцээ	253.8	258.7	263.3	267.4	276.1	285.2	294.6
Дотоодын үйлдвэрлэл	143.4	105.2	114.8	246.4	239.4		
Дотоодын үйлдвэрлэлийн %	56.5	40.6	42.9	92.1	86.7		
Импортлосон	Гурил	71.1	70.5	50.3	23.9	11.6	
	Улаан буудай	66.2	7.3	4.0	12.0	34.2	

Хүснэгт: 16 Гаалийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо





Үнэт цаасны танилцуулга



Манай улс гурил үйлдвэрлэлээрээ өөрийн орны хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгаа бөгөөд зарим жил (2011, 2012 онд) дөнгөж 40 гаруйхан хувийг үйлдвэрлэж, гурилын хэрэгцээний 15-60 хувийг жил бүр гадаадаас худалдан авч байна. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас зөвхөн говь, хээрийн бүсд төдийгүй газар тариалангийн голлох нутагт ч хур тундас багасаж, таримал ургамлын ид ургалтын үе YI-YII сард бороо орохгүй байх, зарим жил бүүр ган болох тохиолдол ихэссэнээс улаанбуудайн ургац алдаж, гадаадаас авдаг үр тариа, гурилаа үлэмж нэмэгдүүлэх шаардлага тулгардаг. Иймд усалгаатайгаар улаанбуудай тариалах нь байгаль цаг уурын нөхцлөөс хамаарахгүйгээр ургац арвин хурааж, гурилын үйлдвэрлэлийг тогтортой байлгах баталгаатай нөхцөл юм.

Баруун бүс буюу Завхан, Увс, Баян-өлгий, Ховд, Говь-алтай аймгуудад улаанбуудай бараг тариалдаггүй, зарим суманд гурилын жижигхэн цех ажилладагаас өөр гурилын үйлдвэр байхгүй. Хүн ардын гурилын хэрэгцээг Улаанбаатар хотоос тээвэрлэж, эсвэл Орос, Хятад улсаас импортоор оруулж хангаж байгаас нэг кг гурилын үнэ төвийн бүсээс дор хаяж 20-70 төгрөгөөр илүү байна.


Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах шаардлага

Манай орны мал сүрэг сүүлийн жилүүдэд тасралтгүй өсч, 2000 онд 30.2 сая байсан бол 2017 оны эцэст 66.4 сая боллоо. Аж үйлдвэр, ялангуяа уул уурхай хөгжихийн хирээр дотоодын нийт бүтээгдэхүүнд мал аж ахуйн эзлэх хувийн жин багасаж байгаа ч ач холбогдол нь хэзээ ч үл буурна. 1995 онд ХАА-н салбар ДНБ-ий 38 %-ийг үйлдвэрлэж байсан бол 2002 онд 20.7 % болж буурсан. УИХ-аас баталсан "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-д хөдөө аж ахуйг эрчимтэй хөгжүүлж, үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгон эрчимжүүлж үйлдвэрлэлийн үр ашигтай найдвартай тогтолцоог бүрдүүлэхийг чухалчлан тэмдэглэсэн. Даяаршиж, зах зээл өргөжиж, бас дэлхийн уур амьсгал ихээхэн өөрчлөгдөж байгаа энэ үед мал аж ахуйн үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлэхгүйгээр түүний үр ашигтай эрхлэх, малчдын амжиргааг тууштай дээшлүүлэх боломжгүй юм.

Малын тоо өсч байвч, харин бэлчээр улам бүр доройтсоор байна. Байгалийн аясаар эргэн сэргэх чадвараа бүрэн алдаж, цаашид ашиглах боломжгүй болж доройтсон бэлчээр нийт бэлчээрийн 7 орчим хувьд хүрч цаашид улам нэмэгдэх хандлагатай байна. Ургамлын ид ургалтын үед аагим халуун өдрүүд олон хоногоор үргэлжилж, 6 7-р сард нутгийн 70 орчим хувьд бага бороо орж, гантай гандуу байдаг болсон. Цаашид ган зудын давтамж ихсэх хандлагатай гэж мэргэжилтнүүд үзэж байна. Уур амьсгалын энэхүү өөрчлөлт нь уламжлалт аргаар мал аж ахуйг эрхлэн хөтлөхөд улам бүр төвөг учруулах төлөвтэй

Манай орны мал сүрэг жилийн турш зөвхөн бэлчээрийн өвс ургамлаар хооллодог бөгөөд намраас хаврын сүүлч хүртэл жилийн 2/3 буюу 240 хоногийн турш дан хагд өвс идэж амьдардаг. Өвөл хаварт бэлчээрийн ургац 20-30%, шимт чанар нь 3-4 дахин буурдаг тул энэ үед бие махбодийнхоо хэрэгцээт шимт бодисыг бүрэн авч чадахгүй, зунд биедээ хуримтлуулсан уураг, өөх тос, нүүрс-усыг шавхан дайчилж, амьдын жингийнхээ 20-30 %-ийг алдан, түрж эцэж онд ордог. Өвөл, хаварт тэжээлийн дутагдлаас болж, олон мал хорогддог. Байгалийн бэрхшээл зуд тохиолдвол мал сүрэг бүүрч олноор хорогддог. Сүүлийн үеийн жишээ гэхэд, 2000-2001 оны зудтай жил 4.2 сая мал хорогдож, малын тоо урьдах жилээсээ 13.8 %-иар цөөрч байв. Иймээс мал сүргээ онд мэнд оруулах, цас зудын гамшгаас хамгаалах үндсэн арга нь хадлан, тэжээл бэлтгэж нөөцлөх явдал.

Манай улс 14 аймгийн нутагт 2.0 сая орчим хадлангийн талбайтай. Дорнод бүсд нийт хадлангийн талбайн 65.1 %, баруун бүсд 3.9 %, төвийн бүсд 13.4-17.6 % байршдаг. Нэгж талбайгаас авах ургац тухайн жилийн цаг агаарын байдал хур чийгээс хамааран янз бүр байдаг ч зун намрын бэлчээрт ашиглагдан талхлагдаж, мөн уур амьсгалын өөрчлөлт нөлөөлж, ерөнхийдөө багассаар байгаа. Тухайлбал, хадлангийн унац 1971-1975 онд 6.0 ц/га; 1976 -1980 онд 5.3 ц/га; 1981 -1985 онд 5.0; 1986 -1990 онд 4.8 ц/га; 2005-2010 онд 4.4 ц/га



Үнэт цаасны танилцуулга



болж жилээс жилд буурсаар байна. Мал өссөөр байвч, бэлтгэж буй хадлан нэмэгдэхгүй байна.

Улсын хэмжээгээр бэлтгэсэн байгалийн хадлан (мянган тн)

1990	1995	2000	2005	2010	2012	2013	2014	2015	2016
1154.2	733.7	689.4	845.1	667.7	667.0	715.2	1178	1028.7	1100.0

Хүснэгт: 17 Хадлан авсан байдал, Эх сурвалж ҮСХ

Гэвч энэхүү бэлтгэж буй хадлангийн өвс болон үйлдвэрлэж буй тэжээл нь нийт мал сүрэгт шаардагдах нэмэгдэл тэжээлийн 30%-д ч хүрдэггүй.

Улаанбаатар, бусад томоохон хотууд, зарим аймгийн төвүүдийн орчимд байгуулагдсан саалийн болон гахайн фермүүдэд хүчит тэжээл ихээхэн дутагдаж, гурилын цөөн үйлдвэрийн үйлдвэрлэж байгаа багсармал болон холимог тэжээлээр аргацааж байна. Гэвч багсармал болон холимог тэжээл нь уургийн агууламж багатай, мал амьтны бие махбодийн хэрэгцээг бүрэн хангаж чадах бүрэн найрлагатай байж чадахгүй байна. Одоогийн үйлдвэрлэж байгаа хүчит тэжээлийн чанар хангалтгүй байгаагийн шалтгаан нь уг тэжээлийн түүхий эдийн шимт бодисын агууламж багатай холбоотой. Багсармал болон холимог тэжээлийн найрлагын 60-70 хувийг уургийн агууламж маш багатай сүрэл юмуу байгалийн хадлангийн өвс, үр тарианы хальс эзэлж байна.

Багсармал тэжээлийг өвс, сүрэл тус бүр 34%, улаан буудай 30%, давс 2 % орцтойгоор үйлдвэрлэж байна. Ийм тэжээл нь химийн найрлагын хувьд протейн 8-11.2 %, тослог 2.6 %, эслэг 19.4 %, азотгүй хандлага бодис (АХБ) 57.6 %, үнс 9.0 % байдаг.

Багсармал, хорголжин тэжээлийн бүтцэд царгас болон бусад уурагт ургамал нэмж, протейны агууламжийг 14-17 % хүргэн, малын төрөл, ашиг шим тохируулан тэжээлийг бүрэн найрлагатай, шимт бодисыг тэнцвэржүүлэн үйлдвэрлэснээр малын ашиг шимийг 10-20 % нэмэгдүүлэх, өвөл хаварт амьдын жингийн алдагдлыг багасгах, ингэснээр махны гарцыг ихэсгэх боломжтой.

Хорголжин тэжээл нь хадгалах, тээвэрлэх зэрэгт чанараа сайн хадгалдгаараа нунтаг багсармал тэжээлээс давуу талтай.

Одоогоор манай улсад том жижиг нийтдээ 100 гаруй тэжээлийн үйлдвэр байгаа ч байнгын ажиллагаатай нь "Алтан тариа", "Милл Хаус", "Агрофийд", "Алтай групп"-ийн тэжээлийн үйлдвэр юм. "Милл хаус", "Агрофийд" үйлдвэр тус бүрдээ хоногт 100 тн, "Алтан тариа" 60 тн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай ч түүхий эдийн дутагдлаас боломжийнхоо дөнгөж 20-30 %-ийг ашиглаж байна. Тэжээлийн үйлдвэрүүд хэрэгцээт түүхий эдийнхээ 70 орчим хувийг гадаадаас авч байна. Хүчит тэжээлийг импортоор авахад үнэ ихтэй, хэрэг дээрээ хүнсний гурилаас ч илүү үнэтэй болдог.

Уур амьсгал өөрчлөгдөж, бэлчээр, хадлангийн ургац улам бүр багасаж байгаа энэ үед усалгаатай тариаланг хөгжүүлснээр МАА-н үйлдвэрлэлийн эрсдэл багасаж, мах сүүний чиглэлийн ашиг шим арвинтай мал үржүүлэх, уурагт тэжээл үйлдвэрлэх боломж бүрдэнэ.

3.5.5 Үнэт цаас гаргаснаар бий болох үр өгөөж

Үнэт цаас гаргагчийн цаашид авч хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр нь одоогийн явуулж буй үйл ажиллагаатай нягт холбоотой буюу өнөөг хүртэл хуримтлуулсан туршлага дээр үндэслэн бизнесээ цаашид өргөжүүлэхээр төлөвлөсөн байна. Түмэн шувуут ХХК нь 2017 онд 13.2 тэрбум төгрөгийн борлуулалт, 1.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь компанийн удирдлагын чадавхи, үйл ажиллагаа явуулж буй салбарын онцлогыг харуулж байна.

Хүнсний салбар тэр дундаа өргөн хэрэглээний хүнсний салбар нь эдийн засгийн мөчлөгөөс үл хамаарч тогтвортой борлуулалтыг үзүүлдэг өвөрмөц онцлогтой бизнесийн салбар. Тэр ч

(Handwritten signature and stamp)



Үнэт цаасны танилцуулга



утгаараа компанийн борлуулалтын өсөлт сүүлийн жилүүдэд тогтмол нэмэгдэж жилд дунджаар 20-30 хувийн өсөлтийг үзүүлээд байна.

Компани цаашид авч хэрэгжүүлэх үндсэн 4-н бизнесийн төрөл нь бүгд хүнсний салбарт буй бөгөөд хүн амыг эрүүл хүнсээр хангахад нэн чухал өндөг, тахианы мах, ургамлын бордоо, малын тэжээл зэрэг өдөр тутмын эрэлт хэрэгцээ өндөртэй салбарууд байгаа юм. Тэр ч утгаараа компанийн хөгжил олон жил тогтвортой үргэлжилж Монголын хөрөнгийн зах зээлд өндөр байр суурийг эзлэх нь тодорхой байна. Үнэт цаас гаргагч нь Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн журамд заасны дагуу 1-р самбарын тавигдах шалгуур үзүүлэлтийг аль хэдийнэ хангасан буюу нийт борлуулалтын орлого 10 тэрбум төгрөгөөс дээш, цэвэр ашгийн хэмжээ 1 тэрбум төгрөгөөс давсан байдалтай байгаа нь компанийг хөрөнгийн биржид бүртгэлтэй болсон өдрөөс хойш нэр хүнд нь хөрөнгийн зах зээлд шууд тодорч гарч ирэх нөхцлийг бүрдүүлж байна.

Түмэн шувуут компанийн хувьцааг эзэмшин хөрөнгө оруулагч болсоноор Монголын хүнсний салбарт чанартай, найдвартай хүнс үйлдвэрлэх нэгэн компанийн хувь эзэмшигч болж цаашид авч хэрэгжүүлэх чухал алхмуудад хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийн дагуу санал бодлоо тусган, улс орны хүнсний аюулгүй байдалд хувь нэмрээ оруулах боломжтой болох юм. Компанийн тухай хуулийн 3.3 дагуу хувьцаа эзэмшигч нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хуралд оролцон компанийн удирдлагын түвшинд оролцох боломжтой бөгөөд нөгөө талаараа компанийн ашигт ажиллагаанаас ногдол ашиг хүртэх эрхтэй юм.

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч болж урт хугацааны хөрөнгө оруулагч болсноор жил бүрт тогтмол ногдол ашгийг аваад зогсохгүй хувьцааны үнийн өсөлтөөс өгөөж хүртэх боломжтой болох юм.

3.6 Цаашдын бизнес төлөвлөгөөний тойм;

Үнэт цаас гаргагчийн цаашдын бизнес төлөвлөгөөнд өндөгний үйл ажиллагааг тогтвортой эрхэлж явуулахаас гадна тэжээлийн зах зээлрүү нэвтэрч мал амьтан, тахиа шувууны тэжээлийг үйлдвэрлэж борлуулалтын сувгаа өргөжүүлэх ажлууд багтаж байна.

Өндөгний зах зээлд компани нийт өндөглөгч шувууны тоог 300,000-с давуулахгүй байх зорилготой бөгөөд энэ нь 8-н өндөглөгч шувууны байр, 2 дэгдээхэйний байр, 1 инкубатор төвийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулахад хүрэлцээтэй тоо юм. Цаашид өндөглөгч шувууны тоог нэмэхгүй байснаар компани үйлдвэрлэлийн үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх улмаар ашигт ажиллагааг сайжруулах боломжийг олгоод зогсохгүй, бүтээгдэхүүний чанарт анхааран стандартын түвшинг өндөрт барихад хувь нэмэр оруулна.

Цаашлаад Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны төлөвлөгөөнд мал амьтны тэжээлийн зах зээлд илүү анхаарал хандуулан дотоодын зах зээлд өндөр чанартай бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд анхааран ажиллах юм. Тэжээлийн зах зээл, өндөгний зах зээлтэй харьцуулахад 10-15 дахин том зах зээл бөгөөд уг салбарт дотоодын үйлдвэрийн өргөжин дэвших боломж маш өндөр байгааг Үнэт цаас гаргагчийн удирдлагууд мэдэрч уг зах зээлийг түлхүү хөгжүүлэхээр ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь дунд хугацаандаа өөрийн охин компани болох "Усжуулах" ХК-н Увс аймгийн Баруунтуруун сумын нутагт байрлах 2,300 га талбайд "Усалгаатай тариалан, гурил, малын тэжээл, мах үйлдвэрлэж экспортлох цогцолбор байгуулах" төслийг хэрэгжүүлж малын тэжээлийн олон наст ургамал, буудай, царгас зэрэг бүтээгдэхүүн тариалж цаашлаад хурганы аж ахуй байгуулах зорилготой бөгөөд улмаар экспортод мах гаргах боломжийг бүрдүүлэх юм.

Төслийн зорилго

Усалгаатайгаар газар тариалан эрхэлж, манай улсын эдийн засгийн чухал нэг салбар хөдөө аж ахуй, тэр дундаа мал аж ахуйн үйлдвэрлэлд шинэ хандлага, дэвшил буй болгон хөгжүүлэх, баруун бүсийн хүн ардыг эх орны үйлдвэрийн эрүүл, чанартай гурилаар хангах, мах

Үйлдвэрлэлийн технологид шинэчлэл хийж, махны экспортыг нэмэгдүүлэх, хөдөөгийн иргэд, малчдын амжиргааг дээшлүүлэхэд энэхүү төслийн зорилго оршино.

Зорилтууд

1. Дээд зэрэглэлийн чанартай гурил үйлдвэрлэн баруун аймгуудыг хангах
2. Уургаар баялаг хүчит тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, малын тэжээлийн хангамжийг сайжруулах
3. Мах үйлдвэрлэлд орчин үеийн технологи нэвтрүүлж, олон улсын стандартад нийцүүлэн махны экспортод дэвшил гаргах
4. Орон нутагт ажлын байр шинээр буй болгохоос гадна хөдөөгийн иргэд, малчдын бодит орлогыг нэмэгдүүлэх.

Хөрөнгө оруулалтын онцлох зүйлс - МАА-н үйлдвэрлэлийг эрчимжүүлэх хөгжлийн шинэ хандлага буй болгох

- Тарих нийт талбай 2300 га, үүнээс усалгаатай 2300 га
- Чанартай хүчит тэжээл үйлдвэрлэх
- Малчдаас хурга худалдан авч, бодит орлогыг нь нэмэгдүүлэх
- Олон улсын стандартад нийцсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан мах бэлтгэх
- Мал эмнэлэг, хорио цээрийн хяналт дор 2-3 сар байлгасны дараа малыг нядлах тул бэлтгэсэн мах нь хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагагыг баталгаатай хангасан байна.
- Энэ нь Монголд мах бэлтгэлийн цоо шинэ хандлагыг буй болгоно.
- Экспортын нэр төрлийг олшруулж, валютын хуримтлалыг нэмэгдүүлэх

Төслийн үндэслэл - Хөдөөг хөгжүүлэх, малчдын амьжиргааг дээшлүүлэх оновчтой гарц нь бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг шинэчлэх, эрчимжүүлэх явдал

- Баруун бүсийн 5 аймаг хүн амын гурилын хэрэгцээг Улаанбаатар хотоос тээвэрлэх юмуу ОХУ, БНХАУ-аас импортоор авч хангадаг.
- Уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр бэлчээр доройтон, нийт нутгийн 78% нь цөлжилтөнд өртөж, бэлчээр доройтон, 1990-ээд онтой харьцуулахад нэг га-гаас авах хадлан 2 дахин буурсан өнөөгийн нөхцөлд мал сүргийн тэжээлийн хангамжийг сайжруулах арга хэмжээ зайлшгүй чухал.
- Царгас нь шингэх протейн болон кальц, фосфор зэрэг зарим эрдэс бодисын агууламжаар бусад олон наст ургамлуудаас бараг 2 дахин их. 1 кг царгас нь шимт чанараараа 3 кг байгалийн өвстэй тэнцэх тул царгас тариалах нь малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх хамгийн шилдэг арга.
- Усалгаатай 1 га талбайгаас 110 цн ургац хураах боломж нь байгалийн хадлангаас 15 дахин их.
- Баруун аймгууд зах зээлээс алслагдмал, малын тоо толгой өсч байгаа ч малаа борлуулах боломж хязгаарлагдмал.
- АНУ, Европын холбоо, Ойрх Дорнодын орнуудад хурганы мах импортлох нь улам бүр ихсэж байна.

Төслийн танилцуулга

Төсөл хэрэгжүүлэх хугацаа: Төслийг хоёр үе шатаар хэрэгжүүлнэ.

1-р үе. 2018 – 2019 он. Бэлтгэх, эхлэх үе.

- 500 га-д 2018 онд царгас тариалж үрийн нөөцтэй болно.
- 500 га-д улаан буудай тариалж 1000 тн ургац хураан гурил үйлдвэрлэнэ.
- Бороожуулах тоног төхөөрөмжүүдийг худалдан авч угсарна.
- Өдөрт 100 тн хорголжин тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай тэжээлийн үйлдвэр байгуулна.

2-р үе. 2020 – 2021. Үндсэн үйл ажиллагаанд бүрэн шилжих.

- 1000 га-д царгас тариалж, 960 тн ургац хураана.
- 1000 га-д усалгаатайгаар, 500 га-д усалгаагүйгээр улаан буудай тариалж, 3200 тн ургац хурааж гурил үйлдвэрлэнэ.
- Тус бүрдээ 5000 хурга хурга бордох 6 байр барина.
- 120,000 хурга бордож, 1860 тн мах үйлдвэрлэнэ.
- Мал нядлах, мах боловсруулах үйлдвэр байгуулна.
- Мах хадгалах хөргөлттэй агуулах барина.

Төсөл хэрэгжүүлэх компанийн танилцуулга

“Усжуулах” ХК нь Увс аймгийн Баруунтурууны сангийн аж ахуйн өмчийг хувьчлахад төрийн өмчит хувьцаат компаний хэлбэрээр 1991 онд анх байгуулагдаж, 1998 онд өөрчлөгдөн зохион байгуулагдсан. Компаний үндсэн үйл ажиллагаа нь газар тариалан, мал аж ахуй, үйлдвэрлэл, худалдаа. Байгуулагдсанаасаа хойш эдүгээ хүртэл жил бүр 324-540 га-д усалгаатайгаар үр тариа, малын тэжээл тарьж байна. 2004 онд 108 га-д царгас тариалж 8 жил ургац хураан жилд дунджаар 13,000 боодол (325 тн) хадлан бэлтгэж байсан. Сүүлийн жилүүдэд зөвхөн улаан буудай тариалж, га тутмаас 12-17 ц ургац хурааж, түүгээрээ өөрийн гурилын үйлдвэрт чанар сайтай гурил үйлдвэрлэн Увс аймагт төдийгүй, Завхан, Ховд, Баян-өлгий аймгуудын хэрэгцээг хангаж байна.

Компани жил дараалан аймаг, сумандаа шилдэг аж ахуйн нэгжээр шалгарсан. Газар тариалан, мал аж ахуй эрхлэх туршлагатай, мэргэшсэн ажилтнуудтай.

Усжуулах системийн онцлог, давуу тал.

- Хан хөхийн нуруунаас эх авсан Туруун гол дээрх услалтын системийн цөөрөм нь 15 сая м3 ус хуримтлуулах багтаамжтай. Энэ нь 4000 га талбайг услахад хүрэлцэнэ.
- Ган болоход ус дутагдах эрсдэлгүй
- Ус дамжуулах шугам хоолой, толгойн байгууламж нь найдвартай.

Төслийн нийгэм эдийн засгийн ач холбогдол

- Бэлчээр доройтон, хадлан хомсдож байгаа өнөө үед зөвхөн баруун аймгуудын төдийгүй төвийн аймгуудын малын тэжээлийнх нь нилээд хувийг найдвартай хангах боломж бүрдэнэ.
- Баруун аймгуудыг чанартай, үнэ хямд экологийн хувьд цэвэр гурилаар хангана
- Өвөл хаварт үлэмж гардаг нэг хүртлэх насны малын зүй бус хорогдол эрс багасна.
- Хургыг одоогийн зах зээлийн ханшнаас 2 дахин илүү үнээр худалдан авснаар малчдын орлого нэмэгдэнэ.
- 100 гаруй ажлын байр шинээр буй болно.
- Суурин, хагас суурин маллагаатай мал аж ахуй эрхэлдэг аж ахуйнуудын тэжээлийн хангамж сайжирна.
- Дэлхийн зах зээлд царгасны хэрэглээ их тул Хятад, Солонгос, Японд борлуулах боломжтой.
- Хурганы махыг Арабын Нэгдсэн Эмират, БНХАУ зэрэг оронд гаргах боломжтой. Ингэснээр Монголын экспортын нэр төрөл, хэмжээ нэмэгдэж, валютын орлого арвижна.

Гурил үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлага

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд импортын хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх, улмаар экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нэн чухал юм. Хүнсний тухай хууль”-ийн 3 дугаар



зүйлийн 3.1.6 дахь заалтад “стратегийн хүнс” гэж монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаанбуудай, гурил, ундны усыг хэлнэ гэж заасан байдаг. Эрүүл мэндийн сайдын 2008 оны 257 тоот тушаалаар баталсан “Жишсэн дундаж хүний илчлэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-нд заасны дагуу жишсэн дундаж нэг хүний хоногт хэрэглэх гурил (100 гр/хоног), гурилан бүтээгдэхүүний (220 гр/хоног) хэмжээг үндэслэн тооцов.

Гурилын дотоодын үйлдвэрлэл, импортын тоо хэмжээ

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Хүн амын хэрэгцээ	253,8	258,7	263,3	267,4	276,1	285,2	294,6
Дотоодын үйлдвэрлэл	143,4	105,2	114,8	246,4	239,4		
Дотоодын үйлдвэрлэлийн %	56,5	40,6	42,9	92,1	86,7		
Импортлосон	Гурил	71,1	70,5	50,3	23,9	11,6	
	Улаан буудай	66,2	7,3	4,0	12,0	34,2	

Хүснэгт: 18 Гурилын дотоодын үйлдвэрлэл, Эх сурвалж: ГЕГ, ҮСХ

Манай улс гурил үйлдвэрлэлээрээ өөрийн орны хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгаа бөгөөд зарим жил (2011, 2012 онд) дөнгөж 40 гаруйхан хувийг үйлдвэрлэж, гурилын хэрэгцээний 15-60 хувийг жил бүр гадаадаас худалдан авч байна. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас зөвхөн говь, хээрийн бүсд төдийгүй газар тариалангийн голлох нутагт ч хур тундас багасаж, таримал ургамлын ид ургалтын үе YI-YII сард бороо орохгүй байх, зарим жил бүүр ган болох тохиолдол ихэссэнээс улаанбуудайн ургац алдаж, гадаадаас авдаг үр тариа, гурилаа үлэмж нэмэгдүүлэх шаардлага тулгардаг. Иймд усалгаатайгаар улаанбуудай тариалах нь байгаль цаг уурын нөхцлөөс хамаарахгүйгээр ургац арвин хурааж, гурилын үйлдвэрлэлийг тогтортой байлгах баталгаатай нөхцөл юм.

Баруун бүс буюу Завхан, Увс, Баян-өлгий, Ховд, Говь-алтай аймгуудад улаанбуудай бараг тариалдаггүй, зарим суманд гурилын жижигхэн цех ажилладагаас өөр гурилын үйлдвэр байхгүй. Хүн ардын гурилын хэрэгцээг Улаанбаатар хотоос тээвэрлэж, эсвэл Орос, Хятад улсаас импортоор оруулж хангаж байгаас нэг кг гурилын үнэ төвийн бүсээс дор хаяж 20-70 төгрөгөөр илүү байна.

Мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлага



НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын мэдээлснээр сүүлийн 10 жилд дэлхийн хүн амын махны хэрэглээний жилийн дундаж өсөлт 2.7 % байгаа ажээ. Эдүгээ дэлхий дахинаа өөх багатай, зөөлөн шүүслэг махны хэрэглээ их болж буйтай холбоотойгоор өсвөр малыг шахан бордох нь ихсэж байна.

Дэлхийн хүн ам түргэн өсч, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хүнсний хангамж түүнээс үлэмж хоцорч байгаа тул улс орнууд хүн амыг амьтны гаралтай уургаар хангахад ихээхэн анхаарч, махны арилжаа улам бүр ихсэж байна.

Судлаачид монгол мал жил тойрон байгалийн бэлчээрт идээшилж, амтлаг ургамлыг өөрөө сонгон иддэг, нөгөөтэйгүүр монголын уудам нутгийн өвс ургамал, ус химийн ямар нэг бодисоор бохирдоогүй учир малын мах нь эмчилгээ - сувиллын ач холбогдолтой биологийн идэвхт бодисын агууламж ихтэй, экологийн цэвэр бүтээгдэхүүн хэмээн дүгнэдэг. Манай улс бэлчээрийн мал аж ахуй эрхлэдэг учраас мах бэлтгэл улирлын чанартай. Улсын хэмжээнд жилд дунджаар 8.2 гаруй сая толгой мал хүнсэнд хэрэглэж, 200 орчим мян.тн мах үйлдвэрлэн, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангадаг.

Одоо манай улсад байгаа мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн тоо:

- Мал нядлах, эхлэн боловсруулах - 42
- Хиам, нөөшилсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэх - 131
- Хагас боловсруулах - 21



Нийт үйлдвэрийн нядалгааны хүчин чадал: жилд 18620 толгой бог, 3600 толгой бод мал

- Хөлдөөлтийн хүчин чадал - 11,60.2 тн
- Хөргөлттэй агуулахын хүчин чадал - 80,237 тн.

Мах үйлдвэрлэлийн салбарт хүн амыг чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан мах, махан бүтээгдэхүүнээр жилийн турш, жигд тогтвортой хангах, үйлдвэрийн аргаар боловсруулж, эрүүл ахуйн шаардлагад бүрэн нийцсэн мах бэлтгэх, махны экспортыг нэмэгдүүлэх нь махны үйлдвэрлэлийн салбарын нэн чухал зорилт юм. Хэрэглэгчдийн хүнсэндээ хэрэглэж буй нийт махны 10 хүрэхгүй хувь нь стандартын шаардлага хангадаг байна. Мөн мах бэлтгэлийн дийлэнх хувийг үйлдвэрлэлийн бус уламжлалт гар аргаар бэлтгэж, стандартын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг нь махны бохирдлыг ихэсгэж, эрүүл ахуйн стандартын шаардлагыг хангахгүйд хүргэдэг.

№	Аймгийн нэр	Үйлдвэрийн үйл ажиллагааны чиглэл			Бүгд
		Мал нядлах, мах боловсруулах	Хиам, консерв үйлдвэрлэх	Өлөн гэдэс, хүнсний тос үйлдвэрлэх	
1	Архангай	1		1	2
2	Баян-Өлгий	4	1	2	7
3	Баянхонгор		1	2	3
4	Булган				0
5	Говь-Алтай		2		2
6	Дорнод	2	6		8
7	Дундговь		1	1	2
8	Дорноговь		2		2
9	Завхан	1	1	1	3
10	Өвөрхангай	1		1	2
11	Өмнөговь				0
12	Сүхбаатар	1	1		2
13	Сэлэнгэ	2			2
14	Төв				0
15	Увс	1	4	2	7
16	Ховд	2	3	2	7
17	Хөвсгөл		1	1	2
18	Хэнтий	2			2
19	Дархан-Уул	1	6	1	8
20	Орхон	3	3		6
21	Говьсүмбэр				0

Хүснэгт: 19 Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, Эх сурвалж: ҮСХ


Он	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Мян.тн	7.8	11.5	10.9	10.3	18.0	26.0	10.2	3.1	3.0	2.2	2.8	8.5

Хүснэгт: 20 Экспортлосон мах (Мянган тн)

Мах үйлдвэрлэлтэй холбогдсон төрийн бодлого, баримт бичгүүдэд мал бордох аж ахуй хөгжүүлэх, махны экспортыг нэмэгдүүлэхийг чухалчлан заасан.

Манай улс 2014 онд ОХУ-д 37 тн, 2016 онд БНХАУ-д 107.2 тн хонины мах экспортлосон. Хэрэв манай улсын бэлтгэж буй мах нь мал амьтнаас хүнд халдварладаг зооноз болон халдварт өвчнөөс ангид гэдэг нь баталгаатай, мал эмнэлэг, эрүүл ахуйн шаардлагад бүрэн нийцсэн байвал зөвхөн хойт, урд хөршөөр тогтохгүй бусад орнуудад экспортлох боломж хангалттай бий.





Гурил үйлдвэрлэх боломж

Байгалийн нөхцөл, уур амьсгал

Манай улсад 1922 оноос газар тариалан эрхэлдэг улсын сангийн аж ахуйнууд байгуулагдаж эхэлсэн бөгөөд 1929 онд Увс аймагт “Улаан сангийн тариалан” нэртэй байгуулагдсан сангийн аж ахуй нь одоогийн Баруунтуруун сумын эх үүсвэр юм. Баруунтуруун сум 329.2 мянган га нутаг дэвсгэртэй. Нийт нутгийн 54.1 % буюу 278.3 мянган га-г ХАА-н эдэлбэр газар эзэлнэ. Баруунтуруун сум царгас тариалахад байгаль цаг уурын нөхцлийн хувьд боломжтой нутаг. Баруунтурууны жилийн дундаж агаарын температур -40С хэм, нэгдүгээр сарын дундаж хэм -25-350С, заримдаа -400С, долдугаар сард +300С. Урьд -45 (1965 онд -520С) хүрч хүйтэрч байсан. Сүүлийн жилүүдэд -40 хэмээс хэтэрдэггүй болсон. Мөн зун хэт халах нь багассан. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 218.3 мм, ерөнхийдөө 250-350 мм. Нийт тундасны 60-65 % нь VII-VIII сард унадаг. Цас их унадаг. X сарын дундаас дараа жилийн IV сарын дунд хүртэл цасан бүрхүүл тогтдог. Ихэнхдээ цасны зузаан 20 см, зарим жил 33 см, хамгийн бага нь 18 см.


Он	Жилийн агаарын дундаж температур (°C)		Жилийн нийлбэр хур тунадас (мм)		Жилийн дундаж дулааны нийлбэр		Жилийн цэлмэг өдрийн тоо	
1997	- 1.6	- 2.1	219.4	236.8	-	-	27	88
1998	- 0.1	- 1.0	85.7	292.8	-	-	32	63
1999	- 1.0	- 2.0	111.0	176.6	2745.0	2574.6	29	62
2000	- 2.7	- 3.2	155.7	247.7	2700.7	2586.2	31	54
2001	- 1.2	- 1.9	101.4	200.3	2792.1	2635.2	22	52
2002	- 1.2	- 1.6	87,9	171.1	2784.9	2748.3	27	59
2003	- 2.8	- 3.5	242.8	296.0	2540.8	2334.0	35	50
2004	- 1.5	- 2.1	132.1	193.3	2630.8	2522.3	41	64
2005	- 3.3	- 4.1	122.8	212.5	2695.3	2499.3	55	88
2006	- 1.3	- 2.0	154.6	212.8	2461.5	2302.0	33	50
2007	- 0.3	- 1.1	81.4	184.3	2892.3	2747.7	38	59
2008	- 1.5	- 2.3	107.1	201.7	2753.9	2560.9	32	62
2009	- 3.2	- 3.8	118.4	172.7	2590.6	2397.6	23	55
2010	- 3.1	- 4.1	163.5	305.6	2568.3	2376.2	30	62
2011	- 2.4	- 3.4	73,4	184.9	2670.1	2483.3	38	90
2012	- 3.1	- 4.1	166.3	288.6	2741.4	2521.4	17	72
2013	- 0.7	- 2.2	153.4	258.3	2526.3	2305.8	7	37
2014	- 1.8	- 2.4	103.7	197.6	2651.9	2510.2	16	53
2015	- 0.3	- 1.1	118.8	127,7	2852.6	2700.1	32	38
2016	- 2.3	- 3.2	215.9	261.6	2728.9	2556.3	18	37

Хүснэгт: 21 Увс аймгийн цаг агаарын түүхэн мэдээ

Сүүлийн 20 жилийн цаг агаарын мэдээнээс үзэхэд, жилийн агаарын дундаж температур, жилийн нийлбэр хур тунадас, жилийн дулааны нийлбэр зэрэг нь газар тариалан эрхлэхэд таатай нөхцөл байгаа нь нэн чухал боломж юм.

Тоног төхөөрөмж, туршлага

Төсөл хэрэгжүүлэгч “Усжуулах” компани Увс аймгийн Баруунтуруун суманд сүүлийн 8 жил 320-540 га талбайд улаан буудай тариалж, га тутмаас 12-17 ц ургац хурааж, түүгээрээ чанар сайтай “Хан хөхий” гурил үйлдвэрлэн Увс аймагт төдийгүй, Завхан, Ховд, Баян-өлгий аймгуудад борлуулж хангаж байна. Тус компани өөрийн гурилын үйлдвэртэй. Энэхүү үйлдвэр хоногт 20 тн гурил үйлдвэрлэх хүчин чадалтай. Байнгын туршлагажсан ажилчидтай.



“Усжуулах” компани Увс аймгийн Баруунтуруун сумын Туруун гол дээр 1980-аад оны сүүлчээр барьсан усалтын системийг эзэмшдэг. Уг усалтын системийн зарим хэсгийг зураг 1, 2, 3, 4–д харуулав.



Зураг 26 Усалтын системийн толгойн байгууламж, ус хуримтлуулсан цөөрөм



Зураг 27 Толгойн байгууламжаас илүүдэл ус дамжуулах хэсэг



Зураг 28 Илүүдэл усыг Туруун голоор урсгах хэсэг

“Усжуулах” компани 2017 онд Баруунтуруун сумын “Хар цагаан ус” гэдэг газарт урьд тариа тарьж байсан атарсан 10,000 га талбайг эзэмшихээр шилжүүлж авсан. Энэ талбайд усалгаагүйгээр улаанбуудай тариална.

Малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тэжээлийн чанарыг сайжруулах

Уургийн “хаан ургамал” гэддэг царгас дэлхийн бөмбөрцгийн умарт өргөргийн 200-өөс 400 хооронд далайн түвшнээс 2500 м-ийн өндөр хүртэл, уул өөд өгсөж тархсан. Байгалийн нөхцлийн хувьд 300 мм орчим тундастай, 1-р сарын дундаж температур – 16 хэм, 7-р сарынх +20 хэм, дулаан хангамж нийлбэрээр цельсийн 2200—4000 хэм газар царгас тариалахад хамгийн тохиромжтой нутаг.

Манай оронд 1987-1988 оноос царгас хөтөлбөр боловсруулж, ХААЯ-ны дэргэдэх Хөдөө аж ахуйн Шинжлэх ухааны зөвлөл удирдан эхний шатыг нь 1988-1990 онд хэрэгжүүлсэн.

Судлаачид Монголд царгас тариалахад боломжтой бүс нутгийг далайн түвшнээс 1500-2000 м өргөгдсөн өргөн хөндийнүүд буюу жилийн дундаж тундас 340-460 мм, 1-р сарын температур -20-250C 7-р сарынх +150C нутаг гэж тэмдэглэдэг. Монголын Их нууруудын хотгорт дулаан хангамж 1000-14000C. Энэ нь таримал ургамал ургах нэн тааламжтай нөхцөл.

Манай орны зарим аж ахуйнуудын туршлагаас үзэхэд, олон наст ургамлуудыг царгастай хольж тариалахад га-гаас авах ургац нэмэгдэж, дунджаар 53.3 ц буюу дангаар тариалснаас 14.4 % илүү (олонх тохиолдолд 25 %-иас илүү), усалгаатай нөхцөлд 116.3 ц/га хүрдэг байна.

Увс аймгийн Баруунтуруун суманд 1980-аад оны сүүлчээр барьсан, 4000 га талбайг услах хүчин чадал бүхий усалтын томоохон систем байдаг. Энэхүү усалтын систем нь Хан хөхийн нуруунаас эх авсан Туруун гол дээр баригдсан бөгөөд голын болон шар усны үерийн ус хуримтлуулах цөөрөм нь 15 сая м3 багтаамжтай. Бороо хур бага юмуу ямар ч гантай жил тариалангийн талбайн усалгаа багасах эрсдэлгүй.


Увс аймгийн Тариалан суманд тариалж буй царгасны 2017 оны 8-р сарын сүүлчээр хураасан ургацнаас дээж авч, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Малын тэжээл үнэлгээний лабораторт шинжлүүлэв.

Царгасны тэжээллэг чанарын гол үзүүлэлтүүд (%-иар)

Чийг	Нийт үүраг	Нийт эслэг	Нийт тослог	Нийт үнс
6.6	14.3	20.7	1.7	15.6

Хүснэгт: 22 Царгасны тэжээллэг чанарын үзүүлэлт

Үнэт цаас гаргагч Баруунтуруун сумын Бортын хошуу хэмээх газрын усалгаатай тариалангийн талбайн атаршсан болон одоо ашиглаж буй хэсгээс 2017 оны 10-р сард хөрсний дээж авч,



Үнэт цаасны танилцуулга



"НАРТ ШУУН КОНСАЛТИНГ" ХХК-ны хөрсний физик химийн задлан шинжилгээний лабораторт шинжлүүлсэн.

Дээж авсан гүн см	рН	ЦДЧ %	Давс %	Ялзмаг %	Шингээгдсэн сууриуд Экв мг/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр		
					Ca	Mg	NO ₃	P ₂ O ₅	K ₂ O
10-аас дээш жил тариа тариагүй, атаршсан									
0-10	8.3	0.145	0.05	1.47	8	7	0.14	1.2	19
10-20	8.3	0.125	0.04	1.55	10	5	0.08	0.9	12
20-30	8.3	0.075	0.02	0.99	8	7	0.11	0.6	11
Сүүлийн жилүүдэд тасралтгүй тариа тарьж буй									
0-10	8.1	0.087	0.03	1.49	14	4	0.08	0.3	15
10-20	8.0	0.099	0.03	1.26	15	5	0.10	1.2	12
20-30	8.0	0.042	0.01	0.65	14	5	0.07	0.7	8

Хүснэгт: 23 Баруунтуруун сумын Бортын хошууны тариалангийн талбайн хөрсний шинжилгээ 2017 оны 10-р сард

Шинжилгээний дүнгээс үзэхэд хөрсний урвалын орчин рН=8.0-8.4 буюу сул шүлтлэг байгаа нь таримал ургамалд тийм ч таатай биш, Нитрат азот (NO₃) хөдөлгөөнт фосфор (P₂O₅) солилцох кали (K₂O), ялзмагийн хэмжээ зэрэг үзүүлэлт "дунд зэргийн хангамжтай" хэмжээнд байгаа нь тарих ургамлынхаа төрөлд нийцүүлэн хөрсний боловсруулалтыг хийх шаардлагатайг харуулж байна.

Царгас нь хөрсийг азотоор баяжуулан сайжруулдаг тул нэмэлт ямар нэг бордооны шаардлагагүй.

Хүчин чадал сайтай, найдвартай услалтын системээс гадна усалгаагүйгээр ч газар тариалан эрхлэхэд цаг уурын хувьд боломжтой, мөн урьд газар тариаланд ашиглаж байсан, үржил шим сайтай хөрс бүхий атаршсан талбай ихтэй, тэдгээрт тэжээлийн ургамал болон үр тариа тариалж, түүндээ тулгуурлан хүчит тэжээлийн үйлдвэр байгуулан ажиллуулах боломжтой.

Махны үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх

1970-аад онд манай оронд нутгийн үүлдрийн хонины хургыг бордон, мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх судалгаа туршилтын ажил амжилттай хийгдэж байсан. Тэр үед Засгийн газрын дэргэд "Махны нөөц нэмэгдүүлэх" улсын комисс байгуулагдан монгол хонины хургыг 8-р сард эхээс ялган отроор таргалуулж, дараа нь 11-р сараас байран маллагааны нөхцөлд бордож, амьдын жинг үлэмж нэмэгдүүлэн нядалж, мах үйлдвэрлэх ажил нилээд өргөн хүрээтэй хийгдсэн. Тэр үед хийгдсэн судалгаанаас үзэхэд, 23-29 кг амьдын жинтэй хургыг 8-р сарын дундуур эхээс ялган, бэлчээрээр оторлож 1/XI нээс 30-45 хоног бордон 36.5-43.2 кг-д хүргэн нядалсан. Хурганы хоногийн дундаж нэмэгдэл жин 133-163 гр, нядлагын гарц 52.3-55.0 % байжээ. Тэгэхэд ердийн бэлчээрийн маллагаанд байсан хурганы нядлагын гарц 43.7-44.0 % байсан аж.


Монгол хонины махны гарц

(Г.Чадраабал, Н.Баясгалан, Д.Чойжил нарынхаар)

Тарга хүч	Амьдын жин (кг)	Гулуузны жин (кг)	Гулуузны гарц(%)
Дундаас дээш	45,8	21,5	46,9
Дунд	43,5	19,5	44,7
Дундаас доош	40,5	17,0	41,9

Хүснэгт: 24 Монгол хонины махны гарц

Үнэт цаасны танилцуулга



Хурга бордох тэжээлийн загвар жор (кг-аар)	
Өвс	0.8 - 1.0
Хивэг, багсармал тэжээл	0.2
Няцалсан хошуу будуу	0.3-0.4
Тэжээлийн нэгж	1.1-1.3

Эрдэс тэжээлийг байранд байнга тавьж, дураар идүүлнэ. Бүдүүн тэжээлийг сараалжинд, хүчит болон эрдэс тэжээлийг онгоцонд өгнө. Бордож байгаа байранд ус байнга байлгах, эсвэл өдөрт 2-3 удаа ханатал усална.

Увс аймаг 2016 оны жилийн эцсийн байдлаар 1376.4 мянган хоньтой, үүний 639.1 мянга нь хээлтэгч, сүүлийн 4 жилд жил бүр 400000 мянга гаруй хурга бойжуулж байна. Жил бүр 100 мянган хурга бордож, маханд борлуулахад Увс аймгийн тухайн жилд бойжуулсан хурганы дөнгөж 20 орчим хувь болно.

Тэрчлэн махны үйлдвэр байгуулахаар төлөвлөж буй Баруунтуруун суманд ойролцоо Завхан аймгийн Баянтэс, Баянхайрхан, Нөмрөг Ургамал зэрэг 10 сумын нийт хонь нь 1717.2 мянга, жилд 140000 мянга гаруй хурга бойжуулдаг. Тэдгээр сумдаас манай шаардлага, стандартад нийцсэн хурга худалдан авах боломжтой.

Увс аймгийн 2016 онд бойжуулсан хурга


№	Сум	Хонины тоо	Үүнээс хээлтэгч	Төллөсөн	Гарсан хурга	Бойжсон хурга	Төллөлт %	Хурга бойжилт %
1.	Баруунтуруун	22 587	11143	8160	8190	7027	73,2	85,7
2.	Бөхмөрөн	52541	25199	18238	18239	15300	72,3	83,9
3.	Давст	34730	17339	11119	11119	10676	64,1	96,0
4.	Завхан	33958	14929	9867	9920	9376	66,1	94,5
6.	Зүүнговь	60832	29349	23352	23387	19465	79,5	83,2
7.	Зүүнхангай	78083	36886	32013	32114	25906	86,7	80,6
8.	Малчин	93956	40964	37538	37668	34105	91,6	90,5
9.	Наранбулаг	112506	48612	40638	40898	37117	83,6	90,7
10.	Өлгий	41543	19016	15980	16029	11793	84,0	73,5
11.	Өмнөговь	93624	42322	28658	28712	23688	67,7	82,5
12.	Өндөрхангай	79836	41161	33385	33394	23360	81,1	69,9
13.	Сагил	73038	34206	26283	26283	25381	76,8	96,5
14.	Тариалан	75228	33240	28434	28450	25475	85,5	89,5
15.	Түргэн	66814	32125	26254	26280	23970	81,7	91,2
16.	Тэс	162967	79375	54378	54520	51080	68,5	93,6
17.	Ховд	42633	19217	16228	16376	15617	84,4	95,3
18.	Хяргас	102883	43839	37702	37738	35495	86,0	94,0
19.	Цагаанхайрхан	70279	31418	22422	22422	17764	71,3	79,2
20.	Улаангом	78445	38842	32654	32657	31236	84,0	95,6
Бүгд		1376483	639182	503303	504396	443831	78,7	87,9


Хүснэгт: 25 Увс аймгийн 2016 онд бойжуулсан хурга

Бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ

Гурилын хэрэглээ

Гурил манай улсын хүн ардын хамгийн өргөн хэрэглээт хүнсний барааны нэг. Хувийн хэвшлийн компани, аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгө оруулалтаар техник, технологийн шинэчлэл хийж, гурилын томоохон үйлдвэрүүд барьж ашиглалтад оруулж байна. Тухайлбал,





Үнэт цаасны танилцуулга



“Талх чихэр” ХК БНЧУ-аас шинэ тоног төхөөрөмж, Орхон аймгийн “Эрдэнэт гурил” ХХК хоногт 150 тонн улаанбуудай, 30 тонн хөх тарианы буудайүйлдвэр, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Хөтөл тосгонд “Жавхлант групп” ХХК хоногт 120 тонн улаанбуудай боловсруулах хүчин чадалтай БНХАУ-ын тоног төхөөрөмжтэй үйлдвэрүүдийг тус тус ашиглалтанд оруулаад байна.

Засгийн газраас хүн амын нэн хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний нэг болох гурилын хангамж болон үнийг тогтвортой байлгахад анхаарч, “Гурилын үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд 2013 онд 23 гурилын үйлдвэрт 48,7 тэрбум төгрөгийн хөнгөлттэй зээлийг олгож, 1 кг 1-р зэргийн гурилын бөөний үнийг 550 төгрөг, жижиглэнгийн үнийг 650 төгрөгт тогтвортой байлгасан. Хөнгөлөлттэй зээл авсан гурилын үйлдвэрүүд нь 141.3 мянган тонн гурил үйлдвэрлэсэн нь хэрэгцээт гурилын 57,7%-ийг хангасан байна. 2014 онд 17 гурилын үйлдвэртэй гэрээ байгуулж, 11 үйлдвэр 49,0 тэрбум төгрөгийн зээл авч, 1 кг 1-р зэргийн гурилын бөөний үнийг 850 төгрөгт тогтвортой байлгахаар гэрээ байгуулж, 167.4 мян.тн гурил үйлдвэрлэсэн нь хэрэгцээт гурилын 70%-ийг хангасан байна.

Малын тэжээлийн хэрэглээ

Хэдийгээр манай улс бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг, мал нь жилийн турш зөвхөн байгалийн бэлчээрт маллагддаг ч гэсэн 12-р сараас дараа оны 5-р сар хүртэл 90-120 хоног нэмэгдэл тэжээл өгөх зайлшгүй шаарддага байдаг ч тэжээлийн хүрэлцдэггүйгээс төллөсөн болон ядарч доройтсон хонь, ямаа, үнээ, хурга, ишиг тугалд л бага хэмжээний нэмэгдэл тэжээл өгч байна. Тэгвч тэжээлийн хэмжээ, шимт чанар нь дээрх малуудын бие махбодын хэрэгцээг бүрэн хангаж чаддаггүй. Одоо манай улсад бэлтгэж байгаа тэжээл нь нийт малыг хонин толгойд шилжүүлэх тооцоход ердөө л 7 хоног өгөхөд хүрэлцэх хэмжээ юм. Нэмэгдэл тэжээл нь хадлангийн өвс болон үйлдвэрийн аргаар бэлтгэсэн хүчит тэжээл (хивэг, багсармал, хорголжин тэжээл) гар аргаар бэлтгэсэн тэжээлээс бүрддэг. Жилээс жилд өсч байгаа малыг байгалийн эрсдлээс хамгаалах, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тогтвортой байлгах, мөн сүүлийн жилүүдэд шинээр үүсч хөгжиж байгаа саалийн болон махны фермерийн аж ахуйнуудын малын тэжээлийн хангамжийг сайжруулахад үйлдвэрийн аргаар тэжээл бэлтгэхийг нэмэгдүүлэх, тэжээлийн төрлийг олшруулах, чанарыг сайжруулах шаардлага улам ихсэж байна.


Малын төрөл, ашиг шимийн чиглэл, гарц хэмжээнд нийцүүлэн тэжээлийн жор, найрлагыг шинжлэх ухааны үндэстэй тооцох, тэжээл үйлдвэрлэхдээ малд шаардлагатай шимт бодис, эрдэс, амин дэмийг зохистойгоор тохируулах шаардлага тавигдах боллоо.

Дэлхийн улс орнууд тэжээх мал амьтныхаа төрөл, ашиг шимд тохируулан олон янзын жороор багсармал тэжээл үйлдвэрлэдэг бөгөөд манай улс МААЭШХ-гийн Бэлчээр тэжээлийн салбарын эрдэмтдийн зохиосон 30 шахам жороор багсармал, хорголжин тэжээлийг үйлдвэрлэж байна. Багсармал тэжээлийн жорд 6-8 төрлийн түүхий эд орж байна. Манай тэжээлийн үйлдвэрүүдийн үйлдвэрлэж байгаа, бүх төрлийн малд зориулсан багсармал тэжээлийн жишиг жор доор бүрэлдэхүүнтэй (%) байна.

1. Улаанбуудайн хивэг	34
2. Улаанбуудайн сүрэл	30
3. Улаанбуудай	14
4. Хошуу будаа	10
5. Арвай	10
6. Давс	2
7. Бүгд	100


Царгас бол 3000 жилийн тэртээгээс тарималжсан, дэлхийн таван тивийн 90 гаруй улсад 40 шахам сая га-д тариалагдаж байгаа олон наст буурцагт, өвслөг ургамал юм.

Яагаад царгасны хэрэглээ дэлхий дахинаа ийнхүү их байна вэ?





Үнэт цаасны танилцуулга



Царгас нь протеин ба үл төлөөлөгдөх амин хүчил, нүүрс ус, эрдэс давс бусад бодисын зохистой харьцаа бүрдсэн малын тэжээлийн гойд сайн ач холбогдолтой ургамал. Царгасыг дэлхийн улс орнууд уургийн "хаан" гэж нэрлэдэг. АНУ, Канад, Герман, Франц, Хятад зэрэг олон улс царгасыг олон мянган га талбайд тариалж малын тэжээлийнхээ хэрэгцээг бараг бүрэн хангагдаас гадна олон нэр төрлийн уурагт тэжээл үйлдвэрлэн гадаадад гаргаж байна. Цэцэглэлтийн үед нь хадаж бэлтгэсэн царгасны 1 кг өвс 18-20 хувийн протеинтэй, 13-14 г кальц, 2-5 г фосфор, 8-9 г зэс агуулсан байдаг. Энэ нь олон наст үет ургамлынхаас бараг хоёр дахин их үзүүлэлт юм. Судалгаанаас үзэхэд, таримал царгас нэгж талбайгаас авах протеины хэмжээгээр шар буурцагнаас 3-5 дахин, улаан буудайнаас 6,3 дахин их байдаг. Энэ утгаараа шимт чанарын хувьд байгалийн хадлангаас 2-3 дахин илүү.

Царгас хөрсний үржил шимийг нөхөн сэргээдэг. Аливаа ургамал хөрснөөс шимт бодис авч, хөрсийг ямагт ядууруулж байдаг бол царгас нь хөрсний үржил шимийг тэтгэдэг онцлогтой. Тухайлбал, царгас тарьсан талбайн га тутамд жилд 250-290 кг, заримдаа 500 кг хүртэл ургамалд хялбар шингэх азот хуримтлагддаг. Энэ нь 1 га талбайг 4-5 ц азотын бордоо буюу 30-50 тн бууцаар бордсонтой тэнцэнэ. Царгас тариалаад 4-5 жил болоход хөрсний үржил шим 45-50 хувиар дээшилж, нийт азот 5-7 дахин нэмэгдэж, хөрсний бүтэц эрс сайжирна. Академич Прянишников "Царгас тариалсан нэг сая га талбай бүр нь томоохон хүчин чадалтай азотын бордооны хэд хэдэн үйлдвэрийн үйлдвэрлэх хэмжээний ургамалд ашиглагдах азотоор хөрсийг баяжуулдаг" гэж дүгнэсэн байдаг. Түүнчлэн царгасыг нэг удаа тариад 10-15 жил хадаж ашигладаг. Нэг га талбайгаас 8-10 тонн өвс хураан авдаг. Энэ нь байгалийн хадлангийн 24-30 тонн өвстэй тэнцдэг.

2013 оны байдлаарх царгас тариалалтыг тивээр авч үзвэл, Хойд Америк 11.9 сая га-д (Дэлхийн нийт царгас тариалсан талбайн 41%), Европ 7.12 сая га (25%), Өмнөд Америк 7 сая га (23%) Ази 2.23 сая га (8%)-д царгас тариалжээ. (Африк 2% , Австрали тив 1%). Царгас хамгийн их тариалдаг орнууд : Америк 9 сая га, Аргентин 6.9 сая га, Канад 2 сая га, Орос 1.8 сая, Итали 1.3 сая га, Хятад 1.3 сая га. Америк 2016 онд 57,5 сая тонн царгас хураан авсан байна. Үүнийнхээ 12.6% -ийг буюу 7,3 сая тонныг экспортоложээ.


Манай оронд 1988 онд царгасны үр үржүүлэх "Царгас" хөтөлбөр батлагдаж Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны зөвлөл удирдан 1988-1991 онд хэрэгжүүлж байв.

Хонь, хурганы махны хэрэглээ

2016 оны байдлаар дэлхийн хэмжээнд хонины тоо 1960 оны хэмжээнд байгаа ч, харин хонины махны хэрэглээ 5.0 тэрбум тн байснаа 8.2 тэрбум тн болж өсчээ. Хонины мах үйлдвэрлэгч зарим гол орнуудад хонины тоо цөөрсөн байна. Тухайлбал, Австрали улс 1992 онд 163 сая хоньтой байсан бол 2002 онд 111.0 сая, 2016 онд 70.0 сая болж, Шинэ Зеландынх 1990 онд 170 сая байснаа 2014 онд 72.0 сая, Европын холбооны улсуудынх 2000 онд 102.0 сая байснаа 2011 онд 85.0 сая болон цөөрчээ. Харин Хятад, Энэтхэг, Пакистан болон Хойд Африкт хонины тоо ч, мах үйлдвэрлэлийн хэмжээ ч өсч байна. Одоогийн байдлаар хонины мах үйлдвэрлэлээр Хятад улс дэлхийд тэргүүлж, дараа нь Европын Холбоо, Австрали, Шинэ Зеланд орж байна.

Хонины махны хэрэглээ дэлхийн улс орнуудад харилцан адилгүй байна. Ази болон Мексикт махны хэрэглээ нь өсч байхад АНУ, Австрали, Европын орнуудад 1965 онтой харьцуулахад 50% гаруй буурчээ. Дэлхийн дунджаар нэг хүнд оногдох хонины махны хэрэглээ 2014 оны байдлаар 1.8 кг, Америкт 0.31 кг Австрали болон Казакстанд 8.5 кг, Африкт 2 кг байна.

Монголчууд хэзээнээс нааш хонины махыг бусад малынхаас илүүгээр хүнсэндээ хэрэглэж ирсэн. Харин хурганы махыг иддэг ч, хүнсэнд өргөн хэргэлдэггүй, нас гүйцсэн хониныхыг голчлон хэргэлдэг байв. Байгаль цаг уурын нөхцөл, түүнтэй уялдан малын тарга хүч өөрчлөгддөг онцлогт зохицуулан мах бэлтгэл нь улирлын шинжтэй, өвлийн хүйтэн эхлэхэд дараа жилийн намар хүртэл буюу бараг бүтэн жил хэрэглэх махаа бэлтгэн, хэсгийг нь хөлдөөн, хэсгийг нь борцлон, нөөцөлдөг байв. Энэ уламжлал хөдөөгийн айл өрхүүдэд одоо хүртэл хадгалагдсаар байгаа ч хүн амын дийлэнх нь хот суурин газар амьдардаг болсноор



мах хөлдөөж хадгалах том агуулахууд байгуулагдсан. Мөн суурин газруудад үхрийн махны хэрэглээ хониныхоос илүүтэй өсч байна. Манай улс жилд 8-10 сая мал хүнсэнд хэрэглэж, 200 гаруй (2013 оны байдлаар 238.2) мянган тонн мах бэлтгэж байна.

Монгол хонины нас ахих тутам гулууз маханд өөхний эзлэх хувийн жин нэмэгддэг. Судлаачдын тогтоосноор 2.5 наснаас өөхний хэмжээ эрчимтэй (58.3-86.2 %-иар) нэмэгдэж, 2.5 настайд дунджаар гулууз махны 25.9 %-ийг гадар өөх эзэлдэг байснаа 4.5 настайд 29.3 % болж ихэсдэг байна. Тэрчлэн нас ахих тутам булчингийн ширхэг бүдүүрч, мөн махны чийг багасаж (76.6 - гаас 51.6 % хүртэл), мах хатуурдаг тул хэрэглэгчид шүүслэг, зөөлөн, өөх багатай махыг илүүд үзэж, бага насны буюу өсвөр малын махыг худалдан авах нь ихэссэн.

Зах зээлийн судалгаа

Дотоодын зах зээлд

Гурил

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 257 тоот тушаалаар баталсан нэг хүний хоногт хэрэглэх гурил, гурилан бүтээгдэхүүний жишиг дундаж хэмжээг үндэслэн баруун аймгуудын жилийн гурилын жилийн хэрэгцээг тооцвол:

Баруун аймгуудын гурилын жилийн хэрэгцээ



Аймгийн нэр	Баян-өлгий	Говь-алтай	Завхан	Увс	Ховд	Дүн
Хүн ам	100,172	56,587	70,546	81,278	84,486	393,069
Гурилын хэрэгцээ (тн)	11,700	6,609,3	8,239,7	9,493,2	9,867,9	45,910,4


Хүснэгт: 26 Баруун аймгуудын гурилын жилийн хэрэгцээ

Тайлбар: Хоногт нэг хүний хоногийн хэрэгцээг гурил 100 гр, гурилан бүтээгдэхүүн 220 гр-аар тооцов.

Малын тэжээл, царгас

Энэхүү баримт бичгийн 3.2 болон 5.2-д малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх үндэслэл, шаардлагын тухай товч өгүүлсэн билээ. Уур амьсгалын өөрчлөлт болон хүний үйл ажиллагааны нөлөөгөөр бэлчээр доройтон, хадлангийн ургац муудаж буй өнөө цагт өвөл хаварт мал сүргийг нэмэгдэл тэжээлээр хангах, зудын бэрхшээл тохиолдоход эрсдлээс хамгаалах хадлангийн нөөц бэлтгэхэд усалгаатайгаар малын тэжээл тариалж, түүндээ тулгуурлан хүчит тэжээлийг үйлдвэрийн аргаар бэлтгэх нь хамгийн оновчтой шийдэл юм. Царгасны тэжээллэг чанар байгалийн хадлангаас үлэмж давуу тул түүнийг тариалдаг аж ахуйн нэгж олширч, талбайн хэмжээ нэмэгдэж байна. Бүрэн бус мэдээллээр, Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл, Түнэл, Бүрэнтогтох сумууд тус бүр 45 га-д царгас тариалаад 5 дахь жилдээ ургац хураав. Хэнтий аймгийн Хэрлэн-Баянулаан сум 30 га-д 6 дахь жилдээ, Өвөрхангайн Хархорин сум 100-125 га-д 8 дахь жилдээ, Төв аймгийн Архуст 250 га-д, Цээл сум 214 га-д царгас тарьж, ургац хураасаар байна. Мөн Дорнод, Сүхбаатар аймгийн зарим сум, Улаанбаатар хот орчмын сүүний фермүүд багахан талбайд тарьж буй мэдээлэл байдаг. Гэвч царгасны хэрэгцээ, эрэл сурал улам нэмэгдэж байна. Сүүлийн 3 жилийн байдлаар, жилд 1100-1178.7 мянган тонн хадлангийн өвс бэлтгэж байгаа ч энэ нь манай улсын зөвхөн бог мал, үхэрт шаардлагатай нэмэгдэл тэжээлийн дөнгөж 30 орчим хувийг хангадаг. Нийслэл болон Эрдэнэт, Дархан мэт томоохон хотын ойролцоох фермерийн цөөхөн аж ахуйн үхрээс бусад бүх мал жилийн турш гагцхүү байгалийн бэлчээрт маллагдаж, өвс тэжээл хүрэлцээгүйн улмаас зөвхөн турж эцсэн, ядарч доройтсон малд өвлийн хүйтэн, хаврын тарчиг үеэр багахан хэмжээний нэмэгдэл тэжээл өгч байна. Шинээр төрсөн хурга, ишиг, тугалд хэсэгхэн хугацаанд өвс тавьж өгдөг. Ийнхүү дээд зэргээр хязгаарласан байдлаар хэрэглэдэг ч хадлангийн өвс манай орны альч аймаг суманд хангалттай хүрэлцдэггүй. Тэрчлэн сүүлийн жилүүдэд саалийн үнээний, гахайн, шувууны фермерийн аж ахуйнууд чамгүй хөгжиж, уураг ихтэй өвс, хүчит тэжээлийг хэрэгцээ үлэмж ихсэж байна. Зарим жил өвс тэжээл хүрэлцэхгүй, хөрш орнуудаас импортоор авч байна.





Аймаг бүрд сум дундын аюулаас хамгаалах өвс, тэжээлийн фонд хэд хэд байдаг. Энэхүү нөөцийн нэгж болгон жил бүр 150-300 мянган тонн хадлангийн өвс худалдан авч хадгалдаг. Тэдгээр нөөцийн газруудад байгалийн хадлангаас илүү чанартай таримал царгасыг борлуулах боломжтой.

Хурганы мах

Манай оронд хонины махын хэрэглээ бусад төрлийн малынхаас илүү байдаг. Харин сүүлийн жилүүдэд хотын оршин суугчид үхрийн махыг түлхүү хэргэлдэг болсон ч хонины махны хэрэглээ давуу хэвээр байна. Сүүлийн 5 жилийн дунджаар жилд 302.3 мянган тонн мах хүнсэнд хэрэглэснээс 98.1 мянган тн буюу 32.4 %-ийг зөвхөн хонины мах эзэлж байна.

Хүснэгт 11. Мах бэлтгэл (мянган тонноор)

Малын төрөл	2010	2011	2012	2013	2014	2015
Адууны	23.0	25.5	31.2	29.8	29.5	50.8
Үхрийн	47.5	54.8	59.7	57.7	54.9	93.2
Тэмээний	5.8	6.2	5.3	6.7	6.4	8.2
Хонины	77.4	75.4	67.2	91.0	91.3	134.6
Ямааны	49.1	44.7	56.3	64.0	60.5	86.6
Бүгд	201.2	219.6	220.4	249.2	242.6	373.1

Хүснэгт: 27 Мах бэлтгэл (мянган тонноор)

Дээрх хүснэгтээс үзэхэд, 2013-2015 онд хонины махны хэрэглээ үхрийнхээс 44.2-66.3 % илүү байна. 2015 оныг 2010 онтой харьцуулахад хонины махны хэрэглээ 73.9 %-иар ихэсчээ.

Хүмүүсийн махны хэрэглээ жилийн аль ч улиралд жигд ч олдоц нь харилцан адилгүй, намар элбэг, харин хавар болон зуны эхээр ховорддог. Энэ үед хүмүүс зооринд хадгалснаас илүүтэйгээр шинэ махыг чухалчилдаг. Тиймээс хаварт махны, тэр дундаа шинэ махны үнэ огцом нэмэгддэг. Үүнийг харгалзан I сараас төлөг бордож, III сард махыг нь хөлдөөхгүйгээр загсаан, шинэ мах худалдаанд гаргавал ямар ч саадгүй борлогдоно.


Гадаадын зах зээл

6.2.1. Царгас

Доорх диаграммаас царгас экспорлодог гол орнуудыг харж болно.

Царгас экспортогч орнууд

Царгасны экспортын харьцаа, 2010 он






■ Испани ■ АНУ ■ Франц ■ Австрали ■ Итали ■ Бусад

График 19 Царгас экспортогч орнууд⁹


Манай улсад ойр Япон 1.5 сая тн; Хятад 1.4; Солонгос 0.8; Арабын нэгдсэн Эмират 0.45; Тайван 0.2 сая тн царгас 2016 онд импортлон авсан байна.

⁹ <https://rankingamerica.wordpress.com/2012/10/20/the-u-s-ranks-2nd-in-alfalfa-exports/>





Үнэт цаасны танилцуулга



Доорх графикаас үзэхэд царгасны хэрэглээ Японд буурч байгаа ч зах зээл нь том хэвээр, Хятадынх сүүлийн 8 жилд огцом өсөж байгаа нь харагдаж байна.

Сүүлийн жилүүдэд царгас импортоор авч буй орнууд



График 20 Өвсний экспортын хэмжээ¹⁰

Хятад улс 2016 онд дэлхийд царгас хамгийн ихээр хэрэглэгч орон болжээ. Хэрэглээ нь сүүлийн 9 жилд 10 дахин нэмэгдсэн байна. Саудын Араб болон Арабын Нэгдсэн Эмират улсууд усны гачаалаас шалтгаалан царгасыг импортоор авдаг болоод байна.

Зөвхөн царгас төдийгүй бусад өвсийг ч нилээд орнууд импортоор авдаг. Сүүлийн 10 жилд царгас болон хадлангийн бусад өвсийг импортоор авсан гол орнуудыг дараах диаграмм-д харуулав.



График 21 Зарим орны импортлосон царгас, бусад өвс (тн-оор)





График 22 Бусад өвсний экспортын хэмжээ


<http://alfalfa.ucdavis.edu/+symposium/2016/PDFfiles/4%20Putnam%202016ExportSymposiumPUTNAMfinal.pdf>

¹⁰ <http://ucanr.edu/blogs/blogcore/postdetail.cfm?postnum=17566>





Үнэт цаасны танилцуулга



Нийт үнийн дүнгээр Хятад улс \$380 сая долларын царгас, \$170 сая долларын өвс, Япон \$195 сая долларын царгас, \$270 сая долларын өвс импортлосон байна.

Хурганы мах

Арван том экспортлогч, арван том үйлдвэрлэгч орон



График 23 Арван том экспортлогч, арван том үйлдвэрлэгч орон




График 24 Хурганы мах үйлдвэрлэгч 10 орон¹¹

Австрали болон Шинэ Зеланд нь тус бүр 400,000 тн хурга хонины мах экспортлож байна. Харин нийт хурга хонины махны нийлбэр дүнгээр Хятад 2.2 сая тн мах, Австрали 700 мянга, Шинэ Зеланд 500 – аад мянган тн-ыг үйлдвэрлэсэн байна.


Австрали нь нийт нядалсан хонины махны 44% -ийг, хонины тэжээлийн ургамлын 80% -ийг, Шинэ Зеланд нийт нядалсан хонины махны 80% -ийг болон хонины тэжээлийн ургамлын 84% -ийг экспортлодог.

Австрали улс хонины махны ихэнх хэсгийг Америк руу, мөн Ойрх Дорнод, Европын Холбоо, Хятад руу гаргадаг. Йордан, Катар, Кувейт улсууд хонь амьдаар авдаг.

Доорх диаграммаас Австралийн хонь, хурганы махны экспортын хэмжээг харж болно.

Австралиас сүүлийн 3 жилд экспортод гаргасан хонь, хурганы мах мян. тн-оор

¹¹ https://www.trueaussteebeefandlamb.eu/globalassets/mla-corporate/prices--markets/documents/trends--analysis/fast-facts-maps/mla_sheep-fast-facts-2015.pdf



Австралийн хонь, хурганы махны экспорт (Мянган тонн)



График 25 Австралийн хурганы махны экспорт¹²

2016 онд Австрали 260000 тн хурганы мах, 142000 тн хонины мах нийт 402000 тн мах экспортлосон байна. Экспортынх нь 38% - 45%-ийг Ойрх Дорнод эзэлдэг. Урьд дэлхийн улс орнууд бүдүүн хонины махыг голдуу хүнсэндээ хэргэлдэг байсан бол сүүлийн үед хурганы махыг илүүтэй хэрэглэдэг болов. 2014 онд Австраль улс хаашаа хэдий хэмжээний хурганы мах экспортод гаргасныг дараах хүснэгтээр харуулав.

Австрали улсаас 2015 онд экспортлосон хурганы мах

№	Улсын нэр	Хурганы мах (тн-оор)	Урьдах жилтэй харьцуулбал	2010-2014 оны дундажтай харьцуулбал
1.	Ойрх Дорнод	68 355	6%	38%
2.	АНУ	49 904	8%	31%
3.	Хятад	31 326	- 19%	8%
4.	Шинэ Гвиней	15 716	74%	46%
5.	Зүүн өмнөд ази	13 319	16%	43%
6.	Европын холбооны улсууд	10 656	-24%	-15%
7.	Япон	7 977	-21%	-15%
8.	Канад	7 098	15%	48%
9.	Солонгос	6 267	30%	98%
	Нийт	233 999	-1%	23%

Хүснэгт: 28 Австрали улсаас 2015 онд экспортлосон хурганы мах¹³

Хүснэгтээс үзэхэд, 2015 онд Австраль ойрх дорнод руу 68.355 тн хурганы мах гаргасан нь урьд жилийнхээс 6 %, 2010-2014 оны дунджаас 38 %-иар, АНУ руу 49.904 тн мах гаргасан нь урьдах жилийнхээс 8 %, 2010-2014 оны дунджаас 31% нэмэгдэж, харин Европын холбоо руу гаргасан мах дээр дурьдсан онуудтай харьцуулахад 24%; 15% -иар, Япон руу гаргасан нь 21 %; 2%-иар тус тус багасчээ. Доорх тахирмагаас Ойрх дорнод руу Австралиас гаргасан хурганы мах, хонины махнаас сүүлийн жилүүдэд давамгайлах болсныг харж болно.

Австралиас Ойрх Дорнодруу экспортлосон хурга (улаан), хонь (цэнхэр)-ны махны хэмжээ (сая кг-аар)

¹² <http://beefandlamb.ahdb.org.uk/market-intelligence-news/mutton-supply-squeezed-australian-exports-2016/>

¹³ <https://www.mla.com.au/prices-markets/market-news/How-did-2015-fare-for-Australian-lamb-exports-12012015/>



Үнэт цаасны танилцуулга




График 26 Австралиас Ойрх Дорнодруу экспортлосон хурга (улаан), хонь (цэнхэр)-ны махны хэмжээ¹⁴

Австралиас Ойрх дорнод руу гаргасан хонь, хурганы махны үнийн дүнг дараах тахирмагаар харуулав.

Хонь, хурганы махны үнийн дүн.




График 27 Хонь хурганы махны үнийн дүн

Тайлбар : Цэнхэр- хонь, улаан – хурга (Сая \$ - оор)¹⁵


2007 онд Австралийн экспортлосон хонины махны нийт үнэ \$54 сая доллар хүрч байсан бол 2013, 2014 онд \$36 сая болж буурсан байхад, харин хурганы махны дүн дээрх онуудад \$50 саяаас \$89 сая болж, 77 хувиар өссөн байна.

Австралиас Европын холбоо, АНУ, Ойрх Дорнод руу экспортолж байгаа 1 кг хурганы махны үнийн өөрчлөлтийг дараах тахирмагаар харуулав. Европын холбооны хурганы 1 кг махны үнэ 2008 онд, АНУ-ынх 2010 -2011 онд 8 австраль доллар хүрч ихссэнээ аль аль нь 2013 оноос буурч, 2014-2015 онуудад 6.5-7.0 австраль доллар байжээ. Харин Ойрх Дорнодод энэ хугацаанд 5.14 -өөс 7.25 болж өссөн байна.

Австралиас экспортод гаргаж байгаа хурганы 1 кг махны үнэ

¹⁴ <https://www.agric.wa.gov.au/newsletters/sheep-notes-volume-3?page=0%2C5>

¹⁵ <https://www.agric.wa.gov.au/newsletters/sheep-notes-volume-3?page=0%2C5>





Үнэт цаасны танилцуулга





График 28 Австралийн экспортын хурганы махны үнэ

Тайлбар. Цэгэн улаан нь - Европын холбоо, тасархай цэнхэр - АНУ, үргэлжилсэн хар – Ойрх Дорнод, хол тасархай ногоон – Хятад, Макао, Хонг Конг, Тайваны дундаж дүнгээр¹⁶

Европын холбоо нь Шинэ Зеландын хонины махны экспортын 57% - ийг эзэлдэг. Шинэ Зеландын экспортлодог хонины махны 19 %-ийг Английн Нэгдсэн Вант Улс, 12 %-ийг Хятад, 7 %-ийг АНУ авдаг. Шинэ Зеландын амьд хонины махыг авдаг гол орон нь Саудын Араб.

Шинэ Зеландаас экспортлосон нэг тонн хурганы махны үнэ

Тээвэрлэлтийн зардал орсон тонн махны үнэ (Шинэ Зеланд \$)




График 29 Шинэ Зеландаас экспортлосон нэг тонн хурганы махны үнэ

Тайлбар: Тээвэрлэлтийн зардал орсон үнэ (Шинэ Зеландын доллараар. Ногоон нь 2015-2016; хар нь 2016-2017 он¹⁷

АНУ хонины мах бага хэмжээгээр экспортолдог /дотоодын махныхаа 2%-ийг/, эм хонь, зусаг, хуцыг амьдаар нь Мексик руу эктортолдог ч энэ нь сүүлийн жилүүдэд багасаж байгаа.

Хонь, хурганы мах хамгийн ихээр импортлогч орнууд нь Европын Холбооны орнууд. Жилд дунджаар 222 мянган тн-ыг авдаг. Америк, Хятад тус бүрдээ 63.5 мянган тн мах импортлодог. Хятадын нэг хүнд ногдох хонины махны хэрэглээ нь 1980 оноос хойш 4% -иар өсөв. Энэ нь хэдийгээр бага өсөлт мэт харагдавч, тэрбум гаруй хүнд тооцоход сүүлийн 20 жилд махны

¹⁶ <https://www.agric.wa.gov.au/newsletters/sheep-notes-volume-3?page=0%2C5>

¹⁷ <http://www.beeflambnz.com/sites/default/files/data/files/Export%20Lamb%20FOB%20%24%20per%20tonne%20by%20Country.pdf>



импорт нь 500% -иар өссөн гэсэн үг. Америкийн хонины махны импорт сүүлийн арван жил өсч, Европын орнуудынх нэг түвшиндээ байна. Европын орнуудын хонины махны хэрэглээний бараг 50 % импортоор орж ирдэг ба үүний 65% -ийг Австрали, 35% - ийг Шинэ Зеланд эзэлдэг.

Хонины мах үйлдвэрлэлээр тэргүүлдэг Австрали, Шинэ Зеланд хоёр улс дэлхийн нийт экспортын бараг 90% -ийг эзэлдэг. Эдгээр орны хонины аж ахуйнууд нь эрчимжсэн, хямд төсөр зардлаар чанартай мах үйлдвэрлэдэг ч уур амьсгалын өөрчлөлт, хөрсний хужирсалт, байгалийн нөөц баялагийн ашиглалт зэрэг олон шалтгаанаар сүүлийн үед үйлдвэрлэгчид нь хонины мах гэхээсээ илүү саалийн ферм, газар тариалан, бусад малын аж ахуйг илүү сонирхох болжээ. Дээрх хоёр орны мах нийлүүлэлт буурч байгаа нь олон улсын хэмжээнд хонь, хурганы махны үнийг өсөхөд хүргэж байна. Хэдийгээр Энэтхэг, Пакистин, Алжир, Суданд хонины тоо өсч байгаа ч, тэдгээр орны хүн амын өсөлт нь мах үйлдвэрлэлээсээ түрүүлж байгаа тул дотоодынхоо хэрэгцээг ч бүрэн хангаж чадахгүй байна.

3.7 Ирээдүйн санхүүгийн төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн ирээдүйн санхүүгийн төсөөллийг гүйцэтгэхэд Монголын эдийн засгийн төлөв байдал, өргөн хэрэглээний зах зээлийн судалгаа тэр дундаа өндөг, тахианы махны цаашдын төлөв, үнэт цаас гаргагчийн өнөөгийн үйлдвэрлэлийн хүчин чадал, цаашид авч хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөөнд тулгуурлан тооцоолсон.

Үнэт цаас гаргагч нь 2018 оны байдлаар орлогын 4-н үндсэн эх үүсвэртэй байгаагаас хамгийн өндөр хувь буюу 90 орчим хувийг өндөгний борлуулалт эзэлж байна. Харин цаашид авч хэрэгжүүлэх гол төслүүд болох тахианы махны аж ахуй, тэжээлийн үйлдвэрийн орлогын хэмжээ 2019 оноос нийт борлуулалтын орлогын 8 болон 7 хувийг эзлэх төлөвлөгөөтэй байна. Өөрөөр хэлбэл компани борлуулалтаа төрөлжүүлж, учирч болох эрсдлийг бууруулж байгаа нь цаашид хөрөнгө оруулагчдын хөрөнгийг хамгаалахад нэн чухал алхмыг авч хэрэгжүүлж байна.

Санхүү байдлын тайлангийн төсөөлөл /сая.төг/

	2018	2019	2020	2021	2022
Эргэлтийн хөрөнгө	10,022	10,295	14,345	21,213	28,191
Бэлэн мөнгө	6,242	5,266	8,323	14,795	21,277
Дансны авлага	1,222	1,840	2,327	2,526	2,754
Бараа материал	1,510	2,141	2,647	2,844	3,112
Урьдчилж төлсөн зардал	1,048	1,048	1,048	1,048	1,048
Эргэлтийн бус хөрөнгө	15,321	18,698	18,882	16,643	14,882
Барилга, тоног төхөөрөмж	13,823	16,778	17,286	15,238	13,594
Бодит бус хөрөнгө	16	16	16	16	16
Биологийн хөрөнгө	936	1,468	1,234	1,117	1,058
НИЙТ ХӨРӨНГӨ	24,797	28,557	32,881	37,584	42,859
Нийт өр төлбөр	3,767	3,839	3,495	2,996	2,532
Богино хугацаат өр төлбөр	767	1,089	1,345	1,446	1,582
Дансны өглөг	767	1,089	1,345	1,446	1,582
Урт хугацаат өр төлбөр	3,000	2,750	2,150	1,550	950
Урт хугацаат зээл	3,000	2,750	2,150	1,550	950
Бусад урт хугацаат зээл	-	-	-	-	-
Эздийн өмч	21,059	24,742	29,406	34,605	40,341
ХНХ	13,000	13,000	13,000	13,000	13,000
Дахин үнэлгээний наац	-	-	-	-	-
Хуримтлагдсан ашиг	8,030	11,718	16,386	21,588	27,327
Өртөлбөр, эздийн өмч	24,797	28,557	32,881	37,584	42,859



Үнэт цаасны танилцуулга



Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр компани төлөвлөгөөт ажлуудаа авч хэрэгжүүлснээр компанийн ашигт ажиллагаа нэмэгдэх бөгөөд улмаар нийт хөрөнгийн хэмжээ жил дараалан өсөх тооцоололтой байна. Ялангуяа эхний жилд буюу 2018 онд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдэж 13 тэрбум төгрөгт хүрэх юм. Цаашлаад компани жил бүр ашигт ажиллагааны хэмжээг нэмэгдүүлснээр нийт хөрөнгийн хэмжээ 2025 онд 65 тэрбум төгрөгт хүрнэ гэж тооцоолоод байна. Цаашлаад хөрөнгө оруулалтын хэмжээг тогтмол түвшинд барьж техник тоног төхөөрөмжүүддээ шинэчлэлийг хийн ажиллах төлөвлөгөөтэй байгаа нь нийт хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх бас нэгэн хүчин зүйл болж байна.

Орлогын тайлангийн төсөөлөл /сая.төг/

	2018	2019	2020	2021	2022
Борлуулалтын орлого	17,581	26,474	33,482	36,350	39,630
Өндөг	15,634	21,209	23,669	24,009	26,811
Тэжээл	1,634	2,038	2,565	3,231	3,609
Сав баглаа	156	106	118	120	134
Бусад орлого	156	212	237	120	134
Бордоо	-	954	1,027	1,051	1,121
Махны тахиа	-	1,955	5,865	7,820	7,820
ББӨ	13,806	19,583	24,201	26,006	28,457
Нийт ашиг	3,775	6,891	9,280	10,344	11,172
Бусад орлого	246	246	246	246	246
ҮА-ны зардал	2,080	2,827	3,704	4,104	4,265
ҮА-ны ашиг	1,941	4,317	5,823	6,486	7,154
ҮА-ны бус ашиг/алдагдал					
Татварын өмнөх ашиг	1,941	4,317	5,823	6,486	7,154
Татвар	194	629	956	1,134	1,313
Цэвэр ашиг	1,747	3,688	4,867	5,352	5,841

Компанийн ашигт ажиллагаа жил бүрт тогтвортой өсөхөд дараах хүчин зүйлсийг голлон нөлөөлнө гэж үзлээ. Үүнд:

- Шинэ бизнесийн төрөл буюу бордоо, тахианы махны борлуулалтын хэмжээ өснө
- Өндөгний 8-р байрыг барьж ашиглалтад оруулснаар компанийн орлого нэмэгдэх
- Өндөг боловсруулах үйлдвэрийг суурилуулж өндөгний өртөгийг багасгаснаар цэвэр ашгийн хэмжээ нэмэгдэх
- Тэжээлийн үйлдвэрт импортоор худалдан авдаг бүтээгдэхүүнийг дотооддоо тарьснаар бүтээгдэхүүний өртөгийг бууруулж зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх
- Үйл ажиллагааны хувьд ойролцоо үйл ажиллагаа эрхлэх нь үйл ажиллагааны зардалд төдийлөн өндөр нэмэгдэл үүсгэхгүй нь цэвэр ашгийн түвшинд эерэгээр нөлөөлнө гэж тооцоолж байна.






Үнэт цаасны танилцуулга



3.8 Ногдол ашгийн бодлого

"Түмэн шувуут" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2018 оны 06 дугаар сарын 07-ны 2018/06/07 тоот
Уригтгоолын шийдвэр



"ТҮМЭН ШУВУУТ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь "Түмэн шувуут" ХК-ийн (цаашид "компани" гэх) Төлөөлөн удирдах зөвлөлөөс баримтлах ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл журмыг "Компанийн тухай" хууль, Монголын компанийн засаглалын кодекст нийцүүлэн тодорхойлоход оршино.
- 1.2 ТУЗ нь "Ногдол ашгийн бодлого"-ыг нийтийн хүртээл болгох үүрэгтэй ба ТУЗ-ийн нарийн бичгийн дарга сонирхсон бүх этгээдэд уг баримттай танилцах боломж олгохоос гадна компанийн сайтад байрлуулсан байна.

Хоёр. Ногдол ашиг хуваарилах нөхцөл

- 2.1. Нэг төрлийн нэгж хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.
- 2.2. Компани дор дурьдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилж болно. Үүнд:
 - 2.2.1. шийдвэр гаргах өдрийн байдлаарх эзэлийн багцын чанар байдал;
 - 2.2.2. ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
 - 2.2.3. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, гатан буулгах үед төлөх дүн, компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
 - 2.2.4. компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн, өөрийн бичгээ эргүүлэн худалдан авах хугацаа болсон бол эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн авсан, эсхүл бүрэн худалдан авахад шаардагдах хөрөнгөтэй байх.
 - 2.2.5. Компанийн дүрэм болон хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт заасан тусгай зориулалтын сангуудад зориулсан хуваарилалтыг бүрэн хийсний дараа хуваарилагдаагүй цэвэр ашиг үлдэж байгаа.
 - 2.2.6. Компани дараах тохиолдолд заавал ногдол ашиг хуваарилна. Үүнд:
 - 2.3.1. Энэхүү бодлогын 2.2-г заасан нөхцөл хангагдсан;
 - 2.3.2. Компани ашигтай ажилласан бөгөөд компанийн дүрэм, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт заасан компанийн нөөцийн болон хөрөнгө оруулалт, нийгмийн хөгжлийн санд зориулсан хуваарилалтыг бүрэн хийсний дараа хуваарилагдаагүй цэвэр ашгийн 20-оос доошгүй хувь.

Гурав. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр

- 3.1. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг тухайн жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулснаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ нэг хувьцаанд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг олгох хэлбэр, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт мэдээлэл хүргүүлнэ. Энэ хэсэгт дурдсан бүртгэлийн өдөр нь "Түмэн шувуут" ХК-





Үнэт цаасны танилцуулга



- ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зэр мэдээ хүргэх журам"-д заасан бүртгэлийн өзөргүй ижил байна.
- 3.2. Ногдол ашгийг бэлэн мөнгө, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.
 - 3.3. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлж, хувийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.
 - 3.4. Жилийн тайланд тусгах мэдээлэлд ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн тусгасан байх бөгөөд ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэртэсэн бол түүний үндэслэлийг энэ журмын дагуу тайлбарласан байна.
 - 3.5. Компания ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд тайлбартаа ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар зэргийг тусгасан байна.

Дөрөв. Ногдол ашиг хуваарилах, тайлагнах

- 4.1. Ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.
- 4.2. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ногдол ашгийг ТУЗ-оос тогтоосон хугацаанд төлөөгүйгээс компанид учирсан хохирлыг гүйцэтгэх захирал болон холбогдох бусад албан тушаалтнууд хариуцна.
- 4.3. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан бол төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан болох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтөлнө. Ногдол ашгийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-н дамжуулан хувьцаа эзэмшигч бүрийн "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК дахь дансанд шилжүүлэх бодлого баримтална.
- 4.4. Ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын санхүүгийн тайлан гаргах үед "Ногдол ашгийн хуваарилалтын тайлан"-г гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.


-----00-----

3.9 Үнэт цаасны эрх зүйн орчин

3.9.1 Хууль эрх зүйн орчин

Үнэт цаас гарган санхүүжүүлэх үйл ажиллагаа нь дараах хууль тогтоомжийн холбогдох хэсгээр зохицуулагдана. Үүнд:

Компанийн тухай хууль





Үнэт цаасны танилцуулга



УИХ-аар 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Компанийн тухай хуульд заасан дараах эрх, үүргийн хүрээнд Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулж, хувьцаа нэмж гаргах замаар хөрөнгө оруулалт татаж байгаа болно. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хувьцаа нэмж гаргах бүрэн эрх /Компанийн тухай хуулийн 62.1.3 дахь заалт/
- Энгийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх мэдэгдэл хүргүүлэх болон хурал зарлах журам /Компанийн тухай хуулийн 38.2, 62.1.3 дахь заалт/
- Нэмж гаргах хувьцааны бүртгэлийн эрх зүйн үндэслэл болон төлбөр төлөх журам /Компанийн тухай хуулийн 44 дүгээр зүйл/

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль

Услын Их Хурал 2013 оны 05 дугаар сарын 24-ний өдөр шинэчлэн батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон дараах харилцааг зохицуулдаг. Үүнд:

- Нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааны журам, заавар, дарааллыг Хороо батлах эрх зүйн үндэслэл
- Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах, анхдагч зах зээлд худалдах, бүрдүүлэх бичиг баримт, үнэлгээ тайлан, тайлагнах үүрэг
- Үнэт цаасны танилцуулгын талаарх нарийвчилсан зохицуулалт
- Нийтэд санал болгох үнэт цаас гаргах ажиллагаан дахь андеррайтерийн оролцоо
- Үнэт цаас гаргагчийн удирдлагад тавигдах нөхцөл, шаардлагын Хороо тогтоох эрх зүйн үндэслэлийг заасан

Тус хуульд зааснаар Компанийн нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг Хороо бүртгэж, үнэт цаасны анхдагч зах зээлд санал болгох зөвшөөрлийг олгох бөгөөд үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон тухай шийдвэр гаргаж, нийтэд мэдээлсэнээс хойш үнэт цаасны анхдагч зах зээлийн хэлцлийг буцаахгүй.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хуулиар хориглосон байдаг.

3.9.2 Холбогдох журмууд

Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан дараах журмуудын холбогдох хэсгээр зохицуулагдана. Үүнд:

Үнэт цаасны бүртгэлийн журам

СЗХ-ны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 408 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмаар нийтэд санал болгон шинээр болон нэмж гаргах үнэт цаасыг СЗХ-нд бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах, худалдах, үнэт цаасны гүйлгээний тайланг СЗХ-нд ирүүлэх зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд шууд хамааралтай харилцааг зохицуулдаг.

Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам

СЗХ-ны 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 443 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журмаар үнэт цаас гаргагчаас хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагааны талаарх болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад



Үнэт цаасны танилцуулга



шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулдаг.

Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилалтад хяналт тавих тухай журам

СЗХ-ны 2003 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 65 тоот тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилалтад хяналт тавих тухай журмаар үнэт цаас гаргагч буюу хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилах үйл ажиллагааг зохицуулдаг. Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа нь Биржээс батласан дараах журам, заавруудын холбогдох хэсгээр зохицуулагдана.

Бүртгэлийн журам

МХБ ТӨХК-н Бүртгэлийн журам нь 2018 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан бөгөөд тус журмаар Биржийн бүртгэлийн ангилал, шалгуурыг тогтоох, нийтэд санал болгон, эсхүл хаалттай хүрээнд шинээр нэмж гаргах үнэт цаасыг биржийн бүртгэлд бүртгэх, түүнд өөрчлөлт оруулах, арилжааг түр зогсоох, бүртгэлээс хасах зэрэг биржийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Үнэт цаасны зах зээлийн анхдагч арилжааны журам

МХБ-н Үнэт цаасны зах зээлийн анхдагч арилжааны журам нь 2009 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан бөгөөд тус журмаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн шинээр болон нэмж гаргаж буй хувьцааг анхдагч зах зээлд байршуулах, хувиарлах, арилжих үйл ажиллагааг зохицуулдаг.



Бүртгэлтэй компаниудаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар


МХБ-н Бүртгэлтэй Компаниудаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар нь 2009 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан бөгөөд тус заавраар Биржид бүртгэлтэй компаниудаас хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх мэдээллийг ил тод болгох, компаниудаас ирүүлэх мэдээллийн төрөл, жагсаалтыг тогтоох, түүнийг компаниудаас цахим хэлбэрээр илгээх, хүлээн авах, хянах боловсруулах, хадгалах, олон нийтэд мэлээллийг хүргэхтэй холбоотой харилцааг зохицуулдаг.

"Түмэн шувуут" ХХК-ны 2018 оны 06 сарын 07-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 06/2018 тоот тогтоолоор компанийн Ногдол ашгийн журмыг баталсан ба уг журамд компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилж байна гэж заасан байна. Мөн энэхүү ногдол ашгийн дүн нь тухайн жилийн цэвэр ашгийн .. хувиас хэтрэхгүй байхаар тусгасан байна.

Компанийн ногдол ашгийн журмын дагуу ногдол ашиг хуваарилах асуудлыг ТУЗ хэлэлцэн шийдвэрлэх ба тухайн санхүүгийн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд тайлагнаж, ногдол ашиг хуваарилаж болохгүй байгаа үндэслэл, шалтгаан, хөрөнгө, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулна. Тухайн жил тараасан ногдол ашгийн хэмжээ болон тараах журмыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар мэдэгдэн, компанийн веб хуудсаар дамжуулан нийтийн хүртээл болгохоос гадна ТУЗ-ийн нарийн бичгээр дамжуулан саадгүй танилцах боломжийг бүрдүүлэхийг уг журмаар зохицуулсан.

Мөн компани ногдол ашиг хуваарилах хэлбэр, олгох цаг хугацаа нь компанийн бүх хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байхаар уг журамд заасан байна.





3.9.3 Татвар

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хувь хүн нь "Хувь хүний орлогын албан татварын тухай хууль"-ийн 13.1.3-т заасан орлого (ногдол ашгийн орлого)-ын нийт дүнгээс, 14.1.3-т заасан орлого (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого)-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 23.1-т заасан 10 хувийн хэмжээгээр татвар төлнө.

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж нь "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль"-ийн 16.3.1-т заасан "ногдол ашгийн орлого"-ын нийт дүнгээс, 16.8-д заасан "хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс энэ хуулийн 17.1, 17.2.1-т заасан албан татвар төлнө.

3.10 ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

3.10.1 Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон МХБ-ийн ТУЗ-ийн 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан "Арилжааны журам"-ын дагуу явагдана.

Үнэт цаас гаргагчийн 2018 оны 06 сарын 07-ны өдрийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит бус хурлын 05/2018 тоот тогтоолын дагуу нийтэд санал болгох хувьцааны үнийг 200 төгрөгөөр тогтоосон бөгөөд МХБ-н Анхдагч зах зээлийн арилжааны Тогтоосон үнийн аргыг ашиглан санал болгохоор шийдвэрлэсэн.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй 50,000,000 ширхэг энгийн хувьцааны худалдан авах захиалгыг 2019 оны 01 сарын 02-ний өдрөөс 2019 оны 01 сарын 14-ний өдрийг хүртэл 13 хоног Үнэт цаасны танилцуулга арга хэмжээнүүд явагдсаны дараа 2019 оны 01 сарын 15-ний өдрөөс 17 хоногийн турш авах ба 2019 оны 01 сарын 31-ний өдөр анхдагч зах зээлийн арилжааг хаахаар төлөвлөж байна.

1. Бүртгүүлэх МХБ, СЗХ-с үнэт цаасыг бүртгэж шийдвэр гаргах	
2. Roadshow/Олон нийтэд мэдээллэх аян 2019/01/02-с 2019/01/14 хүртэл Олон нийтэд үнэт цаас, үнэт цаас гаргагчийг танилцуулах	13 хоног
3. Захиалга авах/Book building 2019/01/15-с 2019/01/31 хүртэл Олон нийтээс захиалга авах, захиалгын санг бүрдүүлэх	17 хоног
4. Арилжаа 2019/01/31 -ний өдөр Анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хаах, нийлүүлэлт хийх	5 хоног
5. Төлбөр тооцоо Арилжааны журмын дагуу Т+0 горимоор арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэх	

Эдгээр 29 Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө




- МБХ болон СЗХ-с зөвшөөрөл гарч бүртгүүлэх
- 2019/01/02-2019/01/14 13 хоногийн дотор





Үнэт цаасны танилцуулга



- 3. Захиалга авах/Book building - 2019/01/15-2019/01/31 17 хоногийн дотор
- 4. Арилжаа - 2019/01/31 нд анхдагч зах зээлийн арилжааг хаах
- 5. Төлбөр тооцоо - Арилжааны өдрөөс T+0 горимоор

Тогтоосон үнээр санал болгох арилжааны арга

Монголын Хөрөнгийн Биржийн 2009 оны "Анхдагч зах зээлийн арилжааны журам"-д зааснаар тогтоосон үнээр санал болгон арилжих арга гэдэг нь үнэт цаас гаргагчийн зүгээс үнэт цаасыг тогтоосон тодорхой нэг үнээр олон нийтэд санал болгон арилжих үйл ажиллагааг хэлэх бөгөөд хөрөнгө оруулагчийн зүгээс тогтоосон үнээс өндөр үнээр худалдан авах захиалга өгч болон эсхүл үнэт цаас гаргагчийн зүгээс зөвхөн нэг үнээр санал болгох хоёр хувилбар байдаг.

Үнэт цаас гаргагчийн хувьд зөвхөн тогтоосон үнээр буюу нэг үнийн түвшинд арилжааг явуулах ба зөвхөн тогтоосон үнээр буюу нэг үнийн түвшинд арилжааг явуулах үед худалдан авах захиалгын тоо ширхэг худалдах захиалгын тоо ширхгээс илүү гарсан тохиолдолд хувь тэнцүүлэх аргыг ашиглана. Хувь тэнцүүлэх аргаар хувиарлалт хийхэд захиалгын үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй.

Үнэт цаасны анхдагч арилжаанд оролцох заавар

Хөрөнгө оруулагч нар үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд дараах зааврын дагуу оролцох боломжтой.

<p>1 Арилжааны данс нээлгэх</p> <ul style="list-style-type: none"> - Хүссэн ҮЦК дээр арилжааны данс нээлгэх; - ҮЦК нь ҮЦТХТ болон Арилжааны Төлбөр Тооцоо ХХК дээр харилцагчийн 	<p>2 Мөнгөө байршуулах</p> <p>Арилжааны Төлбөр Тооцоо ХХК дээрх өөрийн нэр дээрх 0120 0000 •••• тоот дансанд мөнгөө байршуулна.</p>	<p>3 Захиалга</p> <p>Өөрийн үйлчлүүлдэг ҮЦК-д үнэт цаас худалдан авах захиалга өгнө.</p>	<p>4 Арилжаа хаагдах</p> <p>Анхдагч зах зээлийн арилжаа хаагдаж үнэт цаас хөрөнгө оруулагчийн нэр дээр шилжинэ.</p>
--	--	---	--

Зураг 30 Анхдагч зах зээлд оролцох заавар

Үнэт цаасыг хэн худалдан авч болох вэ?

- Монгол Улсын болон гадаад Улсын иргэн, хуулийн этгээд бүгд худалдан авах эрхтэй. Энэхүү танилцуулгад үнэт цаасыг худалдан авах эрхтэй бүх этгээдийг хөрөнгө оруулагч гэж ойлгоно.
- Үнэт цаасыг анхдагч зах зээлээс худалдан авахыг хүссэн хөрөнгө оруулагчид нь СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж буй үнэт цаасны компаниар зуучлуулан, ҮЦТХТ-д үнэт цаасны данс, үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэгч банкинд төлбөр тооцооны дансаа нээлгэсэн байх шаардлагатай.
- Үнэт цаасны данс шинээр нээлгэж, шинээр хувьцаа худалдах авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь дараах ажлуудыг гүйцэтгэсэн байх шаардлагатайг анхаарна уу:

Гүйцэтгэх ажил

1. БДК-аар дамжуулан "ҮЦТХТ" ХХК-д өөрийн нэрийн дансыг нээлгэсэн эсвэл идэвхижүүлсэн байх

Тасалбар болох огноо

Анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс ажлын 1 хоногийн өмнө





Үнэт цаасны танилцуулга



- Хувьцаа худалдан авах захиалгаа өөрийн БДК-д өгсөн байх
- Хувьцаа худалдах авах төлбөр буюу мөнгөн хөрөнгөө холбогдох шимтгэл (тухайн БДК-н шимтгэлийн хамт)-ийн хамт "ҮЦТХТ" ХХК дахь өөрийн нэрийн дансруу шилжүүлсэн байх

Анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс ажлын 1 хоногийн өмнө

Анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс ажлын 1 хоногийн өмнө

Хүснэгт: 29 Үнэт цаас худалдан авах дараалал

Мөнгөн хөрөнгө байршуулах

Шинээр хувьцаа худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь өөрийн хүссэн банкаар дамжуулан Үнэт цаасны төлбөр, тооцоо төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь өөрийн нэрийн дансандаа мөнгөө байршуулах боломжтой.

"ҮЦТХТ" ХХК болон "Арилжаа төлбөр тооцоо" ХХК-нь хувьцааны мөнгөн төлбөр нь бүрэн байршсан хөрөнгө оруулагчдын дансны мэдээллийг МХБ рүү анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс өмнө хүргүүлэх ба Андеррайтерийн компани нь МХБ-тэй хамтран тус хөрөнгө оруулагчдын захиалгыг нийлүүлэх ажиллагааг анхдагч зах зээлийн арилжаа хаасны дараа явуулан, холбогдох тайлан мэдээг СЗХ-нд хүргүүлнэ.

Арилжааны шимтгэл

Үнэт цаас худалдан авагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон болон захиалга өгсөн БДК-д төлөх ба уг шимтгэлд МХБ, Үнэт цаасны төлбөр, тооцоо төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон БДК-ийн шимтгэлийн нийт дүн багтсан байна. МХБ-ийн гишүүн БДК-уудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.

Албан татвар

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хувь хүн нь "Хувь хүний орлогын албан татварын тухай хууль"-ийн 13.1.3-т заасан орлого (ногдол ашгийн орлого)-ын нийт дүнгээс, 14.1.3-т заасан орлого (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого)-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 23.1-т заасан 10 хувийн хэмжээгээр татвар төлнө.


Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж нь "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль"-ийн 16.3.1-т заасан "ногдол ашгийн орлого"-ын нийт дүнгээс, 16.8-д заасан "хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс энэ хуулийн 17.1, 17.2.1-т заасан албан татвар төлнө.

Валютын ханш

Үнэт цаасны арилжаа нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр хийгдэнэ.

Нэмэлт мэдээлэл

- Үнэт цаасны дансыг СЗХ-оос брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа үнэт цаасны компаниар зуучлуулан ҮЦТХТ-д нээлгэнэ. Үнэт цаасны дансанд хөрөнгө оруулагчийн худалдан авсан бүхий л үнэт цаас байршин хадгалагдаж байдаг.
- Үнэт цаасны төлбөр тооцооны дансыг өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанитай хамтран ажилладаг, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа явуулах эрх бүхий арилжааны банкинд нээлгэнэ. Төлбөр тооцооны дансаар одоогоор хоёрдогч зах зээлийн арилжааны хэлцлүүдийн төлбөр тооцоо Т+1 горимоор хийгдэж байна. Төлбөр тооцооны дансаар зөвхөн үнэт цаасны төлбөр тооцоо хийгдэх бөгөөд өөр зориулалтаар ашиглах боломжгүй, хөрөнгө оруулагч үнэт цаасны компани банк гурвын дундын данс юм.





- Анхдагч зах зээлийн арилжааг СЗХ-с амжилттай болсон гэж үзвэл хөрөнгө оруулагчдын захиалгын дагуу нийлүүлэлтийг хийнэ.
- Нийлүүлэлт хийгдснээр хөрөнгө оруулагчийн үнэт цаасны дансанд хувьцаа байрших бөгөөд захиалгын биелэлтийн мэдээллийг үнэт цаасны компаниас хөрөнгө оруулагчид мэдээлнэ.
- Хувьцаа дансанд нь байршсанаар хөрөнгө оруулагч хувьцаагаа хоёрдогч зах зээл дээр арилжих боломжтой болно.
- Хоёрдогч зах зээлийн арилжааг СЗХ-ны зөвшөөрлөөр эхлүүлнэ.

3.10.2 Үнэт цаасыг олон нийтэд арилжаалах журам

Үнэт цаас гаргагчийн энэхүү танилцуулгын дагуу олон нийтэд санал болгож буй Үнэт цаасыг анхдагч зах зээл дээр арилжаалахад дараах журмыг мөрдлөг болгоно.

- СЗХ-ны үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий Үнэт цаасны компаниар дамжин МХБ-д ирсэн, дансандаа тухайн захиалгыг хангах бэлэн мөнгөний үлдэгдэл бүхий захиалгыг хүчин төгөлдөрт тооцно.
- Үнэт цаасны захиалгын хуваарилалтыг Андеррайтер зохион байгуулж МХБ хяналт тавин ажиллана.
- Хөрөнгө оруулагч хоёр ба түүнээс дээш ҮЦК-р дамжуулан захиалга оруулах, захиалгыг хэд хэд хуваан байршуулсан тохиолдолд нийт захиалгыг нэгтгэж нийлбэр дүнгээр тооцно

(Үнэт цаасыг олон нийтэд арилжаалах журмын төслийг хавсралт ...-өөс харна уу.)

3.10.3 Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа


- Үнэт цаасыг анх удаа нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болсон тохиолдолд Монголын хөрөнгийн биржийн журмын дагуу Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр хувьцааг анхдагч зах зээл дээрээс худалдан авсан хөрөнгө оруулагчид хувьцаагаа бусдад худалдаалах эрх нээлттэй болно.


Голомт Капитал ҮЦК-р дамжуулан Монголын Хөрөнгийн Биржийн үнэт цаасны арилжаанд оролцоход дараах алхмуудыг авч хэрэгжүүлсэн байх шаардлагатай.

1. Голомт Капитал ҮЦК дээр өөрийн биеэр ирж үнэт цаасны данс, төлбөр тооцооны данс нээлгэнэ.

Хаяг:	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Парк плейс оффисын барилга, 4 давхар, 403 тоот Улаанбаатар, 210644, Монгол Улс
Утас/Факс:	+976 70127530 +976 70121529
И-мэйл:	info@golomtcapital.com

2. Голомт банк дахь өөрийн төлбөр тооцооны дансанд арилжаанд оролцох мөнгөн хөрөнгийг байршуулна.





3. Үнэт цаасны захиалга буюу хэдэн ширхэг хувьцааг ямар ханшаар арилжих захиалгаа өөрийн брокерт утсаар, и-мэйлээр эсвэл өөрийн биеэр өгнө.
4. Брокер захиалга биелэгдсэн талаар эргэн мэдэгдэж, худалдан авалт/худалдалтыг баталгаажуулна.
5. Хэрвээ харилцагч үнэт цаасны данснаас мөнгөө татах хүсэлтэй бол Голомт Капитал ҮЦК дээр





Үнэт цаасны танилцуулга



4. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

4.1 Үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагаанд мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээдүүд

4.1.1 Андеррайтер

"Голомт Капитал ҮЦК ХХК" нь 2012 онд "Голомт Банк" ХХК-ийн 100% хөрөнгө оруулалттайгаар түүний охин компани болон байгуулагдсан. Андеррайтер нь 2011 оны 11 сарын 02-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос "Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ эрхлэх" болон 2014 оны 03 сарын 26-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос "Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх" тусгай зөвшөөрөл, 2015 оны 3 сарын 23-ны өдөр "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийг тус тус авч иргэд, ААН-үүдэд хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээг үзүүлж байна.

Нэр	"Голомт Капитал ҮЦК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011287134
Регистрийн дугаар	5481589
Хаяг	401 тоот, Очир төв, Олимпын гудамж 12/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
Утас	+976-70121530
Факс	+976-70121529
И-мэйл	info@golomtcapital.com
Вэб хуудас	www.golomtcapital.com

Андеррайтерийн хөрөнгийн зах зээлд гаргасан гол амжилтууд:

- Анхны Real-time онлайн арилжааны системийг нэвтрүүлсэн
- Анхны даатгагдсан бонд "Эрчим бонд"-г гаргасан
- Анхны ББСБ-ын даатгагдсан бонд "ММФ бонд"-г гаргасан
- Анхны ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг гүйцэтгэсэн
- Засгийн газрын олон улсын зах зээлд гаргасан "Мазаалай бонд"-д дотоод зөвлөхөөр ажилласан
- 2013 онд МХБ-ийн нийт арилжааны 49%-г гүйцэтгэсэн
- Жил бүр "Mongolian Investment Summit"- ийг зохион байгуулдаг
- 2017 онд хаалттай хүрээнд "ММФ бонд II" болон "Урбан бонд I, II"-г гаргасан
- 2017 онд "Сүү" ХК-ийн 6.0 тэрбум төгрөгийн бондыг амжилттай гарган түүхэн дээд амжилт тогтоосон
- 2018 онд хаалттай хүрээнд "NFC Bond", "Urban Bond"-ыг гаргасан

4.1.2 Хараат бус аудит


"Улаанбаатар Аудит Корпораци" ХХК нь 1999 онд аудитын үйлчилгээ эрхлэх чиглэлээр байгуулагдсан, аудитын салбарт 18 жил үйл ажиллагаа явуулж буй боловсон хүчин, материаллаг бааз, санхүүгийн хувьд бэхэжсэн, хараат бус, чанартай, найдвартай мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг, үйлчлүүлэгч хамтран ажиллагчдын итгэлийг хүлээсэн Монгол улсын аудитын салбарт тэргүүлэх томоохон аудитын компанийн нэг юм.

"Улаанбаатар Аудит Корпораци" ХХК нь хамгийн сүүлд Сангийн сайдын 2017 оны 1 сарын 28-ны өдрийн 11 тоот тушаалаар "Аудитын үйл ажиллагаа эрхлэх" тусгай зөвшөөрлийг 2020





Үнэт цаасны танилцуулга



оны 1 сарын 28-ныг хүртэл 3 жилээр сунгуулсан. Мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны 2014 оны 1 сарын 29-ний өдрийн 23 тоот тогтоолоор “Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх аудитын компани”-иар бүртгэгдсэн ба Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 40 тоот тогтоолыг үндэслэн “Даатгалын байгууллагад аудит хийх эрхийн гэрчилгээ”-г авсан байна. Компанийн аудиторүүд нь СЗХ, ММНБИ-ийн хамтран зохион байгуулдаг “Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх аудиторүүдэд зориулсан цогц сургалт”-д 3 жил тутам хамрагдаж, зохих шалгалтуудыг өгч, гэрчилгээ авсан.

Нэр	“Улаанбаатар аудит корпораци” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9018001038
Регистрийн дугаар	2577542
Хаяг	9-р давхар, Далай тауэр, ЮНЕСКО-гийн гудамж-31, Сүхбаатар дүүрэг-1, Улаанбаатар хот
Утас	+976-70110744
Факс	+976-70110799
И-мейл	info@mn.gt.com
Вэб хуудас	www.grantthornton.mn

Компани нь дор дурьдсан салбаруудад үйл ажиллагаа явуулж буй Монгол улсын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, олон нийтийн ашиг сонирхол бүхий байгууллагуудад аудитын үйлчилгээг үзүүлж байсан туршлагатай. Үүнд:

- Банк санхүү
- Даатгал
- Уул уурхай
- Эрчим хүч
- Зам тээвэр
- Үйлдвэрлэл
- Харилцаа холбоо
- Худалдаа үйлчилгээ
- Барилга
- Төрийн болон төрийн өмчит байгууллагууд
- Төрийн бус байгууллага
- Төсөл хөтөлбөрүүд

“Улаанбаатар аудит корпораци” нь 2014 оны 12 дугаар сарын 1-нд аудит, татвар, зөвлөх үйлчилгээний дэлхийд тэргүүлэгч байгууллагын нэг Грант Торнтон Интернэшнлийн Монгол улс дахь корреспондент фирмээр ажиллах гэрээ байгуулан, 3 жил хамтран ажиллаж, тус байгууллагын нөхцөл шаардлагыг хангасны үндсэн дээр 2017 оны 11 сарын 24-ний өдрөөс эхлэн жинхэнэ гишүүн болж, Монгол улсад “Грант Торнтон Монголиа” гэсэн брэнд нэршлээр ажиллахаар болж байна. Грант Торнтон Интернэшнл нь аудит, татвар болон мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг фирмүүдийн олон улсын сүлжээ байгууллага бөгөөд дэлхийн 130 гаруй оронд салбартай, 50,000 гаруй ажилтантай, дэлхийн 6 том аудит, татвар, зөвлөх үйлчилгээний байгууллагын нэг юм.

4.1.3 Хуулийн байгууллага

“ЭмДиЭс ХаанЛекс” ХХН (хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл) нь 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд өөрийн эрхэлж байгаа онцлог үйл ажиллагааныхаа хувьд Монгол Улс дахь хамгийн том, олон гишүүнтэй хуулийн нөхөрлөл юм. Энэхүү нөхөрлөл нь “Эм Ди Эс Ассошэйтс” болон “ХаанЛекс Адвокэйтс” хоёр ЗБН (зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай



нөхөрлөл)-ийн нэгдлийн үр дүнд байгуулагдсан. Санхүүгийн Зохицуулах хорооны 2016 оны 02-р сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолын дагуу Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэгдэн ажиллаж байна.

Нэр	"Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН
Улсын бүртгэлийн дугаар	9022001010
Регистрийн дугаар	5495997
Хаяг	1301 тоот, Централ Тауэр, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
Утас	+976-330048
Факс	+976-330049
И-мэйл	info@mdsa.mn
Вэб хуудас	www.khanlex.mn

Хуулийн фирмийн хөрөнгийн зах зээлд гаргасан гол амжилтууд:

- Эрдэнэс Таван Толгой ХК-ийн үнэт цаасыг олон улсын түвшинд санал болгох, Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн биржүүд дээр хувьцааг нийтэд анх удаа санал болгох Wolf Төсөл дээр хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн.
- АНУ-ын Олон улсын Хөгжлийн Агентлагаас Монгол Улсын ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн Монголын Ипотекийн Корпорацийн бондын эрсдэлийг бууруулах, хөрөнгө оруулагчдыг татах зорилготой хэсэгчилсэн эх үүсвэрийн баталгаа гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн.
- Монголын Ипотекийн Корпораци ХХК байгуулсан Тусгай Зориулалтын Компаниудаар дамжуулан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажил анх Монгол Улсад хэрэгжиж эхэлсэн цагаас үйл ажиллагаанд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлж байна.
- Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмын төслийг олон улсын зөвлөлтэй хамтран боловсруулсан.
- Монголын Хөрөнгийн Биржийн Бүртгэлийн журмын төсөл боловсруулсан.
- Анхны 100% даатгагдсан хувьцаа "Эрчим" хувьцааг гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн.
- ЛэндМН ББСБ ХХК-ийн анх удаа хувьцаагаа нийтэд санал болгох ажилд хууль зүйн дүгнэлт гаргасан.
- Талын Эзэн ХХК-ийн "НААД" хаалттай бонд гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн.
- Хөвсгөл Алтандуулга ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг зөвтгөх, хувьцаа хуваах ажилд хууль зүйн дүгнэлт гаргасан, одоо хувьцаа нэмж гарган нийтэд санал болгох асуудлаар хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлж байна.


4.1.4 Үнэлгээний байгууллага

Түүхэн замнал хөгжил

- 1999-01-14-нээс Хууль зүйн Яам, Сангийн Яамнаас Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл авч Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ хийж эхэлсэн.
- 2001 оны 06-р сарын 01-нээс "Итгэлт-Аудит" ХХК-тай нэгдэж "Итгэлт-Үнэлгээ" төв нэрээр үйл ажиллагаа явуулсан.
- 2005 оны 01-р сараас "Итгэлт-Аудит" ХХК-иас тусдаа гарсан.
- 2008 оноос СЗХ-ноосы Даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрөл авсан.



Үнэт цаасны танилцуулга



- 2014 оны Орхон аймгийн Баян-Өндөр суманд салбар байгуулсан.
- 2015 онд УБ-Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн Мөрөн хотод салбараа байгуулсан.
- 2017 онд УБ-Баянзүрх дүүрэгт салбар байгуулсан.

Нэр	"Итгэлт-Эстимэйт" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011085084
Регистрийн дугаар	2866641
Хаяг	БЗД, 26-р хороо, Хүннүгийн гудамж, Олимп плаза оффис 401 тоот
Утас	11-455088, 99995638, 99035638
И-мэйл	info@itgeltgroup.mn
Вэб хуудас	www.itgeltgroup.mn

Бизнесийн үнэлгээ

ХААН банк, Говь ХХК, Улсын цирк, Шарын гол ХК зэрэг ОУ-ын тендерээр хувьчлагдсан аж ахуй нэгжүүдийн бизнесийн үнэлгээг хийсэн. Тус үнэлгээг үндэс болгон Олон улсын тендер зарласан цөөн тохиолдлууд юм.

Сүүлийн 3 жилд Монгол шир ХК, Монгол Экспресс ХХК, Лел Металл ХХК, Улаанбаатар Синема, Тэнгис Кино Театр, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, Усан спорт сургалтын төв, Баялаг Налайх ХК зэрэг олон арван ХК болон ХХК-д бизнесийн үнэлгээ хийж гүйцэтгэсэн.

4.2 Тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын тухай мэдээлэл.


4.2.1 Андеррайтертай байгуулсан гэрээ

Андеррайтер нь 2015 оны 3 сарын 23-ны өдөр СЗХ-ны 156 тоот тогтоолоор авсан 3/97 тоот "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд Үнэт цаас гаргагчтай байгуулсан 2018 оны 05 сарын 11-ний өдрийн 18/014 тоот "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд үнэт цаас гаргагчийн хувьцааг санал болгох үйл ажиллагаанд андеррайтерийн үүрэг гүйцэтгэж байгаа болно.

Тус гэрээнд үнэт цаас гаргагч хөрөнгийн зах зээлд нээлттэй үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт татах үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомжийн дагуу мэргэжлийн андеррайтерийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, шаардагдах тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулагч нарт Компанийг танилцуулах, санал болгох, санхүүжилт татаж өгөх, Үнэт цаас гаргагч нь нь гэрээгээр хүлээсэн ажлаа гүйцэтгэхэд нь дэмжин ажиллаж шаардлагатай мэдээлэл, материалыг гарган өгч хамтран ажиллахаар харилцан тохиролцсонтой холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулсан байна.

Энэхүү гэрээний хүрээнд талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Андеррайтер нь Үнэт цаас гаргагчид нээлттэй хүрээнд санхүүжилт татахад СЗХ болон МХБ-ээс гаргасан Үнэт цаасны бүртгэлийн журын дагуу үнэт цаас гаргах төлөвлөгөөг боловсруулах, үнэт цаасны бүртгэлийн шалгуурыг хангахад зөвлөгөө өгөх, үүнтэй холбоотойгоор компанийн нэрийн өмнөөс СЗХ болон МХБ-тэй харилцах, үнэт цаасны танилцуулга материалыг бэлтгэх, болон гэрээний хавсралтуудад өөрөөр заагаагүй тохиолдолд тухай бүр холбогдох үнэт цаасыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3 дугаар зүйлд заасан андеррайтерийн үйлчилгээний төрлөөр өөрийн бүхий л хүчин чармайлтыг гарган арилжаалах
- Үнэт цаас гаргагч нь Андеррайтерийг Гэрээгээр хүлээсэн ажлаа гүйцэтгэхэд нь шаардагатай үнэн зөв, бодит мэдээлэл, бичиг баримт болон материалуудын эх хувь болон баталгаажсан хуулбарыг цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх үүрэг хүлээнэ.



Үнэт-цаасны танилцуулга



4.2.2 Хараат бус аудитын гэрээ

"Улаанбаатар Аудит Корпораци" ХХК нь хамгийн сүүлд Сангийн сайдын 2017 оны 1 сарын 28-ны өдрийн 11 тоот тушаалаар "Аудитын үйл ажиллагаа эрхлэх" тусгай зөвшөөрлийг 2020 оны 1 сарын 28-ныг хүртэл 3 жилээр сунгуулсан. Мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны 2014 оны 1 сарын 29-ний өдрийн 23 тоот тогтоолоор "Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх аудитын компани"-иар бүртгэгдсэний дагуу Үнэт цаас гаргагчтай 2018 оны 04 сарын 11-ны өдөр 2018/33 тоот Аудитын үйлчилгээний гэрээг байгуулсан байна.

Тус гэрээний зорилго нь Монгол улсын "Иргэний хууль", "Нягтлан бодох бүртгэлийн болон Аудитын тухай" хууль бусад холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар, олон улсын хэмжээнд дагаж мөрддөг санхүүгийн тайлагналын болон аудитын стандартын дагуу үйлчлүүлэгчийн санхүүгийн тайланд 2017 оны 12 сарын 31-ны байдлаар аудит хийж, тайлан дүгнэлт гаргаж өгөхөд оршино.

Энэхүү гэрээний дагуу талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Монгол улсын хууль, тогтоол, тушаал, дүрэм, журам, заавраар батлагдсан маягтын дагуу гаргасан санхүүгийн тайлан (баланс)-г үйлчлэгчид өгч баталгаажуулуулах, Санхүүгийн тайланг гаргахтай холбогдсон ерөнхий журнал, данс, тусгай журнал, дэлгэрэнгүй бүртгэл, ажлын хүснэгт, санхүүгийн тайлангийн судалгаа шинжилгээ, тайлбар, тодруулга, илтгэх хуудас зэрэг баримт бичиг, өөрийн байгууллагын онцлог, бүртгэлийн бодлого, дотоод хяналтын журам, үйл ажиллагаа явуулдаг горимоо үйлчлүүлэгчийн зүгээс үйлчлэгчийн хүсэлт, шаардлага, зөвлөмжийн дагуу үзүүлж, тайлбарлан танилцуулах.

Үйлчлүүлэгчийн гаргасан санхүүгийн (баланс) тайланг аудиторроор шалгуулж баталгаажуулах, бүртгэлээ улам сайжруулан зохион байгуулахад нь туслах, зөвлөх, Санхүүгийн тайланд аудит хийж тайлан дүгнэлт гаргахдаа Монгол улсын "Аудитын тухай", "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулиуд, бусад холбогдох хууль, тогтоол, дүрэм, журам, аудитын Олон улсын стандарт, компанийхаа дотоод стандарт, бодлого, журам, горим, аргачлалыг үндэслэн санхүүгийн тайлан дахь тоон үзүүлэлтүүдийг нотлох баримтуудаар шалган, удирдлагын ашигласан бүртгэлийн бодлого, зарчим болон гол чухал тооцооллуудыг үнэлж, аудитын явцад илэрсэн дотоод хяналтын сул тал ба материаллаг болон материаллаг бус зөрчил дутагдлуудын тайлан бичиж бүхэлд нь дүгнэлт өгөх зэрэг үүргүүд багтаж байна.

4.2.3 Хуулийн гэрээ

Хуулийн "Эм Ди Эс Ханлекс" ХХН нь Санхүүгийн Зохицуулах хорооны 2016 оны 02-р сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолын дагуу Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэгдсэний дагуу Үнэт цаас гаргагчтай 2018 оны 4 сарын 11-ны өдөр Б18-020 тоот гэрээг байгуулан ажиллаж байна.

- Уг гэрээний зорилго нь хуулийн байгууллага нь үйлчлүүлэгчид анх удаа хувьцаагаа нийтэд санал болгоход Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхэд СЗХ-ны 408 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ийн 1.2.2-т заасан 9 асуудал, МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ийн 4.5-д заасан 7 асуудлыг шалгаж хуулийн дүгнэлтийг Монгол хэл дээр бэлтгэх





Үнэт цаасны танилцуулга



- Үнэт цаас гаргагч нь Хуулийн зөвлөхтэй бүх талаар хамтран ажиллаж үнэт цаасны танилцуулгад тусгагдах бүх мэдээллийг хуулийн байгууллагад үнэн зөв гаргаж өгөхөд оршиж байна.


4.2.4 Үнэлгээний гэрээ

"Итгэлт Эстимэйт" ХХК нь 1999-01-14-нээс Хууль зүйн Яам, Сангийн Яамнаас Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл авч Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ хийж эхэлсэн. Дээрх тусгай зөвшөөрлийн хүрээнд 2018 оны 4 сарын 11-ны өдөр Үнэт цаас гаргагчтай 18/02 тоот Хөрөнгийн үнэлгээний ажлын гэрээг байгуулсан.

Тус гэрээний зорилго нь Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн болон бизнесийн зах зээлийн үнийг өнөөгийн байдлаар тогтооход оршиж байна.

Энэхүү гэрээний хүрээнд талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Захиалагчийн үнэлгээ хийлгэж буй хөрөнгөтэй танилцаж, шинж байдлыг нь тодорхойлж, үнэлгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зах зээлийн өнөөгийн эрэлт шаардлагад нийцүүлэн гэрээт хугацаанд хийж гүйцэтгэх, хөрөнгийн өнөөгийн байдалд судалгаа хийх, ажлын төлөвлөгөө зохиох, мэдээлэл цуглуулах, түүнийг шалгах, үнэлгээ хийх, тайлан бичих, хүлээлгэн өгөх графикийг захиалагчтай хамтран боловсруулах
- Үнэт цаас гаргагч нь Үнэлгээний компанитай бүр талаар хамтран ажиллаж шаардлагатай бүхий л мэдээллийг гаргах үүргийг хүлээнэ.



Үнэт цаасны танилцуулга



СЗХ
2018.02.01.14 өдөр
БҮРТГЭВ
№ 01
ҮНДЭСНИЙ ҮЙЛДЭВЭРЛЭГЧ
ТҮМЭН ШУВУУТ ХХК

5. Үнэт цаасны үйл ажиллагаанд оролцсон талуудын дүгнэлт

5.1 Андеррайтерийн дүгнэлт



ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Олимпийн гудамж 12.11 Огноо Центр 401 тоот,
Улаанбаатар, 210644, Монгол Улс
Утас: 75121520, 70121529
И-мэйл: info@golomtcapital.com

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД

2018.06.11 № 15/089

Танхай

№ Н°

Т

"ТҮМЭН ШУВУУТ" ХХК-ИЙН ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ САНАЛ БОЛГОЖ БУЙ ХУВЬЦААНД ӨГӨХ АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

"ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК" (цаашид "Андеррайтер" гэх) нь Санхүүгийн зохицуулах хорооноос 2015 оны 3 сарын 23-ны өдөр олгосон "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд "ТҮМЭН ШУВУУТ" ХХК (цаашид "Үнэт цаас гаргагч" гэх)-тай 2018 оны 05 сарын 11-ний өдрийн 18/014 тоот "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ" (цаашид "Андеррайтерийн гэрээ" гэх)-г байгуулж, Үнэт цаас гаргагчийн 50,000,000 ширхэг хувьцааг нэмж гарган Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нэгж хувьцааны үнийг 200 төгрөгөөр олон нийтэд нээлттэй санал болгон нийт 10,000,000,000 (арван тэрбум) төгрөгийг татан төвлөрүүлж нээлттэй хувьцаат компани болох үйл ажиллагаанд андеррайтераар ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь энэхүү татан төвлөрүүлсэн хөрөнгөөр өндөгний үйлдвэрлэлийг өргөжүүлэх, өндөглөгчийн байр нэмж барих, шинээр тэхманы махны аж ахуйг хөгжүүлэх, малын тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчилэх, малын тэжээлийн тасралтгүй нэгдвэртэй байдлыг хангахад тариалалтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, усжуулалт бүхий өөрийн эзэмшлийн талбайд улаанбуудай, царгас, ногоон тэжээл зэрэг бүтээгдэхүүнийг тарьж хүн малын хүнсний аюулгүй байдлыг хангахад зарцуулахаар төлөвлөсөн байна. Мөн үнэт цаас гаргагч нь дээрх ажлуудыг авч хэрэгжүүлэхэд холбогдох бэлтгэж ажлууд болох тоног төхөөрөмж нийлүүлэх тал, барилгын төлөвлөгөө, усжуулалттай тариаланг хөгжүүлэх төлөвлөгөө, бэлтгэл бааз сүүрийг бүрдүүлэн, хөрөнгө оруулагчаас татан төвлөрүүлэх хөрөнгийг зарцуулах төлөвлөгөөг боловсруулсан байна.

Андеррайтер нь энэхүү Үнэт цаас гаргагчийн хувьцааг арилжаалах үйл ажиллагааг Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Монголын хөрөнгийн бирж (МХБ)-ийн ТУЗ-ийн 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон бусад холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэж байгаа болно. Мөн андеррайтерийн үйлчилгээний төрлийг Андеррайтерийн гэрээний дагуу Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3 дугаар зүйлд заасан андеррайтерийн төрлөөр буюу "Best Effort" төрлөөр гүйцэтгэж байна.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд нээлттэй худалдах үнэт цаасны бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, СЗХ-ны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 408 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам шинэчлэн батлах тухай" журмын 4.1, Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-н 2015 оны 04-р сарын 30-ны өдрийн 2015/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан МХБ-н ТУЗ-н 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан "МХБ" ТӨХК-н "Арилжааны журмын" дагуу явагдана.



Үнэт цаасны танилцуулга



Олон нийтэд үнэт цаас санал болгон хөрөнгө оруулалт татах бэлтгэл ажлын хүрээнд Үнэт цаас гаргагч нь Андеррайтертай Андеррайтерийн үйлчилгээний гэрээ байгуулан ажиллахаас гадна дараах бэлтгэл ажлуудыг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Үнэт цаас гаргагч нь "ЭмДиЭс ХаанЛекс" ХХН хуулийн 2018 оны 4 сарын 11-ны өдөр Б18-020 тоот "Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулан Үнэт цаас гаргагчийн хувьцааг анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагаанд хууль зүйн зөвлөхийн үүргийг гүйцэтгүүлж байна. "ЭмДиЭс ХаанЛекс" ХХН (хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл) нь 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд өөрийн эрхэлж байгаа онцлог үйл ажиллагааныхаа хувьд Монгол Улс дахь хамгийн том, олон гишүүнтэй хуулийн нөхөрлөл юм. Энэхүү нөхөрлөл нь "Эм Ди Эс Ассошэйтс" болон "ХаанЛекс Адвокэйтс" хоёр ЗБН (зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл)-ийн нэгдлийн үр дүнд байгуулагдсан. Санхүүгийн Зохицуулах хорооны 2016 оны 02-р сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолын дагуу Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэгдэн ажиллаж байна. "ЭмДиЭс ХаанЛекс" ХХН Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхэд СЗХ-ны 2015 оны 408 тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 4.2.2-т заасан шаардлагын дагуу хууль зүйн дүгнэлт гаргах, хууль зүйн магадлан шинжилгээ (due diligence) хийх, шаардлагатай бичиг баримт зэргийг хуульд нийцсэн эсэхийг хянах ажил үйлчилгээг хийж гүйцэтгүүлсэн.
2. Үнэт цаас гаргагч нь "Улаанбаатар Аудит Корпораци" ХХК аудитын компанитай Үнэт цаас гаргагчтай 2018 оны 04 сарын 11-ны өдрийн 2018/33 тоот Аудитын үйлчилгээний гэрээг байгуулан Үнэт цаас гаргагчийн хувьцааг анхдагч зах зээлд санал болгоход үйл ажиллагаанд аудитын байгууллагын үүргийг гүйцэтгүүлж байна. "Улаанбаатар Аудит Корпораци" ХХК нь хамгийн сүүлд Сангийн сайдын 2017 оны 1 сарын 28-ны өдрийн 11 тоот тушаалаар "Аудитын үйл ажиллагаа эрхлэх" тусгай зөвшөөрлийг 2020 оны 1 сарын 28-ныг хүртэл 3 жилээр сунгуулсан. Мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны 2014 оны 1 сарын 29-ний өдрийн 23 тоот тогтоолоор "Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх аудитын компани"-иар бүртгэгдсэн байна. Аудитын компани нь "Үнэт цаасны зах зээлд оролцогчдод аудитын үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд "Аудитын тухай хууль", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль", бусад холбогдох хууль, тогтоол, дүрэм журам, аудитын Олон улсын стандарт, компанийн дотоод стандарт, бодлого, журам, горим, аргачлалыг үндэслэн Үнэт цаас гаргагчийн 2017 оны 12 дугаар 31-ээр тасалбар болгосон санхүүгийн тайланд аудит хийж, тайлан дүгнэлт гаргуулсан.
3. Үнэт цаас гаргагч нь "Итгэлт Эстимэйт" ХХК үнэлгээний компанитай 2018 оны 4 сарын 11-ны өдөр Үнэт цаас гаргагчтай 18/02 тоот "Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний гэрээ" байгуулан Үнэт цаас гаргагчийн хувьцааг анхдагч зах зээлд санал болгоход үйл ажиллагаанд хөрөнгийн ба бизнесийн үнэлгээний байгууллагын үүргийг гүйцэтгүүлж байна. "Итгэлт Эстимэйт" ХХК нь 1999-01-14-нээс Хууль зүйн Яам, Сангийн Яамнаас Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл авч Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ хийж эхэлсэн ба үнэлгээчин Ө. Эрдэнэбаяр нь Сангийн яамны хөрөнгийн үнэлгээ хийх 071200002 тоот тусгай зөвшөөрлийн үндсэн дээр Монгол улсын холбогдох хууль тогтоомж, стандарт, СЗХ болон МХБ-ээс баталсан дүрэм, журам нийцүүлэн,

МОНГОЛЫН ШУВУУТ ХХК



Үнэт цаасны танилцуулга



ҮНДЭСНИЙ ҮЙЛДЭВЭРЛЭГЧ
ТҮМЭН ШУВУУТ ХХК



тэдгээр байгууллагаас тавигдсан шаардлагын дагуу Үнэт цаас гаргагчийн бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг 2018 оны 5 сарын 25-ны байдлаар хийж гүйцэтгэсэн.

4. Үнэт цаас гаргагч нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 06 сарын 07-ны өдрийн 05/2018 тоот тогтоолоор компанийг нээлттэй хувьцаат компани болгохоор шийдвэрлэж, 50 сая ширхэг хувьцааг нэмж гаргах тухай шийдвэрлэсэн.

Энэхүү Үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгон арилжих ажлын хүрээнд Андеррайтер нь дараах үндсэн чиглэлүүдээр холбогдох судалгаа шинжилгээний ажлуудыг хэрэгжүүлээ. Үүнд:

1. Компанийн бизнесийн тухай болон өнөөгийн байдлын судалгаа, танилцуулга
2. Компанийн үйл ажиллагаа явуулж буй салбарын өнөөгийн байдал болон эрх зүйн орчин
3. Компанийн санхүүгийн байдлын талаар нарийвчилсан дүгнэлт, шинжилгээ
4. Компанийн ирээдүйн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний шинжилгээ
5. Нэгж хувьцааны үнийг тогтоох, компанийн бизнесийн үнэлгээтэй холбоотой шинжилгээ
6. Үнэт цаасны борлуулалтын төлөвлөгөөг боловсруулах, хөрөнгө оруулагчдыг олж тодорхойлох
7. Нэмж хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт, үр ашгийн тооцоо болон санхүүгийн төсөөлөл
8. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн хүчин зүйлсийн шинжилгээ

Дээрх судалгаа, шинжилгээнд тулгуурлан Андеррайтер нь энэхүү Үнэт цаас гаргагч "Түмэншувуут" ХХК-ийн олон нийтэд нээлттэй санал болгох үнэт цаасны танилцуулгыг бэлтгэн гаргалаа.

Андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийсэн судалгаа шинжилгээнүүдээс бид дараах дүгнэлтүүдийг гаргалаа. Үүнд:

Компанийн бизнес, үйл ажиллагааны талаар


Түмэн шувуут ХХК нь (цаашид Компани гэх) 2004 онд 20,000 өндөглөгч тахиатай аж ахуйг байгуулсан цагаас өнөөг хүртэл өндөгний аж ахуйн үйл ажиллагааг тогтмол амжилттай эрхэлж өнөөгийн байдлаар 250,000 гаруй өндөглөгч тахиатай, 140-н ажиллагсадтай Монгол улсын өндөгний хэрэгцээний 30 орчим хувийг дангаар хангагч аж ахуй болон хөгжөөд байна.

Компани хэрэглэгчдэд өдөр бүр 100,000 орчим шинэ өндөгийг хүргэхээс гадна дараах шувуутай холбоотой үйл ажиллагааг цогцоор нь эрхэлж байна. Үүнд:

▪ Нэг хоногийн настай дэгдээхэй нийлүүлэх

Эмбриотой буюу үр хөврөл бүхий өндөгийг импортоор тусгай зориулалтын автомашинаар тээвэрлэн нэг ээлжиндээ 150 мянган өндөг дарах хүчин чадал бүхий өөрийн инкубатор төвд авчирч 18-21 хоног дарсны эцэст дэгдээхэй гарган авдаг. Уг гарсан дэгдээхэйнүүдийг дотоодын тахианы аж ахуйн нэгжүүдэд худалдан борлуулж тэдгээр аж ахуйн нэгжүүдийн сүргийн бүтцийг бий болгоход үнэтэй хувь нэмэр оруулаад зогсохгүй Монгол Улсын тахианы аж ахуйн тогтвортой байдлын хангаж ажиллаж байна.

▪ Өндөгний сав баглаа, боодол





Үнэт цаасны танилцуулга



Өндөгийг хэрэглэгчдэд хүргэх хамгийн чухал алхамын нэг нь сав баглаа боодол байдаг. Компанийн хувьд өөрийн үйлдвэртээ сав баглаа боодлоо хаягдал цаасыг өндөр температурт боловсруулан, ариутган хэрэглэдэг нь байгаль экологид ач тустай, цаашлаад эдийн засгийн хувьд хэмнэлтийг хэрэглэгчдэд үзүүлдэг бизнесийн нэгэн чухал хэсэг болон хөгжсөн байна. Компани өөрийн хэрэгцээнээс илүү гарсан сав баглаа боодлыг мөн бусад аж ахуй нэгжүүдэд борлуулдаг бөгөөд компанийн орлогын 1.2 хувийг бүрдүүлэгч жилд 175 сая төгрөгийн эх үүсвэр бий болгодог бизнесийн нэг хэсэг байна.

▪ Шувууны болон малын тэжээл

Үнэт цаас гаргагч нь 2015 онд хоногт 100 тонн тахианы болон малын тэжээл үйлдвэрлэх хүчин чадал бүхий Агро Фийд (Agro Feed) үйлдвэрийг Сонгино хайрхан дүүргийн 21-р хороонд байлах өөрийн эзэмшлийн 150,000 м² талбайд байгуулсан. Уг үйлдвэрт компани дотоодын бүтээгдэхүүнийг ашиглан шувууны болон малын тэжээлээ үйлдвэрлэснээр өндөгний чанарт хяналт тавих, эрүүл мэндийн хувьд гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж байна.

Үнэт цаас гаргагч нь тэжээлийн үйлдвэртээ малын төрөл, насны ангилал зэргийг удаан хугацаанд идэвхитэй судалсны эцэст шувууны 5-н төрлийн тэжээл, малын 6-н төрлийн тэжээлийг тухайн амьтадын бие физиологид нийцсэн онцлогт тааруулж үйлдвэрлэж байна. Тухайлбал тахианы насны онцлогоос хамаарч 5-н төрлийн тэжээлийг үйлдвэрлэж буй бөгөөд Селинээр баяжуулсан тэжээлийг өндөглөгч тахианд өгсөнөөр Селинээр баялаг өндөгийг үйлдвэрлэн хүн амын эрүүл мэндэд хувь нэмэр оруулж байна.

Мөн бүх төрлийн малд зориулсан "Тарга", саалийн үнээний "Сүүт", хурдан морины "Хурд", адууны "Амар", "Шингүүртэй овъёос" зэрэг шинэ нэр төрлийн, төгс чанарын тэжээл үйлдвэрлэж, тэдгээр нь хэрэглэгчдэд өндөр үнэлэгддэг.

Тэжээлийн үйлдвэрийн дэргэдэх чанарын лабораторит үйлдвэрлэх бүтээгдэхүүний түүхий эдийг шинжлэн худалдан авах, бэлэн болсон бүтээгдэхүүний чанарыг тогтмол шалгадаг нь хэрэглэгчдэд өндөр чанартай бүтээгдэхүүн хүргэх баталгаа болж өгдөгөөрөө онцлогтой.

▪ Тахианы мах үйлдвэрлэх

Өндөглөгч шувуу нь 640-700 хоног насалсны эцэст үржил шим нь буурдаг тул шинэ залуу тахиагаар солих шаардлага үүсдэг. Харин нэгэнт өндөглөгөөний үе шатыг бүрэн туулсан тахиануудыг компани өөрийн бүрэн автомат мах нядалгааны төвд бэлтгэн тахианы махыг зах зээлд нийлүүлдэг. Хэдийгээр өндөглөгч тахианы мах нь махны тахиагаар харьцуулахад жин бага байдаг боловч бордоо бага хэрэглэсэн, органик байдлыг агуулдагаараа шим тэжээлийн хувьд ялгарч чаддаг онцлогтой.

Үнэт цаас гаргагч компанийн үйл ажиллагаа нь жигдэрсэн, салбартаа арвин туршлагыг хуримтлуулсан аж ахуйн нэгж юм. Монгол улсын өндөг үйлдвэрлэн, борлуулах зах зээлд НВЦ компанийн дараа ордог хоёрдагч том аж ахуй нэгж бөгөөд шувууны тэжээлийг өөрийн үйлдвэртээ үйлдвэрлэдгээрээ бусад өрсөлдөгч байгууллагуудаас ялгарч чаддаг аж ахуйн нэгж юм.

Үйл ажиллагаа явуулж буй салбарын өнөөгийн байдлын талаар

Манай улсын хувьд шувууны аж ахуй нь хожим хөгжсөн хөдөө аж ахуйн залуу салбар боловч 2010 оноос хойш энэ салбарын өсөлт хөгжил маш эрчимтэйгээр нэмэгдэж байна. Нөгөөтэйгүүр хүн ардын хэрэглээний сагсанд өндөгний эзлэх хувь нэмэгдэж байгаа хэдий ч Монгол хүний өндөгний дундаж хэрэглээ дэлхийн дундаж түвшнээс даруй 3 дахин бага байгаа нь цаашид уг салбарын өсөх боломжийг харуулж буй тод жишээ юм. 2017 онд Монгол улс нийт 120 сая ширхэг өндөгийг зөвхөн импортоор авч хүнсэндээ хэрэглэж буй нь цаашлаад импортын бүтээгдэхүүнээс өндөр чанартай дотоодын аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд ирээдүй буйг баталж байна.

Монгол улсын хэмжээнд нийт 705 мянган ширхэг шувуу бүртгэлтэй байгаа бол үүний 444 мянган ширхэг нь өндөглөгч шувуу байна. Уг тоо сүүлийн жилүүдэд өөрчлөлт ихтэй байгаа нь өндөгний зах зээлд импортын өндөгний байр суурь нэмэгдсэн, дотоодын зах зээлд жижиг үйлдвэрүүд оршин тогтноход өрсөлдөөн их хэмжээгээр нэмэгдсэн зэрэг нь нөлөөлж байна.




График 30 Өндөглөгч шувууны статистик мэдээлэл

Монгол улс 2017 оны байдлаар нийт 7.4 сая ам.долларын өртөг бүхий 120 сая ширхэг өндөгийг импортоор оруулж ирэн хэрэглэсэн бөгөөд уг дүн нь өмнөх оноос даруй 43 хувь өссөн байгаа нь хүн амын хэрэглээний бүтцэд өндөгний эзлэх байр суурь нэмэгдсэн, Монгол хүмүүсийн бие физиологиоо анхаарал хандуулах хандлага нэмэгдэх фитнес, бодибилдингээр хичээллэгчдийн тоо өссөн зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна.




График 31 Импортын өндөгний зах зээлийн мэдээлэл

Мөн нөгөө талаар импортоор оруулж ирсэн тахиа, тэжээвэр шувууны тоо 2017 онд 257 мянган толгойд хүрч нийт 349 мянга ам.долларын буюу 840 орчим сая төгрөгийн тахиаг импортоор худалдан авсан байна. Монгол улс нь тахианы дэгдээхэйг импортоор худалдан авдаг ба нэгж дэгдээхэйний өртөг нь 1-1.3 ам.долларын өртөгтэй байна.

Монгол Улсын нэг хүний өндөгний дундаж хэрэглээ нь жилд 87 ширхэг байгаа бол олон улсын түвшинд 220 ширхэг өндөг хэрэглэж байна. Энэ нь цаашлаад Монгол Улсын хэрэглэгчдийн түвшин олон улсын түвшинд хүрэхэд нийт зах зээл 2.5 дахин нэмэгдэж нийт өндөгний хэрэглээ 660 сая ширхэг болох боломжтойг илтгэж байна.

Үнэт цаас гаргагч нь зөвхөн өндөг үйлдвэрлээд зогсохгүй өөрийн шувууны болон малын тэжээлийн аж ахуйг эрхэлдэг бөгөөд уг салбарт дотоодын эрэлт маш өндөр байдаг. Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны судалгаагаар Манай улсын сүүний үхрийн аж ахуйд

ТҮМЭН ШУВУУТ ХХК
ТТЭ 01

117



Үнэт цаасны танилцуулга



66.9 мянган тн, мах-сүүний үхрийн аж ахуйд 7.6 мянган тн, махны үхрийн аж ахуйд 22.5 мянган тн, эрчимжсэн хонины аж ахуйд 23.6 мянган тн, сүүний чиглэлийн ямааны аж ахуйд 0.2 мянган тн, гахай, шувууны аж ахуйд 66.9 мянган тн, нийт эрчимжсэн мал аж ахуйд байгаа мал, амьтанд 187.4 мянган тн тэжээл шаардлагатай.

Цаашид Монгол улсын Засгийн газраас эрчимжүүлсэн мал аж ахуйг хөгжүүлэх төлөвлөгөөтэй байгаа нь компанийн үйлдвэрлэдэг тэжээлийн эрэлтэд эерэгээр нөлөөлөх боломжтой бөгөөд хөдөө аж ахуйн тариалалтад хууль эрх зүйн орчны хувьд мөн эерэг нөлөөллийг авчрах боломжтой юм. Тухайлбал, үнэт цаас гаргагчийн хөгжүүлж буй усжуулалттай тариалалтыг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд төрийн зүгээс хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд тоног төхөөрөмжийн олон улсын хөнгөлөлттэй зээлд хамруулах хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа нь компанийн бизнес амжилттай явагдахад хувь нэмэр оруулах юм.

Хууль эрх зүйн орчны талаар

Үнэт цаас гаргагч нь 2004 оны 8 сарын 30-нд байгуулагдсан ба Улсын бүртгэлийн 9011127143 тоот гэрчилгээний дугаартай, 2844753 тоот регистрийн дугаартайгаар улсын бүртгэлд бүртгэгдсэн байна.

Түмэн шувуут нь “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн дагуу Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2011.12.30-ны өдрийн А/369 дугаар тушаалаар Малын эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2011.12.30-ний өдөр авсан ба Монгол Улсын Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014.09.16-ны өдрийн А/342 дугаар тушаалаар Үржлийн тахиа, дэгдээхэй, үржлийн өндөг импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2014.09.16-ны өдөр авсан байна.


Үнэт цаас гаргагч нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 06 сарын 07-ны өдрийн 05/2018 тоот тогтоолыг тус тус үндэслэн нэмж хувьцаа гаргаж байгаа бөгөөд хувьцаагаа Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлж олон нийтэд санал болгох замаар Нээлттэй хувьцаат компани болж байгаа болно.

Компанийн санхүүгийн байдалд хийсэн шинжилгээ

Үнэт цаас гаргагч нь 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 14.3 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй, 3 тэрбум төгрөгийн урт хугацаат өр төлбөр, 2 тэрбум төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй байна. Компанийн нийт хөрөнгийн 31 хувийг эргэлтийн хөрөнгө 69 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна. Өндөг, тэжээлийн үйлдвэр нь капитал их хэмжээгээр шаарддаг бизнес тул эргэлтийн бус хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хэмжээ нь зохистой түвшинд байгааг илтгэж байна. Харин нийт хөрөнгийн 64 хувийг өөрийн хөрөнгө 36 хувийг өр төлбөр бүрдүүлж байна. Өр төлбөр дунд урт хугацаат өр төлбөр хамгийн өндөр хувь буюу 20 хувийг эзэлж байна. Урт хугацаат өр төлбөр нь 3 тэрбум төгрөгийн Хас банкны зээл байгаа бөгөөд Азийн хөгжлийн банкны 8 хувийн хөнгөлөлттэй зээл байгаа юм.

Үнэт цаас гаргагч нь 2017 онд 13.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлогтой, 1.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд өмнөх тайлант оны түвшнээс борлуулалтын орлого 28 хувь, цэвэр ашиг 66 хувиар өссөн байна. Өнгөрсөн жилүүдэд үнэт цаас гаргагч нь жил бүр өөрийн хүчин чадлаа нэмэгдүүлж тахианы шинэ байр ашиглалтад оруулах, тэжээлийн үйлдвэр барих зэргээр орлогын хэмжээг нэмэгдүүлж ирсэн. Харин 2014 онд өндөгний импорт буурч дотоодын өндөг үйлдвэрлэл нэмэгдсэн нь компанийн орлогыг 2014 онд 10.2 тэрбум, цэвэр ашгийг 3 тэрбум төгрөгт хүрэхэд нөлөөлсөн байна.

2017 оны сүүлийн хагасд компани өндөглөгч шувууны 7-р байрыг ашиглалтад оруулсан бөгөөд 2018 онд өндөглөгч шувууны байр 8-г ашиглалтад оруулснаар борлуулалтын орлогын түвшин болон цэвэр ашгийн түвшин нэмэгдэх боломжтой. Мөн тэжээлийн үйлдвэрт шинэ





Үнэт цаасны танилцуулга

бүтээгдэхүүнийг хөгжүүлж, зах зээлд түлхүү таниулж ажиллаж байгаа нь цаашдаа компанийг илүү өндөр санхүүгийн үзүүлэлттэй ажиллахад нөлөөлөх юм.

Үнэт цаас гаргагчийн нийт борлуулалтын 79 хувийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 10 хувийг үйл ажиллагааны зардал эзэлж байгаа бөгөөд цэвэр ашиг 10 хувьтай байна. Цэвэр ашгийн хэмжээ 10 хувь байгаа нь цаашид компанийн хувь эзэмшигчдэд өгөөж хүртэх боломж өндөр байгааг илтгэж байна. Ялангуяа үнэт цаас гаргагчийн авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажилд борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардлыг бууруулах арга хэмжээнүүд тусгагдсан, цаашлаад шинээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр дунд ашигт ажиллагааны хувь өндөртэй махны тахиа, шинэ төрлийн тэжээлүүдийг бий болгох нь ашигт ажиллагааны хувийг нэмэгдүүлэх юм. Тухайлбал, өндөг боловсруулах үйлдвэр нь өндөгийг цуглуулах, угаах, ариутгах, хэмжээгээр нь ялгах, савлах зэрэг үйлдлүүдийг цогцоор нь шийдэж өгсөн нь үйл ажиллагааны зардлыг бууруулах бөгөөд өндөгний үнийг бага түвшинд барихад нөлөөлөх юм.

Үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын талаар

Үнэт цаас гаргагч нь компанийн энгийн хувьцааны 25 хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгох замаар нийт 10 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Үнэт цаасны тухай хуулийн 12.9, МХБ-н Үнэт цаасны бүртгэлийн журмын 15.2.1.5-г үндэслэн Үнэт цаас гаргагч нь олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулахаар энэхүү танилцуулгад дэлгэрэнгүй мэдээллийг тусгав, үүнд:

5. Өндөгний үйлдвэрийн үйл ажиллагааг өргөжүүлэх төсөл
6. Махны тахианы үйлдвэр эрхлэх төсөл
7. Сангас боловсруулж бордоо үйлдвэрлэх төсөл
8. Тэжээлийн үйлдвэрийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх зэрэг төслүүд багтаж байна.

Дээрх ажлуудын хүрээнд компани дараах байдлаар хөрөнгө оруулалтын зарцуулалтын төлөвлөгөө гаргаад буй бөгөөд олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг хамгийн өндөр өгөөж болохуйц бизнесийн салбаруудад зарцуулахаар төлөвлөсөн байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАДАРГАА

	сая.төг	Эзлэх хувь
Өндөглөгчийн 8-р байр	1,249	13%
Өндөг боловсруулах үйлдвэр	1,531	15%
Махны тахианы аж ахуй, тэжээл үйлдвэрлэл	3,928	39%
Сангасны бордооны үйлдвэр	946	10%
Сангасны бордооны байр	705	7%
Усжуулах ХК-д хөрөнгө оруулалт	625	6%
Эргэлтийн хөрөнгө	1,016	10%
НИЙТ	10,000	100%

Хүснэгт: 30 Хөрөнгө оруулалтын задаргаа

Нийт хөрөнгө оруулалтын 40 хувийг тахианы махны төсөлд зарцуулах бөгөөд улмаар цаашдын бизнесийн гол шугамыг нээхээр төлөвлөж байна. Мөн өндөгний үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өндөгний өртөгийг бууруулахад нийт хөрөнгө оруулалтын 28 хувийг зарцуулах юм.

Үнэт цаас гаргагч нь дунд хугацааны буюу 2018-2022 оны бизнес төлөвлөгөөндөө

Өндөгний 8-р байрыг ашиглалтад оруулах

"Өндөглөгчийн 8" төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд уг байрыг барьсанаар нийт тахианы тоог 250.0-300.0 болгон нэмэгдүүлээд зогсохгүй жилийн 65-70 сая өндөг үйлдвэрлэх боломжтой болох юм. Энэ нь 2016 оны борлуулалтын хэмжээ болох 50 сая ширхэг



Үнэт цаасны танилцуулга



өндөгнөөс даруй 30-40 хувиар их юм. Өндөг үйлдвэрлэх процессд сүргийн бүтцийг зөв тодорхойлох, дэгдээхэйний байр, өндөглөгчийн байрны зохистой харьцааг тогтоох нь чухал байдаг. Үнэт цаас гаргагч нь 2016 онд 6-н өндөглөгчийн байртай, 2 дэгдээхэйний байртай үйл ажиллагаа явуулж байсан бол 2017 онд 1 өндөглөгчийн байр нэмж оруулснаар бүтээмжийг 25-30 хувиар нэмэгдүүлсэн. Харин 2018 онд дахин нэг өндөглөгчийн байр нэмж барьсанаар инкубатор, дэгдээхэй, өндөглөгчийн байрны зохистой харьцааг зөв тогтоох боломжтой болох юм.

Өндөг боловсруулах үйлдвэр

Үнэт цаас гаргагч нь Япон улсын Набел компанитай хамтран өндөг боловсруулах үйлдвэрийг одоогийн байгаа үйлдвэр дээрээ суурилуулах юм. Уг өндөг боловсруулах тоног төхөөрөмж нь дараах давуу талыг компанид авчирах юм. Үүнд:

4. Өндөгийг угааж, цэвэрхэн болгоно
5. Өндөгийн чанарыг тухай бүр шалган, жинг хэмжин ангилна
6. Өндөгийг ангилсны дараа савлана

Эдгээр үйл ажиллагаа нь өнөөдрийн байдлаар гар ажиллагаатай буюу хүн хүч их хэмжээгээр шаардан, зардлыг өсгөж байгаа бол шинэ тоног төхөөрөмжийг суурилуулснаар зардлыг хэмнээд зогсохгүй, өндөгний чанарыг дээд зэргийн түвшинд байлгах юм.

Нөгөө талаар өндөгийг ангилах, тээвэрлэх, угаах явцад гардаг хагарал, цаг алдалтыг багасгана.

Улмаар гар ажиллагааг багасган, зардлыг хэмнэснээр өндөгний үйлдвэр нь 5-6 жилийн дотор өөрийн өртөгөө нөхөх бөгөөд цаашид компанид хэмнэлтийг авчран, өндөгний үнийг бууруулан хэрэглэгчдэд хямд бүтээгдэхүүн нийлүүлэхэд нэг алхам нэмэх юм.

Тахианы махны аж ахуй

Үнэт цаас гаргагч нь шувууны аж ахуй хөгжүүлсэн олон жилийн туршлага дээрээ үндэслэн тахианы махны аж ахуйг хөгжүүлж, хэрэглэгчдийг чанартай, найдвартай бүтээгдэхүүнээр хангахаар зорьж ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар компани нас нь хөгширсөн буюу 640-700 хоногтой өндөглөгч тахиаг нядлан, мах бэлтгэн зах зээлд нийлүүлж буй туршлагатай бөгөөд энэ туршлагад үндэслэн цаашид махны тахиаг үржүүлэх юм.

Улмаар Монголын хэрэглэгчдийн дунд гарал үүсэл тодорхой, өөрийн үйлдвэрт бэлтгэсэн тэжээлээр хооллосон, чанарын өндөр түвшний лабораторид бэлтгэгдсэн тахианы махыг нийлүүлснээр хэрэглэгчдийн хүсэл сонирхолд нийцсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх юм.



Хөрөнгийн зах зээлээс олон нийтээр татан төвлөрүүлсэн хөрөнгөөр тахиа үржүүлэх байр, Jansen Bromaxx Broiler компанийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулан үйл ажиллагаагаа эхлүүлэх юм. Үйлдвэрт Cobb-500 үүлдрийн бага тэжээлээр их хэмжээний мах гаргах чадвартай, чанар сайтай тахиаг үржүүлэх бөгөөд үр тогтсон өндөгийг ОХУ-с худалдан авахаар төлөвлөн ажиллаж байна.


Сангасны бордооны аж ахуй

Өндөглөгч тахианы дайвар бүтээгдэхүүн сангас нь биологийн бордоо болохуйц шим тэжээл бүхий органик бүтээгдэхүүн юм. Өнөөдрийн байдлаар компанийн эзэмшиж буй 250,000 гаруй шувуу нь жилдээ 5,750 тонн сангасыг үйлдвэрлэж байгааг компани хаягдал байдлаар өөрийн хашаандаа буулган, тухайн орчмын айл, аж ахуйн нэгжүүдэд үнэгүй өгч байна.

Уг сангасыг боловсруулан, хөдөө аж ахуйн компаниудад борлуулах нь эдийн засгийн хувьд хамгийн оновчтой шийдэл төдийгүй, эрүүл ахуйн хувьд тухайн ойр орчмыг цэвэр байлгах чухал шийдэл юм.

Дэлхийн технологийн компаниуд дундаас сангасны бордооны үйлдвэрлэлээр мэргэшсэн Кошин (Kohshin - www.kohshin-s.jp) компаниас тоног төхөөрөмжөө худалдан авч, өөрийн эзэмшлийн газарт шинээр үйлдвэр байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.





Үнэт цаасны танилцуулга

Тэжээлийн үйлдвэрийн өргөтгөл, царгас тариалалт

Үнэт цаас гаргагч нь өөрийн эзэмшлийн Агро Фийд тэжээлийн үйлдвэртээ 10 гаруй нэр төрлийн малын болон тахиа, шувууны тэжээл үйлдвэрлэж байна. Хоногт 100 тонн тэжээл үйлдвэрлэх хүчин чадал бүхий уг үйлдвэрийн гол түүхий эд нь улаанбуудай, хивэг, рапс, рапсын тос зэрэг дотоодод үйлдвэрлэж болохуйц бүтээгдэхүүнүүд байгаа бол зарим нэр төрлийн орцууд болох эрдэнэшиш, шар буурцаг, премикс зэрэг нь импортоор орж ирж байна. Тиймээс энэ нь малын тэжээлийн өртөг нэмэгдэх үндсэн хүчин зүйл болж байна.

Компани Агрофийд үйлдвэртээ түүхий эд бэлдэх, цаашлаад хямд үнэтэй боловч уургийн агууламжаар баялаг тэжээл үйлдвэрлэх зорилгоор Увс аймгийн Баруунтуруун суманд байрлах усалгаатай газар тариалан бүхий Усжуулах ХК-ны нийт хувьцааны 80.6 хувийг худалдан аваад байна.

Уг тариалангийн бүс нутагт царгас болон малын ногоон тэжээлийг тариалахаас гадна, одоо үйл ажиллагаа явуулж буй гурилийн үйлдвэрийн үйл ажиллагааг өргөтгөж баруун бүс нутгийн ард иргэдийг гурилаар хангах ажлыг хэрэгжүүлж байна.



Компанийн бизнесийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн хүчин зүйлсийн талаар

Андеррайтерийн хувьд үнэт цаас гаргагч компанийн бидэнд ирүүлсэн мэдээлэл үнэн, цаашид хэрэгжих төсөл хөтөлбөрүүд төлөвлөсний дагуу хэрэгжих боломжтой бөгөөд компанийн шинэ үйлдвэрийн төсөл амжилттай санхүүжилтаа татаж хэрэгжиж дуусна гэсэн таамаглалд үндэслэн энэхүү проспектусыг боловсруулсан боловч энэхүү төсөөлөл нь ирээдүйд тухайн цаг үеийн байдлын улмаас өөрчлөгдөх боломжтой юм. Ингэсэн тохиолдолд компанийн ирээдүйн орлогын төсөөлөлд өөрчлөлт орж хувьцааны үнэ өөрчлөгдөх боломжтой. Ялангуяа өнөөгийн хурдацтай хөгжил, эдийн засгийн өндөр хөрвөх чадвартай цаг үед бизнесийн орчин өөрчлөгдөх, улс орны эдийн засгийн байдал солигдох зэрэг олон төрлийн гадаад эрсдэл бизнес эрхлэгчдэд тулгарч байдаг. Жишээлбэл Монгол Улсын зээлжих зэрэглэл 2016 оны 11 сард олон улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээний Мүүдис болон Фитч хоёр В3, В үнэлгээнээс Саа1, В- болгон бууруулсан нь дотоодын компаниудын зээлжих зэрэглэл, зээлийн хүүгийн түвшинд шууд нөлөөлж байсан. Тиймээс компанид учирч болох эрсдэлүүдийг нарийн судалж, аль болох сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах үндсэн алхам болох бөгөөд компанийн үнэт цаасанд хөрөнгө оруулагч нь энэхүү эрсдэлийг ойлгосны үндсэн дээр хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй гэж үзэж байна.

Компанид учирч болохуйц эрсдэлийг ангилан харвал:

Компанийн удирдлага, засаглалаас шалтгаалах эрсдэл

Компанийн гүйцэтгэх удирдлагын бодлого шийдвэр, менежментийн хэв маяг нь бизнесийн ашиг, маркетинг, хүний нөөцийн бодлого, нийгмийн хариуцлага гэх мэт компанийн бүх үйл ажиллагаа, нэр хүндийг тодорхойлж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх нөлөөтэй. Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчид болон гүйцэтгэх удирдлагын хооронд эрх ашиг, сонирхлын зөрчил үүсэх асуудал ч байдаг. Тиймээс, гүйцэтгэх удирдлагын туршлагын байдал, багийн буруу бодлого, алдаатай шийдвэрээс шалтгаалан компанийн үйл ажиллагаа доголдох, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөх эрсдэл байхыг үгүйсгэхгүй. Түүнчлэн, компанийн хувьцааны хяналтын багц эзэмшигчид нэгж хувьцаанд ногдох саналын эрхийн дагуу аливаа бодлого шийдвэр гаргахад давамгайлж, жижиг хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөх эрсдэл байдаг. Компанийн сайн засаглал, соёлыг зөв бүрдүүлэх, хувьцааны төвлөрлийг бууруулах, хууль журмын дагуу ажиллахыг шаардах, хяналт тавихад хувьцаа эзэмшигчид идэвхтэй оролцож, эрхээ хэрэгжүүлэх хэрэгтэй байдаг. Мөн гүйцэтгэх удирдлага, тэр дундаа шинээр байгуулагдах Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэг, ажлын зохион байгуулалтыг компанийн дүрэм, журамд тодорхой тусгаж, гишүүдийг Компанийн засаглалын сургалтанд суулгах зэргээр компанийн сайн засаглалыг нэвтрүүлэх нь энэ төрлийн эрсдэлийг зөв удирдахад чухал ач холбогдолтой.





Үнэт цаасны танилцуулга



Хууль эрх зүйн эрсдэл ба Хорио цээрийн эрсдэл

Тахианы аж ахуй нь эрчимжүүлсэн аж ахуйн нэг тул Монгол Улсын Хүнс Хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны 2017-2030 оны бодлогуудад ихээр дэмжигдэж буй салбар юм. Тэр ч утгаараа фермерийн аж ахуйг хориглосон хууль, тогтоомж гарах магадлал тун бага. Харин дэлхий дахин болон бүс нутгийг дамжсан халдварт өвчин гарч, хорио цээр тогтоох нөхцөл бүрдэх тохиолдолд аж ахуйд эрсдэл үүсэх боломжтой.

Нэгэнт халдвар өвчин гарч тахианы сүрэг гол халдварт өвчинд нэрвэгдэн устгалд орсон тохиолдолд "Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль"-н 15.1.4-т Өвчтэй малыг зайлшгүй шаардлагаар устгасан тохиолдолд тухайн үеийн улсын дундаж үнийн 90 хувийг нөхөн төлөх, устгахад шаардагдах хөрөнгө /Устгагдсан малын нөхөн төлбөрийг хорио цээр, хязгаарлалтын дэглэм цуцлагдсанаас хойш 30 хоногийн дотор олгоно/ гэж заасны дагуу нөхөн төлбөрийг компанид олгох юм. Энэ нь халдварт өвчнөөс үүдсэн хор хохирлыг бууруулах маш том түлхэц, хүчин зүйл болж байна.

Гадаад валютын эрсдэл

Үнэт цаас гаргагч нь гадаадаас тоног төхөөрөмж, үр хөврөлтэй өндөг, зарим тэжээл баяжуулах гол эрдэс бодисоо худалдан авдаг. Тиймээс гадаад валютын огцом савлалт нь үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг. Харин Монгол улс ОУВС-н Өргөтгөсөн Санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсан, гадаад худалдааны тэнцэл сайн байгаа зэрэг нь төгрөгийг гадаад валютын эсрэг сулрах нөхцлийг хааж өгч байна.

Мөн компани олон жил харилцсан гадны түнш байгууллагууд ихтэй байдаг нь гадаад валютаас үүсэх эрсдэлийг багасгах, төлбөрийн уян хатан нөхцлийг бүрдүүлэх боломжийг бий болгодог. Хэдийгээр дээрх арга хэмжээ нь валютын ханшийн өөрчлөлтийн эрсдэлийг бууруулж буй боловч компани гадаадаас үр тогтсон өндөг, тэжээлийн зарим түүхий эд, сав баглаа боодлын тодорхой хэсэг, тоног төхөөрөмжүүдийг оруулж ирдэг тул ханшийн савлагааны эрсдэл бий юм.

Өрсөлдөгчийн эрсдэл



Тахианы аж ахуйн өрсөлдөгчийн эрсдэл харьцангуй багатай салбар юм. Учир нь их хэмжээний тахиатай аж ахуй эрхлэхэд маш их хөрөнгө, мэдлэг, цаг хугацаа шаарддаг салбар тул шинэ оролцогчид орж ирэх нөхцөл харьцангуй бага байна. Ялангуяа НВЦ, Түмэншувуут гэсэн 2 том үйлдвэрүүд дотоодын зах зээлийн 60 орчим хувийг хангаж буй тохиолдолд дотоодын үйлдвэрлэгчид хүч түрэн гарч ирэх боломж багатай.

Харин импортын өндөгний өрсөлдөгчид зах зээлд нийлүүлэлтийн эрсдэл үүсгэх боломжтой байдаг. Хэдийгээр Монголын Засгийн газраас өндөгөнд ногдуулах гаалийн албан татварыг 15% болгон нэмэгдүүлсэн боловч ОХУ-н хямд өртөгтэй өндөгнүүд зах зээлд ихээр нийлүүлэгдэх явдал багасахгүй байна. Энэ нь дотоодын үйлдвэрлэгчидэд хүндрэлийг авчирдаг боловч эрүүл мэндийн хувьд баталгаатай, шинэ, дотоодод ургасан ургамал ашигласан тэжээлээр тэжээгдсэн шувууны өндөгний эрэлт цаашид хэрэглэгчдийн боловсрол нэмэгдэх, эрүүл мэнддээ хандах хандлага нь өсөхийн хэрээр эрэлт нь нэмэгдэх юм.

Мөн Үнэт цаас гаргагч нь хувьцаагаа олон нийтэд арилжсанаар хэрэглэгчдийн дунд роялти үүсгэх боломжтой бөгөөд тухайн хэрэглэгчид бүгд компанийн хувь эзэмшигчид болсноор компанийн борлуулалт нэмэгдэх боломжийг бий болгох юм.

Нэр хүндийн эрсдэл

Өргөн хэрэглээний барааны зах зээлд бүтээгдэхүүний нэр хүндтэй холбоотой эрсдэл маш өндөр жинг эзэлдэг. Зах зээл дэх бүтээгдэхүүний тоо хэмжээ их байх хэрээр өрсөлдөгчдийн хэрэглэх бүтээгдэхүүнээ солих, өөр брендийн бүтээгдэхүүн хэрэглэх нөхцлийг бүрдүүлж





Үнэт цаасны танилцуулга



2019.12.14

байдаг. Тиймээс компани өөрийн бүтээгдэхүүний чанарт үргэлж анхаарал хандуулан, брендийн үнэ цэнийг хангаж ажиллах шаардлагыг бий болгож байдаг.

Зах зээл дээр бүтээгдэхүүний нэр хүндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс бүтээгдэхүүний чанар муу, сав баглаа боодлын чанаргүй байдал зэрэг нөлөөлдөг. Харин компаниас хэрэглэгчдийн санал хүсэлт, гомдлыг өөрийн цахим хуудас, олон нийттэй харилцдаг фэйсбүүк хуудас зэргээр хүлээн авч, бууруулах тал дээр ажилладаг нь бүтээгдэхүүний нэр хүндийг хадгалахад чухал нөлөөг эзэлж байна.

Тиймээс үйлдвэртээ аль болох автоматжуулсан тоног төхөөрөмжүүдийг суурилуулах, хүний оролцоог бууруулах нь бүтээгдэхүүний жигд, чанарыг тогтвортой байдлыг хангах бөгөөд өндөг боловсруулах төхөөрөмж нь муудсан өндөгийг ялгаж чаддагаараа онцлогтой тул хэрэглэгчдэд чанарын өндөр түвшний бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөх юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэл

Үнэт цаас гаргагчийн ихэнх ажилчид нь шувуу болон шувууны тэжээлтэй шууд харьцдаг буюу тухайн хүмүүсд малын гаралтай өвчин халдварлах боломжтой орчинд ажилладаг. Ажилчдыг чадавхижуулах, мэдлэг мэдээллээр байнга хангах нь тухайн хүмүүсийг аливаа төрлийн эрсдлээс хамгаалах хамгийн том хүчин зүйл болдог. Тиймээс компани ажилчиддаа зориулсан сургалтуудыг тогтмол зохион байгуулж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын ажилчидтай хамтран Мал аж ахуй, хорио цээрийн алхамуудыг дагаж мөрдөн эрүүл мэнд, эрүүл орчныг хангах сургалтуудыг зохион байгуулдаг нь ажилчдыг хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлээс сэргийлж өгдөг.

Үнэт цаасны зах зээлийн эрсдэл

Үнэт цаасны зах зээлд оролцогчдийн итгэл үнэмшил буурч дотоодын үнэт цаасны зах зээлийн эрэлт буурснаар үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадвар саарах, арилцааны идэвх буурах, хувьцаа үнэгүйдэх зэрэг зах зээлд эрсдэл үүсдэг. Энэ нь үнэт цаас гаргагчийн хувьцаанд болон гаргахаар төлөвлөж буй өрийн бичигт сөргөөр нөлөөлж ханшийн хэлбээлийг нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгодог.

Ялангуяа сүүлийн үед хөрөнгийн зах зээлд бий болсон үзэгдлээс ажиглахад хөрөнгө оруулагчид компанийн IPO-д оролцохдоо тухайн компанийн санхүүгийн чадавхиас илүүтэйгээр спекуляц хийх зорилгоор хувьцааг худалдан авч байгаа нь нийт хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлж болохуйц үзэгдэл болж байна.

Үнэт цаасны зах зээлийн эрэлттэй холбоотой үүсч болох эрсдэл

Монголын хөрөнгийн зах зээл дээр 2005 оноос хойш нийт 31 компани хөрөнгийн зах зээлээс хувьцаагаар хөрөнгө татан төвлөрүүлсэн бөгөөд нийт 190 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татсан байна. Үүнээс сүүлийн 1 жилд хийгдсэн "Сүү" бонд, "Ай Түүлс" ХК, "Лэнд.мн ББСБ" ХК, "Монголбазальт"-н хувьцааны арилжаа амжилттай явагдсан нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулагчдын идэвх сонирхлыг нэмэгдүүлсэн гэж үзэж байна. Гэсэн хэдий ч нийт иргэдийн санхүүгийн боловсрол, хуримтлалын түвшин бусад өндөр хөгжилтэй улсуудтай харьцуулахад бага, зах зээлд идэвхитэй тоглогч оролцогчдын тоо харьцангуй цөөн хэвээр байгаа тул үнэт цаасны хөрвөх чадвар сул байх эрсдлийг дагуулж байна.





Үнэт цаасны танилцуулга



Дүгнэлт

Голонт Капитал ҮЦК нь андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийсэн дээрх болон бусад судалгаа шинжилгээ, тооцоо, мөн үнэт цаас гаргахтай холбогдуулан бусад мэргэжлийн байгууллагуудын хийсэн тайлан дүгнэлтүүдэд үндэслэн "Түмэншувуут" ХХК-ийн хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалах боломжтой гэж үзсэн бөгөөд энэхүү хувьцааны анхдагч зах зээлийн нэг бүрийн үнийг 200 төгрөгөөр, нийт 50,000,000 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгон 10,000,000,000 төгрөгийг татан төвлөрүүлэх боломжтой гэж үзэн энэхүү дүгнэлтийг гаргалаа.

Харин энэхүү дүгнэлт нь дээрх тооцрол болон компанийн ирээдүйн төсөөллийн биелэлтийн баталгаа болохгүй бөгөөд компанийн хөрөнгө оруулагчид нь компанийн үйл ажиллагаа болон хувьцааны үнэлгээнд нөлөөлж болох гадаад дотоод эрсдэлийг ойлгосны үндсэн дээр өөрийн шийдвэрээр хөрөнгө оруулахыг зөвлөж байна.

Дүгнэлтийг гаргасан:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЕНЕЖЕР

В. ОРГИЛ-ЭРДЭНЭ

Хянаж баталгаажуулсан:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э. АМАРБАЯСГАЛАН





Үнэт цаасны танилцуулга



5.2 Аудитын тайлан

Санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан

“Түмэн шувуут” ХХК

2017 оны 12 дугаар сарын 31





Үнэт цаасны танилцуулга



Агуулга

Хараат бус аудиторын дүгнэлт	1
Санхүүгийн байдлын тайлан	4
Орлогын дэлгэрэнгүй тайлан	6
Өмчийн өөрчлөлтийн тайлан	7
Мөнгөн гүйлгээний тайлан	8
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	9





Үнэт цаасны танилцуулга



“УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ” ХХК

Хараат бус аудит, баталгаажуулалт, татварын болон зөвлөх үйлчилгээний
Грант Торнтон Интернашнлын Монгол улс дахь гишүүн

Хараат бус аудиторын дүгнэлт

“Улаанбаатар аудит
корпораци” ХХК
Далайн талуур, ЮНЕСКО-гийн
тулалж, Сүхбаатар дүүрэг-1,
Улаанбаатар 14230,
Монгол улс
Т + 976 70 110744
Ф + 976 70 110799

Ulaanbaatar audit
corporation LLC
Dala Tower, UNESCO street,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230, Mongolia
T + 976 70 110744
F + 976 70 110799

“Түмэн шувуут” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид “Түмэн шувуут” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нятлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн Санхүүгийн тайлан (цаашид “Санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, “Түмэн шувуут” ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхав Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Нятлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нятлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нятлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болохад хангалттай, тохиромжтой гэж илтгэж байна.

Бусад асуудал

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь Компанийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин Санхүүгийн тайлан болох манай аудиторын тайланг багтаажгүй.


Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.



www.grantthornton.mn



Үнэт цаасны танилцуулга



Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь Санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь Санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс Санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ Санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэргэлчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг тооцогддог.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас Санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үл үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхуйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа Санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүртэж болно.





Үнэт цаасны танилцуулга



- Тодруулгыг багтаагаад Санхүүгийн тайлангийн ерөнхий тогилуулга, бүтэц, агуулгыг үнэлж Санхүүгийн тайланд үнэн зөв тогилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн асаацыг тодорхойлдог.

Энд бусад асуудлуудын дундаас аудитын ажилын хангалттай хэвээр үлрэх, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аргаар мэргэжлийн дотоодлыг багтаагаад аудитын өлөрсөн төлөвөөн асуудлуудыг зөвхөн эрх мэдэл бусад этгөөдүүдтэй хариуцдаг.

Энэхүү Хяналт бус аудитын тайланг гаргахад оролцсон гэрээт ажилынartner нь Б.Осоргарав болно.


Аудитын тайлангийн хариулт

Энэхүү тайланг "Компанийн тухай" хуулийн 94-р зүйлд заасны дагуу эвээн компанийн хувицаа ажиллагаанд зориулсан ба бусад оор этгөөдэд зориулаагүй болно. Энд энэхүү тайлангийн хураанд бусад аргаар нэгэн гурвадагч талын өмнө хариуцлага хувицаагүй.

Хүндэтгэсэн

Б. ОСОРГАРАВ
 УДИРДАХ ПАРТНЕР
 Монгол улс, Улаанбаатар хот
 2018 оны 5 дугаар сарын 21

www.graithornton.mn






Үнэт цаасны танилцуулга




Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Хөрөнгө			
<i>Эргэлтийн хөрөнгө</i>			
Мөнгөн хөрөнгө	4	1,583,994	180,925
Дансны авлага	5	980,306	692,641
Бусад авлага		1,080	-
Бараа материал	6	1,243,310	983,471
Урьдчилж төсөн зардал	7	513,575	517,311
Эргэлтийн биологийн хөрөнгө	10	717,485	530,540
		<u>5,039,750</u>	<u>2,904,888</u>
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>			
Үндсэн хөрөнгө	8	8,806,622	7,804,869
Биет бус хөрөнгө	9	15,524	13,303
Эргэлтийн бус биологийн хөрөнгө	10	442,955	699,702
		<u>9,265,101</u>	<u>8,517,674</u>
Нийт хөрөнгө		<u><u>14,304,851</u></u>	<u><u>11,422,562</u></u>





Үнэт цаасны танилцуулга



Санхүү байдлын тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Өмч ба өр төлбөр			
<i>Эрэгтийн өр төлбөр</i>			
Дансны өглөг	11	73,081	205,279
Урьдчилж орсон орлого		-	805
Албан татварын өглөг		203,787	231,590
Богино хугацаат зээл	13	675,000	-
Урт хугацаат зээлийн богино хугацаанд ногдох хэсэг	13	-	1,561,887
Бусад богино хугацаат өр төлбөр	12	1,088,888	818,885
		<u>2,021,737</u>	<u>2,818,228</u>
<i>Эрэгтийн бус өр төлбөр</i>			
Урт хугацаат зээл	13	3,000,000	635,068
		<u>3,000,000</u>	<u>635,068</u>
<i>Капитал ба нөөц</i>			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	14	3,000,000	2,847,850
Хуримтлагдсан ашиг		6,283,114	5,121,418
		<u>9,283,114</u>	<u>7,969,268</u>
Нийт өмч ба өр төлбөр		<u>14,304,851</u>	<u>11,422,562</u>

Уг санхүүгийн тайланг 2018 оны 5 дугаар сарын 21-д батлав:

Ж. Болд
Захирал


Н. Должинсүрэн
Ерөнхий нягтлан бодогч

Энэхүү санхүү байдлын тайланг 9-өөс 26 дугаар хуудсан дахь тодруулуудын хамт унших бөгөөд тодруулууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.





Үнэт цаасны танилцуулга




Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Борлуулалтын орлого	15	13,229,757	10,310,223
Борлуулалтын өртөг	16	(10,754,152)	(8,728,282)
Нийт ашиг		2,475,605	1,581,941
Түрээсийн орлого		10,276	11,163
Түгээлт ба маркетингийн зардал	17	(105,522)	(76,285)
Ерөнхий ба удирдлагын зардал	18	(1,133,347)	(932,568)
Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бодит үнэ цэнийн олз	19	325,235	331,494
Үндсэн үйл ажиллагааны үр дүн		1,572,247	915,745
Санхүүгийн орлого / (зардал)	20	(13,072)	13,970
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	21	20	4,659
Үйл ажиллагааны бус бусад орлого		5,227	20
Үйл ажиллагааны бус бусад зардал		(27,225)	(8,445)
Орлогын татварын өмнөх ашиг		1,537,197	925,949
Орлогын татварын зардал	22	(156,758)	(93,237)
Тайлант жилийн цэвэр ашиг		1,380,439	832,712
Бусад дэлгэрэнгүй орлого			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ			
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		1,380,439	832,712

Энэхүү орлогын дэлгэрэнгүй тайланг 9-өөс 26 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.



Түмэн Шувуут ХХК
Санхүүгийн тайлан
2017 оны 12 сарын 31




Үнэт цаасны танилцуулга



Өмчийн өөрчлөлтийн тайлан


Мянган төгрөгөөр	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт
2016.01.01-ний байдлаар	2,847,850	4,330,342	7,178,192
Тайлант жилийн ашиг	-	832,712	832,712
Ногдол ашиг	-	(41,636)	(41,636)
2016.12.31-ний байдлаар	2,847,850	5,121,418	7,969,268
Тайлант жилийн ашиг	-	1,380,439	1,380,439
Ногдол ашиг	-	(88,593)	(88,593)
Өмчид гарсан өөрчлөлт	152,150	(152,150)	-
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
2017.12.31-ний байдлаар	3,000,000	6,283,114	9,283,114

Энэхүү өмчийн өөрчлөлтийн тайланг 9-өөс 25 дугаар хуудсан дахь тодруулгуудын хамт уншиж бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.






Үнэт цаасны танилцуулга




Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
<i>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</i>		
Бараа борлуулсан орлого	14,370,801	11,540,322
Бусад мөнгөн орлого	1,594	246
Ажиллагсаддад олгосон мөнгө	(1,254,682)	(940,967)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	(334,585)	(262,087)
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	(10,357,019)	(8,824,391)
Ашиглалтын зардал	(25,407)	(18,688)
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(103,344)	(70,155)
Хүүний төлбөрт төлсөн мөнгө	(19,015)	(11,967)
Татварын байгууллагад төлсөн мөнгө	(999,157)	(476,600)
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	(1,716)	(1,680)
Бусад зарлага	(102,083)	(75,274)
<i>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</i>	<u>1,175,387</u>	<u>858,759</u>
<i>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</i>		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хүлээн авсан хүүний орлого	11,024	2,256
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(79,291)	(20,807)
<i>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</i>	<u>(68,267)</u>	<u>(18,551)</u>
<i>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</i>		
Зээл авсан	4,612,000	2,121,835
Валютын ханшйн тэгшитгэлийн ашиг	56	5,560
Зээл төлсөн	(4,278,616)	(3,204,560)
Төлсөн ногдол ашиг	(37,473)	(14,744)
Валютын ханшйн тэгшитгэлийн алдагдал	(18)	(787)
	<u>295,949</u>	<u>(1,092,698)</u>
<i>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн цэвэр гүйлгээний дүн</i>		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,403,069	(252,488)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	180,925	433,413
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>1,583,994</u>	<u>180,925</u>

Энэхүү мөнгөн гүйлгээний тайланг 9-өөс 25 дугаар хуудсан дахь тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлдэг.





Үнэт цаасны танилцуулга



Санхүүгийн тайлангийн тодруулгууд

1 Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл

"Түмэн шувуут" ХХК (Компани) нь 2004 онд өндөглогч тахианы аж ахуй эрхлэх үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Тахианы аж ахуйг олон улсын стандартад хүргэж, сайн чанартай, шинэхэн өндгөөр хэрэглэгчдийн хэрэгцээг ханган ажиллаж байна. Одоогийн байдлаар компани нь тахианы аж ахуйг цогцоор нь хөгжүүлсэн үндэсний тэргүүлэгч үйлдвэрлэгчийн нэг компани болсон.

Компани нь дунджаар 144 ажилтан, албан хаагчидтай (2016: 117) байна.

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Монгол улсын "Улсын бүртгэлийн алба"-нд бүртгүүлж, 2844753 тост регистр бүхий 9011127143 тост улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байна. Компанийн үүсгэн байгуулагчийн 2004 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 001 тост тогтоолоор дүрмээ баталсан.

Компанийн байршил: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 13-р хороо, Туул тосгон, өөрийн байр;

Утас: 976-7000-5225, 976-8800-0373

2 Санхүүгийн тайлан бэлтгэх суурь

2.1 Үндсэн зарчим

Эдгээр Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт ("СТОУС")-ын дагуу бэлтгэв.

2.2 Хэмжилтийн суурь

Эдгээр санхүүгийн тайланг бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн дахин үнэлсэн дүнгээр илэрхийлсэн тодорхой үндсэн хөрөнгө болон борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр илэрхийлсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээс бусдаар түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

2.3 Үйл ажиллагааны ба толилуулгын валют

Монгол улсын мөнгөн тэмдэгт Төгрөг нь Компанийн үндсэн үйл ажиллагаа болон ажил гүйлгээний эдийн засгийн бодит байдлыг хамгийн тохиромжтой илэрхийлж байгаа учраас төгрөг нь уг Компанийн үйл ажиллагааны валют юм.

Санхүүгийн тайлангуудын хэрэглэгчдэд хамгийн тохиромжтой гэж удирдлага үзэж байгаа учраас эдгээр Санхүүгийн тайлангуудыг Монгол төгрөгөөр толилуулна. Монгол төгрөгөөр илэрхийлсэн санхүүгийн бүх мэдээлэл мянган төгрөгөөр бүхэлтгэн илэрхийлэгдсэн.

3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

3.1 Гадаад валют

Гэдвэд валютаарх ажил гүйлгээ

Санхүүгийн тайланг бэлтгэхэд үйл ажиллагааны валютаас бусад валютаарх ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдөр Монгол банкнаас зарласан ханшаар бүртгэнэ. Тайлант хугацаа бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг Монгол банкнаас тайлагналын өдрөөр зарласан ханшийг ашиглан дахин хөрвүүлэх бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 31-нд төгрөгийн 1 ам доллартай харьцах ханш 2,427.13 төгрөгтэй (2016 оны 12 дугаар сарын 31-нд: 1 ам доллар 2,489.53 төгрөг) байв.



Түмэн шувуут ХХК
Бүртгэлийн танилцуулга
2017 оны 12 сарын 31



Үнэт цаасны танилцуулга



Мөнгөн бус зүйлсийг дахин хөрвүүлэхгүй бөгөөд бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар дахин хөрвүүлсэн гадаад валютаар илэрхийлэгдсэн бодит үнэ цэнээр бүртгэсэн мөнгөн бус зүйлсээс бусад мөнгөн бус зүйлсийг ажил түйлгээ гарсан өдрийн валютын ханшиг ашиглан хөрвүүлсэн түүхэн өртгөөр хэмжинэ.

3.2 Үндсэн хөрөнгө

Үйлдвэрлэл, нийлүүлэлтийн зорилгоор ашиглаж буй барилга, байгууламжуудыг санхүүгийн тайланд түүхэн өртгөөр нь тайлагнана.

Бусад үндсэн хөрөнгийн зүйлс өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр илэрхийлэгдэнэ. Өртөг нь импортын татвар, худалдан авалтын буцаалтгүй татвар болон бусад шууд хамааралтай зардлыг багтаасан худалдан авалтын үнээс бүрдэнэ. Үндсэн хөрөнгийн зүйлс өөр өөр ашиглах хугацаатай томоохон хэсгүүдээс бүрдэж байвал тэдгээрийг үндсэн хөрөнгийн тусдаа зүйлсээр бүртгэнэ.

Өртөгт шууд хамааралтай зардал, талбайн бэлтгэл, суурилуулалт угсралтын зардал, мэргэжлийн төлбөр багтах ба бэлтгэл шаардагдах хөрөнгийн хувьд эзэлийн өртгийг Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу капиталжуулна.

Үндсэн хөрөнгийн данснаас хассан, ашиглалтаас гаргаснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулалт болон дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Тусад нь бүртгэсэн үндсэн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгийг солих зардлыг уг данснаас хассан бүрэлдэхүүн хэсгийн дансны үнээр капиталжуулна. Бусад дараа үеийн зардал ираадуйд эдийн засгийн үр өгөөж өгөхөөр бол капиталжуулна. Засвар үйлчилгээ гэх мэт бусад бүх зардлыг үүссэн дүнгээр нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Элэгдлийг хөрөнгө тус бүрийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгана. Хөрөнгийг ашиглах боломжтой болсон үед элэгдүүлж эхэлнэ. Хөрөнгийн ашиглах хугацааг ерөнхийдөө дараах байдлаар тогтооно.

Байлын барилга	- 40 жил
Автомашин	- 10 жил
Төвчилгэ, эд хөгжил	- 10 жил
Компьютер дагалдах хэрэгсэл	- 3 жил
Бусад	- 10 жил

3.3 Биет бус хөрөнгө

Компани нь худалдан авсан хязгаарлагдмал ашиглах хугацаатай биет бус хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан хорогдлыг хассан дүнгээр тайлагнана.

Хорогдлыг биет бус хөрөнгийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгана.

3.4 Бараа материал


Бараа материал бол бизнесийн хэвийн үйл ажиллагаанд эсвэл үйлдвэрийн процесс юм уу үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах материал болон хангамжийн хэлбэрээр худалдан борлуулах зорилготой хөрөнгө юм.

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжтой үнэ цэнийн аль багаар тайлагнана. Цэвэр боломжтой үнэ цэнийг бизнесийн хэвийн ажиллагааны үеийн бараа материалын борлуулах үнээс бараа материалыг иж бүрдэл болгох зардал ба борлуулах зардлыг хасч тооцно. Бараа материалын өртөг жинлэсэн дунджийн зарчимд суурилдаг ба бараа материалын худалдан авалтын зардал болон одоогийн байршил, нөхцөлд авчрахтай холбоотой гарсан бүх зардал багтана.





Үнэт цаасны танилцуулга



3.5 Биологийн хөрөнгө

Ангилал

Компани нь биологийн хөрөнгөө эргэлтийн болон эргэлтийн бус биологийн хөрөнгө гэж ангилдаг.

"Эргэлтийн биологийн хөрөнгө"-ийн ангилалд үр шимийг нь ирээдүйд хүртэхээр тэжээж буй дэгдээхийнүүд байна.

"Эргэлтийн бус биологийн хөрөнгө"-ийн ангилалд өндөглөгч тахианууд багтдаг ба үр шимээ өгдөг боловч өөрөө хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болдоггүй хөрөнгө юм.

Нэг жилээс ихгүй хугацаанд үйлдвэрлэлийн процессод ашиглагддаг өндөглөх чиглэлийн үүлдрийн тахиаг өндөглөгч болсноос хойш нас дэвшүүлдэггүй (НББОУС 41.51). Өндөглөгч тахиа нь дунджаар 1 жилийн турш эрчимтэй үр ашгаа өгдөг ба энэ хугацаа өнгөрөхөд биологийн хөрөнгийн насжилт гүйцсэн гэж үздэг.

Харин эргэлтийн биологийн хөрөнгө буюу дэгдээхий нь дунджаар 6 сар болоход өндөглөгч тахиа болох ба эргэлтийн бус биологийн хөрөнгөнд шилжүүлэн бүртгэдэг.

Хэмжилт

Монгол улсын Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 411 дугаар тушаалаар батлагдсан "Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт"-ын 6.1.1.6 заалт болон НББОУС 41.12 дугаар заалтыг үндэслэн биологийн хөрөнгөө өртгийн загварын дагуу хэмжих бүртгэдэг. Өндөглөх чиглэлийн үүлдрийн тахианууд зах зээл дээр идэвхтэй борлогддоггүй тул зах зээлийн бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжих боломжгүй байдаг. Тиймээс бодит үнэ цэнийн тооцооллын аргыг хэрэглэх нь тус компанийн үйл ажиллагааны онцлогт тохиромжгүй гэж компанийн удирдлагууд үздэг.

Дараа үеийн бүртгэл

Биологийн хөрөнгөөр анх хүлээн зөвшөөрснөөс хойш өндөглөгч тахиагай холбогдон гардаг тэжээл, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн холбогдох зардлуудыг бүгдийг нь компанийн гол хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болох өндөгний өртөлт шингээдэг ба үндсэн сүргийн өртөлт шингээдэггүй. Биологийн хөрөнгийг 1 жил элэгдүүлдэг ба элэгдлийн зардлыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өртөлт шингээдэг.

Биологийн хувьсал

Биологийн хувьсал гэж биологийн хөрөнгөнд тооны ба чанарын өөрчлөлт гарахад нөлөөлдөг өсөлт, хөгшрөлт, үйлдвэрлэл болон нөхөн үржлийн үйл явц буюу түүнд гарч буй жам ёсны өөрчлөлтийг хэлдэг. Үүнд тахианы өсөлтийг даган өндөгний гарц өсөх болон насжилтын улмаас өндөгний гарц буурах зэрэг орно.

3.6 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн


Компани нь өндөгний чиглэлийн тахианы фермийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг тул компанийн биологийн хөрөнгөөс хүлээн авдаг хөдөө аж ахуйн үндсэн бүтээгдэхүүн нь өндөг байна.

Өндөглөгч тахиаг нас дэвшүүлдэггүй, түүхэн өртгийн загвараар бүртгэдэг тул өндөглөгч тахиагай холбогдон гардаг тэжээл, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн холбогдох зардлуудыг бүгдийг нь компанийн гол үндсэн бүтээгдэхүүн болох өндөгний өртөлт шингээдэг.

Өндөг хүлээн авалтын үед борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр өндөгний өртгийг хэмждэг. [НББОУС 41.13]

Борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг анхлан хүлээн зөвшөөрөх үед үүсэх элз ба гэрзэг тухайн үеийн ашиг ба элдэгдлээр хүлээн зөвшөөрдөг. [НББОУС 41.28]

Түмэн Шувуут ХХК
Санхүүжилт хэлтэс
2010 оны 12 сарын 16



Үнэт цаасны танилцуулга



3.7 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зардал

Үйлдвэрлэлийн зардал нь шууд материал, шууд хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлаас бүрдэнэ.

Шууд материалын зардалд тэжээлийн зардал, үржлийн өндөгний өртөг ордог.

Шууд хөдөлмөрийн зардалд тахичин, техникч, лаборант, эмч, мэргэжилтнүүдийн үндсэн цалин, нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлууд ордог.

Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардалд хангамжийн зардал, цахилгаан, хөдөлмөр хамгаалал, эм тариа, шатахуун, засвар, фермийн барилга, тоног төхөөрөмж, автомашин гэх мэт үндсэн хөрөнгийн элэгдэл, даатгалын зардал, газрын төлбөр, нүүрсний зардал, нядалгааны зардал гэх мэт байна.

Өртөг тооцолт

Тайлант хугацааны үйлдвэрлэлийн зардлыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн буюу өндөг болон биологийн хөрөнгө буюу дэгдээхийний тоо хэмжээнд нь харьцуулан тооцож, шингээдэг. Харин үр шимээ өгч байгаа өндөглөгч тахиануудын хувьд биологийн хөрөнгийн ангилалд анх хүлээн зөвшөөрснөөс хойш дахин өртгийн хэмжилт хийхгүй.

3.8 Санхүүгийн хэрэглүүр

Хүлээн зөвшөөрөлт, анхдагч хэмжилт ба үл хүлээн зөвшөөрөлт

Компани нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний заалтуудын нэг хэсэг болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний урсгал дах гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгө ба бүх бодит эрсдэл, өгөөж шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөрийг барагдуулсан, чөлөөлсөн, хүчингүй болгосон эсвэл хугацаа дууссан үед нь үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн ангилал ба дараа үеийн хэмжилт

Дараа үеийн хэмжилтийн зорилгоор санхүүгийн хөрөнгө анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр дараах категорид хуваагдана.


- Зээл ба авлага
- Гэрээний хугацаа дуустал зээмших санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгүүд хэрэглүүрийн шинж чанар, зорилгоос шалтгаалан анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр өөр өөр категорид ордог. Санхүүгийн хэрэглүүрийн категори нь түүний хэмжилт, санхүүгийн хэрэглүүрийн үр дүнд бий болсон орлого, зарлагыг ашиг, алдагдлаар эсвэл шууд бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх эсэхэд чухал хамааралтай. Компанийн категорилсон санхүүгийн хөрөнгийн хураангуйг тодруулга 24.2-оос харна уу.

Компани нь ерөнхийдөө бүх санхүүгийн хөрөнгөө төлбөр тооцоо хийх өдрийн бүртгэлээр хүлээн зөвшөөрдөг. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэх талаарх үнэлгээг ядаж тайлант хугацааны эцэс бүрт хийнэ. Бусад зардалд толилуулсан дансны авлагын үнэ цэнийн бууралтаас бусад ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгөтэй холбоотой бүх орлого, зардлыг санхүүгийн зардал, санхүүгийн орлого эсвэл бусад санхүүгийн зүйлсэд толилуулна.

1. Зээл ба авлага

Зээл болон авлага нь идэвхтэй зөх зээл дээр арилжаа алагддаггүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй дериватив бус санхүүгийн хөрөнгө юм. Зээл, авлагад дансны ба бусад авлага, гар дээрх бэлэн мөнгө болон банкн дах мөнгө багтана.





Үнэт цаасны танилцуулга



Дансны ба бусад өвлөг

Эргэлтийн дансны авлагыг бодит үнэ цэнээр анхлан хүлээн зөвшөөрнө. Харин дараа үед хорогдсон өртгөөс үнэ цэнийн бууралтын нөөцийг хассан дүнгээр хэмжинэ. Дансны авлагын үнэ цэнийн бууралтын нөөцийг Компани нь уг авлагыг анхдагч нөхцөлийн дагуу бүтгийг цуглуулах боломжгүй болсон гэсэн бодит нотолгоотой болсон үед байгуулна. Зээлдэгчид учирсан санхүүгийн томоохон бэрхшээл, гэрээ үл биелүүлэх болон төлөлт удаашрах зэрэг нь уг Дансны авлагын үнэ цэнэ буурсныг илтгэнэ. Нөөцийн дүн нь хөрөнгийн дансны үнэ болон анхдагч үр ашгт хүүний төвшингөөр ди-скаунтчилсан ирээдүйд өрхөөр тооцолсон мөнгөн гүйлгээ хоорондын зөрүү юм.

Авлагын хасагдуулгын үлдэгдлийг тайлант хугацааны ашиг, алдагдалд тусгасан төлбөр эсвэл орлогыг бүртгэж тохируулна. Харилцагчийн дансны үлдэгдэлтэй холбоотой данснаас хассан аливаа дүнг өмнө нь байсан найдваргүй авлагын хасагдуулгаас хасна. Цуглуулах боломжгүй гэж үзсэн бүх дансны авлагыг данснаас хасна.

Бэлэн мөнгө ба банкин дах үлдэгдэл

Компанийн бэлэн мөнгө ба банкин дах үлдэгдэл нь гар дээрх бэлэн мөнгө, банкин дах дансад болон замд яваа бэлэн мөнгөөс бүрдэнэ.

ii. Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө

Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө нь тогтоосон эсвэл тодорхойлж болох төлбөртэй, тогтоосон дуусах хугацаатай дериватив бус санхүүгийн хөрөнгө бөгөөд арилжааны банкууд дах хадгаламж үүнд орно. Компанийн удирдлага хөрөнгө оруулалтыг хугацаа нь дуустал эзэмших зорилготой бол түүнийг хугацаа дуустал эзэмших хөрөнгө оруулалтаар ангилна.

Санхүүгийн өр төлбөрийн ангилал ба дараа үеийн хэмжилт

Компанийн санхүүгийн өр төлбөрт зээл ба зээллэг багтаасан дансны ба бусад өглөг орно. Компанийн санхүүгийн өр төлбөрийн категорилоон хураангуйг тодруулга 24.2-д харуулав.

i. Зээл ба зээллэг

Зээл ба зээллэгийг зээллэгтэй холбоотой гаргалтын зардлын цэвэр дүн буюу бодит үнэ цэнээр анхлан хүлээн зөвшөөрнө.

ii. Дансны ба бусад өглөг

Дансны ба бусад өглөгийг бодит үнэ цэнээр, дараа үед хорогдуулсан өртгөөр илэрхийлнэ.

3.9 Үнэ цэнийн бууралт

Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Ашиглах хугацаа нь тодорхойгүй хөрөнгө байхгүй бөгөөд жил бүр үнэ цэнийн бууралтын төст хийнэ. Биет бус хөрөнгийг ашиглах хугацаанд нь шулуун шугамын аргаар хорогдуулдаг. Харин хорогдуулах хөрөнгийн дансны үнэ нөхөгдөхөөргүй болсныг илтэх өөрчлөлт, нөхцөл байдал үүссэн үед үнэ цэнийн бууралт хийх эсэхийг авч үзнэ. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг хөрөнгийн нөхөгдөх дүнгээс давшан дансны үнийн дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Борлуулах үнэ болон ашиглалтын үнэ цэнийн аль их нь нөхөгдөх дүн байна. Холбогдох хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээр илэрхийлж, үнэ цэнийн бууралтын гарзыг дахин үнэлээний бууралтаар авч үзээгүй бол үнэ цэнийн бууралтын гарзыг даруй зардлаар хүлээн зөвшөөрнө.

3.10 Өмч


Хувьцаат капитал нь гаргасан хувьцааны нэрлэсэн үнийг илэрхийлнэ.

Хуримтлагдсан ашигт тайлант болон өмжөх хугацааны бүх ашиг багтана.


Ногдол ашгийг зарласан хугацаанд нь өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө.



TUMEN SHUVUUT HXK
2018 оны 12 сарын 14



Үнэт цаасны танилцуулга



УНДЭСНИЙ ҮЙЛДЭВЭРЛЭГЧ
ТҮМЭН ШУВУУТ ХХК

3.11 Орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь тайлант оны эцсээр хүчинтэй болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тухайн оны татвар ногдох орлогод төлөх татварын өглөг болон өмнөх онуудтай холбоотой татварын өглөгийн залруулга юм.

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дах хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдох ашгийн тооцооллод ашиглан холбогдох татварын суурь хоорондын түр зөрүүгээр хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын өр төлбөрийг ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүнд хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгийг ерөнхийдөө түр хасагдах зөрүүг ашиглаж болохуйц хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалтай байгаа үед бүх хасагдах түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө. Ийм хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг гүүдвилийн анхдагч хүлээн зөвшөөрөлт эсвэл ажил гүйлгээн дэх бусад хөрөнгө, өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт нь татвар ногдох орлого ба нягтлан бодох бүртгэлийн ашгийн аль алинд нөлөөлөхгүй байвал хүлээн зөвшөөрөхгүй.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацаа бүрийн эцэст эргэж харах ба хяналттай хэмжээний татвар ногдох орлогоор тухайн хөрөнгө бүхлээрээ эсвэл тодорхой хэсэг нь нөхөгдөх боломжтой болох үед бууруулна.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эсвэл тайлант оны эцсээр хүчин төгөлдөр болсон татварын хувь хэмжээ (болон татварын хууль)-нд үндэслэн тухайн өр төлбөрийг барагдуулах эсвэл хөрөнгийг хүлээн зөвшөөрөх тайлант онд мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хэмжигдэнэ. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн хэмжилт нь тайлант хугацааны эцэст Компани нь хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийг нөхөх буюу барагдуулахаар хүлээж байгаагаас үүсэх татварын үр дагаварт нөлөөлдөг.

3.12 Орлогын хүлээн зөвшөөрөлт

Орлогыг Компаниас үзүүлэхээр зөвшөөрсөн аливаа худалдааны хөнгөлөлт, урамшууллын дүнг харгалзаж үзэн хүлээж авсан эсвэл авахвар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ.

Орлого нь борлуулалтын буцаалт, урамшуулалт болон бусад төстэй хөнгөлөлтүүдээр буурна.

Бараа борлуулалт

Дараах бүх нөхцөл хангагдсан тохиолдолд бараа борлуулалтыг орлогоор хүлээн зөвшөөрнө:


- Компани барааны өмчлөлтэй холбоотой үүсэх мэдэгдэхүйц эрсдэл ба өгөөжийг худалдан авагч талд шилжүүлсэн
- Компани борлуулсан барааныхав өмчлөлд холбогдох удирдлагын болон хяналтын үүргийг өөртөө авч үлдээгүй
- Орлогын дүнг найдвартай хэмжих боломжтой байгаа
- Ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг Компани хүртэх магадлалтай
- Тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан ба гарах зардлыг найдвартай хэмжих боломжтой байгаа.

Хүүний орлого

Хүүний орлогыг заалийн үлдэгдэл болон тохирох үр ашигт хүүний хувь хэмжээ буюу санхүүгийн хөрөнгийн тооцоолсон хугацаагаар ирээдүйд хүлээж авах мөнгийг тухайн хөрөнгийн дансны үнэ хүртэл дискантчилах хувь хэмжээг харгалзан үзэж тогтмол хуримтлуулан бүртгэнэ.

3.13 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх зорилгоор мөнгөтэй адилтгах хөрөнгөнд үнэ цэнэ нь өөрчлөгдөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдаг. мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацааны хөрөнгө оруулалт зэргийг хамруулдаг. Мөнгөтэй адилтгах хөрөнгийг хөрөнгө оруулалт болон бусад зорилгоос илүү богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшдэг. Хэрэв мөнгөтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг





Үнэт цаасны танилцуулга



СЗХ
ОН ОН 14
2017 12 14

мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг бол Компани нь хөрөнгө оруулалтыг мөнгөтэй адилтгах хөрөнгөөр ангилна.

4 Мөнгө, харилцахын үлдэгдэл

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Бэлэн мөнгө	117,577	74,576
Банкны харилцах дансан дах үлдэгдэл – төгрөгийн харилцах данс	1,466,067	106,192
Банкны харилцах дансан дах үлдэгдэл – ам.долларын харилцах данс	350	157
	1,583,994	180,925

5 Дансны авлага

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Дансны авлага - өндөг	950,863	630,977
Дансны авлага - тэжээл	29,333	61,664
Дансны авлага - савлагаа	110	-
	980,306	692,641

Дансны авлага нь бүгд богино хугацаатай байна бөгөөд цэвэр дансны үнэ нь бодит үнэтэй ойролцоо гэж удирдлагууд үзсэн.

Бараа борлуулалтын эзэгийн дундаж хугацаа нь 30 хоног (2016: 30 хоног) байна.

Дансны авлагад хүү тооцохгүй ба бүгд төгрөгөөрх авлага байна


Эдгээр авлагын нэвчилтын шинжилгээг дор харуулав:

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
1 сараас бага	639,217	627,218
1 сараас 3 сар	279,582	36,767
3 сараас 6 сар	3,650	28,656
	980,306	692,641


6 Бараа материал

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Түүхий эд материал - Тэжээл	948,945	782,623
Түүхий эд материал – Савалгаа	2,880	38





Үнэт цаасны танилцуулга




Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Бэлэн бүтээгдэхүүн - Өндөг	37,837	65,632
Бэлэн бүтээгдэхүүн - Тэжээл	54,268	37,768
Бэлэн бүтээгдэхүүн - Савалгаа	13,938	3,364
Үржлийн өндөг	69,234	-
Ажилчдын хоолны материал	170	937
Эм, ариутгал	11,644	7,325
Хангамжийн материал	104,394	85,884
	1,243,310	983,471

Тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрсөн бараа материалын эртөг нь 10,908,848 мянган төгрөг (2016 онд: 8,842,145 мянган төгрөг) байна. Бүх бараа материал нь зээлийн барьцаанд тавигдсан. Зээлийн талаарх мэдээллийг тодруулга 13-аас харна уу. Тайлант онд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болох өндөгийн гарц нь 52,320 мянган ширхэг (2016 онд: 41,622 мянган төгрөг) байсан.


7 Урьдчилж төлсөн зардал

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Тэжээлийн урьдчилгаа төлбөр	418,661	517,034
Барилгын ажлын урьдчилгаа төлбөр	34,187	-
Бусад урьдчилгаа төлбөр	60,727	277
	513,575	517,311





Үнэт цаасны танилцуулга




8 Үндсэн хөрөнгө

Мянган төгрөгөөр	Барилга, байгууламж	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	Тавилга эд хогшил	Бусад	Нийт
Өртөг					
2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр	4,458,114	5,087,999	61,596	50,016	9,657,725
Нэмэгдсэн	61,010	289,033	17,674	58,340	426,057
Хасагдсан	-	(10,980)	-	-	(10,980)
2016.12.31	4,519,124	5,366,052	79,270	108,356	10,072,802
Нэмэгдсэн	929,319	763,697	5,465	73,760	1,772,241
Хасагдсан	-	-	(840)	-	(840)
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	5,448,443	6,129,749	83,895	182,116	11,844,203
Хуримтлагдсан элгэдэл					
2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр	798,375	744,984	27,932	16,049	1,587,340
Байгуулсан элгэдэл	189,268	480,467	9,822	10,592	690,149
Данснаас хассан	-	(9,356)	-	-	(9,356)
2016.12.31	987,643	1,216,095	37,754	26,641	2,268,133
Байгуулсан элгэдэл	140,143	591,148	14,133	24,024	769,448
Данснаас хассан	-	-	-	-	-
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	1,127,786	1,807,243	51,887	50,665	3,037,581
Үлдээдэг өртөг					
2016.12.31	3,531,481	4,149,957	41,516	81,715	7,804,669
2017.12.31	4,320,657	4,322,506	32,008	131,451	8,906,622

Компанийн бүх үндсэн хөрөнгө 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн барьцаанд тавьсан байна (2016 оны 12 дугаар сарын 31: бүх үндсэн хөрөнгө) Зээлийн талаарх мэдээллийг тодруулга 13-аас харна уу.

2017 онд нэмж худалдан авсан дүн нь 1,648,291 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө (2016: 308,343 мянган төгрөг), ба үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулсан 123,950 мянган төгрөгийн зарцуулалтаас (2016: 117,623 мянган төгрөг) бүрдэнэ.

Үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа хөрөнгийн элэгдлийн зардлыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өртөгт шингээдэг ба ерөнхий удирдлага, Борлуулалтын зориулалтаар ашиглагдаж байгаа хөрөнгийн элэгдлийн зардлыг өрөнхий ба удирдлагын зардалд тусгасан.





Үнэт цаасны танилцуулга



9 Биет бус хөрөнгө

Мянган төгрөгөөр	Газар эзэмших эрх	Компьютерийн програм хангамж	Нийт
Өртөг			
2016 оны 1 дугаар сарын 1-ээрх	-	22,671	22,671
Нэмэгдсэн	-	-	-
Хасагдсан	-	-	-
2016.12.31	-	22,671	22,671
Нэмэгдсэн	10,000	-	10,000
Хасагдсан	-	-	-
2017 оны 12 дугаар сарын 31-ээрх	10,000	22,671	32,671
Хуримтлагдсан хорогдуулга			
2016 оны 1 дугаар сарын 1-ээрх	-	1,797	1,797
Нэмэгдсэн	-	7,571	7,571
Данснаас хасагдсан	-	-	-
2016.12.31	-	9,368	9,368
Нэмэгдсэн	249	7,530	7,779
Данснаас хасагдсан	-	-	-
2017 оны 12 дугаар сарын 31-ээрх	249	16,898	17,147
Үлдэгдэл өртөг			
2016 оны 12 дугаар сарын 31-ээрх	-	13,303	13,303
2017 оны 12 дугаар сарын 31-ээрх	8,751	5,773	15,524

Тайлант онд газар эзэмших гэрчилгээ авсан.

Хорогдуулгын зардлыг өрөнхий ба удирдлагын зардалд тусгасан байна.

10 Биологийн хөрөнгө

10.1 Эргэлтийн биологийн хөрөнгө

	2017	2016
Эхний үлдэгдлийн тоо /дэгдээхий/	54,738	29,988
Эцсийн үлдэгдлийн тоо /дэгдээхий/	119,172	54,738
	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Мянган төгрөгөөр		
Өртөг	717,485	530,540
Элэгдэл	-	-
Үлдэгдэл өртөг	717,485	530,540





Үнэт цаасны танилцуулга



10.2 Эргэлтийн бус биологийн хөрөнгө

	2017	2016
Эхний үлдэгдлийн тоо /өндөглөгч тахиа/	123,797	119,057
Эцсийн үлдэгдлийн тос /өндөглөгч тахиа/	166,423	123,797
Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Өртөг	1,942,190	1,792,838
Элэгдэл	(1,499,235)	(1,093,136)
Үлдэгдэл өртөг	442,955	699,702


11 Дансны өглөг

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Дансны өглөг	46,470	137,348
Сав, хайрцаг худалдан авалтын өглөг	26,611	67,933
	73,081	205,279

Бараа бүтээгдэхүүний худалдан авалтын зээлийн дундаж хугацаа нь 1 сар (2016: 1 сар) байна. Дансны өглөгт ямар нэгэн хүү тооцожгүй.


12 Бусад богино хугацаат өр төлбөр

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Цалингийн өглөг	61,216	45,775
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	3,218	5,064
Хувь нийлүүлэгчээс авсан зээл	943,529	726,529
Ногдол ашгийн өглөг	59,934	37,473
Бусад өглөг	1,972	4,044
	1,069,869	818,885





Үнэт цаасны танилцуулга



13 Зээл

Мянган төгрөгөөр	Богино хугацаат		Урт хугацаат	
	2017.12.31	2016.12.31	2017.12.31	2016.12.31
Баталгаатай банкны зээллэг	675,000	1,561,667	3,000,000	635,068

Банкны зээл нь 2018 оны 6 сард бүрэн дуусах бөгөөд жилийн 6.53%-ийн жинлэсэн дундаж хүүтэй (2016: жилийн 15.93%).

Зээлийг эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгөөр баталгаажуулсан.

Компани нь 2017 оны 7 дугаар сард хөрөнгө оруулалтын зориулалтаар 3,000,000 мянган төгрөгийн зээл Хас банкнаас авсан. Тус зээлийн үндсэн төлбөрийг 2018 оны 8 дугаар сараас 2024 оны 7 дугаар сар хүртэл тэнцүү дүнгээр төлөх ба жилийн 8 хувийн хүүтэй.

Мөн *Мөл хэмээгдэх* сангаас 675,000 мянган төгрөгийн санхүүжилтийн хүүгүй зээл авсан ба 2018 оны 4 дүгээр сараас 2018 оны 8 дугаар сар хүртэл тэнцүү хэмжээгээр эргэн төлөх нөхцөлтэй.

Бүх зээл нь төгрөгийн зээл байна.

14 Капитал ба нөөц

14.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө

	Энгийн хувьцаа	Энгийн хувьцаа
	2017	2016
Зөвшөөрөгдсөн хувьцааны тоо /ширхэгээр/	142,392,500	5,000
Нэмж гаргасан хувьцааны тоо /ширхэгээр/	7,607,500	0
Нийт энгийн хувьцаа /ширхэгээр/	150,000,000	5,000
Нэгж энгийн хувьцааны нэрлэсэн үнэ /төгрөгөөр/	20	569,570
Нийт хувьцаат капиталын дүн /мянган төгрөгөөр/	3,000,000	2,847,850


Компани нь тогтмол орлогын эрхгүй энгийн хувьцааны нэг л ангилалтай.


Тайлант хугацаанд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 152,150 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн. Мөн хувьцааны нэрлэсэн үнийг 20 төгрөг болгосноор хувьцааны тоог 142,392,500 ширхэг болгон жижгэрүүлсэн ба 7,607,500 ширхэг хувьцаа нэмж гаргасан.

Нэгж хувьцаанд ногдох цэвэр ашгийг татварын дараах ашгаас тооцоход 9.2 мянган төгрөг (2016: 166.5 мянган төгрөг) байсан.

14.2 Ногдол ашиг

2017 оны 66,593 мянган төгрөгийн ногдол ашгийг энгийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилж өгсөн. 2016 оны хуваарилсан ногдол ашиг нь 41,636 мянган төгрөг байсан.





Үнэт цаасны танилцуулга



15 Борлуулалтын орлого


Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Борлуулалт - Өндөг	12,063,419	8,800,495
Борлуулалт - Тэжээл	802,206	1,317,487
Борлуулалт - Савалгаа	170,722	193,309
Мах, дэгдээхий борлуулалт	325,446	48,281
Борлуулалтын буцаалт	(73,160)	(32,289)
Борлуулалтын хөнгөлөлт	(58,876)	(17,060)
Цэвэр борлуулалт	13,229,757	10,310,223


16 Борлуулалтын өртөг

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг - Өндөг	9,677,178	7,465,687
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг - Тэжээл	675,538	1,062,816
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг - Савалгаа	120,637	146,901
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг - Мах, дэгдээхий	280,799	52,878
	10,754,152	8,728,282

17 Түгээлт ба маркетингийн зардал

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Шатахууны зардал	88,647	62,252
Маркетинг, сурталчилгааны зардал	16,875	14,033
	105,522	76,285





Үнэт цаасны танилцуулга



18 Ерөнхий ба удирдлагын зардал


Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Цалин хөлс, шагнал	596,640	509,522
Нийгмийн даатгалын зардал	83,128	69,845
Зөсвар үйлчилгээний зардал	58,548	45,387
Түрээсийн зардал	27,308	20,537
Албан томилолтын зардал	19,645	6,284
Элэгдлийн зардал	104,389	102,429
Шуудан холбооны зардал	7,792	12,921
Найдваргүй аялагын зардал	6,000	11,000
Хослуунаа, утасны зардал	57,581	43,452
Акталсан өндөг	25,921	3,672
Хандив, сургалтын зардал	5,645	2,003
Шагнал, урамшууллын зардал	45,820	8,101
Хангамжийн материал зардал	17,894	14,575
Бичиг хэргийн зардал	13,438	11,841
Даатгалын төлбөрийн зардал	1,716	1,679
Ашиглалтын зардал	25,407	19,412
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс	5,964	3,580
Төсөвт төлсөн АТБӨЯТХ-ийн тэтгэвэр	1,847	1,885
Төсөвт төлсөн газар, байгалийн нөөц ашигласны тэтгэвэр	10,543	8,839
Төсөвт төлсөн үл хөдлөх хөрөнгийн албан тэтгэвэр	7,285	14,067
Бусад зардал	11,636	21,537
	1,133,347	932,568

19 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бодит үнэ цэнийн олз

Компанийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг биологийн хөрөнгөөс хүлээн авах үеийн борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ болон түүхэн өртгийн зөрүүнээс тайлант онд 325,235 мянган төгрөгийн (2016 онд: 331,494 мянган төгрөг) олз хүлээн зөвшөөрсөн.

20 Санхүүгийн орлого, зардал

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Харилцах дансны хүүний орлого	12,818	20,937
Зээлийн хүүний зардал	(25,890)	(6,967)
Цэвэр санхүүгийн орлого/зардал	(13,072)	13,970





Үнэт цаасны танилцуулга



21 Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз

Мянган төгрөгөөр	2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2015 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	109,420	51,915
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(109,400)	(47,256)
	20	4,659

22 Орлогын татварын зардал


Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Тайлант жилийн татвар	156,758	93,237
Хойшлогдсон татвар	-	-
	156,758	93,237


Хүчин төгөлдөр татварын хувь хэмжээний нэгтгэл нь дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	Хүчин төгөлдөр татварын хувь хэмжээ (%)	2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	Хүчин төгөлдөр татварын хувь хэмжээ (%)
Татварын өмнөх ашиг (СТОУС-ын дагуу)	1,537,197		925,949	
Тусгайлсан татварын хувь хэмжээгээр тооцох орлого	(12,818)		(20,937)	
Татвар тооцох орлого нэмэгдүүлэх/(бууруулах хэсэг), цэвэр	30,383		6,420	
Нийт татвар ногдох орлого	1,554,762		911,432	
10%-аар татварын хувь хэмжээг тооцсон татвар (2016: 3 тэрбум хуртгал 10%, илүү гарсан дүнгээс 25%)	155,476	10.11%	91,143	9.84%
Тусгайлсан хувь хэмжээгээр тооцсон татвар (2016: 10%)	1,282	0.08%	2,094	0.23%
Орлогын татварын зардал	156,758	10.20%	93,237	10.07%

23 Балансын дараах үйл явдал

Компани нь тахианы аж ахуйн үйл ажиллагаагаа улам өргөжүүлэн, бэхжүүлэх, болон газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн үйл ажиллагаа шинээр эхлүүлэх зорилгоор "Түмэн шувуут" ХХК-ийг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн, үнэт цаасны анхдагч зах зээлд олон нийтэд хувьцаагаа гаргахаар ажиллаж байна.





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



Компани нь 2018 онд үндсэн хөрөнгөө дахин үнэлж, НББОУС 16 заасны дагуу дахин үнэлгээний загвараар бүртгэж нягтлан бодох бүртгэлийн бодлогыг баримтлан ажиглаж байна.

24 Санхүүгийн хэрэгсэл

24.1 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Хүлээн зөвшөөрөх шалгуур, орлог зарлагыг хүлээн зөвшөөрөх үндэслэл, санхүүгийн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн хэрэгслийн ангиллын талаар хэрэглэж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, арга зэргийг тодруулга 3-д дэлгэрэнгүй харуулсан болно.

24.2 Санхүүгийн хэрэгслийн ангилал

Санхүүгийн байдлын тайланд тайлагнасан дансны үнэ нь дараах хөрөнгө, өр төлбөрийн ангилалтай холбоотой:

Санхүүгийн хөрөнгө

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Зээл, авлага:		
Дансны болон бусад авлага	981,386	892,641
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	1,583,994	180,925
	<u>2,565,380</u>	<u>873,566</u>

Санхүүгийн өр төлбөр

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Хорогдуулсан өртгөөр нь хэмжсэн санхүүгийн өр төлбөр:		
Зээл, зээллэг	3,675,000	2,196,735
Дансны болон бусад өглөг	1,346,737	1,256,559
	<u>5,021,737</u>	<u>3,453,294</u>

25 Санхүүгийн эрсдэлийн удирдлага


Компани нь санхүүгийн хэрэгслүүдийг ашиглах явцад зарим эрсдэлүүдтэй тулгарч байна. Үүнд зах зээлийн эрсдэл, зээлийн эрсдэл, хөрвөх чадаарын эрсдэл зэрэг байна.


Компанид тулгарч буй томоохон санхүүгийн эрсдэлүүдийг дор харуулав.

Санхүүгийн эрсдэлийн хүчин зүйлс

а) Зах зээлийн эрсдэл

Компани санхүүгийн хэрэгслүүдийг хэрэглэх явцад зах зээлийн эрсдэл, үүнд үндсэн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүдэн гарах хүүгийн түвшин болон бусад үнийн эрсдэлтэй тулгардаг байна.





Үнэт цаасны танилцуулга



b) Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл нь Компанид санхүүгийн эрсдэл үүссэний улмаас гэрээний үүргээ гүйцэтгэж чадахгүй болох эрсдэлийг харуулдаг. Компанийн хувьд энэхүү эрсдэлийн нөлөөлөл нь дансны авлага, санхүүгийн байгууллагын дансны өргөх мэт өөр өөр санхүүгийн хэрэгслээс үүсдэг.

Тайлант хугацаанд дансны болон бусад авлагатай холбоотой зээлийн эрсдлийн томоохон асуудал байхгүй байна.

c) Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь Компани хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байх эрсдэл юм.

Компанийн бодлого нь үйл ажиллагааны болон зээлийн үйлчилгээтэй холбоотой төлбөрийг барагдуулахад хангалттай мөнгөн хөрөнгө болон түргэн хөрвөх хөрөнгөтэй байх оновчтой хөрвөх чадварын удирдлагын бодлого хэрэгжүүлэх юм.

Дараах хүснэгтээр гэрээнд заасан эргэн төлөгдөх хугацаатай үүсмэл бус санхүүгийн өр төлбөрүүдийг төлөх Компанийн зээлийн үлдэгдэлтэй гэрээний хугацааг харуулав. Компани нь төлөх шаардлагатай эхний өдөр санхүүгийн өр төлбөрийн дискантчилаагүй мөнгөн гүйлгээнд үндэслэн уг хүснэгтийг гаргасан. Хүснэгтэд хүүний түвшин болон үндсэн мөнгөн гүйлгээг харуулсан.

2017	Тогтмол хүүтэй арга хэрэгсэл		Нийт
	Хүүгүй	Хүүтэй	
Жинлэсэн дундаж үр ашигт хүүний түвшин (%)	0%	5.53%	
6 сараас бага	407,902	600,000	1,007,902
6 сараас 1 жил	938,835	75,000	1,013,835
1 жилээс 5 жил	-	1,800,000	1,800,000
5-с дээш жил	-	1,200,000	1,200,000
	<u>1,346,737</u>	<u>3,675,000</u>	<u>5,021,737</u>


2018	Тогтмол хүүтэй арга хэрэгсэл		Нийт
	Хүүгүй	Хүүтэй	
Жинлэсэн дундаж үр ашигт хүүний түвшин (%)	0%	15.93%	
6 сараас бага	533,919	1,089,392	1,623,311
6 сараас 1 жил	721,835	495,351	1,217,186
1 жилээс 5 жил	-	611,992	611,992
	<u>1,255,754</u>	<u>2,196,735</u>	<u>3,452,489</u>


Компани нь хөрвөх чадварын эрсдэл ялангуяа мөнгөний эх үүсвэр, дансны авлагыг үнэлэх, удирдахад санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй мөнгөн урсгалыг авч үздэг. Дансны болон бусад авлагын мөнгөн урсгал нь бүгд 1 сарын дотор төлөгдөх гэрээтэй юм. Тиймээс авлагын эргэн төлөгдөх хугацаа харьцангуй хурдан тул Компанийн мөнгөний эх үүсвэр, дансны авлага нь эргэлтийн мөнгөн урсгалын шаардлагаас их байна.

26 Капиталын эрсдэлийн удирдлага

Компани нь цаашид тасралтгүй ажиллах боломжийг хангах, оролцогч талуудад ноогдох ашгийг хамгийн их байлгахын тулд өөрийн хөрөнгөө удирддаг.

Компанийн капиталын бүтэц нь эздийн өмч, Тодруулга 13-д харуулсан зээл, өр төлбөрөөс бүрдэнэ.





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



Санхүүгийн хараат байдлаас зайлсхийх үр ашигтай санхүүгийн бүтцийг бий болгохын тулд удирдлага Компанийн капиталын шаардлагыг үнэлнэ. Энэ нь Компанийн өрийн ангилал бүрийн дэд түвшинг харгалзан авч үздэг. Капиталын бүтцийг удирдахын тулд Компани хувьцаа эзэмшигчдэд төлөх ноогдол ашгийн хэмжээг тогтоох, шинээр хувьцаа гаргах, эвсэл өр төлбөрөө бууруулахаар хөрөнгө борлуулах гэх мэтээр удирддаг.

Компанийн тайлант хугацааны капиталын дүнг доор хураангуйлан харуулав.

Мянган төгрөгөөр

Нийт эздийн өмч
Хасах: мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө
Капитал
Нийт эздийн өмч
Зээл
Бүх санхүүжилт

	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
	10,131,398	7,969,268
	1,583,994	180,925
	8,547,404	7,788,343
	10,131,398	7,969,268
	3,675,000	2,196,735
	13,806,398	10,166,003
	62%	77%

Нийт санхүүжилт дэх капиталын харьцаа

27 Үүрэг

27.1 Капиталаас хүлээх үүрэг

Тус компани нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ямар нэгэн томоохон шүүхийн нэхэмжлэл, маргаангүй байна. Тийм учир компани нь холбоотой талтай холбоотой ирээдүйн капиталын зарцуулалтаас хүлээх үүрэг байхгүй.

28 Холбоотой тал

28.1 Хяналтын харилцаа

Компанийг тус компанийн 40 хувийг эзэмшдэг Л.Эрхэмбаяр, 40 хувийг эзэмшдэг Б.Тунгалаг, 10 хувийг эзэмшдэг Ж.Болд, 10 хувийг эзэмшдэг Э.Баяржаргал нар хянадаг.

28.2 Удирдлага болон тэдний ойр дотнын гэр бүлийн гишүүдтэй хийсэн ажил гүйлгээ

Компанийн захирал, тэдний ойр дотнын гэр бүлийн гишүүд нь 2017 оны 12 дугаар сарын 31 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ээрх Компанид ихээхэн хэмжээний хувьцаа эзэмшдэг. Ажилчдын цалингийн тооцоон оос харахад удирдлага нь тайлант жил дараах цалинг авсан байна.


Мянган төгрөгөөр

	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
	68,300	54,080


Цалин урвшуулал

Компанийн хувьцаа эзэмшигчээс 2017 онд нийт 832,000 мянган төгрөгийн (2016 онд: 721,835 мянган төгрөг) богино хугацаат зээл авсан. Үүний 943,529 мянган төгрөгийн (2016 онд: 726,529 мянган төгрөг) үлдэгдлийг бусад өглөгөөр тайлагнасан.





Үнэт цаасны танилцуулга






Үнэт цаас гаргагчийн 2016 оны санхүүгийн аудитлагдсан тайлан

Санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан

“Түмэн шувуут” ХХК

2016 оны 12 дугаар сарын 31





6. Үйл ажиллагааны гол үндэслэл болсон аливаа тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх.....	16
7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх.....	18
8. Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх.....	23
9. Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд нь хэн болох.....	25
10. Тухайн компанийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх болон нэмэлт шинжилгээ, судалгаа.....	26
11. Тухайн компанийн эрхэлж буй үйл ажиллагааны нийцэл (compliance)-ийн талаар хийсэн зарим нэмэлт судалгаа шинжилгээ.....	27
12. Гол дүгнэлт.....	32
13. Хязгаарлалт.....	33





MDSKhanLex

III. Нийтэлгээний үндэс

Өмгөөллийн "Эм Ди Эс энд Хаан Лекс" ХХН (цаашид "ХУУЛИЙН ФИРМ" гэх) нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "СЗХ" гэх)-ны 2014.01.29-ний өдрийн 25 дугаар тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1 дэх хэсэгт зааснаар Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх бүхий энгээдээр анх бүртгэгдсэн бөгөөд "Эм Ди Эс энд Ассошэйтс" ХХН болон "ХаанЛекс адвокатс" ХХН 2 хуулийн фирм нэгдэж, өөрчлөн байгуулагдсаны дараа СЗХ-ны 2016.02.24-ний өдрийн 42 дугаар тогтоолоор нэрээ шинэчлэн бүртгүүлсэн Үнэт цаасны зохицуулалттай этгээд (**Хавсралт 1.1**)-ийн хувьд энэхүү хууль зүйн үйлчилгээг үзүүлэх эрхтэй болно.


Монгол Улсын хуулийн этгээд болох "Түмэн шувуут" ХХК (цаашид "Түмэн шувуут" гэх) нь хувьцаагаа анх удаа нийтэд санал болгох гэж буйтай холбогдуулан Хууль зүйн дүгнэлт гаргахыг биднээс хүсэж улмаар бид 2018.04.11-ний өдөр "Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ" (**Хавсралт 1.2**) байгуулац тус гэрээний дагуу энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргаж байна.

Энэхүү хууль зүйн дүгнэлтийг зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, түүний дотор Компанийн тухай хуулийн 23.1-г "... хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилж болно", 4.2-г "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол нээлттэй хувьцаат компани нь нээлттэй буюу хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаасыг гаргаж болно" гэж хуульчилсны дагуу Түмэн шувуут нь нэмж гаргах энгийн эрхийн хувьцаагаа олон нийтэд санал болгох замаар хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдах эрх зүйн үндэслэлтэй гэж үзсэний үндсэн дээр гаргаж байна. Тус Компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйл (Үнэт цаас), 6 дугаар зүйл (Үнэт цаас гаргах), 7 дугаар зүйл (Үнэт цаас гаргагч), 8 дугаар зүйл (Нийтэд санал болгон үнэт цаас гаргах журам), 9 дүгээр зүйл (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 11 дүгээр зүйл (Үнэт цаасыг нийтэд санал болгох)-д заасны дагуу хувьцаагаа Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "СЗХ" эсхүл "Хороо" гэх), Монголын хөрөнгийн бирж (цаашид "МХБ" гэх)-д бүртгүүлж, нийтэд санал болгон гаргахаар төлөвлөсөн байна.

Энэхүү хувьцааны бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, СЗХ-ны 2015.11.23-ны өдрийн 408 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2018.01.25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон МХБ-ийн ТУЗ-ийн 2012.02.10-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан "МХБ" ТӨХК-ийн "Арилжааны журам"-ын дагуу явагдана.


Бид хууль зүйн дүгнэлт гаргах зорилгоор Түмэн шувуутас түүний Гэрчилгээ, Дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолууд болон бидний хувьд шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримтыг эх хувиар болон хуулбарыг гаргуулан авч, хууль зүйн үндэслэл болон мэдээллийг тулган шалгаж, судалсан болно. Түүнчлэн компанийн үйл ажиллагааны





талаар шүүх, төрийн эрх бүхий байгууллагуудаас шаардлагатай гэж үзсэн хөндлөнгийн мэдээллийг гаргуулж судалсан болно.

Бид ийнхүү судалгаа шинжилгээ (due diligence) хийж, дүгнэлт гаргахдаа (а) үнэт цаасны танилцуулгад тусгасан андеррайтер, аудитор, хөрөнгийн үнэлгээчний хийсэн судалгаа, дүгнэлт, тайлан, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв, (б) бидэнд ирүүлсэн бүх бичиг баримтад дурдсан мэдээлэл үнэн, зөв; (в) тэдгээр баримт бичигт зуралдсан гарын үсэг, дарагдсан тамга, тэмдэг бодит, зөв; (г) бидэнд ирүүлсэн бичиг баримтуудын хуулбар нь тэдгээрийн эх хувьтай нийцсэн, бүрэн; (д) бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй гэж үзсэний үндсэн дээр, дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн дор дурдсан хууль зүйн дүгнэлт гаргаж байна:





MDSKhanLex

1. Компани хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байх талаар

"Түмэн шувуу" ХХК нь Компанийн тухай хуулийн дагуу хоёр гишүүн (Монгол Улсын иргэн Л.Эрхэмбаяр РД: А362022114, БНХАУ-ын иргэн Лу Жианхуа АА02010608)-тэйгээр үүсгэн байгуулагдаж, 2006.06.09-ний өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн байна. (Улсын бүртгэлийн дугаар: 9011127143, Регистрийн дугаар: 2844753) (**Хавсралт 9.1**).

ӨОУБЕГ-ын 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 002885909 дугаартай Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа (**Хавсралт 9.1**)-аар үзвэл Түмэн шувууны хувьцаа эзэмшигч Лу Жианхуа, Л.Эрхэмбаяр нар өөрсдийн эзэмшлийн бүх хувьцааг 2007.12.20-ны өдөр Эрхэмбаярын Баяржаргалд шилжүүлсэн, Э.Баяржаргал нь 2011.12.01-ний өдөр 18 тоот Хувьцаа эзэмшигчийн шийдвэр (**Хавсралт 1.3**) гаргаж, тус компанийн өөрийн эзэмшлийн энгийн хувьцаа, түүнд хамаарах эрхийн 40 хувийг Ломбын Эрхэмбаярт, 40 хувийг Балаагийн Тунгалагт, 10 хувийг Жигжидийн Болд нарт шилжүүлж, өөрөө 10 хувийг эзэмших болсон бөгөөд үүнтэй холбоотой дүрэмд орсон өөрчлөлтийг 2011.12.08-ны өдөр улсын бүртгэлд бүртгэсэн. Иргэний хуулийн 183.1, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 3.1.4-т зааснаар улсын бүртгэл үнэн зөв, бодитой байна.

Түмэн шувуу нь 2006.06.29-ний өдрийн гэрчилгээ (**Хавсралт 1.4**), 2018.05.10-ны өдрийн компанийн дүрмийн (**Хавсралт 1.5**) дагуу тахиа шувууны аж ахуй, малын тэжээлийн үйлдвэрлэл, өндөгний сав баглаа боодлын үйлдвэрлэл, худалдаа, гадаад дотоод худалдаа, тахианы мах боловсруулах үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагаа эрхэлнэ хэмээн заасан байна.

Түмэн шувуу нь "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 15.11.4, 15.11.7-д заасны дагуу Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2011.12.30-ны өдрийн А/369 дугаар тушаалаар Малын эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (**Хавсралт 1.6**), мөн Монгол Улсын Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014.09.16-ны өдрийн А/342 дугаар тушаалаар Үржлийн тахиа, дэгдлээхэй, үржлийн өндөг импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (**Хавсралт 1.7**) авсан байна.

Компани нь Монгол улсын Компанийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн байна.





MDSKhanLex


2. Компанийн Гүйцэтгэх захирал, Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль бус болон Компанийн засагчид өлсөж төгсөж таасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тэдний компанийг удирдах чадвар, дадлага туршлагын байдлаар


Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй "Түмэн шувуут" ХХК-ийн дүрмийн 3.13-т тус компанийн эрх бүхий албан тушаалтан нь гүйцэтгэх захирал бийн хэмээн тодорхойлсон байгаа хэдий ч Компанийн тухай хуулийн 84-р зүйлийн 84.2, 84.3 дахь заалт болон Түмэн шувуутын холбогдох баримт бичигт үндэслэн тус компанийн 4 хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлагч, бодогч, Үйлдвэрийн дарга, Борлуулалтын албаны дарга, Шувууны аж ахуйн дарга нарыг тус компанийн эрх бүхий албан тушаалтан гэдэгт хамруулан авч үзлээ.

Компанийн Эрх бүхий албан тушаалтнуудын үр чадвар, дадлага туршилагын байдлыг авч үзвэл:

1. Компанийн үүсгэн байгуулагч, тус компанийн энгийн хувьцааны 40 хувийг эзэмшигч, Түмэн шувуутын зөвлөх Ломбо овогтой Эрхэмбаяр нь Хөдөө аж ахуйн их сургуулийг генетикч, мал зүйч мэргэжлээр 1985 онд, мөн тус их сургуулийг Хөдөө аж ахуйн ухааны доктор зэрэгтэйгээр 2000 онд, Монгол Улсын их сургуулийг эрх зүйч мэргэжлээр 2008 онд тус тус суралцаж төгссөн. 2008 оноос 2014 оныг хүртэл Монгол улсын Ерөнхийлөгчийн зөвлөхөөр, 2014-2017 оныг хүртэл Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн даргаар тус тус ажиллаж байсан бөгөөд одоо Түмэн шувуутын Зөвлөхөөр ажиллаж байна (**Хавсралт 2.1**).
2. Компанийн энгийн хувьцааны 40 хувийг эзэмшигч, Түмэн шувуутын зөвлөх Батай овогтой Тунгалаг нь Хөдөө аж ахуйн их сургуулийг мал зүйч мэргэжлээр 1985 онд суралцаж төгссөн. 2004 оноос 2010 оны хооронд Түмэн шувуутын ерөнхий захирлаар ажиллаж байсан бөгөөд 2010 оноос хойш одоог хүртэл Түмэн шувуутын нөв.н.хөөр ажиллаж байна (**Хавсралт 2.2**).
3. Компанийн энгийн хувьцааны 10 хувийг эзэмшигч, Түмэн шувуутын Гүйцэтгэх захирал Жигжид овогтой Болд нь Монгол улсын их сургуулийн Эдийн Засгийн сургуулийг эдийн засагч мэргэжлээр 2001 онд суралцаж төгссөн. 2001-2003 онд Хас банкинд эдийн засагчаар, 2003 онд Капитрон банкинд эдийн засагчаар ажиллаж байсан бөгөөд 2005 оноос одоог хүртэл Түмэн шувуутын Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна (**Хавсралт 2.3**).
4. Компанийн энгийн хувьцааны 10 хувийн хувьцааг эзэмшигч, Түмэн шувуутын гадаад харилцааны захирал Эрхэмбаярын Баяржаргал нь Санхүү эдийн засгийн дээд сургуулийг эдийн засагч мэргэжлээр 2000 онд, БНХАУ-ын Олон улсын эдийн засгийн дээд сургуулийг эдийн засагч мэргэжлээр 2005 онд суралцаж төгссөн. 2006-2007 онд БСБ ХХК-ийн захиалгын мэргэжилтнээр ажиллаж байсан 2007 оноос одоог хүртэл Түмэн шувуутын гадаад харилцааны захирлаар ажиллаж байна (**Хавсралт 2.4**).

Түмэн шувуутын Гүйцэтгэх захирал Ж.Болд нь 2015.08.24-ний өдрийн 05/2015 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол (**Хавсралт 2.5**)-оор томилогдон ажиллаж





байгаа бөгөөд түүнтэй "Түмэн шувуу"ын хувьцаа эзэмшигчдээс гүйцэтгэх захиралтай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээ"-г 2015.08.24-ний өдөр байгуулсан. Ерөнхий нягтлан бодогч Н.Должинсүрэн нь 2012.02.01-ний өдрийн 12/041 дугаартай Захирлын тушаал (Хавсралт 2.6)-аар, Үйлдвэрийн дарга Н.Баянмөнх нь 2014.07.20-ны өдрийн 01/257 дугаартай Захирлын тушаал (Хавсралт 2.7)-аар, Борлуулалтын албаны дарга Б.Мөнгөнтуяа нь 2012.09.06-ны өдрийн А/75 дугаартай Захирлын тушаал (Хавсралт 2.8)-аар, Шувууны аж ахуйн дарга Ч.Нэмэхжаргал нь 2010.04.01-ний өдрийн 04/01 дугаартай Захирлын тушаал (Хавсралт 2.9)-аар тус тус томилогдон ажиллаж байна.

Компанийн өдөр гутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж байгаа эрх бүхий албан тушаалтнуудын ур чадвар, дадлага туршлагын байдлыг авч үзвэл:

1. Гүйцэтгэх захирал Жижигдийн Болд (дээрхээс танилцана уу).
2. Ерөнхий нягтлан бодогч Найманжингийн Должинсүрэн нь Худалдааны техникумыг нягтлан бодогч мэргэжлээр 1992 онд МУИС-ийн ЭЗС-ийг нягтлан бодогч мэргэжлээр 2006 онд суралцаж төгссөн. 1993-1995 онд Багахангай ХХК-ийн нягтлан бодогчоор, 1996 оноос Нийгмийн даатгалын газар улсын байцаагчаар ажиллаж байгаад 2013 оноос одоог хүртэл Түмэн шувууын Ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байна (Хавсралт 2.10).
3. Үйлдвэрийн дарга Наранбазарын Баянмөнх нь 1999-2002 онд Бээт ХХК-д худалдагчаар, 2002-2014 онд АНУ-д тогтоочоор ажиллаж байгаад 2014 оноос одоог хүртэл Түмэн шувууын Үйлдвэрийн даргаар ажиллаж байна (Хавсралт 2.11).
4. Борлуулалтын албаны дарга Бөхцэвээний Мөнгөнтуяа нь ТИС-ийг хүнсний технологич мэргэжлээр 2001 онд бакалавр, МУИС-ийг хүнсний технологич мэргэжлээр магистр зэрэгтэй, ХУИС-ийг англи хэлний эрчуулагч мэргэжлээр 2012 онд тус тус суралцаж төгссөн. 2001-2004 онд Витафит ХХК-ийн технологич инженерээр, 2004-2012 онд MCS Coca Cola ХХК-ийн технологич инженерээр ажиллаж байгаад 2013 оноос одоог хүртэл Түмэн шувууын Борлуулалтын албаны даргаар ажиллаж байна (Хавсралт 2.12).
5. Шувууны аж ахуйн дарга Ч.Нэмэхжаргал нь СЭЗДС-ийг нягтлан бодогчоор 1998 онд ХААДС-ийг нягтлан бодогч мэргэжлээр 1992 онд суралцаж төгссөн. 1996-2008 онд Ар бээт ХХК-ийн худалдааны ажилтнаар, 2008-2010 онд Батнайд ХХК-ийн борлуулалтын менежерээр тус тус ажиллаж байгаад 2010 оноос одоог хүртэл Түмэн шувууын шувууны аж ахуйн даргаар ажиллаж байна (Хавсралт 2.13).

Компанийн Хувьцаа эзэмшигчид, Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнууд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр авч үзвэл:

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДАГА						
№	Нэр/Шаардлага	Боловсролын зэрэг, Мэргэжил	Ял шийтгэл эзэмш байгаа эсэх (К/Х-ийн 84.2.2)*	Компанийн засаглалын чиглэлээр суралцаж, хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх (К/Х-ийн	Хувь сүүн байх (К/Х-ийн 77.3, 83.2, 83.3)	Нийт ажилласан жил/Урсгас Түмэн шувуунал





75.8)						
1	Ж.Болд (Гүйцэтгэх захирал, хувьцаа эзэмшигч)	Үгүй	Үгүй*	Тийм /2017.09.15-ны өдөр, Дугаар 0430531/	Тийм	17/13
2	Л.Эрхэмбаяр (Хувьцаа эзэмшигч)	Үгүй	Үгүй*	Тийм /2017.09.15-ны өдөр, Дугаар 0430530/	Тийм	33/1
3	Б.Тувигалаг (Хувьцаа эзэмшигч)	Үгүй	Үгүй*	Тийм /2017.09.15-ны өдөр, 0430536/	Тийм	33/14
4	Э.Баиршаргал (Хувьцаа эзэмшигч, Гялаад харилцааны захирал)	Үгүй	Үгүй*	Тийм /2017.09.15-ны өдөр, Дугаар 0430532/	Тийм	12/11
5	Н.Дэлгэрсүрэн (Ерөнхий нагтлан бодогч)	Үгүй	Үгүй*	Үгүй	Тийм	25/8
6	Н.Баянмөнх (Үйлдвэрийн дарга)	Үгүй	Үгүй*	Үгүй	Тийм	24/3
7	Б.Мөнгөтүвш (Борлуулалтын албаны дарга)	Үгүй	Үгүй*	Үгүй	Тийм	17/5
8	Ч.Нэмэхшаргал (Шуууны аж ахуйн дарга)	Үгүй	Үгүй*	Үгүй	Тийм	30/8

Түмэн шувуутын хувьцаа эзэмшигчид болон Түмэн шувуутын Гүйцэтгэх захирал, бусад эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шавардлага хангасан бөгөөд компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай гэж дүгнэв.



MDSKhanLex

3. Компанийн дүрэм бусад татонд журмууд нь хууль төгтөөмж Хярооноос баталсан "Монгол компанийн асар талын кодекс" т нийцсэн зсх

Түмэн шувуут ХХК-ийн дүрэм. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018.05.10-ны өдрийн 18/03 дугаар тогтоолоор Компанийн одоогийн мөрдөгдөж буй дүрэм (шашид "Дүрэм" гэх)-ийг (Хавсралт 3.1) баталсан байна. Дүрэм нь нийт 12 бүлэгтэй бөгөөд Компанийн эрх зүйн байдал, эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, хувьцаа эзэмшигчид, Компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтныг тодорхойлж, тэдний эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлох, компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт, Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Түмэн шувуут хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан тусгагдвал зохих мэдээлэл бүрэн тусгагдсан бөгөөд тус ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөлгүй байгаа нь Компанийн тухай хуулийн 75.2-т: "... хязгаарлагдмал хариуцлагатай компани дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болно" гэсэнд нийцэж байна.

Компанийн засаглалын журмууд

Түмэн шувуут ХХК-ийн ногдол ашгийн бодлого. Компанийн ХХК нь хувьцаа эзэмшигчид хөрөнгө оруулагчдын эрх ашиг, санхүүгийн тогтвортой үйл ажиллагааг хангах, хөрөнгө оруулах сонирхлыг хамгаалахаар Компанийн тухай хууль, Компанийн засаглалын Кодекс т нийцүүлэн Компанийн жилийн ашгийг зөв зохиистой хуваарилах зорилгоор нийт 4 бүлэгтэй "Ногдол ашгийн бодлого"-ыг 2018.06.07-ны өдрийн 06/2018 дугаар тогтоолын Хавсралт 1-р баталсан (Хавсралт 3.2) байна. Тус журамд Компанийн ногдол ашиг хуваарилах бодлогыг гүдэрхойлсноос гадна ногдол ашиг хуваарилах нөхцөл, ногдол ашиг төлөх хэлбэр, ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах хугацаа, түүнд тусгах мэдээлэл, ногдол ашиг хуваарилах шийдвэр гарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ тэргийг зохицуулсан байна.

Тус журам нь Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл, журамд нийцсн гадна тус хуулийн 76.1.12, Компанийн засаглалын кодексийн 2.2.2-т заасан компани ногдол ашгийн бодлоготой байх, ногдол ашиг тодорхойлох журамтай байх зэрэг шаардлагыг хангаж байна.

Түүнчлэн IPO амжилттай болсны дараа зохион байгуулагдах Хувьцаа эзэмшигчдийн анхны хурлаар хэлэлцэн батлуулах зорилгоор Түмэн шувуут нь Хувьцаа компанийн дүрэм (Хавсралт 3.3)-ийн төсөл, ХК-ийн анхны ТУЗ сонгогдсоны дараа зохион байгуулагдах ТУЗ-ийн анхны хурлаар батлуулах зорилгоор "Түмэн шувуут" ХХК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам (Хавсралт 3.4)-ын төсөл, Хувьцаа эзэмшигчдийн хурлын эр хүргэх журам (Хавсралт 3.5)-ын төсөл, Мэдээллийн үйл ажиллагааны журам (Хавсралт 3.6)-ын төсөл, Нэгдмэл сонирхолтой этгээдгэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам (Хавсралт 3.7)-ын төслийг тус тус боловсруулсан байна. Эдгээр дүрэм, журмын төслүүд нь шашид жөдүү найруулгаараа батлагдана гэж үзвэл Компанийн тухай





зэрэг Монгол Улсын хуулиуд, СЗХ-ны журам, Компанийн засвглалын кодекст нийцсэн байна.

Хөдөлмөрийн дотоод журмуул

Хөдөлмөрийн дотоод журам. Компанийн гүйцэтгэх захирал нь 2017.01.01-ний өдрийн А/01 тоот тушаалын хавсралтаар хөдөлмөр зохион байгуулалт, ажил олгогч ба ажилтны эрх, үүрэг, хариуцлагатай холбогдох харилцааг зохицуулах зорилгоор нийт 9 бүлгээс бүрдсэн Хөдөлмөрийн дотоод журам (**Хавсралт 3.8**) батлан мөрдүүлж байна. Энэ журмаар хөдөлмөрийн удирдлага, зохион байгуулалт, хөдөлмөрийн гэрээ байгуулах нөхцөл, журам, ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл, журам, ажил амралтын цагийн горим, захиргааны чөлөө, цалин хөлс урамшууллын тогтолцоо, хөдөлмөрийн сахилга зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачилгаар цуцлах үйл ажиллагааг зохицуулсан байна.

Энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хуулийн 80.2, 130.1-д заасан шаардлагад нийцсэн байна.

Байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам. Компанийн гүйцэтгэх захирал нь 2016.06.10-ны өдрийн 09 тоот тушаалын хавсралтаар байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор нийт 12 бүлгээс бүрдсэн Байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг (**Хавсралт 3.9**) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь дотоод хяналт шалгалтын зарчим, зорилго, хамрах хүрээ, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажилтны эрх, үүрэг, дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааны чиглэл, итгэсэн зөрчил дутагдал ногдуулах хариуцлага, байгууллагын чиглэл тус бүрийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг зохицуулжээ.

Энэхүү журам нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 299 дүгээр тогтоол болон Компанийн тухай хуулийн 83.1-д нийцэж байна.

Техникийн комиссын журам. Түмэн шувуутын гүйцэтгэх захирал 2016.06.20-ны өдрийн 35 тоот тушаалын хавсралтаар компанийн машин техникийн бүрэн бүтэн байдал, эвдрэл гэмтэл, элэгдэл хорогдол, тээвэрлэлтийн нөхцлийг бүрдүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор нийт 5 бүлгээс бүрдсэн Техникийн комиссын журмыг (**Хавсралт 3.10**) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь комиссын удирдлага, бүтэн зохион байгуулалт, комиссын үйл ажиллагаа зэргийг зохицуулсан.

Энэхүү журам нь Компанийн тухай хуулийн 83.1, Авто тээврийн тухай хуулийн 3.1.16-д заасан авто тээврийн хэрэгслийн болон техник, тонног төхөөрөмжийг зүй зохистой ашиглах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах шаардлагыг тус компанийн хувьд хангах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгод нийцэж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлийн дүрэм. Түмэн шувуутын гүйцэтгэх захирал 2016.10.15-ны өдрийн 10/2016 тоот тушаалын хавсралтаар компанийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, хяналтыг






зохион байгуулах, ажилчдын нохцолыг сайжруулах, зохистой орчныг бүрдүүлэх, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 4 бүлгээс бүрдсэн дүрмийг (**Хавсралт 3.11**) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн зохион байгуулалт, түүний эрх, үүрэг зэргийг зохицуулсан байна.


Энэхүү журам нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.6-д заасан "ажил олгогч ажлын байрны онцлогтоо нийцсэн дүрэм, журам баталж, мөрдүүлэх" шаардлагад нийцэж байна.

Вакцины дүрэм. Гүйцэтгэх захирал нь 2016.01.01-ний өдөр Тахианы вакцин хүлээн авах, хадгалах, хэрэглэх, устгахтай холбоотой дүрмийг (**Хавсралт 3.12**) батлан мөрдүүлж байна. Энэхүү дүрэм нь 3 төрлийн вакцинийг хүлээн авах, хадгалах, хэрэглэх, вакцины хэрэглээний хориглох нөхцөлүүд зэргийг зохицуулсан байна. Энэхүү журам нь Химийн хорт болон аюултай бодисын тухай (2006) хуулийн 3.1.5-д "пестицид" гэж мал, амьтан, ургамлыг аливаа өвчнөөс сэргийлэх, хөнөөлт шавж, мэрэгч, хогийн ургамлаас хамгаалах зориулалттай химийн бодис, тэдгээрийн нэгдлийг ойшгоно гэж заасан байна. Мөн 8.1-д: "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах явцад хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, гарсан хор уршгийг арилгах арга хэмжээг өөрийн зардлаар авч хэрэгжүүлнэ". 8.2-т: "Энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь холбогдох хууль тогтоомж, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горимыг дагаж мөрдөнө" гэсэнтэй нийцэж байна.

Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм. Гүйцэтгэх захирал нь 2016.06.05-ны өдрийн 08 тоот тушаалын хавсралтаар хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг орон тооны бус комиссоор хянан шийдвэрлүүлэх зорилгоор нийт 3 бүлгээс бүрдсэн дүрмийг (**Хавсралт 3.13**) батлан мөрдүүлж байна. Энэхүү дүрэм нь хөдөлмөрийн маргаан таслах комиссын бүтэц, зохион байгуулалт, хөдөлмөрийн маргааныг хянан хэлэлцэх үйл ажиллагаа зэргийг зохицуулсан байна.

Энэхүү дүрэм нь Хөдөлмөрийн тухай хуулийн 126 дугаар зүйл, Засгийн газраас баталсан Хөдөлмөрийн маргаан таслах комиссын загвар дүрэмд үндэслэсэн байна.





Үнэт цаасны танилцуулга



4. Бусадтай байгуулсан худалдан авалт, бэлтгэл үйлдвэрлэл, зээлийн гэрэл үнэт цаас гаргалгын үйл ажиллагаанд гол төхөөрөмж хөлболодтой гэрээний хууль, тэг тоомжид нийцж байгаа эсэх

Бид тус компаниас ирүүлсэн Түмэн шувуутын үйл ажиллагаанд голлох ач холбогдол бүхий дор дурдсан гэрээг хянасан болно.

Зээлийн гэрээнүүд

1. Хас банк болон Түмэн шувуут нарын хооронд 2017.07.28-ны өдөр байгуулагдсан ЗГ15400000645 тоот Зээлийн гэрээ (Хавсралт 4.1).

Гэрээний мэдээлэл:


- Зээлийн дүн: 3,000,000,000 төгрөг
- Зээлийн зориулалт: Хөрөнгө оруулалт
- Зээлийн хүү: жилийн 8 хувь
- Нэмэгдүүлсэн хүү: зээлийн үндсэн хүүгийн 20 хувь
- Зээлийн хугацаа: 84 сар, 2019 оны 8 дугаар сараас эхлэн зээлийг төлж эхлэнэ.
- Хариуцлага: Түмэн шувуут нь төлбөрийг нэмэгдүүлсэн хүү, хүү, үндсэн төлбөр гэсэн дарааллаар төлнө. Түмэн шувуут нь гэрээний үүргээ биелүүлдэггүй, зохих ёсоор биелүүлдэггүй эсхүл гэрээг цуцалсан тохиолдолд Банк Түмэн шувуутын харилцах, хадгаламж, картын бусад дансууд дахь мөнгөн хөрөнгийг болон уг дансанд орох орлогыг үл маргах журмаар зээлийн төлбөрт шилжүүлэн авна. Барьцаа хөрөнгийг худалдан борлуулж үндсэн төлбөр, хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр, барьцаа хөрөнгийг худалдан борлуулахтай холбогдож гарсан бусад зардлыг тэргүүн ээлжинд төлүүлнэ.

Энэхүү гэрээг талууд бичгээр байгуулан эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байгаа нь Иргэний хуулийн 451.2-т заасан "зээлийн гэрээг бичгээр байгуулах" шаардлагыг хангасан байна.

Гэрээнд зээлийн дүн, үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ, зээлийн хугацаа, зориулалт, зээл төлөх хэлбэр, эргэн төлөлтийн хуваарь, зээлдэгч болон зээлдүүлэгчийн эрх, үүрэг, талуудын хүлээх хариуцлага, баталгаа ба зовшоорол, гэрээ дуусгавар болох цуцлах нөхцөл, журам, маргаан шийдвэрлэх звалтуудыг тусгасан байх ба эдгээр нөхцөлүүд нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Барьцааны гэрээ: Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор 2017.07.28-ны өдөр байгуулагдсан БГ1540000645-01 тоот Барьцааны гэрээ, 2018.04.13-ны өдөр байгуулагдсан БГ1540000645-02 тоот Барьцааны гэрээг Хас банк болон Түмэн шувуутын хооронд байгуулсан. Энэхүү гэрээг бичгээр байгуулан эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байгаа нь Иргэний хуулийн 156.1-д заасан "барьцааны гэрээг бичгээр байгуулах" шаардлагыг хангасан байна.





MDSKhanLex

Хас банкны 2018.05.01-ний өдрийн албан бичгийн (Хавсралт 4.2) дагуу 2018.05.01-ний өдрийн байдлаар 3,000,000,000 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байх ба уг зээл "хэвийн" ангилалд хамаарч байна.

Зээлийн гэрээ: ОХУ-аас малын өвс, тэжээл импортлон оруулж ирэх аж ахуйн нэгжтэй байгуулах зээлийн 2017/Ү/01 тоот гэрээ (Хавсралт 4.3). Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамны Мал хамгаалах сан болон Түмэн шувуут нарын хооронд 2017.12.06-ны өдөр байгуулсан 2017/Ү/01 тоот Оросын холбооны улс (шашид "ОХУ" гэх)-аас малын өвс, тэжээл импортлон оруулж ирэх аж ахуйн нэгжтэй байгуулах зээлийн гэрээ.

Гэрээний мэдээлэл:



- Зээлийн хугацаа: 9 сар
- Зээлийн зориулалт: ОХУ-аас малын тэжээл импортлон борлуулах малын тэжээл хангамжийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх санхүүжилтэд зарцуулна.
- Зээлийн ерөнхий нөхцөл: 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөгийн урьдчилгаа 30 хувь болох 300,000,000 төгрөгийг зээлдэгчийн Төрийн банкны 104400478271 тоот дансанд шилжүүлэх бөгөөд үлдэх 70 хувийг төрийн банкинд Түмэн шувуутын нэр дээр нэгсэн 10440047271 тоот нөхцөлт дансанд байршуулна.
- Хяналтын зардал: Олгосон санхүүжилтээ 0,1%-тай тэнцэх хэмжээтэй хяналтын зардал авч төслийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийнэ.

Хариуцлага: Зээлийг хуваарийн дагуу толоогүй тохиолдолд гүйцэтгэхгүй үүргийн үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,5 хувийн алдангийг Зээлдэгч Зээлдүүлэгчид төлөх бөгөөд Зээлдэгч нь зээлийн гэрээний үүргээ зөрчсөн, зээл, зээлийн хүүгийн гөлбөрийг зээлийн гэрээний хавсралтад заасан хугацаанд зээлийг эргэн толоогүй, эсхүл зээлийн гэрээний хугацаа дуусгавар болсон бол барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулна.

Барьцааны гэрээ: Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор 2017.12.06-ны өдөр 2017/Ү/01 тоот Барьцааны гэрээг байгуулсан. Энэхүү гэрээг бичгээр байгуулан эрх бүхий этгээдүүд тарын үсэг зурж баталгаажуулсан байгаа нь Иргэний хуулийн 156.1-д заасан "барьцааны гэрээг бичгээр байгуулах" шаардлагыг хангасан байна.

Мал хамгаалах сангаас 2018.05.02-ны өдөр ирүүлсэн 30 тоот тодорхойлолтын дагуу 2018.05.02-ны өдрийн байдлаар 600,000,000 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байх ба зээлийн "хэвийн" ангилалд хамаарч байна.

Үйлчилгээний гэрээ. Түмэн шувуут нь tumenshuvuut.mn домэйн нэрийг ашиглах, гөлбөр тооцоотой холбогдох харилцааг 2012.01.04-ний өдөр "Мобинет" ХХК-тай байгуулсан 23148501 тоот "Домэйн нэр эзэмшүүлэх, веб хостинг үйлчилгээний гэрээ" (Хавсралт 4.4)-ээр зохицуулагдаж байна. Дээрх гэрээний дагуу Мобинет нь Түмэн шувуутын домэйн нэрийг худалдан авч өгөх, веб хостинг үйлчилгээг үзүүлэхээр тохиролцсон.



MDSKhanLex

Тэжээл бэлтгэн нийлүүлэх гэрээ. Түмэн шувуут нь нийт 4,000,000 ам.долларын үнийн дүнгэй эрдэнэ шиш, тэжээл тэргийг 2018.12.31-ний өдрийг хүртэл 100% урьдчилгаа төлбөр хийх нөхцөлөөр ОХУ-аас тогтмол худалдан авах, түүнтэй холбоотой төлбөр тооцоотой холбогдох харилцааг 2018.01.01-ний өдөр ОХУ-ын хуулийн этгээд "Янта-Г" ХХК-тай байгуулсан 496/71782727/0418 тоот гэрээ (**Хавсралт 4.5**)-ээр зохицуулдаг байна. Энэхүү гэрээний дагуу Түмэн шувуут нь сар бүрийн 20-ны дотор Янта-Г-д худалдан авах барааны захиалгыг өгөх ба гухай бүр үнэ, барааны нэр, барааны чанар, нөхцөл зэргийг Хавсралтуудаар тодорхойлохоор тохиролцсон байна. Энэхүү гэрээг талууд 2 хувь орос хэл дээр, ОХУ-ын хуулийн дагуу байгуулжээ. Энэхүү гэрээтэй холбоотой аливаа үл ойлголцол, маргаан гарсан тохиолдолд Эрхүүгийн Арбитрын шүүхээр маргааныг шийдвэрлүүлэхээр тохиролцжээ. Түмэн шувуутын Гүйцэтгэх захирлын 2018.06.06-ны өдрийн 230/2018 тоот албан бичигт дурдсанаар Түмэн шувуут нь Янта-Г ХХК-тай 2015 оноос хойш хамтран ажиллаж байгаа бөгөөд хамтын ажиллагааны хугацаанд гэрээний нөхцөлийн дагуу Түмэн шувуут урьдчилан захиалга өгч, төлбөрөө төлсний дараа нийлүүлэгч ачилт хийж заншсан, Янта-Г ХХК-ийн зүгээс төлбөр төлсний дараа ачилт хийх хугацааг хожимдуулж, гэрээний зорчил гаргаж байгаагүй байна.

Худалдааны хамтын ажиллагааны гэрээ. Түмэн шувуут нь эрүүл ахуй, чанар, стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг 2019.01.23-ны өдрийг хүртэл хамгийн хямд үнээр нийлүүлэх, Миний дэлгүүр нь нийлүүлсэн барааг борлуулах, борлуулалтын дараа төлбөр тооцоо хийх, талуудын эрх үүрэг, хариуцлага тэдгээртэй холбогсон бусад харилцааг "Миний дэлгүүр" ХХК-тай 2018.01.23-ны өдөр байгуулсан ИГ-Г-17 тоот "Худалдааны хамтын ажиллагааны үндсэн гэрээ" (**Хавсралт 4.6**)-ээр зохицуулдаг байна. Миний дэлгүүр барааны хугацаа дуусахаас өмнө Түмэн шувуутад мэдэгдэх ба Түмэн шувуут нь өөрийн зардлаар барааг буцаан гагахаар зохицуулсан байна.

Бараа худалдах, худалдан авах гэрээ. Түмэн шувуут нь өөрийн барааг супермаркет, бөөний төвд худаллаалах, борлуулагч барааг хүлээн авч борлуулан, борлогдсон дүнгээр үнийг төлөлтэй холбогдсон харилцааг 2017.02.01-ний өдөр Моннилер ХХК-тай байгуулсан ИГ/22-53 тоот гэрээ (**Хавсралт 4.7**)-ээр зохицуулсан байна. Гэрээний дагуу Түмэн шувуут нь нийлүүлсэн барааны үнийн дүнгээс [redacted] борлуулагчид төлбөр тооцоо хийхдээ суутгаж өгөхөөр тохиролцсон байна. Борлуулагч нь барааг хугацаа дуусахаас 10 хоногийн өмнө лангуунаас буулгаж агуулахад хадгална. Буцаах мэдэгдэлд заасан хугацаанд барааг буцаан аваагүйгээс барааны хугацаа дууссантай холбоотой хохирлыг Түмэн шувуут хариуцахаар зохицуулжээ.

Хөдөлмөрийн болон Нууцлалын гэрээний загваруудыг (**Хавсралт 4.8, 4.9**) хянасан бөгөөд хөдөлмөрийн гэрээ нь Хөдөлмөрийн гухай хуулийн 21-р зүйлд заасан гэрээнд тусгах гол нөхцөлүүд болох ажлын байрны буюу албан тушаалын нэр, ажлын байрны тодорхойлтод заасан ажил, үүрэг, үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээ, хөдөлмөрийн нөхцөлийг тусгасан бөгөөд Хөдөлмөрийн гухай хуульд нийцсэн байна.

Бид Түмэн шувуутын бусадтай байгуулсан худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн зэрэг үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой гэрээнүүдийг авч үзсэн бөгөөд тэдгээр нь хууль тогтоомжид нийцэж байгаа бөгөөд дүгнэлт гаргах өдрийн байдлаар компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсээгүй байна.




MDSKhanLex

Андеррайтерийн гэрээ. Түмэн шувуутын энгийн хувьцааг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Хөрөнгийн биржид бүртгүүлж, олон нийтэд нээлтэй арилжаалах үйл ажиллагаанд Андеррайтерийн үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3-т заасан хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах нөхцөлөөр үзүүлэх. Түмэн шувуут нь хүлээн авсан үйлчилгээний хөлсийг гэрээнд заасны дагуу төлөхтэй холбоотой харилцааг Түмэн шувуутын "Голомт Капитал ҮЦК" ХХК-тай 2018.04.11-ний өдөр байгуулсан 18/014 тоот "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 4.10)-г Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.1-д заасны дагуу байгуулж талуудын харилцааг зохицуулсан байна.

Аудитын үйлчилгээний гэрээ. Иргэний хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Аудитын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, дүрэм, заавар, олон улсын хэмжээнд мөрддөг санхүүгийн тайлагналын болон аудитын стандартын дагуу Түмэн шувуутын санхүүгийн тайланд аудит хийж, тайланд дүгнэлт гаргахтай холбоотой харилцааг Түмэн шувуутын "Улаанбаатар Аудит корпораци" ХХК-тай 2018.04.11-ний өдөр байгуулсан 2018/33 тоот "Аудитын үйлчилгээний гэрээ" (Хавсралт 4.11)-ээр зохицуулсан байна. Уг гэрээнд талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлага, ажлын хүрээ, гүйцэтгэх хугацаа, хөлс, үр дүнг хүлээлгэн өгөх, гэрээг дуусгавар болгох журмыг тусгасан нь Аудитын тухай хуулийн 13-т заасан шаардлагад нийцсэн байна.

Хөрөнгө үнэлгээний ажлын гэрээ. Түмэн шувуутын Хөрөнгийн болон Бизнесийн зах зээлийн үнийг өнөөгийн байдлаар тогтоохтой холбоотой харилцааг Түмэн шувуутын "Итгэлт Эстимэйт" ХХК-тай 2018.04.11-ний өдөр байгуулсан 18/02 тоот "Хөрөнгө үнэлгээний ажлын гэрээ" (Хавсралт 4.12)-ээр зохицуулсан байна. Уг гэрээнд хөрөнгийн үнэлгээний зориулалт, хөрөнгийн үнэлгээний зүйл, түүний шинж, талуудын эрх үүрэг, үнэлгээчний хариуцлагын даатгалд даатгуулсан тухай мэдээлэл, талуудын эрх үүрэг, хөрөнгийн үнэлгээний хөлс, хөрөнгийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгөх журмыг тусгасан нь Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 6-д заасан шаардлагад нийцсэн байна.






MDSKhanLex

5. Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан зох.

Түмэн шувуутын 2018.01.01-ний өдөр ОХУ-ын хуулийн этгээд “Янта-Г” ХХК-тай байгуулсан 496/71782727/0418 тоот гэрээ нь Компанийн тухай хуулийн 87.1-д заасан их хэмжээний хэлцэлд хамаарч байх тул Компанийн тухай хуулийн 88.1-д заасны дагуу гэрээ байгуулах шийдвэрийг Түмэн шувуутын ХЭХ санал нэгтгэйгээр гаргасан байх шаардлагатай. Түмэн шувуутын ХЭХ-ын 2017.12.19-ний өдрийн хурлаар Мал хамгаалах сангаас 1 тэрбум төгрөгийг 9 сарын хугацаатай эзлэх асуудлыг хэлэлцэж санал нэгтгэйгээр дэмжиж, 2017.12.19-ний өдөр 01/63 тоот “Их хэмжээний хэлцэл хийх тухай” тогтоол (Хавсралт 5.1) гаргасан байгаа нь Компанийн тухай хууль болон Иргэний хуульд нийцсэн байна.

Сонирхлын зөрчилтэй хэлцлийг Компанийн тухай хуулийн 89.1-р заалтаар тодорхойлсон байдаг ба Түмэн шувуутын Гүйцэтгэх захирлын 2018.06.06-ны өдрийн 230/2018 тоот Баталгааны (Хавсралт 5.2) дагуу тус компанийн хувьд дүгнэлт гаргах өдрийн байдлаар сүүлийн 3 жилийн дотор байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцэл байхгүй болно.



MDSKhanLex


6. Үйл ажиллагааны гол үндэстэд бэлтгэл ажилла тусгай зөвшөөрөл, лиценз, зөвшөөрлийн эрх, патент, бараа, үйлчилгээний гэмтлэг нь хүчин төгөлдөр бусад эрхийн хугацааг дуусгах, шатаагдах, баринаамааг зах зургаар үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох нөхцөл байдал эсэх

Түмэн шувуутын эрхэлж байгаа, түүний дүрэмд заасан тухна шувууны аж ахуй, машины тэжээлийн үйлдвэрлэл, худалдаа, өндөгний сав баглааны үйлдвэрлэл, худалдаа, тахианы мах боловсруулах үйлдвэрлэл, худалдаа, гадаад дотоод худалдаа эрхлэхэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар тусгай зөвшөөрөл авах шаардлага тавигддаггүй боловч "Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч"-ийн хувьд Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиар тодорхой үүрэг хүлээдэг. Энэ талаар энэхүү гайлангийн төгсгөлд авч үзэх болно.

Харин Түмэн шувуут нь Үржлийн тахиа, дэгдээхэй, үржлийн өндөг импортлох тусгай зөвшөөрлийг 2014.09.16-ны өдөр Монгол Улсын Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014.09.16-ны өдрийн А/342 тоот тушаалыг үндэслэн 2014.07.0 дугаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл (Хавсралт 6.1)-ийг 3 жилийн хугацаатайгаар авсан байна. Тус тусгай зөвшөөрлийг 2017.09.15-ны өдөр Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А426 тоот тушаалаар 2017.09.15-ны өдрөөс эхлэн дахин 3 жилийн хугацаатайгаар буюу 2020.09.14-ны өдрийг хүртэл сунгасан байна. Энэхүү тусгай зөвшөөрөл нь Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.11.7-р заалтад нийцэж байна.

Мөн Малын эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрлийг 2011.12.30-ны өдөр Монгол Улсын Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2011.12.30-ны өдрийн А369 тоот тушаалыг үндэслэн 56 дугаар Аж ахуйн үйл ажиллагааны зөвшөөрөл (Хавсралт 6.2)-ийг 3 жилийн хугацаатайгаар авсан байна. Тус зөвшөөрлийг 2015 оны А213 тоот тушаалаар 2015.06.02-ны өдрөөс эхлэн дахин 3 жилийн хугацаатайгаар буюу 2018.06.01-ний өдрийг хүртэл сунгасан байна. Түмэн шувуут нь 2018.05.16-ны өдрийн 207/2018 тоот албан бичгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд Малын эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрлийг сунгуулах хүсэлтээ (Хавсралт 6.3) өгсөн болно. Энэхүү тусгай зөвшөөрөл нь Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.11.4-р заалтад нийцэж байна.

Түмэн шувуутын нэр дээр байх дээрх Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлүүд нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчинтэй бөгөөд тэдгээрийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүсээгүй, тэдгээрийг эзэмших хугацаанд тэдгээртэй холбоотой ямар нэгэн зөрчил илэрч байгаагүй бөгөөд үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлж болох нөхцөл байдал үүсээгүй байна. Түмэн шувуутын Гүйцэтгэх захирлын 2018.06.06-ны өдрийн 230/2018 тоот баталгаанд дурдсанаар тусгай зөвшөөрлийг эзэмших хугацаанд тэдгээртэй холбоотой аливаа зөрчил гаргаж байгаагүй, тэдгээрийг түдгэлзүүлэх хүчингүй болгох нөхцөл байдал үүсээгүй болно.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИЛЭЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга



Оюуны өмч, улсын бүртгэлийн Ерөнхий газраас 2018.05.09-ний өдөр ирүүлсэн 10/3817 тоот Тодорхойлолт (Хавсралт 6.4)-ын дагуу Түмэн шувуут нь аливаа зохиогчийн эрх, барааны тэмдэг, патент эзэмшдэггүй болно.



MDSKhanLex

7. Үнэт цаас, үзэхэд нух болон бусад өс хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр зөх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээн зөх

Үнэт цаас. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2018.06.07-ны өдрийн 01/1401 дугаартай албан бичгээр ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа (**Хавсралт 7.1**)-аар Түмэн шувуут нь “Усжуулах” ХК (Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 1510001014, Р.Д.2001314)-ийн 394,833 ширхэг буюу нийн энгийн хувьцааны 80,69 хувийг эзэмшиж байна.

Охин компани болох “Усжуулах” ХК-ийн талаар. Усжуулах хувьцаат компани нь Түмэн шувуутын 80,69 хувийн хөрөнгө оруулалттай охин компани болно. Тус компанийн Гүйцэтгэх захирлаар Усжуулах ХК-ийн ТУЗ-ийн 2017.11.14-ний өдрийн 17/02 тоот тогтоол (**Хавсралт 7.6**)-ын дагуу Балай овогтой Ундрахыг томилон ажиллуулж байна.

Усжуулах ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2017.10.17-ны өдрийн 2017/01 тоот тогтоол (**Хавсралт 7.7**)-ын дагуу ТУЗ нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:



1. Л.Эрхэмбаяр – ТУЗ-ийн дарга
2. Б.Тунгалаг – ТУЗ-ийн гишүүн
3. М.Баяржаргал - ТУЗ-ийн гишүүн
4. Ж.Болд - ТУЗ-ийн гишүүн
5. Л.Отгонбаяр - ТУЗ-ийн гишүүн
6. Ж.Ганболд - ТУЗ-ийн гишүүн
7. З.Шагдарсүрэн - ТУЗ-ийн хараат бус гишүүн
8. М.Мандах - ТУЗ-ийн хараат бус гишүүн
9. Б.Бархасбадь - ТУЗ-ийн хараат гишүүн

Усжуулах ХК-ийн ТУЗ Компанийн тухай хуулийн 60.1, 60.2, 76.1.2, 76.1.3 дахь хэсэгт зөвхөн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2018.07.05-ны өдрийн 10 цагт хуралдуулахаар зарлаж, Санхүүгийн юхицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Биржид 2018.05.28-ны өдөр мэдэгдэл хүргүүлсэн байна. Тус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэхээр болсон байна. Үүнд:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах төвлөлийн дүгнэлт;
2. Нөгдөл ашгийн тухай;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн тухай;
4. “Усжуулах” ХК-ийг “Усжуулах” ХХК болгон өөрчлөх төсөл;
5. Компанийн нэгж хувьцааг худалдан авах үнийг тогтоох тухай.

Газар эзэмших эрх. Түмэн шувуутаас өгсөн мэдээллийн дагуу болон Нийслэлийн газрын албаны 2018.04.27-ны өдрийн 02-06/2127 тоот лавлагааны (**Хавсралт 7.8**) дагуу Түмэн шувуут нь доорх газруудыг эзэмшдэг болно. Үүнд:





MDSKhanLex

№	Нэгж галбарын дугаар	Газрын зориулалт	Байршил	Газрын хэмжээ мкв, эсхүл м2-аар	Газрын гэрчилгээний дугаар /Хавсралт №	Газрын талбэрийн эмгээг, жилээр	Барьцаалагчдын эсвэл
1.	80435425	Аж ахуй	ХУД, 13-р хороо	47434	0232077/ Хавсралт 7.9	379,472	Мал хамгаалах санд байгуулсан 2017.01 тоот барьцааны гэрээ
2.	1780410194 186172910886 78	Аж ахуй	ХУД, 13-р хороо	35291	000321350/ Хавсралт 7.10	35,291	Хас банктай байгуулсан БТ154000000645-01 тоот барьцааны гэрээ
3.	1780410300	Үйлдвэрлэл	ХУД, 13-р хороо	12362	0293177/ Хавсралт 7.11	12,362	Хас банктай байгуулсан БТ154000000645-01 тоот барьцааны гэрээ
4.	187980112 186153249013 68	Тэжээлийн үйлдвэр	СХД, 21-р хороо	50000	000316727/ Хавсралт 7.12	200,000	Хас банктай байгуулсан БТ154000000645-01 тоот барьцааны гэрээ
5.	186153248410 66	Тэжээлийн үйлдвэр /рашаант өртөө	СХД, 21-р хороо	100000	000314593/ Хавсралт 7.13	400,000	Мал хамгаалах санд байгуулсан 2017.01 тоот барьцааны гэрээ
6.	18450046 186353112477 31	Аж ахуй	СХД, 27-р хороо	4493	000323509/ Хавсралт 7.14	395,384	
7.	1780410290 186172910677 80	Аж ахуй	ХУД, 13-р хороо	13283	000318332/ Хавсралт 7.15	106,264	
8.	1780410289 186172910677 81	Аж ахуй	ХУД, 13-р хороо	35755	000318333/ Хавсралт 7.16	286,040	Хас банктай байгуулсан БТ154000000645-01 тоот барьцааны гэрээ


Газрын төлбөр. Түмэн шувуутын бидэнд гаргаж өгсөн баримтуудаас үзвэл газрын төлбөрийг дараах байдлаар төлсөн байна. Үүнд:

- ✓ 2017.03.26-ны өдөр 3,397,872 төгрөг (Хавсралт 7.17)
- ✓ 2017.07.28-ны өдөр 98,896 төгрөг (Хавсралт 7.18)
- ✓ 2017.08.01-ний өдөр 282,328 төгрөг (Хавсралт 7.19)
- ✓ 2017.09.25-ны өдөр 2,759,932 төгрөг (Хавсралт 7.20)


Түмэн шувуутын эзэмшдэг дээрх нийт 8 газраас хүснэгтийн 6, 7-д дурдсан газруудаас бусад газрууд нь эзлийн гэрээний үүргийг хангуулах зорилгоор Хас банк болон Мал хамгаалах санд тус тус барьцаалагдсан байна. Итгэлт Эстимэйт ХХК-ийн 2018.05.25-ны өдөр хийж гүйцэтгэсэн "Үнэлгээний ажлын тайлан"-д дээрх хүснэгтэд дурдсан бүх газруудыг тусгаж үнэлгээ гаргасан байна.

Үл хөдлөх эд хоронгов. Түмэн шувуутаас өгсөн мэдээллийн дагуу болон Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Эд хөрөнгийн бүртгэлийн газрын 2018.05.05-ны өдрийн 1339202 тоот лавлагааны (Хавсралт 7.21) дагуу Түмэн шувуут нь доорх үл хөдлөх эд хөрөнгүүдийг эзэмшдэг болно. Үүнд:





Үнэт цаасны танилцуулга



№	Утсын бүртгэлийн дугаар	Үл хөдлөх дэ хөрөнгийн зориулалт	Байршил	Хэмжээ мкв-аар	Гэрчилгээний дугаар/Хавсралт №	Үзэлийн Гэрээний дагуу Барьцалалт дотор нэвч
1.	У-2201052334	Агуулах	СХД, 27-р хороо, 21-р хороолол, 1808.2, 59-1 тоот	360	000605033/ Хавсралт 7.22	Мал хамгаалах сантай байгуулсан 2017/У-01 тоот барьцалалт гэрээ
2.	У-2206054722	Үйлдвэрлэл	ХУД, 13-р хороо, Шувуун фабрикийн зам гудамж, Ф378.2	1589	000619349/ Хавсралт 7.23	Хас бөмбөрцөг байгуулсан БГ 15400000645-01 тоот барьцалалт гэрээ
3.	У-2206053158	Үйлдвэрлэл	ХУД, 13-р хороо, Шувуун фабрикийн зам гудамж, Ф378.1	1275	000601711/ Хавсралт 7.24	
4.	У-2206055214	Үйлдвэрлэл	ХУД, 13-р хороо, Шувуун фабрик, 55.5 тоот	747	000353685/ Хавсралт 7.25	Мал хамгаалах сантай байгуулсан 2017/У-01 тоот барьцалалт гэрээ
5.	У-2206055215	Үйлдвэрлэл	ХУД, 13-р хороо, Шувуун фабрик, 55.4 тоот	328	000353686/ Хавсралт 7.26	Мал хамгаалах сантай байгуулсан 2017/У-01 тоот барьцалалт гэрээ
6.	У-2206024431	Агуулах	ХУД, 13-р хороо, Шувуун фабрик, 58.3 тоот	216	000249812/ Хавсралт 7.27	Мал хамгаалах сантай байгуулсан 2017/У-01 тоот барьцалалт гэрээ
7.	У-2206011652	Комгор	ХУД, 13-р хороо, Шувуун фабрик, 376.1 тоот	286	000451479/ Хавсралт 7.28	
8.	У-2206024430	Үйлдвэрлэл	ХУД, 13-р хороо, Шувуун фабрик, 56 тоот	432	000450686/ Хавсралт 7.29	
9.	У-2206004020	Үйлдвэрлэл	ХУД, 13-р хороо, Шувуун фабрик, 376.4 тоот	1132	000451496/ Хавсралт 7.30	
10.	У-2206004021	Үйлдвэрлэл	ХУД, 13-р хороо, Шувуун фабрик, 376.3 тоот	1238	000451402/ Хавсралт 7.31	
11.	У-2206007054	Үйлдвэрлэл	ХУД, 13-р хороо, Шувуун фабрик, 56 тоот	3954	000168862/ Хавсралт 7.32	
12.	У-2206006066	Үйлдвэрлэл	ХУД, 13-р хороо, Шувуун фабрик, 376.2 тоот	1307	000451497/ Хавсралт 7.33	
13.	У-2206017949	Агуулах	ХУД, 13-р хороо, Шувуун фабрик, 376.5 тоот	945.5	000451401/ Хавсралт 7.34	
14.	У-2206007469	Үйлдвэрлэл	ХУД, 13-р хороо, Туул 5 Б хэсэг, 372/17, 372/17 А	1595	000187979/ Хавсралт 7.35	
15.	У-2206017873	Хувийн сууц	ХУД, 13-р хороо, Шувуун фабрик, 67	176	000451495/ Хавсралт 7.36	
16.	У-2201007750	Үйлчилгээ	СХД, 27-р хороо, 21-р хороолол, 59	1013.2	000465728/ Хавсралт 7.37	

Түмэн шувуутын эзэмшдэг дээрх нийт 16 үл хөдлөх хөрөнгөөс хүснэгтийн 1, 2, 4, 5, 6-д дурдсан үл хөдлөх хөрөнүүд нь үзэлийн гэрээний үүргийг хангуулах зорилгоор бусдад






MDSKhanLex

барьцаалагдсан байна. Итгэлт Эстимэйт ХХК-ийн 2018.05.25-ны өдөр хийж гүйцэтгэсэн “Үнэлгээний ажлын тайлан”-д дээрх хүснэгтэд дурдсан үл хөдлөх хөрөншүүдийг бүгдийг нь тусгаж үнэлгээ гаргасан байна.

Түмэн шувуутанс өгсөн мэдээллийн дагуу тус компани нь дараах тээврийн хэрэгслийг өмчилдөг бөгөөд тус тээврийн хэрэгслийг даатгалд хамруулсан байна. Үүнд:

№	Тээврийн хэрэгслийн улсын дугаар	Марк/ өнгө	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ	Хавсралт дугаар
1.	1582У111	Kia Bongo frontier/ цагаан	2017.11.10-ны Монгол даатгалын 26С1720001086 тоот гэрээ	Хавсралт 7.38
2.	1140УБД	Kia Bongo 3/ цагаан	2017.10.17-ны Монгол даатгалын 17045201041892 тоот гэрээ	Хавсралт 7.39
3.	4346УБЧ	Hyundai Porter/ цагаан	2017.06.15-ны Монгол даатгалын 17042402502192 тоот гэрээ	Хавсралт 7.40
4.	4574У113	Hyundai Porter/ цагаан	2017.11.10-ны Монгол даатгалын 17042600506192 тоот гэрээ	Хавсралт 7.41
5.	5522У110	Toyota Camry/ хар	2017.11.10-ны Монгол даатгалын 17042600506352 тоот гэрээ	Хавсралт 7.42
6.	6187УНӨ	Kia Bongo frontier/ цагаан	2018.05.23-ны Монгол даатгалын 18042300604512 тоот гэрээ	Хавсралт 7.43
7.	6194У119	Kia Bongo 3/ цагаан	2017.09.11-ний Монгол даатгалын 17045201037842 тоот гэрээ	Хавсралт 7.44
8.	6236У114	Hyundai Porter/ цагаан	2017.09.11-ний Монгол даатгалын 17045201037892 тоот гэрээ	Хавсралт 7.45
9.	9701У11Х	Hyundai Grace/ мөнгөлөг саарал	2017.11.10-ны Монгол даатгалын 17045201037892 тоот гэрээ	Хавсралт 7.46
10.	9068УНН	Kia Bongo frontier/ цагаан	2017.11.10-ны Монгол даатгалын 17042600506202 тоот гэрээ	Хавсралт 7.47
11.	3489УНЦ	Kia frontier/ цагаан	2017.11.10-ны Монгол даатгалын 17042600506222 тоот гэрээ	Хавсралт 7.48


Түмэн шувуут нь Усжуулах ХК-ийн 80,69 хувийг эзэмшдэг. Тэр дурдсан 8 нэгж талбар бүхий газар эзэмших эрхтэй, 16 үл хөдлөх эд хөрөнгө буюу барилга объект өмчлөх эрхтэй, дүгнэлт гаргах өдрийн байдлаар газар эзэмших эрхүүд болон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхүүд нь хүчин тоголдоор байна. Тус компанийн эзэмшлийн 6 нэгж талбар бүхий газар



MDSKhanLex

Эзэмших эрх, өмчлөлийн 5 үл хөдлөх эд хөрөнгө буюу барилга объект нь банкны, эсхүл мал хамгаалах сангийн зээлийн барьцаанд байна. Мөн Түмэн шувуут нь 11 тээврийн хэрэгсэлтэй бөгөөд тус бүрийг жолоочийн хармуцлагын албан журмын даатгалд хамруулсан ба дүтгэлт гаргах өдрийн байдлаар тус даатгалын гэрээнүүд хүчин төгөлдөр байна.





MDSKhanLex

8. Үнэт цаас бүртгүүлдх өрнөлт, татан буулгах зөвлөлийн мэдээлэл нь, хурин төрөл бүр баримтаар шийдвэрлэж байгаа үзэх.

Түмэн шувуутын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2018.06.07-ны өдрийн Хувьцаа нэмж гаргах, хувьцаагаа анх удаа нийтэд санал болгох тухай 05/2018 дугаартай тогтоол (Хавсралт 8.1)-оор доорх асуудлуудыг шийдвэрлэсэн байна. Үүнд:

Нэг. Компанийн одоо гаргасан байгаа нэг бүр нь 20 (Хорин) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 150,000,000 (нэг зуун тавин сая) ширхэг энгийн хувьцаан дээр нэмж, компанийн нийт хувьцааны 25 (Хорин таван) хувьтай тэнцэх 50,000,000 (Тавин сая) ширхэг энгийн хувьцааг нэмж гаргах;

Хоёр. Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн одоогийн хувьцаа эзэмшигч нар нэмж гаргах хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхээ бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэхгүй байх;

Гурав. Компанийн нэмж гаргасан хувьцааны олон нийтэд санал болгох нэг бүрийн үнийг 200 (Хоёр зуун) төгрөгөөр тогтоож, Монголын хөрөнгийн биржийн хувьцааны хоёрдугаар ангиллаар тогтоосон үнийг аргаар анхдагч зах зээлийн арилжаагаар нийтэд санал болгох; **Дөрөв.** Анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулсны дүнд одоогийн хувьцаа эзэмшигчид болон олон нийтийн эзэмших хувь дараах байдалтай болох. Үүнд:

Хувьцаа эзэмшигч	Хувьцаа гаргахээс өмнө		Хувьцаа гаргасны дараа	
	Эзэмшж буй хувьцааны тоо	Эзэмшлийн хувь	Эзэмшж буй хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
Л.Эрээбийяр	60,000,000	40 %	60,000,000	30 %
Б.Тунгалаг	60,000,000	40 %	60,000,000	30 %
Э.Баярцэцэгэл	15,000,000	10 %	15,000,000	7,5 %
Ж.Болд	15,000,000	10 %	15,000,000	7,5 %
Олон нийт	-	-	50,000,000	25%
	150,000,000	100%		
Хувьцаа гаргасны дараа нийт дүн			200,000,000	100%

Тав. Анхдагч зах зээлийн арилжаагаар олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нь 10,000,000,000 (Арван тэрбум) төгрөг байхаар тогтоож, уг монгол хөрөнгийг Үнэт цаасны танилцуулгал дурдсан зориулалтаар зарцуулах;

Зургаа. Хувьцааг олон нийтэд санал болгон амжилттай арилжсаны дараа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэх Хувьцааг компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлах бусад дүрэм, журмын төслийг дэмжиж, хувьцаагаа Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэх талаар мэргэжлийн байгууллагуудтай шуурхай хамтран ажиллаж, хувьцаа эзэмшигчдийг холбогдох мэдээллээр хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгохоор тус тус шийдвэрлэжээ.

Энэхүү тогтоол нь Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.4 дэх заалт,




MDSKhanLex

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Түмэн шувуутын дүрмийн 6.2 дахь заалтад нийцсэн байна.

Тус компанийн нийтэд ил болсон мэдээлэл, төрийн болон бусад эрх бүхий байгууллагаас гаргуулсан, компани, түүний холбогдох этгээд болон гуравдагч этгээдээс гаргуулсан мэдээллүүдийг шинжилжээний үндсэн дээр Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгасан мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байна гэж дүгнэв.





Үнэт цаасны танилцуулга



MDSKhanLex

9. Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд нь хийн болох

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын улсын бүртгэлийн тов архивын газраас 2018.04.26-ны өдөр 002885909 тоот албан бичгээр ирүүлсэн Түмэн шувуутын хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа (**Хаявсрэлт 9.1**)-с тус өдрийн байдлаар гаргуулан судлав. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Түмэн шувуутын нийт энгийн хувьцааны 40 хувийг Ломбын Эрхэмбаяр, 40 хувийг Балайн Тунгалаг, 10 хувийг Эрхэмбаярын Баяржаргал, 10 хувийг Жигжидын Болд тус тус эзэмшиж байна. Эдгээр хувьцаа эзэмшигчдийн анкет, нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдэгдлээс үзвэл Л.Эрхэмбаяр нь Б.Тунгалагийн эхнэр, Э.Баяржаргал нь Л.Эрхэмбаярын охин, Ж.Болд нь Э.Баяржаргалын нөхөр юм. Л.Эрхэмбаяр нь тус компанийн үүсгэн байгуулагч, бизнесийн байгууллагын төдийгүй, төрийн байгууллага (Архангай аймгийн Засаг дарга, ЗГХЭГ-ын референт, Ерөнхийлөгчийн зөвлөх), улс төрийн намын удирдах албан тушаалд ажиллаж байсан, удирдах, манлайлах арга барил эзэмшсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

Дээр дурдсаныг үндэслэн энэхүү хуулийн дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар С.Эрхэмбаяр, Б.Тунгалаг, Ж.Болд, Э.Баяржаргал нар нь Түмэн шувуутын жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгч хэмээн тодорхойлож байна.





10. Тухайн компанийн улсын бүртгэл, тагвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх болон нэмэлт шинжилгээ, судалгаа

Түмэн шувуут нь 2018.04.25-ны өдрийн байдлаар Гаалийн байгууллагад татварын өргүй (**Хавсралт 10.1**), 2018.05.09-ний өдрийн байдлаар Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагад нийгмийн даатгалын шимтгэлийн 22,145,047.16 төгрөгийн өглөгтэй (**Хавсралт 10.2**), 2018.04.29-ний өдрийн байдлаар Татварын байгууллагад 90,743,272.80 төгрөгийн дутуу төлөлттэй (**Хавсралт 10.3**) байна.

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Түмэн шувуутад татварын дутуу төлөлттэй холбоотой нөхөн татвар, торгууль, алданги омогдуулаагүй байна.







11. Тухайн компанийн эрх зүй үйл ажиллагааны нийцэл (compliance)-ийн талаар хийсэн зарим нэмэлт судалгааг үнэмжлэгтэй

Бид Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны болон МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын зохицуулалтаас гадна хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад ач холбогдолтой гэж үзэн хөндлөнгийн мэдээлэл (**Хавсралт-11.1-11.14**) цуглуулж, тус компанитай холбоотой дараах нөхцөл байдлуудыг тогтоосон болно. Үүнд:

- Төрийн банкнаас 2018.05.02-ны өдөр гаргасан Тодорхойлолт №18/116-д тусгаснаар Түмэн шувуут нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар тус банкинд зээлийн өр төлбөргүй байна;
- Голomt банкнаас 2018.05.03-ны өдөр гаргасан Тодорхойлолт №10-2/337-д тусгаснаар Түмэн шувуут нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар тус банкинд зээл болон хүүгийн өр төлбөргүй байна;
- Хас банкнаас 2018.05.01-ний өдөр гаргасан Тодорхойлолт №09/416-д тусгаснаар Түмэн шувуут нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар тус банкинд хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өр төлбөргүй байна;
- Хаан банкнаас 2018.04.30-ны өдөр гаргасан Тодорхойлолт №20180501041-д тусгаснаар Түмэн шувуут нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар тус банкинд зээл болон хүүгийн өр төлбөргүй байна;
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2018.05.02-ны өдөр гаргасан Тодорхойлолт №1/258-9-д тусгаснаар Түмэн шувуут нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар тус сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж байгаагүй;
- Мал хамгаалах сангаас 2018.05.02-ны өдөр гаргасан Тодорхойлолт №30-д тусгаснаар Түмэн шувуут нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар тус санд хугацаа хэтэрсэн зээлгүй байна;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 2018.05.02-ны өдөр Тодорхойлолт №181-д тусгаснаар Түмэн шувуут нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар тус санд зээлийн өр төлбөрийн үлдэгдэлгүй байна;
- Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрын 2018.04.25-ны өдөр гаргасан Тодорхойлолт №4/392-д тусгаснаар Түмэн шувуут нь сүүлийн гураван жилийн байдлаар арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравлагч этгээдээр оролцоогүй байна;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий Газрын Шийдвэр гүйцэтгэх албанаас 2018.04.24-ны өдөр гаргасан Тодорхойлолт №0015568-д Түмэн шувуут нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй байна;
- Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Шүүхийн Төрөлжсөн Архиваас 2018.04.26-ны өдөр гаргасан Тодорхойлолт №6062-д тусгаснаар Түмэн шувуут нь Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүдийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт харнуцагчаар оролцож байгаагүй байна;
- Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны Шүүхийн Гамгын Гатраас 2018.04.30-ны өдөр гаргасан Тодорхойлолт №2/2887-д тусгаснаар Түмэн шувуут нь





Үнэт цаасны танилцуулга




MDSKhanLex

захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр сүүлийн 3 жилд оролцож байгаагүй байна;

- Шударга Өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас 2018.05.14-ны өдөр гаргасан Тодорхойлолт №1/699-д тусгаснаар Түмэн шувуут нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар Өрсөлдөөний тухай хуулийг зөрчөөгүй, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас торгууль шийтгэвэр оноглуулж байгаагүй ба давамгай байдалтай аж ахуйн нэгжээр тогтоогдоогүй байна;
- Оюуны өмч, улсын бүртгэлийн Ерөнхий газраас 2018.05.09-ны өдөр гаргасан Тодорхойлолт №10/3817-д тусгаснаар зохиогчийн эрх, барааны гэмдэг, патентын санд хайлт хийхэд Түмэн шувуутын нэр дээр эрхийн хамгаалалт хийгдсэн зүйл байхгүй байна.

Дүгнэлт гаргахад ач холбогдолтой гэж үзэн Усжуулах ХК-тай холбоотой хөндлөнгийн мэдээлэл (**Хавсралт-11.14-11.23**) цуглуулж, тус компанигай холбоотой дарах нөхцөл байдлуудыг тогтоосон болно. Үүнд:

- Төрийн банкнаас 2018.05.02-ны өдөр гаргасан Тодорхойлолт №18/115-д тусгаснаар Усжуулах ХК нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар тус банкинд зээлийн өр төлбөргүй байна;
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2018.05.02-ны өдөр гаргасан Тодорхойлолт №1/258-8-д тусгаснаар Усжуулах ХК нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар тус сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж байгаагүй;
- Хаан банкнаас 2018.05.01-ний өдөр гаргасан Тодорхойлолт №20180501042-д тусгаснаар Усжуулах ХК нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар тус банкинд зээл болон хүүгийн өр төлбөргүй байна;
- Мал хамгаалах сангаас 2018.05.02-ны өдөр гаргасан Тодорхойлолт №31-д тусгаснаар Усжуулах ХК нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар тус санд зээлийн өр, авлагын тооцоогүй болно;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 2018.05.02-ны өдөр Тодорхойлолт №181-д тусгаснаар Түмэн шувуут нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар тус санд зээлийн өр төлбөрийн үлдэгдэлгүй байна;
- Гаалийн Ерөнхий газраас 2018.04.25-ны өдөр гаргасан Тодорхойлолт №01-1/1838-д тусгаснаар Усжуулах ХК нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар гаалийн байгууллагад татварын өр төлбөргүй байна;
- "Арилжаа төлбөр тооцоо ҮЦК" ХХК-аас 2018.05.15-ны өдөр гаргасан албан бичигт тусгаснаар Усжуулах ХК нь тус байгууллагад төлбөр тооцооны данс нээлтээгүй бөгөөд ямар нэгэн гэрээ, өр төлбөргүй байна;
- Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрын 2018.04.25-ны өдөр гаргасан Тодорхойлолт №4/393-д тусгаснаар Усжуулах ХК нь сүүлийн гурван жилийн байдлаар арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна;
- Увс аймвг дахь шүүхийн тамгын газраас 2018.04.27-ны өдөр гаргасан Тодорхойлолт №167-д тусгаснаар Усжуулах ХК нь сүүлийн 3 жилийн байдлаар иргэний болон захиргааны хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр болон авилгын асуудлаар шалгагдаж байгаагүй болно;





MDSKhanLex


- Оюуны өмч, улсын бүртгэлийн Ерөнхий газраас 2018.05.09-ны өдөр гаргасан Годорхойлолт №10/3819-д тусгаснаар зохиогчийн эрх, барааны тэмдэг, патентын санд хайлт хийхэд Түмэн шувуутын нэр дээр эрхийн хамгаалалт хийгдсэн зүйл байхгүй.

Түүнчлэн Түмэн шувуутын эрхэлж буй үйл ажиллагаатай холбоотой нэмэлт мэдээлэл авч, хууль зүйн судалгаа шинжилгээ хийж, зарим хуулийн хэрэгжилтийн талаар дараах нөхцөл байдлыг тогтоосон. Үүнд:

Хүнсний тухай хууль (2012). Уг хуулийн 10.1.6-д зааснаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь үйл ажиллагаагаа эхлэхийн өмнө хуульд заасны дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэсэн байх шаардлагатай ба Түмэн шувуут нь 2016.12.14-ний өдөр Нийслэлийн яншиг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчны газраар Сангас боловсруулах цех дээр 2016/146 тоот Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэж, тайлан (**Хавсралт 11-24**) гаргуулсан байна. Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудасны дагуу Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 13-р хороонд байрлах Сангас боловсруулах цех /Үйлдвэр/-т байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийснээр уг төслийг нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн байна.

Мөн тус байгууллагаар 2017.05.03-ны өдөр Агро фийд малын тэжээлийн үйлдвэрийн төсөл дээр 2017/048 тоот Байгаль орчны ерөнхий үнэлгээ (**Хавсралт 11-25**) хийж гүйцэтгүүлсэн байна. Энэхүү үнэлгээний дагуу Сонгинохайрхан дүүрэг, 21-р хороонд байрлах Агро фийд малын тэжээлийн үйлдвэрийн төсөл нь нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг “дунд” зэрэг гэж дүгнэсэн байна. Уг нөлөөллийн үнэлгээнд хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, тогтоосон стандартыг дагаж мөрдөх талаар тодорхой тусгасан байна. Энэхүү үнэлгээ түүний нөхцөлийн талаар Түмэн шувуутын Гүйцэтгэх захирлын 2018.06.06-ны өдрийн 230/2018 тоот албан бичигт: импортыг орлох малын амьтны тэжээл үйлдвэрлэх зориулалтаар 2015 онд хонигт 12-16 тонн тэжээл үйлдвэрлэх хүчин чадал бүхий “Агро фийд” үйлдвэрийг барьж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлүүлсэн. Тус үйлдвэр нь төвийн эрчим хүчээр бүрэн хангагдсан, дулааны өөрийн эх үүсвэртэй, Нийслэлийн байгаль орчны газраар баталгаажуулсан гүний худагтай. Агро фийд тэжээлийн үйлдвэр нь малын болон шувууны тэжээл үйлдвэрлэлд ба өөрийн шувууны аж ахуйн хэрэгцээг хангахаас гадна малчдад зориулан бог, бод малын нийт 6 нэр төрлийн тэжээл үйлдвэрлэж байна. Орчны бохирдлыг багасгах үүднээс үйлдвэрийн орчинд 2017 онд 294 мод тариалсан бол 2018 онд 488 мод шинээр суулгасан гэжээ.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль (2012). Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч уг хуулийн 6.1-д зааснаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн нэр, байршил, хаяг, утас, факсын дугаар, цахим хаяг; хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, иргэний регистрийн дугаар, хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр, дотоод хяналтын журмын талаарх мэдээллийг батлагдсан маягтын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр харьяалах нутаг дэвсгэр дэх хүнсний хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллага /цаашид “хяналтын байгууллага” гэх /-д мэдээлснээр үйл ажиллагаагаа эхлүүлж болно гэж заасан. Мэргэжлийн хяналтын улсын





ахлах байцаагчийн 2015.05.22-ны өдрийн 08/023/303 тоот дүгнэлт (**Хавсралт 11.26**)-д зааснаар Түмэн шувуутын малын эм ханган нийлүүлэх байгууллагын ажлын байр нь холбогдох хууль тогтоомж, стандартын холбогдох шаардлагыг хангасан байна.

Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үүргийг тодорхойлсон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль 10.1-д заасан 10 шаардлагыг хэрхэн хангаж байгааг дотоод хяналт шалгалт хийж байх талаар Дотоод хяналтын журамдаа тусгасан байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуульд зааснаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гарлан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалдааг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг хэдэн ажилтан байдаг. тэдгээр ажилтныг эрүүл ахуй, ариун цэврийн сургалтад хамруулсан, эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулсан байх шаардлагатай байдаг. Түмэн шувуут нь 2017 оны турш ажилчдад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хийх, үзлэг хийх, эмчлэх үйлчилгээ авахаар 2017.04.21-ний өдөр Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн говтэй "Урьдчилан сэргийлэх үзлэг хийх гэрээ" (**Хавсралт 11.27**) байгуулан ажилласан байна. Түмэн шувуут нь энэхүү гэрээний дагуу 2017 онд байгууллагын нийт 60 ажилтныг сүрьеэ, арьсны халдварт өвчнүүд, нян тээгч, хамар залгиурын арчлас, цагаан хорхойн шинжилгээнд хамруулсан байна. Мөн 2018 оны ажилчдын эрүүл мэндийн үзлэг, багц шинжилгээтэй холбоотой үйлчилгээ авахаар Эмчийн Өргөө эмнэлэгтэй 2018.04.17-ны өдөр DBA-HS-18-03 тоот гэрээ (**Хавсралт 11.28**) байгуулсан байна. Энэхүү гэрээний дагуу Түмэн шувуут нь нийт 80 ажилтныг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд 2018 оны 5 дугаар сард хамруулсан байна. Түмэн шувуут ХХК Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулиар хүлээсэн үүргээ тухих ёсоор хэрэгжүүлж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Малын эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагад тавих нийтлэг шаардлага MNS6461:2014 стандартын дагуу 2015.05.20-ны өдөр мал эмнэлгийн улсын ахлах байцаагч, хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын улсын ахлах байцаагч болон малын их эмч нар Түмэн шувуутын малын эм ханган нийлүүлэх байранд хяналт шалгалт хийсэн байна. Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчийн 2015.05.22-ны өдрийн 08/023/303 тоот дүгнэлт (**Хавсралт 11.26**)-д: Түмэн шувуутын малын эм ханган нийлүүлэх байр нь эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, агуулах нь бараа хүлээн авах, хадгалах хэсэг, хадгалалтын онцгой нөхцөл шаарддаг эм, буцаагдсан бараа тэргийг хадгалах зориулалтын өрөөтэй, эм хадгалах тавиур суурь, цахилгаан жин зэрэг нь эм био бэлдмэл хадгалах зориулалтын тохируулгатай хөргөгч, термометр, гигрометр, тоног төхөөрөмжөөр хангагдсан, аюулгүй ажиллагааны зааврыг баримталдаг байна. Шавьжгүйтгэл, мэргэжгүйтгэл, халдваргүйтгэлийг зааврыг дагуу графикт хугацаанд холбогдох байгууллагаар хийлгэдэг, малын эмийн хүчинтэй хугацаа болон чанарын баталгаажуулалтын бүртгэлийг хөтөлж, бүх шатанд хяналт тавих ажлыг малын эмч хариуцан ажиллаж байна. Дээрхээс үндэслэн дүгнэхэд Түмэн шувуутын малын эм ханган



Үнэт цаасны танилцуулга



нийлүүлэх байгууллагын ажлын байр нь холбогдох хууль тогтоомж, стандартын холбогдох шаардлагыг хангасан байна гэж дүгнэсэн.


Үүнээс гадна, Онцгой байдлын газраас 2016.04.11-ны өдөр гаргасан 0015223 тоот “Ажлын байрны аюулгүй байдлын дүгнэлт” (Хансралт 11.29)-д Түмэн шувуутын Агро фийд тэжээлийн үйлдвэр нь гал унтраах тоног төхөөрөмжтэй (гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж), анхан шатны багаж хэрэгсэл, бодис материалтай байна гэжээ.






12. Гол дүгнэлт

“Түмэн шувуут” компанийн Үнэт цаасны танилцуулгад дурдсан мэдээгэл үнэн зөв, хуульд нийцсэн байна. Энэ тухай **Хавсралт 12**-оос үзнэ үү.





MDSKhanLex

13. Хязгаарлалт

Бидний үйлдсэн хууль зүйн дүгнэлтэд дор дурдсан хязгаарлалт хамаарна. Үүнд:

- a) Бид Монгол Улсын хууль тогтоомжоос бусад улсын хууль тогтоомжийг хэрэглээгүй болно.
- b) "Хүчин төгөлдөр", "дагаж мөрдөнө", "хэрэгжинэ" гэдэг нь Монгол Улсын шүүх хэрэгжүүлж болох үүрэг болон нөхцөлүүдийг илэрхийлнэ. Гэхдээ энэ нь бүхий л нөхцөл байдалд хэрэгжих боломжтой гэсэн ойлголт биш болно. Тухайлбал:
 - (i) Гэм хор арилгах, хориг тавих, тусгай гүйцэтгэл, дур зоргоор хандах;
 - (ii) Таган буулгахтай холбоотой хууль болон санхүүжүүлэгчид нөлөөлж болох бусад хуулиудын нөлөөлөл;
 - (iii) залилан, хууран мэхлэх, алдаа, албадлагын, шудрага бус үйл явдал, хууль бус үйлдлийн эсрэг хуулийн нөлөөл.
- c) Энэхүү хууль зүйн дүгнэлт нь Баримт бичигүүд дээр тусгагдсан асуудлуудтай холбоотой бөгөөд тухайн Баримт бичиг дээр тусгагдсан хууль зүйн факт, үйл явдалд хамаарна. Тухайн Баримт бичиг дээр тусгагдсан аливаа үүргийг нэмэгдүүлэх эсхүл бизнесийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй болно.

Бид энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргахдаа гагцхүү Монгол Улсын хууль тогтоомжид холбогдуулан өөрсдийн туршлага, мэргэжлийн ур чадвараа ашигласан бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжид үндэслэсэн болно. Хуулийн фирм нь бусад аливаа улсын хууль тогтоомжийн хүрээнд аливаа үйл явдлын талаар саналаа илэрхийлээгүй болно. Хуулийн фирм нь энэхүү дүгнэлтийг гаргахдаа санхүүгийн, статистикийн, нягтлан бодох бүртгэлийн, үйл ажиллагааны чиглэлийн ямар нэгэн ур чадвар, туршлага ашиглаагүй, эдгээрээс татгалздаг болно.


ХҮНДЭТГЭСЭН.

ПАРТНЕР  Д.ДҮГЭРЖАВ


ПАРТНЕР  Г.БАТЖАРГАЛ

ӨМГӨӨЛЛИЙН "ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН





Үнэт цаасны танилцуулга



MDSKhanLex

13 Хөндөгсөн

Бидний үйлдсэн хууль зүйн дүгнэлтэд дор дурдсан хязгаарлалт хамаарна. Үүнд:

- а) Бид Монгол Улсын хууль тогтоомжоос бусад улсын хууль тогтоомжийг хэрэглээгүй болно.
- б) "хүчин төгөлдөр", "дагаж мөрдөнө", "хэрэгжинэ" гэдэг нь Монгол Улсын шүүх хэрэгжүүлж болох үүрэг болон нөхцөлүүдийг илэрхийлнэ. Гэхдээ энэ нь бүхий л ноцол байдалд хэрэгжих боломжтой гэсэн ойлголт биш болно. Тухайлбал:
 - (i) Гэм хор арилгах, хориг тавих, тусгай гүйцэтгэл, дур зоргоор хандах;
 - (ii) Таган буулгахтай холбоотой хууль болон санхүүжүүлэгчид нөлөөлж болох бусад хуулиудын нөлөөлөл;
 - (iii) залилан, хууран мэхлэх, алдаа, албадлагын, шудрага бус үйл явдал, хууль бус үйлдлийн эсрэг хуулийн нөлөөл.
- в) Энэхүү хууль зүйн дүгнэлт нь Баримт бичгүүд дээр тусгагдсан асуудлуудтай холбоотой бөгөөд тухайн Баримт бичиг дээр тусгагдсан хууль зүйн факт, үйл явдалд хамаарна. Тухайн Баримт бичиг дээр тусгагдсан аливаа үүргийг нэмэгдүүлэх эсхүл бизнесийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй болно.

Бид энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргахдаа гагцхүү Монгол Улсын хууль тогтоомжид холбогдуулан өөрсдийн туршлага, мэргэжлийн ур чадвараа ашигласан бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжид үндэслэсэн болно. Хуулийн фирм нь бусад аливаа улсын хууль тогтоомжийн хүрээнд аливаа үйл явдлын талаар саналаа илэрхийлээгүй болно. Хуулийн фирм нь энэхүү дүгнэлтийг гаргахдаа санхүүгийн, статистикийн, нягтлан бодох бүртгэлийн, үйл ажиллагааны чиглэлийн ямар нэгэн ур чадвар, туршлага ашиглаагүй, эдгээрээс гагцалдаг болно.


ХҮНДЭТГЭСЭН,

ПАРТНЕР  Д. ДҮГЭРЖАВ

ПАРТНЕР  Г. БАТЖАРГАЛ

ӨМГӨӨЛЛИЙН "ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН





Бидний үйлдсэн хууль зүйн дүгнэлтэд дор дурдсан хязгаарлалт хамаарна. Үүнд:

- а) Бид Монгол Улсын хууль тогтоомжоос бусад улсын хууль тогтоомжийг хэрэглээгүй болно.
- б) "хүчин төгөлдөр", "дагаж мөрдөнө", "хэрэгжинэ" гэдэг нь Монгол Улсын шүүх хэргжүүлж болох үүрэг болон нөхцөлүүдийг илэрхийлнэ. Гэхдээ энэ нь бүхий л нөхцөл байдалд хэрэгжих боломжтой гэсэн ойлголт биш болно. Тухайлбал:
 - (i) Гэм хор арилах, хориг тавих, тусгай гүйцэтгэл, дур зоргоор хандах;
 - (ii) Татан буулгахтай холбоотой хууль болон санхүүжүүлэгчид нөлөөлж болох бусад хуулиудын нөлөөлөл;
 - (iii) залилан, хууран мэхлэх, алдаа, албадагын, шударга бус үйл явдал, хууль бус үйлдлийн эсрэг хуулийн нөлөөл.
- в) Энэхүү хууль зүйн дүгнэлт нь Баримт бичгүүд дээр тусгагдсан асуудлуудтай холбоотой бөгөөд тухайн Баримт бичиг дээр тусгагдсан хууль зүйн факт, үйл явдалд хамаарна. Тухайн Баримт бичиг дээр тусгагдсан аливаа үүргийг нэмэгдүүлэх эсхүл бизнесийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй болно.

Бид энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргахдаа гагцхүү Монгол Улсын хууль тогтоомжид холбогдуулан өөрсдийн туршлага, мэргэжлийн ур чадвараа ашигласан бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжид үндэслэсэн болно. Хуулийн фирм нь бусад аливаа улсын хууль тогтоомжийн хүрээнд аливаа үйл явдлын талаар саналаа илэрхийлээгүй болно. Хуулийн фирм нь энэхүү дүгнэлтийг гаргахдаа санхүүгийн, статистикийн, нягтлан бодох бүртгэлийн, үйл ажиллагааны чиглэлийн ямар нэгэн ур чадвар, туршлага ашиглаагүй, эдгээрээс тагналдаг болно.

ХҮНДЭТГЭСЭН,

ПАРТНЕР

Д. ДҮГЭРЖАВ

ПАРТНЕР

Г. БАТЖАРГАЛ

ӨМГӨӨЛИЙН "ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН



5.2 Хөрөнгийн үнэлгээний тайлан

БИЗНЕС, ҮЛ ХӨДЛӨХ БОЛОН ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ
“ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ” ХХК



БИЗНЕС ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Захиалагч:	“Түмэн Шувуут” ХХК РД:2844753
Захиалагчийг төлөөлж:	Захирал Б.Болд
Үнэлсэн хөрөнгийн нэр:	“Түмэн Шувуут” ХХК-ийн бизнесийн үнэ цэнэ
Үнэлгээний дүн:	43,552,500,000 /Дөчин гурван тэрбум таван зуун тавин хоёр сая таван зуун мянга/- төгрөг
Гүйдэтгэгч:	“Итгэлт-Эстимэйт” ХХК Регистр 2866641 Улсын бүртгэлийн дугаар 24/4539 Утас: 455088, 99115638, 99995638 E-mail: itgelt_estimate@magicnet.mn
Үнэлгээний огвоо:	2017 оны 12 сарын 31-ны өдөр
Үнэлгээ хийсэн огвоо:	2018 оны 05 сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Handwritten signature and stamp of the valuator.

Stamp of the valuator company: "ITGELT ESTIMATE" LLC, Ulaanbaatar, Mongolia.



“ИТГЭЛТ-ЭСТИМЭЙТ” ХХК
Бизнес, Үл хөдлөх хөдлөх хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН
(Хураангуйлал)

Захиалагчийн нэр: “Түмэн Шувуут” ХХК

Захиалагчийг төлөөлж: Б.Болд (Захирал)

Компанийн регестрийн дугаар: 2844753

УБ-ийн гэрчилгээний дугаар: 901112143

Үнэлсэн хөрөнгийн нэр: “Түмэн Шувуут” ХХК-ийн хөрөнгийн болон бизнесийн үнэ цэнэ

Хөрөнгийн байршил: Улаанбаатар хот Сонгинохайрхан 27-р хороо 21-р хороолол /18082/, 59/1 тоот “Түмэн шувуут” ХХК-ийн байр. Хан-Уул дүүрэг, 13-р хороо, Шувуун фабрикийн 55/3 тоот. Сонгинохайрхан 21-р хороо, Хужиртын даваа 18450 гудамж, 197/1, 197/2 тоот.

Хөрөнгийн зах зээлийн өртөг: 43,552,500,000 /Дөчин гурван тэрбум таван зуун таван хоёр сая таван зуун мянга/-и төгрөг /

Гүйцэтгэгч: Итгэлт-Эстимэйт ХХК
Регистр 2866641
Улсын бүртгэлийн дугаар 24/4539
Утас: 455088,
E-mail: Itgelt_estimate@magicnet.mn
<http://www.itgelt-estimate.blogspot.com>


Ерөнхий захирал: Ө.Эрдэнэбаяр нь СЯ-ны хөрөнгийн үнэлгээ хийх эрхийн 071200002 тоот тусгай зөвшөөрөлтэй (Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээчнээр 19-н жил, Машин, тоног төхөөрөмжийн үнэлгээчнээр 17-н жил, Бизнесийн үнэлгээчнээр 16жил тасралтгүй ажиллаж байгаа болно)

Тайлан бичсэн огноо: 2018 оны 05 дугаар сарын 25-ний өдөр



2





“ИТГЭЛТ-ЭСТИМЭЙТ” ХХК
Бизнес, Үл хөдлөх хөдлөх хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Бизнесийн үнэлгээний тайлан
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Бид 2018 оны 04 дүгээр сарын 11-ны өдөр “Түмэн шувуут” ХХК-ийн захирал Ж.Болдтой байгуулсан хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх гэрээний дагуу “Түмэн Шувуут” ХХК-ийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон үнэлгээний ҮОУС-ын дагуу бие даасан хараат бус байдалд хийж гүйцэтгэв. Бид энэхүү санал, дүгнэлтээ “Түмэн шувуут” ХХК-ийн бизнесийн өнөөгийн зах зээлийн үнийг тогтоох зорилгоор хийсэн болно.

Зах зээлийн үнэ цэнэ: Зах зээлийн үнэ цэнэ гэдэг бол зохих маркетинг сурталчилгаа хийгдсэний дараа талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хоорондох харилцаа хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө, өр төлбөрийг арилжвал зохино гэж уг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн юм.

Цэвэр зах зээлийн үнэлгээ нь хөрөнгийг одоо байгаа байдлаар нь цаашид үргэлжлүүлэн ашиглана гэсэн тооцоон дээр үндэслэсэн болно. Хөрөнгийг зах зээл дээр хэсэгчлэн зарах болон өөр зорилгоор ашиглах нөхцөл боломжийн судалгаа тооцоололыг энэхүү үнэлгээнд авч үзээгүй болно.

Хөрөнгийг үргэлжлүүлэн ашиглах гэдэгт үндсэндээ дараах тохиолдлуудыг хэлж байгаа болно.

Үүнд:

- ✓ Хөрөнгө нь үзүүлж буй үйлчилгээнийхээ эдийн засгийн шаардлагыг хангасан байх;
- ✓ Хөрөнгө нь цаашид нэлээд урт хугацаанд ашиглах боломжтой байх;
- ✓ Хариуцлагатай өмчийн эзэн, чадварлаг менежменттэй байх;
- ✓ Хөрөнгийг өөр зорилгоор ашиглах нь эдийн засгийн хувьд тохиромжгүй, хууль зүйн хувьд зөвшөөрөгдөхгүй байх;
- ✓ Одоогийн, эсвэл түүнтэй төстэй хэрэглэгчид өнөөгийн ашиглалтыг цааш нь үргэлжлүүлэх;

Бид бодит байдлыг шинжилж үзээд компанийн өмчийн үнэ, цэнэ буюу бүх хувьцаа эзэмшигчид хамаарах бизнесийн зах зээлийн үнэ цэнийг тогтоосон болно.

Нийт хөрөнгө гэдэг нь бүхий л биет хөрөнгө (барилга, байгууламж, тоног төхөөрөмж, ажлын капитал) болон үргэлжлүүлэн ашиглах биет бус хөрөнгийн нийлбэр юм.

Цэвэр өөрийн хөрөнгө нь нийт хөрөнгөнөөс бусдал төлөх өр төлбөрийг хассан зөрүүгээр тодорхойлогдсон.





“ИТГЭЛТ-ЭСТИМЭЙТ” ХХК
Бизнес, Үл хөдлөх хөдлөх хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Бид “Түмэн шувуут” ХХК-ийн бизнесийн үнэлгээг нэгдүгээрт үл хөдлөх, хөдлөх хөрөнгийн үнэлгээ, хоёрдугаарт бизнесийн үнэлгээ гэсэн дарааллаар хийсэн. Өөрөөр хэлбэл тус компанийн худалдахад бэлэн байгаа хөрөнгийг нь үнэлж түүний зах зээлийн үнийг бодитой тогтоосны үндсэн дээр бизнесийн үнийг нь тогтоосон болно.

ҮЛ ХӨДЛӨХ, ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН ХУВЬ ОРОЛЦООНЫ ҮНЭЛГЭЭГ ХИЙСЭН ТУХАЙ.

А) Үл хөдлөх эд хөрөнгө /ҮЛХЭХ/-ийн хувь оролцоо

Хөрөнгийн зах зээлийн өртгийг тодорхойлоход ҮОУС 400-ийн дагуу хийсэн бөгөөд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн дараах 3-н хандлагын аргаар хийсэн болно.

ӨРТГИЙН ХАНДЛАГА

Өртгийн хандлага нь газрын үнэ өртөг тухайн объектыг шинээр барьж байгуулахад гарах өртгийн тооцоолохоос эхэлнэ. Шинээр барьж байгуулах зардал нь тухайн барилга, байгууламж, объектыг барихад гарах материалын зардал, ажлын хөлс, ашигласан багаж тоног төхөөрөмжийн үнэ, гүйцэтгэгчийн ашиг бусад төлбөр зэрэгт үндэслэнэ.

Хөрөнгийн өртгийн үнэлгээнд үнэ буурч, хямдрах янз бүрийн хүчин зүйлүүдийг харгалзаж тооцно. Элэгдэл бол үнэ буурах нэг шалтгаан бөгөөд энэ нь гурван хэлбэртэй байдаг. Үүнд: Биет элэгдэл, эдийн засгийн элэгдэл, буруу ашиглалтын элэгдэл зэрэг орно.

Зах зээлийн өртгийг өртгийн хандлагын аргаар тодорхойлохдоо Олон улсын үнэлгээний стандарт, өртгийн хандлагын аргаар үнэлгээ хийдэг нийтийн арга аргачлалыг баримтлан дараах загварыг ашигласан.

Үүнд:

- Газрын үнэ өртөг
- Барилга байгууламжийг шинээр барьж байгуулах зардал
- Хасах нь: (Илүүдэл хөрөнгийн өртөг)
- Тэнцэх нь: (Шинэчлэх өртөг)
- Хасах нь: (Биет элэгдэл)

“Түмэн Шувуут” ХХК Бизнесийн үнэлгээний тайлан





“ИТГЭЛТ-ЭСТИМЭЙТ” ХХК
Бизнес, Үл хөдлөх хөдлөх хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

- Хасах нь: (Буруу ашиглалтын элэгдэл)
Хасах нь: (Эдийн засгийн элэгдэл)
Тэнцэх нь: (Ашиглалтанд буй хөрөнгийн зах зээлийн үнэ)

1. Биет элэгдэл.

“Түмэн Шувуут” ХХК-ийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн чанар байдал, ашиглалт, ажиллаж буй орчин зэргийг судлахдаа ашиглалтанд орсон хугацаа, хүчин чадлынхаа хэдэн хувийг ашиглаж байгаа, хадгалалт хамгаалалт хэр зэрэг болохыг харгалзсан юм. Ашиглалтын хугацаа дууссан ч цаашид урьдын үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх бололцоотой хөрөнгийг засвар, ашиглалтын байдал, хоцрогдлын төвшин, хэрэгцээ хангах боломж зэргийг харгалзан элэгдлийг багасгах замаар үнэлсэн.

Ашиглаж байгаа барилга, байгууламж, тусгай зориулалтын машин механизм, багаж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг дараах байдлаар авч үзэж биет элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулсан. Энэ нь Монгол улсын Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуулийн зохих заалтуудад нийцэж байгаа юм. Үүнд:

Тусгай зориулалттай машин, компьютер	3-10 жил
Автомашин, тээврийн хэрэгсэл, ажлын машин	10 жил
Барилга байгууламж	40 жил

2. Эдийн засгийн элэгдэл.

Хөрөнгийн эдийн засгийн хоцрогдлын үндсэн шалтгаан нь эдийн засгийн өгөөжөө нөхөж чадахгүй болох, зах зээлд өрсөлдөх чадвараа алдах зэрэгтэй холбоотой байдаг. Түүнчлэн эдийн засгийн хоцрогдол нь хүчин чадлыг дутуу ашиглах, оруулсан хөрөнгийнхөө өгөөжийг хүртэж чадахгүйд хүргэдэг. Энэ нь компанийн орлогод шууд нөлөөлдөг.

3. Буруу ашиглалтын элэгдэл /функционал/

Үйлдвэрийн барилга, байгууламж нь эзэмшилт, ашиглалтын байдлаас хамаарч янз бүрийн элэгдэл эвдрэлд орсон учир түүнийг арилгах зардлыг бодолцон буруу ашиглалтын элэгдлийг эвдрэлтэй хөрөнгө нэг бүрт харилцан адилгүй тогтоодог.

“Түмэн Шувуут” ХХК Бизнесийн үнэлгээний тайлан

5





БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ.

Бизнесийн үнэлгээг УОУС 200 дагуу Өмчийн үнэ цэнэ буюу бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарах бизнесийн үнэ цэнийг тогтоох зорилгоор хийсэн бөгөөд дараах үндсэн 3-н хандлагыг хэрэглэсэн.

- 1) Орлогын хандлага.
- 2) Өртгийн хандлага.
- 3) Зах зээлийн жишиг үнийн хандлага

ОРЛОГЫН ХАНДЛАГА.

Орлогын хандлагаар үнэлгээг хийхдээ Ирээдүйн мөнгөн орлогын өнөөгийн үнэ цэнийг тооцох аргыг хэрэглэсэн.

Хөрөнгө оруулагч нь компанийг худалдан авах, худалдах эсэх талаар шийдвэр гаргахдаа тодорхой тооцоо судалгаа хийдэг. Ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцох арга нь хөрөнгө оруулагчийн хийх тооцооны хамгийн тохиромжтой аргад тооцогддог. Ихэнх тохиолдолд энэ арга нь хөрөнгө оруулалтын үнэлгээ хийх дүн шинжилгээний нэг хэсэг болдог. Энэ нь урьдчилан тооцох систем буюу хүлээлтийн зарчимд үндэслэгддэг.

Ердийн бус нөхцөл байдлаас бусад тохиолдолд ирээдүйн мөнгөн гүйлгээний урсгалыг хорогдуулан тооцох арга нь цаашид үйл ажиллагаа нь хэвийн байдлаар үргэлжлэх компанийг үнэлэх хамгийн тохиромжтой арга юм.

ӨРТГИЙН ХАНДЛАГА

ТОХИРУУЛГА ХИЙСЭН ЦЭВЭР АКТИВЫН АРГА

Өртгийн хандлагаар үнэлгээг хийхдээ Тохируулга хийсэн цэвэр активын аргыг хэрэглэсэн бөгөөд энэ аргаар хийсэн үнэлгээний онцлог нь тухайн компанийн үнэлгээ хийх цаг үед байсан нийт үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, санхүүгийн чадавхийн хэмжээг мөнгөн хэлбэрээр тодорхойлон үзүүлдэгт оршино.

Тохируулга хийсэн цэвэр активын аргаар үнэлгээг хийхдээ дараах тохируулгуудыг хийсэн.

- Үл хөдлөх эд хөрөнгө, хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүнгээр үндсэн хөрөнгийн үнэлгээг өөрчлөн тохируулсан.
- Болзошгүй өрийг бүртгэж, авлагын ангилалыг нарийвчлан шинжилж, найдваргүй авлагыг активаас хасч тохируулсан.





“ИТГЭЛТ-ЭСТИМЭЙТ” ХХК
Бизнес, Үл хөдлөх хөдлөх хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

- Агуулахад байгаа бараа материалыг нэг бүрчлэн судалж, удаан гүйлгээтэй, олт гүйлгээгүй гэж ялгасны үндсэн дээр чанаргүй барааны үнийг хямдруулах замаар активыг хорогдуулсан.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БИЗНЕСИЙН ОРЧИН БА ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭ

2.1 МАНАЙ ОРНЫ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

2017 оны эхний 9-н сард 5,3%-иар өсөв. Монгол Улсын ДНБ-ний ихэнх хувийг уул уурхай, олборлолтын салбар эзэлдэг бол үйлчилгээний бусад үйл ажиллагаа буюу үйлчилгээний бизнес мөн онд хувийн нөлөөллийг үзүүлж байна. Дараагаар нь хөдөө аж ахуй, бөөний болон жижигтэн худалдаа, авто засварын үйлчилгээнүүд бүрдүүлж байна. 2010 оноос хойш тогтмол өсөлттэй байгаа салбар нь уул уурхай, хөдөө аж ахуй, үйлчилгээний бизнесүүд эзэлж байгаа бол өсөлтөө тогтмол хадгалж байгаа нь барилга, боловсруулах үйлдвэр, тээвэр, мэдээлэл холбооны салбарууд байгаа юм.

ДНБ 2016 оны 4-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үзвэр) 16 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 65.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт 1 хувиар өсөв. ДНБ-ний 1 хувиар өсөхөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 13 хувь, үйлчилгээний салбар 10 хувиар өссөн нь нөлөөлсөн.

МӨНГӨ, ЗЭЭЛ, ҮНЭТ ЦААС

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2017 оны 9 дүгээр сарын эцэст 14.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 233.8 (1.6%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 3.2 (27.7%) их наяд төгрөгөөр өсжээ.

Мөнгөний нийлүүлэлт 2017 оны 9 дүгээр сард өмнөх сараас 233.8 тэрбум төгрөгөөр өсөхөд төгрөгийн харилцах 61.3 тэрбум төгрөг, валютын хадгаламж 185.0 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөллөө.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2017 оны 9 дүгээр сарын эцэст 878.9 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 20.7 (2.3%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 83.1 (10.4%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 9 дүгээр сарын эцэст 13.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 156.5 (1.2%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 930.6 (7.4%) тэрбум төгрөгөөр өсжээ.





“ИТГЭЛТ-ЭСТИМАЙТ” ХХК

Бизнес, Үл хөдлөх хөдлөх хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 9 дүгээр сарын эцэст 827.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 112.1 (11.9%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 37.9 (4.8%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2017 оны 9 дүгээр сарын эцэст 1.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 1.7 (0.1%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 50.2 (4.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр буурсан байна.

УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2017 оны эхний 9 сард 5.0 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 5.8 их наяд төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 737.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1.3 их наяд төгрөгөөр буурахад орлого 1.0 (25.5%) их наяд төгрөгөөр өсөж, харин зарлага 291.4 (4.8%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Татварын нийт орлого 4.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 876.5 (24.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд оншгой албан татварын орлого 132.7 (26.9%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч, орлогын албан татвар 367.9 (51.3%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 378.9 (48.8%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 118.0 (50.6%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 84.0 (10.0%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 45.9 (12.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 80.0 хувийг татварын орлого, 11.7 хувийг татварын бус орлого, 4.6 хувийг ирээдүйн ов сангийн орлого, 3.7 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2017 оны эхний 9 сард 5.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 291.4 (4.8%) тэрбум төгрөгөөр буурахад хүүгийн зардал 255.6 (49.0%) тэрбум төгрөг, урсгал зардал 187.3 (4.0%) тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 352.1 (71.3%) тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 126.6 (13.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүнд урсгал зардал 83.6 хувь, хөрөнгийн зардал 14.0 хувь, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 2.5 хувийг эзэлж байна.

ГАДААД ХУДАЛЦАА

Монгол Улс 2017 оны эхний 9 сард дэлхийн 150 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 7.7 тэрбум америк доллар, үүнээс экспорт 4.6 тэрбум америк доллар, импорт 3.1 тэрбум америк долларт хүрлээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.9 (33.4%) тэрбум америк доллар, үүнээс экспорт 1.3(37.5%) тэрбум америк доллараар, импорт 682.8 (27.9%) сая америк доллараар тус тус өссөн байна.





“ИТГЭЛТ-ЭСТИМЭЙТ” ХХК
Бизнес, Үл хөдлөх хөдлөх хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Гадаад худалдааны тэнцэл 2016 оны эхний 9 сард 884.4 сая америк долларын ашигтай гарч байсан бол 2017 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 567.7 (64.2%) сая америк доллараар нэмэгдэж, 1.5 тэрбум америк долларт хүрчээ.

Экспорт 2017 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум америк доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 1.2 тэрбум америк доллар, үүн дотор пүүрсний экспорт 1.2 тэрбум америк доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Экспорт, импорт, зарим барааны бүлгээр, сая америк доллар

Үзүүлэлт	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2017 I-IX 2016 I-IX
Экспорт	3 540.9	3 332.4	4 582.9	137.5
Эрдэс бүтээгдэхүүн	2 798.8	2 411.4	3 649.9	151.4
Үүнээс: Нуурс	432.9	509.8	1 730.2	3.4
Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн зүйлс	56.9	61.0	75.1	123.2
Түүхий болон боловсруулсан арьс, гонь	23.8	18.2	18.3	100.7
Нэхмэл бүтээгдэхүүн	262.3	252.9	291.4	115.2
Үнэт чулуу, металл, гоёлиг зүйлс	286.8	402.0	404.0	100.5
Импорт	2 856.7	2 448.0	3 130.8	127.9
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	238.6	226.7	270.2	119.2
Эрдэс бүтээгдэхүүн	717.6	502.6	737.6	146.8
Автобензин	208.5	139.4	184.2	132.1
Дизелийн түлш	288.4	161.9	323.1	199.6
Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн зүйлс	302.3	167.8	250.6	149.3
Тээврийн хэрэгсэл, тэдгээрийн салбэр, эд анги	279.5	315.0	450.0	142.8
Машин, механик татварынж, цахилгаан хэрэгсэл	568.1	502.5	639.3	127.2

Импорт өмнөх оны мөн үеэс 682.8 сая америк доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний импорт 235.0 сая америк доллар, үүнээс дизелийн түлш 161.2 сая америк доллар, автобензин 44.8 сая америк доллараар, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн салбэр, эд анги 136.8 сая америк доллараар, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 135.0 сая америк доллараар, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн зүйлсийнх 82.8 сая америк доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.

Эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл бүтээгдэхүүн, үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт нийт экспортын 94.8 хувийг эзэлж байгаа бол импортын 67.0 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон хүнсний бэлэн бүтээгдэхүүний импорт эзэлж байна.



“ИТГЭЛТ-ЭСТИМЭЙТ” ХХК

Бизнес, Үл хөдлөх хөдлөх хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

ҮНЭ

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2017 оны 9-р сард өмнөх сараас 0.2 хувь, өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өсч, өмнөх оны эцсээс 5.3 хувиар өсөв.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 2 хувь (сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 5.8 хувь), орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 2.6 хувь, хувцас, бөс бараа, гутал 1.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

2017 оны 09-р сарын байдлаар хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд өмнөх сараас 0.2 хувь, өмнөх оны эцсээс 5.3 хувь, өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар тус тус өссөн байна.

Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 дугаар сар = 100%), хувь



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өсөхөд тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 10.4 хувь (тээврийн хэрэгслийн худалдан авалтын дэд бүлгийн үнэ 22.7 хувь), хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.5 хувь (төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 31.2 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 12.7 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 11.1 хувь), орон сууц, ус цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 7.4 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 11.2 хувь), боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 5.5 хувь (бүрэн дунд боловсролын үйлчилгээний дэд бүлгийн үнэ 32.1 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 3.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны эцсээс 5.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 8.6 хувиар (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 13.8 хувь, төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 31.6 хувь), тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 10.0 хувиар өссөн нь голлон нөлөөллөө.

Handwritten signature and stamp of the company.

Stamp and signature of the company, with the number 227.



“ИТГЭЛТ-ЭСТИМАЙТ” ХХК
 Бизнес, Үл хөдлөх хөдлөх хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.2 хувиар өсөхөд орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 1.8 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 3.1 хувь) өссөн нь голлон нөлөөллөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2017 оны 9 дүгээр сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2017	2017	2017
		IX	IX	IX
		2016	2016	2017
		IX	XII	VIII
Хувь				
Грэнхий индекс	100.0	105.8	105.3	100.2
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	107.5	108.6	98.9
Согтууруулах ундаа, тамхи	4.4	102.2	102.1	100.1
Хувцас, бөс бараа, гутал	16.6	103.5	102.0	101.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	107.4	103.9	101.8
Гэр ахуйн гавилга, бараа	4.9	102.9	102.6	100.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	105.0	104.3	100.2
Тээвэр	14.4	110.4	110.0	100.8
Холбооны хэрэгсэл, шүүдэнгийн үйлчилгээ	4.4	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	101.1	102.2	100.2
Боловсролын үйлчилгээ	4.8	105.5	105.5	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	102.1	101.7	101.3
Бусад бараа, үйлчилгээ	5.4	105.6	104.5	100.1

ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС

Улаанбаатар хотын төвийн 6-н дүүрэгт орон сууцны үнийн индекс 2017 оны 3 дугаар улиралд 2010 оны эцсээс 82.2 хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс 1.2 хувь, өмнөх улирлаас 0.3 хувиар буурсан байна.


Орон сууцны үнийн индекс 2017 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс Сүхбаатар дүүрэгт 0.6 хувь, Баянзүрх дүүрэгт 1.2 хувь, Чингэлтэй болон Хан-Уул дүүрэгт 1.1 хувь, Баянгол дүүрэгт 1.6 хувь, Сонгинохайрхан дүүрэгт 1.5 хувиар, харин өмнөх улирлаас Хан-Уул, Чингэлтэй болон Баянгол дүүрэгт 0.3 хувь, Баянзүрх болон Сүхбаатар дүүрэгт 0.2 хувь, Сонгинохайрхан дүүрэгт 0.5 хувиар буурсан байна.

Орон сууцны үнийн индекс, хувиар, 2017 оны 3 дугаар улиралд, Улаанбаатар хотын төвийн 6-н дүүргээр, өмнөх оны мөн үстэй харьцуулснаар






“ИТГЭЛТ-ЭСТИМЭЙТ” ХХК
Бизнес, Үл хөдлөх хөдлөх хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ




1970 оноос өмнө ашиглалтад оруулсан орон сууцны үнийн индекс 2017 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 6-н дүүрэгт 0.4-2.2 хувиар, 1970-2001 оны орон сууцных 0.6-1.8 хувиар, 2001 оноос хойш ашиглалтад оруулсан орон сууцных 0.4-1.0 хувиар буурсан байна.

1970 оноос өмнө ашиглалтад оруулсан орон сууцны үнийн индекс 2017 оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас Сүхбаатар дүүрэгт өөрчлөлтгүй, бусад 5 дүүрэгт 0.3-0.6 хувиар, 1970-2001 оны орон сууцных Баянзүрх дүүрэгт өөрчлөлтгүй бусад 5-н дүүрэгт 0.1-0.5 хувиар, 2001 оноос хойш ашиглалтад оруулсан орон сууцны үнийн индекс 6-н дүүрэгт 0.1-0.3 хувиар буурчээ.


АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны эхний 9 сард урьдчилсан гүйцэтгэлээр 9.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.6 (37.4%) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 2.1 (43.5%) их наяд төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт 1.1 (2.5 дахин) их наяд, металлын хүдэр олборлолт 0.8 (23.0%) их наяд төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлөв.

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл, салбараар, сараар, тэрбум төгрөг



Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс (улирлын нөлөөллийг арилгасан тооцоо) 2017 оны 9 дүгээр сард 176.1 (2010=100) болж, өмнөх оны мөн үеэс 20.3 хувиар, өмнөх оны эцсээс 10.0 хувиар, өмнөх сараас 3.5 хувиар өссөн байна.



“ИТГЭЛТ-ЭСТИМЭЙТ” ХХК

Бизнес, Үл хөдлөх хөдлөх хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Боловсруулах аж үйлдвэрийн салбарт архи, шар айраг, самнасан ноолуур, ноолууран сүлжмэл эдлэл, банш, бууз, малын гэжээл, ашууны мах зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.4 хувиас 5.6 дахин өссөн байна.

Харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт газрын тос, зэсийн баяжмал, цайрын баяжмал, хайгуур жонш зэрэг бүтээгдэхүүний олборлолт 7.2-39.2 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт катодын зэс, зүсмэл материал, хиамаг төрлийн бүтээгдэхүүн, вакуум цонх, хаалга, барилцрын модон хаалга, цонх зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.5-26.8 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2017 оны эхний 9 сард 11.0 их наяд төгрөгт хүрч, 7.4 их наяд төгрөг буюу 67.3 хувийг гадаад зах зээлд борлуулжээ.

“Түмэн Шувуут” ХХК Бизнесийн үнэлгээний тайлан

13





2.2 БИЗНЕСИЙН ТҮҮХ, МӨН ЧАНАР, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.2.1 Ерөнхий танилцуулга.

“Түмэн шувуут” ХХК нь 2004 онд байгуулагдсан цагаас хойш тахианы аж ахуйг амжилттай эрхлэн 2017 оны байдлаар дотоодын өндөгний зах зээлийн 30 гаруй хувийг бүрдүүдэгч малай улсын томоохон аж ахуй нэгжийн нэг болж хөгжөөд байна.

Компани анх 20,000 тахиатай эхэлж байсан цагаас хойш системтэйгээр өргөжүүлэлтийг хийсний үр дүнд өнөөдрийн байдлаар өндөглөгчийн 7-н байранд 250,000 тахиа, дэгдэхэйний 2 байранд 100,000 дэгдэхэй, 156,000 өндөгний инкубаторын хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн хоногт 100 тонн тахиа болон малын тэжээл үйлдвэрлэх хүчин чанал бүхий “Агро Фийлд” үйлдвэрийг ашиглалтад оруулан дотоодын хөрсөнд ургасан улаан буудай болон холбогдох бусад бүтээгдэхүүнүүдийг ашиглан сайн чанарын тэжээл үйлдвэрлэн зөвхөн өөрийн үйлдвэртээ бус бусад хэрэглэгчдэд түгээж байна.

Хэрэглэгчдэд шинэ өндөгийг өдөр бүр түгээх үйлддээ шаардлагатай бүхий л үйлдвэрлэлийг өөрийн компанид хэрэгжүүлж байгаа нь компанийг бус даасан бусдаас хараат бус үйлдвэрлэлээ эрхлэх боломжийг хангадаг бөгөөд түүнд өндөгний сав баглаа боодол, эрүүл ахуйн лаборатори, вакцинжуулалт тахиа нядалгааны аж ахуй зэрэг багтаж байна.

Мөн тэжээлийн үйлдвэртээ зөвхөн тахианы тэжээлийг үйлдвэрлэлд зогсохгүй малын олон төрлийн тэжээлийг үйлдвэрлэн эрчимжүүлсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд өндөр хувь нэмэр оруулж байна. Эрчимжүүлсэн мал аж ахуйг уургаар баялаг өндөр чанартай тэжээлээр тогтмол хангах нь тухайн малаас гарах өгөөжийг нэмэгдүүлэн, фермерүүдэд өндөр ашиг олох боломжоор хангадаг гол хүчин зүйл юм.

Цаашлаад Түмэншувуут ХХК нь өнөөдрийг хүртэл цуглуулсан туршлага дээр үндэслэн үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, цаашид эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа олон нийтэд арилжаалан хөрөнгө босгохоор ажиллаж байна. Олон нийтээс таган төвлөрүүлсэн хөрөнгөөр тахианы аж ахуйг өргөжүүлж өндөглөгчийн байрыг нэмэгдүүлэх, тэжээлийн үйлдвэрийн технологийг шинэчлэх, махны тахианы аж ахуйг хөгжүүлэхээр ажиллаж байна.

Монгол улс тахианы махны 90-95 хувийг импортоор худалдан авдаг байдлыг өөрчлөх, дотоодлоо чанарын өндөр түвшинд бэлтгэгдсэн тэжээлээр хооллож, эрүүл ахуйн өндөр шаардлагыг хангасан орчинд бэлтгэгдсэн тахианы махаар хүн ардыг хангах нь Түмэншувуут ХХК-ны бизнесийн дараагийн дэвшил юм.



“ИТГЭЛТ-ЭСТИМЭЙТ” ХХК
Бизнес. Үл хөдлөх хөдлөх хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

1. Ерөнхий мэдээлэл

Үнэг цаас гаргагч “Түмэншувуут” ХХК нь үндэсний томоохон тахианы өндөг, малын тэжээлийн үйлдвэрлэгч аж ахуйн нэг бөгөөд өнгөрсөн 14-н жилийн хугацаанд хуримтлуулсан туршлага дээр үндэслэн олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Компани хөрөнгийн зах зээлд бүртгэгдсэнээр Монголын Хөрөнгийн Биржийн I-р ангилал буюу хамгийн найдвартай, томоохон компаниуд багтдаг ангилалд орох боломжийг шууд хангаж байгаа нь тухайн компанийн үйл ажиллагааны цар хүрээ, санхүүгийн чадавхийг харуулж буй нэг үнэлэлт болж байна.

Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр дараах үйл ажиллагааг эрхлэхээр төлөвлөж буй бөгөөд цаашид тахна, тэжээвэр шувууны зах зээлд тэргүүлэгч байр сууриа хадгалах, хүн ардыг эрүүл хүнсээр хангах ажилдаа улам өндөр амжилтыг үзүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

1. Өндөгнөгч шувууны байрны тоог нэмэгдүүлж, шувууны өндөгний үйлдвэрийн зохистой харьцааг баримтлан бүтээмжийг өндөр түвшинд барих
2. Тахианы махны аж ахуйг хөгжүүлж, дотоодын зах зээлд чанарын өндөр түвшинд бэлтгэсэн тахианы махыг нийлүүлэх
3. Шувууны сангасыг боловсруулж, бордоо үйлдвэрийн газар тариалангийн бүсэд борлуулах
4. Малын гэжээлийн төрөлжсөн үйлдвэрлэлийг явуулж, эрчимжүүлсэн мал аж ахуйг өргөжүүлэх, ялангуяа хурдан морь, сүүний үхрийн фермд бүтээгдэхүүнээ тогтмол нийлүүлэх.
5. Тэжээлийн бэлтгэлийг хангах зорилгоор усжуулалт бүхий газар тариаланг хөгжүүлэх

Дээрх үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд уг дүнг МХБ-р дамжуулан олон нийтээс татан төвлөрүүлснээр цаашид компанийн үйл ажиллагаанд төрөлжил үүсч, нээлттэй хувьцаат компанийн засаглалын зарчмаар ажиллан, дотоодын хүнсний салбарт тэргүүлэгч болон хөгжих зорилго тавин ажиллаж байна.

2. Тогтмол танилцуулга

Түмэн шувуут ХХК нь (цаашид Компани гэх) 2004 онд 20,000 өндөглөгч тахитай аж ахуйг байгуулсан цагаас өнөөг хүртэл өндөгний аж ахуйн үйл ажиллагааг тогтмол амжилттай эрхэлж өнөөгийн байдлаар 250,000 гаруй өндөглөгч тахитай, 140-н ажиллагсадтай Монгол улсын өндөгний хэрэгцээний 30 гаруй хувийг дангаар хангагч аж ахуй болон хөгжөөд байна.

Компани хэрэглэгчдэл өдөр бүр 100,000 гаруй шинэ өндөгийг хүргэхээс гадна дараах шувуутай холбоотой үйл ажиллагааг цогцоор нь эрхэлж байна. Үүнд:

• Нэг ховогийн настай дэгдээхэй нийлүүлэх

Эмбриотой буюу үр хөврөл бүхий өндөгийг импортоор тусгай зориулалтын автомашинаар тээвэрлэн нэг ээлжиндээ 150 мянган өндөг дарах хүчин чадал бүхий өөрийн инкубатор төвд авчирч 18-21 хоног дарсны эцэст дэгдээхэй гарган авдаг. Уг гарсан дэгдээхэйгүүдийг дотоодын тахианы аж ахуйн нэгжүүдэд худалдан борлуулж тэдгээр аж ахуйн нэгжүүдийн сүргийн бүтцийг бий болгоход

232



“ИТГЭЛТ-ЭСТИМЭЙТ” ХХК

Бизнес. Үл хөдлөх хөдлөх хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Үнэтэй хувь нэмэр оруулаад зогсохгүй Монгол Улсын тахианы аж ахуйн тогтвортой байдлын хангаж ажиллаж байна.

• Өндөгний сав баглаа, боодол

Өндөгийг хэрэглэгчдэд хүргэх хамгийн чухал алхамын нэг нь сав баглаа боодол байдаг. Компанийн хувьд өөрийн үйлдвэртээ сав баглаа боодлоо хаягдал цаасыг өндөр температурт боловсруулан, ариутган хэрэглэдэг нь байгаль экологид ач тустай, цаацлаад эдийн засгийн хувьд хэмнэлтийг хэрэглэгчдэд үзүүлдэг бизнесийн нэгэн чухал хэсэг болон хөгжсөн байна. Компани өөрийн хэрэгцээнээс илүү гарсан сав баглаа боодлыг мөн бусад аж ахуй нэгжүүдэд борлуулдаг бөгөөд компанийн орлогын 2 хувийг бүрдүүшж жилд 175 сая төгрөгийн эх үүсвэр бий болгодог бизнесийн нэг хэсэг юм.

• Шувууны болон малын тэжээл

Үнэт цаас гаргагч нь 2015 онд хоногт 100 тонн тахианы болон малын тэжээл үйлдвэрлэх хүчин чадал бүхий Агро Фийд (Agro Feed) үйлдвэрийг Сонгино хайрхан дүүргийн 21-р хороонд байлах өөрийн эзэмшлийн 150,000 м2 талбайд байгуулсан. Уг үйлдвэрт компания дотоодын бүтээгдэхүүнүүдийг ашиглан шувууны болон малын тэжээлээ үйлдвэрлэснээр өндөгний чанарт хяналт тавих, эрүүн мэндийн хувьд гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж байна.

Үнэт цаас гаргагч нь тэжээлийн үйлдвэртээ малын торол, насны ангилал зэргийг удаан хугацаанд идэвхитэй судалсны эцэст шувууны 5-н төрлийн тэжээл, малын 6-н төрлийн тэжээлийг тухайн амьтадын бие физиологид нийцсэн онцлогт тааруулж үйлдвэрлэж байна. Тухайлбал тахианы насны онцлогоос хамаарч 5-н төрлийн тэжээлийг үйлдвэрлэж буй бөгөөд Селинээр баяжуулсан тэжээлийг өндөгнөгч тахианд өгсөнөөр Селинээр баялаг өндөгийг үйлдвэрлэн хүн амьт эрүүл мэндэд хувь нэмэр оруулж байна.

Мөн бүх төрлийн малд зориулсан “Тарга”, саатийн үнээний “Сүүт”, хурдан моринь “Хурд”, адууны “Амар”, “Шингүүртэй овъёос” зэрэг шинэ нэр төрлийн, төс чанарын тэжээл үйлдвэрлэж, тэдгээр нь хэрэглэгчдэд өндөр үнэлэгддэг.

Тэжээлийн үйлдвэрийн дэргэдэх чанарын лабораторит үйлдвэрлэх бүтээгдэхүүний түүхий эдийг шинжлэн худалдан авах, бэлэн болсон бүтээгдэхүүний чанарыг тогтмол шалгадаг нь хэрэглэгчдэд өндөр чанартай бүтээгдэхүүн хүргэх баталгаа болж өгдөгөөрөө онцлогтой.

• Тахианы мах үйлдвэрлэх

Өндөглөгч шувуу нь 640-700 хоног насалсны эцэст үржил шим нь буурдаг тул шинэ залуу тахиагаар солих шаардлага үүсдэг. Харин нэгэлт өндөглөгөөний үе шатыг бүрэн туулсан тахиануудыг компани өөрийн бүрэн автомат мах нядалгааны төвд бэлтгэн тахианы махыг зах зээлд нийлүүлдэг. Хэдийгээр өндөглөгч тахианы мах нь махны тахиатай харьцуулахад жин бага байдаг боловч бордоо бага хэрэглэсэн, органик байдлыг агуулдагаараа шям тэжээлийн хувьд ялгарч чаддаг.



2.2.2. “Түмэн Шувуут” ХХК-ийн гадаад, дотоод орчны (SWOT) шинжилгээ.

	Давуу тал (Strengths)	Сул тал (Weaknesses)
Дотоод орчин	<ul style="list-style-type: none"> Шувууны байр тоног төхөөрөмж, агуулах байгууламж хангалтай Өөрийн компанийн шинжилгээний лабораториятай Энгийн төрөлөө түүштүүтэй Хэрэглэгчдэд танигдсан Удирдлагын баг нь даллага, туршлагатай мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн Удаан жил ажилласан мэргэжсэн ажлаагаасдтай Туршлагатай гадаадын мэргэжилтэнгүүдийг урьж ажиллалууж, сургалт явуулдаг Шувууны гол гэжээлээ өөрийн компанийн Агро Фийд гэжээлийн үйлдвэрт үйлдвэрлэдэг Өндөг шдхаас бусад ажлыг бүрэн автоматажуулсан, дэншил гэд төхөөрөмжийн ашигладаг Зөх судалгаа шинжилгээ тогтмол хийж мөнхжмэнтгийн удирдлаганд ашигладаг 	<ul style="list-style-type: none"> Түргэн хэрэглэгддэг бүтээгдэхүүн учир амархан мууддаг Орон нутгуудаар салбар борлуулалтын суваг байхгүй
	Боломж (Opportunities)	Борхирол (Threats)
№	Үнэлгээний аргууд	Үнэлгээний дүн	Ач холбогдол	Үнэлгээний дүн (мян.төг)
1	Харьцуулан жиших арга	177,295.7	100%	177,295.7
2	Суурь үнийн арга	203,194.3	0%	0.0
	Үнэлгээний дүн		100.00%	177,295.7

(Handwritten signature)
 АТАР ХОТ

(Handwritten signature)
 344



Бизнес, үл хөдлөх, хөдлөх хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээний "ИТГЭТТ-ЭСТИМАЙТ" ХХК

5. Газрын эзэмших эрхийн үнэлгээ #0175032/

А). Харьцуулан зэрэгцүүлэх арга

№	Үзүүлэлтүүд	Увс аймаг, Баруунтуруун сум	Увс аймаг, Баруунтуруун сум	Увс аймаг, Баруунтуруун сум	Үнэлж буй газар
1	Нийт талбай	2,000	1,000	1,400	4,000
2	Худалдсан он	2018 он	2018 он	2018 он	
3	Худалдсан үнэ (мян.төг)	3,000.0	2,000.0	2,000.0	
4	Борлуулалтын итгэлцүүр	0.95	0.95	0.95	1.0
5	Байрлалын итгэлцүүр	0.8	0.8	0.8	1.0
6	Дэд бүтэц	1.0	1.0	1.0	1.0
7	Тохируулсан үнэ цэнэ	2,280.0	1,520.0	1,520.0	
8	1квм-ийн үнэ (3/(1x4x5x6)) (мян.төг)	1.1	1.5	1.1	1.2091
9	Үнэлгээ (1x4x5x6) (мян.төг)	-	-	-	4,836.4



Б). Суурь үнийн арга

№	Орчны үзүүлэлт	Орчны байдал			Итгэлцүүр
		Сайн	Хэвийн	Муу	
1	Харягдах байдал		-		1.0
2	Байрзүй, газрын гадаргуй		-		1.0
3	Хөрөнгө оруулалт		-		1.0
4	Инженерийн байгууламж		+		0.9
5	Алслагдсан байдал		-		0.2
6	Нүүрэн хэсэг		-		0.9
7	Байрлал		-		0.9
8	Гудамжны төвшин		-		1.0
9	Гудамжны тохижилт		+		1.0
10	Бусад хүчин зүйлс		+		1.0
11	Замын хөдөлгөөн		+		1.0
12	Зогсоолын төрөл		+		1.0
13	Зогсоолын багтаамж		+		1.0
14	Эзэмшлэйн байдал		+		1.0
	Суурь үнийг өөрчлөх ерөнхий итгэлцүүр		-		0.15

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Дүн
1	1 квм-ийн суурь үнэ (1997 оны ЗГ-ын 152-р тогтоол)	Мян.төг	0.8
2	Суурь үнийг өөрчлөх ерөнхий итгэлцүүр	Кэф	0.15
3	Үнийн өсөлтийн итгэлцүүр	коэф	0.18
4	Газрын хэмжээ	Квм	4,000
5	Газрын үнэлгээ	Мян.төг	84.0

Газар эзэмших эрхийн үнэлгээний нэгдсэн дүн

№	Үнэлгээний аргууд	Үнэлгээний дүн	Ач холбогдол	Үнэлгээний дүн (мян.төг)
1	Харьцуулан жиших арга	4,836.4	100%	4,836.4
2	Суурь үнийн арга	84.0	0%	0.0
	Үнэлгээний дүн		100.00%	4,836.4





6. Хөдөө аж ахуйн техник, гоног төхөөрөмжийн үнэлгээ

№	Хөрөнгийн нэр	Ордуулалтын өртөг	Үйл ажиллагааны элэгдэл хувь	Элэгдлийн хэмжээ	Үнэлгээ/төг.өөр/
1	Трактор	4,000.0	25%	1,000.0	3,000.0
2	Трактор	4,000.0	25%	1,000.0	3,000.0
3	Трактор	2,500.0	75%	1,875.0	625.0
4	Трактор	4,000.0	75%	3,000.0	1,000.0
5	Кран	3,000.0	75%	2,250.0	750.0
6	Трактор	4,000.0	75%	3,000.0	1,000.0
7	Энд: 130 автомашин	5,000.0	75%	3,750.0	1,250.0
8	Трактор	12,000.0	25%	3,000.0	9,000.0
9	Трактор	6,000.0	75%	4,500.0	1,500.0
10	Трактор	4,000.0	75%	3,000.0	1,000.0
11	Запорошник	3,600.0	75%	2,700.0	750.0
12	Комбайн	10,000.0	75%	7,500.0	2,500.0
13	Комбайн	10,000.0	75%	7,500.0	2,500.0
14	Комбайн	10,000.0	75%	7,500.0	2,500.0
15	Комбайн	10,000.0	75%	7,500.0	2,500.0
16	Комбайн	10,000.0	75%	7,500.0	2,500.0
17	Бордоо цацагч	2,000.0	75%	1,500.0	500.0
18	Гагжуурын алпарат	400.0	5%	20.0	380.0
19	Үрлэн сийх	3,000.0	75%	2,250.0	750.0
20	Емкость	3,000.0	5%	150.0	2,850.0
21	Гурилын үйлдвэр	60,000.0	55%	33,000.0	27,000.0
Дүн					66,855.0


Үнэлгээний нийт дүн

№	Хөрөнгийн нэр	Үнэлгээ /мян.төг/
1	Газар эзэмших эрх-1	5,629.9
2	Газар эзэмших эрх-2	42,059.0
3	Газар эзэмших эрх-3	33,807.2
4	Газар эзэмших эрх-4	177,295.7
5	Газар эзэмших эрх-5	4,836.4
6	Бусад	66,855.0
Нийт дүн		330,483.3
Нийт хувьцааны тоо		489,262 ширхэг
Нэгж хувьцааны үнэ		675,47 төгрөг

Нийт үнэлгээний дүнг 330,483,300 /Гурван зуун гучин сая дөрвөн зуун наан гурван мянга гурван зуун-н төгрөгөөр нэгж хувьцааны үнийг 675,47 /Зургаан зуун далан таван төгрөг дөчин долоон мөнгө/-өөр тогтоов.

ЗУРГАА. НИЙЦЭЛТИЙН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Энэхүү үнэлгээг Монгол улсын хууль, тогтоомж, ҮОУС 2017-ийн дагуу мэргэжлийн болон ёс зүйн шаардлагуудыг мөрдөн, хараат бусаар хийж гүйцэтгэсэн бөгөөд тайланг бичсэн. Бид энэхүү үнэлгээний ажилтай холбоотойгоор дараахь зүйлсийг мэдэгдэж байна. Үүнд:





Бизнес, үл хөдлөх, хөдлөх хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээний "ИТГЭЛТ-ЭСТИМЭЙТ" ХХК

1. Бидний хийсэн үнэлгээний ажилд Монгол улсын хууль, тогтоомж, ҮОУС-аас гажих үндэслэл, шаардлага үүсээгүй бөгөөд аливаа гажилт гараагүй.
2. Бид үнэлгээнд ашигласан мэдээллүүдийг тогтсон журмын дагуу магадлан шалгасан бөгөөд энэхүү мэдээллээ 5-аас доошгүй жил хадгална.
3. Тайланг дурьдсан мэдээллийг захиалагч болон хууль тогтоомжоор шаардсан хүрээнд мэлэх үүрэгтэй этгээдээс бусад хүмүүст урьдчилан бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр дэлгэхийг хориглоно.
4. Объектын бодит байдалтай газар дээр нь очиж танилцан, хэмжилт судалгаа хийсэн, үнэлгээ нь энэхүү тайланг бэлтгэсэн цаг үеийн дүгнэлт бөгөөд уг одрийг хүртэлх хугацаанд ирүүлсэн мэдээлэл бодит байдалд үндэслэсэн учир хөрөнгөнд цаашид орох өөрчлөлтийг хариуцахгүй.
5. Тайланг тусгагдсан үнэ цэнэ нь нийт үл хөдлөх хөрөнгө буюу түүний хэсэгт ногдох ирээдүйн зах зээлийн үнэ буюу түүний зарим хэсгийг татан оролцуулсан арилжаа, гүйлгээний өртгийг илэрхийлнэ гэсэн баталгаа гаргаагүй болно.
6. Өмчлөгчийн эрхийн болон түүний хүчин чадал, материаллаг баазтай холбоотой нууцыг задруулахгүй байх үүргийг үнэлгээчин хүлээнэ.
7. Эрх зүйн актуудыг өөрчлөх, хуурамчаар бүрдүүлэх зэргээс үүсэх хариуцлагыг өмчлөгч өөрөө хүлээнэ.
8. Үнэлгээчид бид захиалагчийн ирээдүйн орлоготой ямар нэгэн холбоогүй, хөрөнгийн өртгийн дүнд үнэлгээний ажлын хөлс ороогүй, үнэлгээний ажлын хөлс нь үнэлсэн хөрөнгийн үнийн дүн болон үйл ажиллагааны аль нэг хэсэгтэй хамааралгүй.
9. Үнэлгээчид болон үнэлгээний байгууллага хариуцлагын даатгалтай болно.

ДОЛОО. ҮНЭЛГЭЭГ АШИГЛАЖ БОЛОХ НӨХЦӨЛ

Энэхүү үнэлгээг худалдан борлуулах, зээлийн барьцаа хөрөнгө болгон ашиглаж болно.

Тайланг 2 хувь үйлдсэн бөгөөд тамга тэмдэг дарж, гарын үсэг зурсан эх хувь болон нотариатаар гэрчлүүлсэн хуулбар хүчинтэй.

Үнэлгээний огноо: 2017-12-31

Үнэлгээ хийсэн огноо: 2018-05-23

Тайлангийн огноо: 2018-05-23

ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН БИЧСЭН:

"ИТГЭЛТ-ЭСТИМЭЙТ" ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

МЭРГЭШСЭН ҮНЭЛГЭЭЧИН



И.ЗОЛБОО

Э.ГАНБААТАР



11



347

6. ХАВСРАЛТ

6.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол



“ТҮМЭН ШУВУУТ” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БҮС ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 07 өдөр

№ 05/2018

Улаанбаатар хот

Хувьцаа нэмж гаргах, Хувьцаагаа анх удаа нийтэд синэл болгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.4 дэх заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, “Түмэн шувуут” ХХК (наагилд “Компани” гэх)-ийн дүрмийн 6.2 дахь заалтыг тус тус удирдлага болгон, хувьцаагаа анх удаа нийтэд санал болгож Монголын Хөрөнгийн Бирж (цаашид “Бирж” гэх)-ээр арилжих талаарх Гүйцэтгэх захирлын болон холбогдох мэргэжлийн байгууллагын тайлан, дүгнэлт, үнэт цаасны танилцуулгатай танилцсаны үндсэн дээр Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бүс хурлаас ТОГТООХ НЬ:


Нэг. Компанийн одоо гаргасан байгаа нэг бүр нь 20 (Хорин) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 150,000,000 (Нэг зуун тавин сая) ширхэг энгийн хувьцаан дээр нэмж, компанийн нийт хувьцааны 25 (Хорин таван) хувьтай тэнцэх 50,000,000 (Тавин сая) ширхэг энгийн эрхийн хувьцааг нэмж гаргасугай.

Хоёр. Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн одоогийн хувьцаа эзэмшигч нар нэмж гаргах хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхээ бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй


Гурав. Компанийн нэмж гаргасан хувьцааны олон нийтэд санал болгох нэг бүрийн үнийг 200 (Хоёр зуун) төгрөгөөр тогтоож, Монголын хөрөнгийн биржийн хувьцааны хоёрдугаар ангиллаар анхдагч зах зээлийг арилжаагаар нийтэд санал болгосугай.

Дөрөв. Анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулсны дүнд одоогийн хувьцаа эзэмшигчид болон олон нийтийн эзэмших хувь дарлал байдалтай болохыг дурдсугай. Үүнд

Хувьцаа эзэмшигч	Хувьцаа гаргахаас өмнө		Хувьцаа гаргасны дараа	
	Эзэмшиж буй хувьцааны тоо	Эзэмшлийн хувь	Эзэмшиж буй хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
Д.Эрхэмбаяр	60,000,000	40 %	60,000,000	30 %
Б.Тунгалаг	60,000,000	40 %	60,000,000	30 %
Э.Биевжаргал	15,000,000	10 %	15,000,000	7,5 %
Ж.Болд	15,000,000	10 %	15,000,000	7,5 %
Олон нийт	-	-	50,000,000	25%
	150,000,000	100%		
Хувьцаа гаргасны дараа нийт дүв			200,000,000	100%







Тив. Анхдагч зах зээлийн арилжаагаар олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нь 10,000,000,000 (Арван тэрбум) төгрөг байхаар тогтоож, уг мөнгөн хөрөнгийг Үнэт цаасны танилцуулгад дурдсан зориулалтаар зарцуулахаар шийдвэрлэсүгэй.

Зургаа. Хувьцааг олон нийтэд санал болгон амжилттай арилжиж, компанийн хэлбэрийг өөрчлөн хувьцаат компани болсны дараа зохион байгуулах Хувьцаа эзэмшигчдийн эзлэлт бус хурлаар хязалдүүлэх Хувьцаат компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлах бусад дүрэм, журмын хавсралтад дурдсан төслүүдийг дэмжсүгэй.

Долоо. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж хувьцаагаа бүртгүүлэхэд шаардлагатай бүх талын арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран шуурхай зохион байгуулж, хувьцаа эзэмшигчдийг холбогдох мэдээллээр хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ЭРХЭМБЯАР



6.2 Компанийн гэрчилгээ

УБ-2 Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав



МОНГОЛ УЛС

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000026783

<u>2006.06.29</u> <i>/ Бүртгэсэн өдөр /</i>	<u>9011127143</u> <i>/ Улсын бүртгэлийн дугаар /</i>	
	<u>2844753</u> <i>/ Рекордлийн дугаар /</i>	
Түмэншууут	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	
<i>/ Зүүлтэн дараагийн нэр /</i>		
<u>Дурам</u> <i>/ Хувийн хэргийн байршил байна /</i>		
<u>Шийдвэр</u> <i>/ шийдвэрийн нэр /</i>	<u>001</u> <i>/ дугаар /</i>	<u>2004.08.20</u> <i>/ т.сар өдөр /</i>
<u>612200</u> <i>/ код /</i>	<u>Энэ шийдвэр аж ахуй</u> <i>/ Ужирч ажил хийж эхэлсэн өдөр /</i>	
<u>153300</u>	<u>Мөнгө хөрөнгийн үйлдвэрлэл</u>	
<u>511000</u>	<u>Төрийн хөрөнгийн үйлдвэрлэл</u>	
<i>/ код /</i>		
<i>/ Урлаг, урлал, үйлдвэрлэл, үйлчилгээний үйлдвэр /</i>		
<u>Хугацаагүй</u> <i>/ хугацаа /</i>	<u>4</u> <i>/ хувийн хэргийн хэмжээ /</i>	<u>2 627 150 0</u> <i>/ Хувийн хэргийн хэмжээ /</i>
<i>/ Хувийн хэргийн хэмжээ /</i>		
<u>Хан-Уул, 13-р хороо, Туул дотгон (Түмэншууут) ХХК байр - утас: 493663, утас: 86001125, Факс:</u>		
<i>/ Хуулийн гэрээний өдөр /</i>		

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн
 этгээлийн бүртгэлийн газар
/ Бүртгэлийн үйлдвэрлэлийн нэр /

Хувийн хэргийн үйлдвэрлэл
 2010.12.14



СЗХ
2018.12.14 өдөр
ОН СБР
БҮРТГЭВ
№ 01

Харилцаж дагсны бүртгэл

Харилцагч бонийн нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүтээгдсэн өмчийн тэмдэг
Головиг тус банк	Тусгаар	1705025354	Д.Чулуутуяа
Монгол шуудан банк	Валютын	1100876731	О.Хайрмод
Монгол шуудан банк	Тусгаар	1100850881	Г.Д.Төрөгшөөл

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах ба нэгт би чиг оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

№	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
	<i>Дэгийн өөрчлөхөд ойлгох</i>	2011.12.8	О.Хайрмод
1	1709 Сая баатар бодлын үйлдвэрлэл, худалдаа зэрэгт үйл ажиллагаа шинээр бүртгэж 1010 Мая мянган бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа зэрэгт үйл ажиллагаа шинээр бүртгэж	2013.09.16	О.Хайрмод
3	Головиг тус банк бонийн 1705043478 тусгаар өмчийн дансыг бүртгэж	2014.02.11	Д.Чулуутуяа
6	Головиг тус банк бонийн 1705044861 тусгаар өмчийн дансыг бүртгэж	2014.05.14	О.Хайрмод
	Монгол банкны 5001148573 тусгаар өмчийн дансыг бүртгэж	2015.03.20	О.Хайрмод
8	Монгол өмчийн Банк-д Гүйцэтгэх захирал-р томилогч бүртгэж	2015.08.24	Д.Оюу
9	Өөрийн хөрөнгийн хэмжээ 372850 мян төгрөг нэмэгдэх нэгт 3000000 мян төгрөг болсон өөрчлөлтийг бүртгэж	2018.05.30	О.Хайрмод

Энэхүү гэрчилгээг хуурамчээр үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



(Signature)

6.3 Компанийн дүрэм

Хувьцаа эзэмшигчийн хурлын 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 18/03 дугаар тигтгөлоор уг дүрмийн 5.2, 5.3-т нэрчгэлт оруулсан.

"ТҮМЭН ШУВУУТ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ


Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Компанийн оноосон нэр
 - а) Монголоор: "Түмэн Шувуут" ХХК /шаашид энэхүү дүрэмд "компани" гэж
 - б) Латинаар: "Tumen Shuvuut" LLC
- 1.2 Компанийн оршин байгаа газар
 - Улсын нэр: Монгол улс
 - Аймаг, нийслэлийн нэр: Улаанбаатар хот
 - Сум дүүргийн нэр: Хан Уул дүүрэг
 - Баг, хороо, хорооллын нэр: 13-р хороо
 - Гудамж, өргөн чөлөө, тойрог, талбайн нэр: Туул тостгон
 - Хашаа, байшин, хяалганы дугаар: Түмэн Шувуут ХХК
 - Утасны дугаар: 70005225, 70005115
 - Факсын дугаар: 70005225
 - Вэб хаяг: www.tumenshuvuut.mn, Э-шуудан: info@tumenshuvuut.mn
- 1.3 Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн нэрс

№	Эцэг эхч-ийн нэр, өөрийн нэр	Регистрийн дугаар	Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн гэрийн хаяг	Утасны дугаар
1	Ломбын Эрхэмбаар	A362022114	УБ хот, ХУДүүрэг, 15-р хороо, Стадион оргод	88112060
2	Балайгийн Тунгалаг	A362092024	Махатма Ганди 25-р байр 31 тоот	88115584
3	Жигжидийн Болд	4178050578	УБ хот, БЗДүүрэг, 26-р хороо, Кристал таун	88001125
4	Эрхэмбаярын Баяржаргал	A382030521	801-р байр 1005 тоот	88115681

- 1.4. Компани нь бие даасан санхүүгийн тайлан тэнцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг, хариуцлага хүлээх, хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь Нэгэний болон компанийн тухай хууль, энэхүү дүрмээр хязгаарлагдмал хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр ажиллана
- 1.5. Компани нь үйл ажиллагаагаа зараах чиглэлээр явуулна. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг энэ заалтад хамааруулахгүй
 - 1.5.1 Тахив шувууны аж ахуй
 - 1.5.2 Малын тэжээлийн үйлдвэрлэл, худалдаа
 - 1.5.3 Гадвал худалдаа
 - 1.5.4 Сив, баглаа, боодлын үйлдвэрлэл, худалдаа
 - 1.5.5 Мах, махан бүтээгдэхүүний, үйлдвэрлэл худалдаа

Түмэн Шувуут ХХК-ийн дүрэм



- 1.6. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрлийг бичгээр авч, энэхүү дүрмэдээ өөрчлөлт оруулан бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.
- 1.7. Компанийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа: Хугацаагүй
- 1.8. Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу салбар, төлөөлөгчийн газраа байгуулан, бүртгэх байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаагаа явуулна.
- 1.9. Компани нь үүсгэн байгуулах баримт бичигт болон улсын бүртгэлийн жагсаалтад агуулагдаж байгаа бусад мэдээлэлд оруулсан өөрчлөлтүүдэд хуульд заасны хугацаанд бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

Хоёр. Компанийн эрх

- 2.1. Компанийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлжнээр үүснэ.
- 2.2. Компани нь өөрийн бэлгэдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.
- 2.3. Компани нь Компанийн тухай хуулийн 6.1-6.8 дахь хэсэгт заасны дагуу хараат болон охин компани байгуулж болох бөгөөд үүнийггээ бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.
- 2.4. Компани нь өөрийн үйл ажиллагаагад бие даасан байдалаар, эсхүл бусад хуулийн этгээдтэй хамтран Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.
- 2.5. Компани нь үндсэн ба туслах үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар, дадалга туршлагагай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдгэрийн ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

Гурав. Компанийн үүрэг

- 3.1. Компани нь энэхүү дүрмийн 1.5, 1.6-д заасан үйл ажиллагааг Монгол Улсын хуульд заасны дагуу эрхлэнэ.
- 3.2. Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана.
- 3.3. Компани нь Монгол Улсын албан татварын хуулийн дагуу орлого, татвараа өөрөө тодорхойлж, албан татвараа сайн дураар төлнө.
- 3.4. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.
- 3.5. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын өмнө хуулиар өгөгдсөн үүргүүдийг биелүүлнэ.
- 3.6. Компани нь энгийн хувьцааг заавал гаргах үүри хүлээж, давуу эрхийн хувьцааг гаргаж болно.
- 3.7. Компани нь хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг танилцуулах үүрэгтэй.
- 3.8. Компанийн дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт, шинэчлэн найруулсан дүрэм нь улсын бүртгэлд бүртгүүлжнээр хүчин төгөлдөр болно.
- 3.9. Компани хувьцаагаа нэгтгэх, хуваахдаа түүнийг худалдан авах эрхийн бичиг болон түүнд хөрвөх үнэт цаасны бүрдүүлдэрт зохих өөрчлөлт оруулах үүргийг хүлээнэ.
- 3.10. Компани нь хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг танилцуулна.
- 3.11. Компани нь ногдол ашиг аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэнэ.





- 3.12. Хувьцаагаа худалдахар санал болгосж байгаа хувьцаа эзэмшигч нь уг саналаа компанид мэдэгдэх бөгөөд энэ тухай компани нь бусад хувьцаа эзэмшигчид бичгээр мэдэгдэнэ.
- 3.13. Компанийн тухай хуулийн 84.1, 84.2 дахь хэсэгт заасны дагуу Гүйцэтгэх захиралыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.
- 3.14. Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, хувьцаа эзэмшигчийн шаардлагаар танилцуулах, тэдгээрийг архивт шилжүүлнэ.

Дөрөв. Компанийн харьцуулага


- 4.1. Компани нь Компанийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан харьцуулага хүлээнэ.
- 4.2. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын эрхийг зөрчсөн тохиолдолд холбогдох хуульд заасан харьцуулага хүлээнэ.
- 4.3. Компани нь улсын бүртгэлд бүртгүүлэхээсээ өмнө иргэний эрх зүйн харилцаанд бие даан оролцохыг хориглоно. Энэхүү заалтыг зөрчсөний улмаас бусдал гэм хор учруулсан бол буруутай этгээд гэм хорыг арилгана.
- 4.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан харьцуулагыг хүлээнэ.
- 4.5. Компани нь Монгол Улсын хуульд заасан бусад харьцуулагыг хүлээнэ.

Тав. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө

- 5.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.1 дэх хэсэгт зааснаар тодорхойлно.
- 5.2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 3,000,000,000 *Туршиг төгрөм* төгрөг ба нэг бүр нь 20 *хорин* төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 150,000,000 *Нэг туун тэмгэн сан* ширхэг энгийн хувьцаа байна.
- 5.3. Компанийн хувьцаа эзэмшигчид дараах байдлаар гаргасан хувьцааг эзэмшинэ

№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Гаргасан хувьцаа			Хувь нийлүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь
		Тоо ширхэг	Нэрлэсэн үнэ /төгрөг өөр/		
			Нэг бүрийн үнэ	Бүгд	
1	Л. Эрхэмбаяр	60,000,000	20	1,200,000,000	40%
2	Б. Тунгалаг	60,000,000	20	1,200,000,000	40%
3	Ж. Болд	15,000,000	20	300,000,000	10%
4	Э. Баяржаргал	15,000,000	20	300,000,000	10%
	Нийт дүн	150,000,000		3,000,000,000	100%

- 5.4. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.2 дахь хэсэгт зааснаар тодорхойлно.
- 5.5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байна.
- 5.6. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхдөө Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасныг баримтлана.
- 5.7. Компанийн хувьцаа, компанийн заргасан болон гаргасан хувьцаатай холбоотой асуудлыг Компанийн тухай хуулийн 32, 33 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэнэ.

Зургаа. Компанийн удирдлага

- 6.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Компанийн тухай хуулийн 59.1 дэх хэсэгт зааснаар хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
- 6.2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит ба ээлжит бус хурал, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэх, хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох журам, хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц, хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болох, хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэрийн талаар гомдол гаргах, саналын хуудас, саналын хуудсыг хүчинтэйд тооцох, эцнээ санал хурвалтаар компанийн хувьцаа эзэмшигчид шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлтэй холбоотой асуудлыг Компанийн тухай хуулийн 59.74 дүгээр зүйлд зааснаар зохицуулна.
- 6.3. Компанийн гүйцэтгэх захирлыг хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр сонгож, өөрчилнө. Гүйцэтгэх захиралтай хувьцаа эзэмшигчид гэрээ байгуулна.
- 6.4. Компанийн хувьцаа эзэмшигчид компаниа өөрчлөн байгуулах асуудлыг шийлвэрлэнэ.
- 6.5. Компанийг өөрчлөн байгуулсандай холбогдуулан хувьцаа эзэмшигч Компанийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан эрхийг эдлэнэ.

Долоо. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эрх

- 7.1. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан эрхийг эдлэнэ.

Найм. Гүйцэтгэх удирдлага

- 8.1. Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн Гүйцэтгэх захирал байна. Гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 8.2. Компанийн гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.
- 8.3. Компанийн хувьцаа эзэмшигч нь гүйцэтгэх захирал байж болно. Энэ тохиолдолд үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигчийн шийдвэрт тусгах бөгөөд гэрээ байгуулахгүй.
- 8.4. Компанийн гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хуулийн 7.11 дэх хэсэгт заасны дагуу компанийн салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг томилж, чөлөөлнө.
- 8.5. Компанийн гүйцэтгэх захирал нь компанийн өрийг хувьцаагаар солих асуудлыг шийдвэрлүүлдэгдээ Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасныг баримтална.
- 8.6. Компанийн гүйцэтгэх захирал нь компанийг татан буулгах комисс томилгох, татан буулгах хугацаа, журам, эзэлдүүлэгчийн нэхэмжлэлийг баримдуулсны дараа компанид үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлүүлнэ.
- 8.7. Компанийн гүйцэтгэх захирлын шийдвэртэй хувьцаа эзэмшигчдийн тэлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна.



- 8.8. Компанийн гүйцэтгэх захирал хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хуулийн 61.1 дэх хэсэгт заасны дагуу зарлан хуралдуулна.
- 8.9. Компанийн гүйцэтгэх захирал Компанийн тухай хуулийн 61.5 дахь хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас татгалзах шийдвэр гаргах бөгөөд санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчид нэвдэр мэдэгдэнэ.
- 8.10. Компанийн гүйцэтгэх захирал Компанийн тухай хуулийн 61.4 дэх хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэр гаргасан тохиолдолд санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор тухайн хурлыг хуралдуулна.
- 8.11. Компанийн гүйцэтгэх захирал Компанийн тухай хуулийн 66.1 дэх хэсэгт заасан хувьцаа эзэмшигч, 66.3 дэх хэсэгт заасны дагуу саналаа бичгээр гаргасан тохиолдолд 66.5 дэх хэсэгт заасан үүргийг хүлээнэ. Мөн хуулийн 66.6 дэх хэсэгт зааснаар компанийн гүйцэтгэх захирал үндэслэл бүхий тайлбарыг шийдвэр гаргаснаас хойш ажлын гурван өдрийн дотор санал гаргасан хувьцаа эзэмшигчид хүргүүлнэ.
- 8.12. Компанийн гүйцэтгэх захирлын бүрэн эрх нь дуусгавар болсон өдрөөс хойш байгуулсан гэрээ, хэлэлцэх хүчин төгөлдөр бус байна.
- 8.13. Компанийн гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хуульд заасан их хэмжээний хэлэлцэл мөн эсэхийг тодорхойлоходоо аудитормын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг мөнгөний ханшийн уналтын түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно.
- 8.14. Компанийн гүйцэтгэх захирал нь компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.

Ес. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих уяналт

- 9.1. Компанийн хувьцаа эзэмшигч Компанийн тухай хуулийн 94.1 дэх хэсэгт зааснаар гэрээний үндсэн дээр аудитын байгууллагыг томилон ажилдуулж болно.
- 9.2. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудитын байгууллагын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.
- 9.3. Компанийн жиллийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд хийсэн аудитын байгууллагын шалгалт нь ээлжит байна.
- 9.4. Аудитын байгууллагын шалгалтын хөлсийг Компанийн тухай хуулийн 94.8 дахь хэсэгт заасны дагуу компани болон хувьцаа эзэмшигч хариуцан төлнө.
- 9.5. Компани нь санхүүгийн тайлангаа эрх бүхий этгээдэд танилцуулна.
- 9.6. Компанийн санхүүгийн жил 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.
- 9.7. Компани нь компанийн санхүүгийн тайланд Компанийн тухай хуулийн 96.1 дэх хэсэгт заасан зүйлийг тусгана.
- 9.8. Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, эрх бүхий этгээдийн шаардлагаар танилцуулах, хуульд заасан хугацаа дууссаны дараа архивт шилжүүлнэ.

Арав. Компанийг өөрчлөн байгуулах

- 10.1. Компанийн хувьцаа эзэмшигч нь компанийг өөрчлөн байгуулахдаа Компанийн тухай хуулийн 18-23 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

Арван нэг. Компанийг татан буулгах

- 11.1. Компанийг Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан үндэслэлээр татан буулгана.







- 11.2. Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд татан буулгах комиссыг томилно
- 11.3. Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24.1 дэх хэсэгт заасан хугацаанд бүртгэх байгууллагад бичгээр мэдэгдэж, холбогдох баримт бичгийг хавсаргасан байна.
- 11.4. Татан буулгах комисс Иргэний хуулийн 32.2-32.10 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 26, 27, 28 дугаар зүйлд заасны дагуу компанийг татан буулгах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.
- 11.5. Компани татан буулгасныг улсын бүртгэлд бүртгүүлэхээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрдүүлж бүртгэх байгууллагад хүргүүлнэ.

Арван хоёр. Бусад зүйл

- 12.1. Энэхүү дүрмийг Монгол хэлээр 3 хувь үйлдэж, нэг хувийг бүртгэх байгууллагад, хоёр хувийг компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх эрх бүхий этгээдэд өгнө.
- 12.2. Компанийн дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болсонд тооцно.

**“Түмэн Шувуут” ХХК-ийн
хувьцаа эзэмшигчдийн гарын үсэг**


1.  Ломбын Эрхэмбаяр
2.  Байлагийн Тунгалаг
3.  Жигжидийн Болд
4.  Эрхэмбаярын Баяржарал



Түмэн Шувуут ХХК

Түмэн Шувуут ХХК-ийн дүрэм

Хавсралт 1 Түмэн шувуут ХХК-н дүрэм

6.4 Хувьцаат компанийн дүрмийн төсөл

ТӨСӨЛ, 2018 ОНЫ 5 ДУГААР САР

"Түмэн шувуут" ХК-ийн 20__ оны __ дугаар сарын
_____-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын
____ дугаар тогтоолоор батлав.

"ТҮМЭН ШУВУУТ" НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1. Нийтлэг үндэслэл

- 1.1. "Түмэн шувуут" (цаашид "Компани" гэх) нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох журам болон бусад хууль тогтоомж, энэхүү дүрэм (цаашид "Дүрэм" гэх)-ийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах нээлттэй хувьцаат компани (цаашид "ХК" гэх) мөн.
- 1.2. Компани нь өөрийн бэлгэдэл, тогтоосон журмын дагуу хийлгэсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
- 1.3. Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд оноосон нэрнийхээ дараа "ХК" гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.
- 1.4. Компани нь хугацаагүйгээр үйл ажиллагаа явуулна.
- 1.5. Компани нь охин буюу хараат компани байгуулж болох бөгөөд Монгол Улсад болон гадаадад өөрийн салбар буюу төлөөлөгчийн газартай байж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхгүй болно.
- 1.6. Энэхүү дүрэм болон ТУЗ-аас батлах журмууд нь Компанийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцсэн байх бөгөөд энэхүү дүрэм болон ТУЗ-аас батлах журмаар тусгайлан зохицуулаагүй харилцааг Компанийн тухай болон бусад хууль тогтоомжид зааснаар зохицуулна.
- 1.7. Энэхүү дүрмийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид үндэслэн боловсруулсан бөгөөд тус хууль, тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлт нь дүрмийн хэсэг, зүйл, заалттай зөрчилдөх тохиолдолд хуулийн зохицуулалтыг мөрдөх ба шаардлагатай тохиолдолд энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

2. Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг

2.1. Компанийн оноосон нэрийг Монгол хэлээр "Түмэн шувуут"ХК, Англи хэлээр "Tumen shuvuut" JSC гэнэ.

2.2. Компанийн төв байр дараах хаягт оршин байрлана:



Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Монгол улс, 13 дугаар хороо

Туул тосгон, Түмэн шувуут ХХК

Харилцах утас: 976-70005225, 70005115

Факс: 976-70005225

Цахим шуудан: info@tumenshuvuut.mn



Цахим хаяг: www.tumenshuvuut.mn

3. Компанийн эрхэм зорилго

- 3.1. Компанийн эрхэм зорилго: Монгол хүний эрүүл мэндийн төлөө шинэ, чанартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, хэрэглэгчдэд нийлүүлэх. Мэргэшсэн, ёс зүйтэй, хариуцлагатай баг хамт олон байх. Хүнс, тэжээл үйлдвэрлэх үйл ажиллагаагаараа мал аж ахуй, газар тариалангийн салбарын уялдаа холбоог сайжруулж, байгаль орчныг хамгаалах.
- 3.2. Компанийн алсын хараа: Өндөг үйлдвэрлэх туршлагаараа хамгийн инновацлаг, тэргүүлэгч байх

ХОЁРДУГААР БҮЛЭГ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэл

- 4.1. Компани нь шувууны аж ахуй, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагааг эрхэлнэ.
- 4.2. Компани нь дор дурдсан үйл ажиллагааг явуулна. Үүнд:
 - 4.2.1. Тахианы шувууны аж ахуй;
 - 4.2.2. Малын тэжээлийн үйлдвэрлэл, худалдаа;
 - 4.2.3. Гадаад худалдаа;
 - 4.2.4. Сав, баглаа, боодлын үйлдвэрлэл, худалдаа;
 - 4.2.5. Мах, махан бүтээгдэхүүний, үйлдвэрлэл худалдаа.
- 4.3. Компани нь тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааг холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авснаар эрхлэх бөгөөд тухайн зөвшөөрлийн нөхцөл, хугацааг чанд мөрдөж ажиллана.
- 4.4. Компани нь өөрийн зорилго болон эрхлэх үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй шууд буюу шууд бус холбоотой, хууль тогтоомжоор хориглоогүй бүхий л төрлийн үйл ажиллагаа эрхлэх болон ажил гүйлгээг хийх бүрэн эрхтэй байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа

- 5.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь компанийн нийт гаргасан бөгөөд эргэлтэнд байгаа хувьцаанаас бүрдэх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгөнд зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.
- 5.2. Компани нь нэг бүр нь 20 (хорин) төгрөгийн нэрлэсэн үнэтэй (усгээр) ширхэг энгийн хувьцаатай байна.
- 5.3. Компанийн энгийн хувьцаа нэг бүр нь нэг саналын эрхтэй байна.
- 5.4. Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд уг нөхцөл байдал бүртгэгдсэн албан ёсны санхүүгийн тайлан гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах, компанийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэгтэй.



6. Компанийн хувьцаа эзэмшигч
- 6.1. Хувьцаа эзэмшигчид нь хувь хүн, хуулийн этгээд байж болно.
 - 6.2. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг үнэт цаасны хадгаламж, бүртгэлийн эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ.



7. Компанийн болон хувьцаа эзэмшигчдийн хариуцлага

- 7.1. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.
- 7.2. Компани нь Хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд Хувьцаа эзэмшигч нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй.
- 7.3. Компанийн хувьцаа эзэмшигчид нь гагцхүү өөрийн эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээгээр эрсдэл, хариуцлага хүлээнэ.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. КОМПАНИЙН УДИРДЛАГА,
ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО**

8. Хувьцаа эзэмшигчдийн хурал

- 8.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
- 8.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит ба ээлжит бус байх бөгөөд ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ нь Компанийн тухай хуульд заасан хугацаанд буюу санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор жилд нэг удаа зарлан хуралдуулна.
- 8.3. Дараах тохиолдолд ТУЗ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:
 - 8.3.1. ТУЗ-ийн нийт гишүүний 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
 - 8.3.2. ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан;
 - 8.3.3. компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;
 - 8.3.4. ТУЗ шаардлагатай гэж үзэж шийдвэр гаргасан;
 - 8.3.5. аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;
 - 8.3.6. компанийн тухай хууль болон дүрэмд заасан бусад тохиолдол.
- 8.4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх бүрэн эрхтэй. Үүнд:
 - 8.4.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
 - 8.4.2. нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
 - 8.4.3. компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
 - 8.4.4. компанийн хэлбэрийг өөрчлөх;
 - 8.4.5. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
 - 8.4.6. хувьцааг хуваах буюу нэгтгэх;
 - 8.4.7. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
 - 8.4.8. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;



- 8.4.9. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- 8.4.10. төлөөлөн удирдах зөвлөлөөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;
- 8.4.11. төлөөлөн удирдах зөвлөлөөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
- 8.4.12. хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;
- 8.4.13. компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- 8.4.14. төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
- 8.4.15. хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал.
- 8.5. Дараах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхиор батална. Үүнд:
- 8.5.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлах;
- 8.5.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
- 8.5.3. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
- 8.5.4. Компанийн өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох;
- 8.5.5. Давуу эрхийн хувьцаа гаргах;
- 8.5.6. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- 8.5.7. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;
- 8.5.8. Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх эсэх;
- 8.5.9. Компанийн хувьцааг нэгтгэх буюу хуваах;
- 8.5.10. Хууль тогтоомжид заасан бусад.
- 8.6. Энэхүү дүрмийн 8.5.1-8.5.6-д заасан асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхиор шийдвэрлэнэ.
- 8.7. Энэхүү дүрмийн 8.6-д зааснаас болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр нь хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхи дэмжсэнээр хүчин төгөлдөр болно.
- 8.8. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ. Энэ аргыг хэрэглэхдээ тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох 9 гишүүний тоогоор үржүүлж саналын эрхийн тоог тодорхойлно. ТУЗ-ийн гишүүнд сонгогдохоор нэр дэвшсэн хүмүүсийн нэрийг саналын хуудсанд оруулахдаа ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй хүмүүсийн нэрсийг тус тусад нь жагсаана.
- 8.9. Хувьцаа эзэмшигч нь ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй хүмүүст тус тусад нь саналаа өгөх бөгөөд ТУЗ нь 9 гишүүнтэй байх тул энгийн гишүүнд нэр дэвшиж буй 1-6 хүртэл тооны хүнд нийт саналынхаа 2/3-ийг, хараат бус гишүүнд нэр дэвшиж буй 1-3 хүртэл тооны хүнд нийт саналынхаа 1/3-ийг өгнө. Энэ хуваарийг зөрчиж санал өгсөн бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.
- 8.10. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тоолохдоо тус бүрд нь тоолж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр тус тус сонгоно.

8.11. Хуралд оролцох журам:


- 8.11.1. Хувьцаа эзэмшигч нь өөрийг нь төлөөлж хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр оролцуулж болно.
- 8.11.2. Төлөөлөх тухай итгэмжлэл нь тодорхой хугацаа заагаагүй бол гагцхүү тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүчинтэй. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл хойшлогдсон хуралд хүчинтэй хэвээр байна.
- 8.11.3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирүүлсэн саналын хуудас, мөн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийг хурлыг зарласан өдрөөс эхлэн хурал хуралдах өдрийн хурал эхлэх цаг хүртэл хүлээн авч бүртгэнэ. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг энэхүү дүрмийн 9.7-д зааснаар тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тодорхойлж, тооллогын комисс эсхүл түүний үүргийг гүйцэтгэхээр ТУЗ-өөс тусгайлан томилсон этгээд гүйцэтгэнэ.
- 8.11.4. Хувьцаа эзэмшигчид нь хэлэлцэж буй асуудлын талаар саналаа санал авах хуудсаар ирүүлсэн тохиолдолд түүнийг тухайн хуралд оролцсонд тооцно. Хурлын ирцийг хэлэлцэх асуудал бүрээр гаргах ба тухайн хэлэлцэх асуудалд санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг тухайн асуудал хэлэлцэхэд оролцсонд тооцно. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно.
- 8.11.5. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.
- 8.11.6. Хурлын ирц хүрээгүй тохиолдолд хурлыг хойшлуулах бөгөөд харин хэлэлцэх асуудал хэвээр байна. Хойшлогдсон хурлыг ажлын долоогоос доошгүй өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын долоогоос доошгүй өдрийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.
- 8.11.7. Саналын эрхийн 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах; нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах; компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох; компанийн хэлбэрийг өөрчлөх; компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох; хувьцааг хуваах буюу нэгтгэх тухай асуудлыг хэлэлцэх хойшлогдсон хурал нь саналын эрхийн гуравны нэгээс доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор хүчин төгөлдөр болно.
- 8.12. Компанийн бүртгэлийн өдрийг төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс өмнө байж болохгүй.
- 8.13. Санал авах хуудас, түүнийг хүчинтэйд тооцох:
- 8.13.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар саналыг санал авах хуудсаар авч болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргахдаа тогтооно.
- 8.13.2. Санал авах хуудасны агуулгыг ТУЗ хурал хуралдуулах тухай шийдвэртээ тогтооно. Санал авах хуудсанд Компанийн оноосон нэр, хурал хийх газар, өдөр, цаг, хувьцаа эзэмшигчдийн нэр, эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо хэмжээ, санал хураалтаар шийдвэрлэх асуудлын нэр, хурлаас хэлэлцэх асуудал бүрээр гарах шийдвэрийн төсөл зэргийг тусгана.
- 8.13.3. Санал авах хуудсанд (ТУЗ болон бусад удирдлагын байгууллагын гишүүнийг сонгохоос бусад тохиолдолд) санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг тэмдэглэсэн


тохиолдолд хүчинтэй байна. Санал авах хуудсыг хурал зарласан өдрөөс эхлэн тухайн асуудлыг хэлэлцэж дуусах хүртэлх хугацаанд авна.

- 8.14. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдох зардлыг компани бүрэн хариуцна.
- 8.15. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр гарах бөгөөд хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хурлын шийдвэр, тэмдэглэлийг албажуулж, хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд хурлын дарга тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна.
- 8.16. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд тусгах мэдээлэл, санал хураалтын дүнг зарлах болон бусад тэмдэглэлтэй холбоотой харилцааг Компанийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.

9. Төлөөлөн удирдах зөвлөл

- 9.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх журам, тэдний үйл ажиллагааны болон үйл ажиллагаанд нь дүгнэлт өгөх журам, ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг зэргийг Компанийн тухай хуульд нийцсэн "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-аар тогтоох бөгөөд уг журмыг ТУЗ батлан мөрдүүлнэ.
- 9.2. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байна.
- 9.3. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 1 (нэг) жил байна. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд ТУЗ-ийн гишүүнийг хэдэн ч удаа улируулан сонгож болно.
- 9.4. ТУЗ-ийн гишүүнд урамшуулал олгож болох бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно. Урамшуулалтай холбоотой асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.
- 9.5. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд Компанийн тухай хууль болон энэхүү дүрэмд заасны дагуу нөхөн сонгох бөгөөд тус асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох үндэслэлийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.
- 9.6. ТУЗ нь Компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурал, Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд хамааруулснаас бусад асуудал буюу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 9.6.1. компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратегийг тодорхойлох, компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөөг батлах;
 - 9.6.2. компанийн үнэт цаасыг гаргах;
 - 9.6.3. компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
 - 9.6.4. компанийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх, стратеги, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд арилжааны эх үүсвэр татан төвлөрүүлэх;
 - 9.6.5. гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг тогтоох;
 - 9.6.6. компанийн гүйцэтгэх захирлыг томилох, түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
 - 9.6.7. компанийн хөндлөнгийн Аудитыг сонгож, гэрээ байгуулах;
 - 9.6.8. ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах;
 - 9.6.9. гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллыг тогтоох;
 - 9.6.10. байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг батлах;
 - 9.6.11. компанийн салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах;
 - 9.6.12. компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох;
 - 9.6.13. хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;


ТТБ №19-1
2844783



363

- 9.6.14. хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
- 9.6.15. өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
- 9.6.16. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;
- 9.6.17. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмуудыг батлах;
- 9.6.18. компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 9.6.19. их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 9.6.20. сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 9.6.21. эрх бүхий албан тушаалтны компанид учруулсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 9.6.22. Компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал, түүнчлэн Компанийн тухай хууль, компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурал, гүйцэтгэх удирдлагын эрхэд хамааруулснаас бусад буюу ТУЗ шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх.
- 9.7. ТУЗ нь хууль тогтоомжид зөвхөн ТУЗ хэрэгжүүлэхээр зааснаас бусад бүрэн эрхээ Гүйцэтгэх удирдлагад хариуцуулан гүйцэтгүүлж болно.
- 9.8. ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн дарга, Компанийн Гүйцэтгэх захирлын санаачилгаар эсвэл ТУЗ-ийн гишүүдийн саналаар нэмэлт хурал хуралдуулж болно.
- 9.9. ТУЗ-ийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүд бүр саналын нэг эрхтэй байна.
- 9.10. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болж, хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 9.11. Төлөөлөн удирдах зөвлөл эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.
- 9.12. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын дарга гарын үсэг зурна.
- 9.13. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдэд зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичиж хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана:
- 9.13.1. тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, бүтэц, зохион байгуулалт, түүний өөрчлөлт;
- 9.13.2. тайлангийн хугацаанд компанийн эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшуулал удирдлагын зардлын хэмжээ;
- 9.13.3. хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

10. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга

- 10.1. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос тэдгээрийн олонхийн саналаар сонгоно.
- 10.2. Компанийн ТУЗ-ийн дарга нь бусад гишүүдтэй адил эрх эдлэхээс гадна ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих чиг үүргийг гүйцэтгэнэ.
- 10.3. ТУЗ-ийн даргын түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон, эсхүл ТУЗ-ийн томилсон аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

И. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнийг нэр дэвшүүлэн сонгох




- 11.1. ТУЗ нь нэр дэвшүүлэх хороотой байна.
- 11.2. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүнд Компанийн тухай хууль болон ТУЗ-ийн зохих журамд заасан шалгуурыг хангасан хүнийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу сонгон шалгаруулж ХЭХ-д нэр дэвшүүлнэ.
12. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн
- 12.1. ТУЗ-ийн хараат бус гишүүнд дараах шалгуурыг хангасан хүнийг ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо дэвшүүлнэ:
- 12.1.1. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй;
 - 12.1.2. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;
 - 12.1.3. төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;
 - 12.1.4. компанитай бизнесийн аливаа холбоогүй;
 - 12.1.5. хууль тогтоомжид заасан бусад шаардлага.
- 12.2. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүргийг хүлээнэ:
- 12.2.1. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцэж буй эсэхэд хяналт тавих, зөрчихөөс урьдчилан сэргийлэх, зөрчсөн тохиолдолд холбогдох этгээдэд тавьж шийдвэрлүүлэх, шаардлагыг эс биелүүлбэл ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах шаардлага хүргүүлэх;
 - 12.2.2. компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
 - 12.2.3. хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн зарим шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлэх эрхтэй;
 - 12.2.4. компанийн нөхцөл байдал, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчдээс асуусан асуултад хариу өгөх, тодруулга хийх;
 - 12.2.5. Компанийн тухай хуульд заасан бусад эрх, үүрэг.
- 12.3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд дараах асуудлыг хэлэлцэхэд заавал оролцож саналаа өгнө. Үүнд:
- 12.3.1. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
 - 12.3.2. Санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
 - 12.3.3. Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох.
13. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга
- 13.1. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно.
- 13.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурал ба ТУЗ-ийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх зэрэг ТУЗ-ийн журмаар тогтоосон ниг үүргийг хэрэгжүүлнэ.

